



MINISTRY OF EDUCATION,
CULTURE, SCIENCE
AND SPORTS



Japan International
Cooperation Agency

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ТАЙЛАН

“СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ” ТӨСӨЛ

УЛААНБААТАР
2018 ОН

УДИРТГАЛ	5
Үндэслэл, зорилго	5
Мэдээлэл цуглуулсан үйл явц	5
Мэдээллийг эмхлэн цэгцэлсэн арга аргачлал	5
БҮЛЭГ 1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ.....	7
P1.1 Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулах.....	7
P1.2 Сурах бичиг, багшийн ном зохиох.....	26
БҮЛЭГ 2. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ.....	50
P2.1 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах.....	50
P2.2 Сургуулийн түвшинд сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.....	66
БҮЛЭГ 3. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ	86
P3.1 Үнэлгээний багийг байгуулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	86
P3.2 Чанарын үнэлгээний судалгаа /5, 9, 12-р ангид/	88
P3.3 Улсын шалгалт /5, 9, 12-р ангид/	92
БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, САНАЛ	95
4.1 Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах	95
4.2 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.....	101
4.3 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх	107
ХАВСРАЛТ	131
1. Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах	131
2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.....	131
3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх	131

ҮГИЙН ТАЙЛБАР

ТОВЧИЛСОН ҮГ	НЭР
A1	Activity 1
P1	Phase 1
T1	Task 1
БМДХБ	Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгжилтийн баг
БМДИ	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
БСГ	Боловсрол соёлын газар
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БҮТ	Боловсролын үнэлгээний төв
БХ	Боловсролын хүрээлэн
БХО	Багшийн хөгжлийн ордон
БЧББ	Байгууллагын чадавхийг бэхжүүлэх баг
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДБХ	Дүүргийн боловсролын хэлтэс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЛС	Лаборатори сургууль
МАЗЗ	Мэргэжил арга зүйн зөвлөл
МБ	Менежментийн баг
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
МУИС	Монгол улсын их сургууль
МХСН	Монголын хичээлийн судалгааны нийгэмлэг
НБГ	Нийслэлийн боловсролын газар
СББ	Сурах бичгийн баг
СБСОСС	Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор
ТББ	Төрийн бус байгууллага
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УБ	Улаанбаатар
ҮБ	Үнэлгээний баг
ХБ	Хэрэгжилтийн баг
ХББ	Хөтөлбөр боловсруулах баг
ХОН	Хөдөө орон нутаг
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль

Хавсралт дахь ажлын хүснэгтийн мэдээллийг “Төлөвлөх-Гүйцэтгэх-Үнэлэх-Сайжруулах” (Plan-Do-Check-Action) загварыг ашиглан хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах чиглэлээр хийсэн ажлыг “Phase–Activity–Task” бүтцийн дагуу эмхтгэн цэгцэлсэн. Ажлын хүснэгт дэх кодийн дагуу энэхүү тайлангийн гарчгийг Phase1, Activity1, Task1 товчлон P1.A1.T1 гэж дугаарласан болно.

- Phase 1: БҮЛЭГ 1. Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах
- Phase 2: БҮЛЭГ 2. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх
- Phase 3: БҮЛЭГ 3. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх

УДИРТГАЛ

.....

Үндэслэл, зорилго

Монгол Улсын боловсролын салбарт бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлт 1990-ээд оноос эрчимтэй хийгдэж иржээ. Тухайлбал, 2004 онд цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг боловсруулж үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн бол 2005 оноос 10 жилийн тогтолцооноос 11 жилийн тогтолцоонд, 2008 оноос 11 жилийн тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд шилжсэн байна. Энэхүү боловсролын бүтцийн болон бодлогын өөрчлөлтийг даган ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг хэд хэдэн удаа шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлжээ.

Богино хугацаанд шинэчлэгдсэн сургалтын хөтөлбөрийг даган боловсролын тогтолцооны тогтвортой, уялдаатай, нэгдмэл, цогц байдал зэрэг асуудал хөндөгдсөөр ирсэн. Эдгээр асуудлын цаана нэгдмэл ойлголт, нэгдсэн төлөвлөлт, нөөцийн хуваарилалт, гүйцэтгэл, үр дүн, сайжруулалт зэрэг асуудлыг зайлшгүй авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын боловсролын цаашид хийх шинэчлэл, сургалтын хөтөлбөрийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, аргачлал боловсруулах хэрэгцээг үндэслэн энэхүү тайланг боловсрууллаа. Уг тайлангийн зорилго нь боловсролын тогтолцооны нэгдмэл, цогц, тогтвортой байдлыг ханган хөтөлбөрийн менежментийг сайжруулах санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Үүний тулд 2012 оноос өнөөг хүртэлх сургалтын цөм хөтөлбөр, сурах бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл ажиллагааны талаарх мэдээ, баримт цуглуулан, эмхтгэн цэгцэлж, давуу, сул талыг дүгнэн, тулгамдсан асуудлыг илрүүлж, түүнээс гарах шийдэл саналыг дэвшүүлсэнийг онцлон тэмдэглэж байна.

Мэдээлэл цуглуулсан үйл явц

2012-2016 онд сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байсан хүмүүсийн хүрээнд 3 өдрийн дадлага ажлыг зохион байгуулан, цуглуулсан мэдээлэл дээр тулгуурлав. Дадлага ажилд боловсролын байгууллагуудаас нийт 73 хүн оролцсон. Үүнд: БСШУСЯ-1, БХ-13, БМДИ-16, БҮТ-10, МУИС-6, МУБИС-6, Хэрэгжилтийн баг-6, Бусад-15

Энэхүү 3 өдрийн дадлага ажлаар сургалтын хөтөлбөрийн шинэчлэлд оролцож байсан багийн гишүүдээс мэдээлэл цуглуулсан хэдий ч дараагийн шатанд мэргэжлийн байгууллагын төлөөлөл мэдээллийг дахин нягталсан болно.

Мэдээллийн хязгаарлалт: Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын мэдээллийн санд өнгөрсөн хугацаанд хийгдсэн хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцын талаарх мэдээ баримтууд системчлэгдэн хуримтлагдаагүйн улмаас тухайн үйл явцад оролцож байсан багийн гишүүдэд байсан мэдээлэлд үндэслэсэн болно.

Мөн сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үйл явцыг төлөвлөсөн үйл ажиллагааны зардлын тухай мэдээлэл хязгаарлагдмал байсан учир санхүүгийн тооцоо, түүнд дүгнэлт хийх боломжгүй байсныг дурдах нь зүйтэй.


Мэдээллийг эмхлэн цэгцэлсэн арга аргачлал

2012 оноос Монгол Улсын бага, дунд боловсролд хэрэгжүүлсэн Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд сургалтын цөм хөтөлбөр боловсруулах, сурах бичиг зохиох, сургуулиудад хэрэгжүүлэх, үнэлэх үйл ажиллагааны талаарх баримт мэдээлэлд тулгуурлан тухайн үед хийгдэж байсан ажлуудыг “PDCA” (Plan-Do-Check-Action) загварыг ашиглан “Үйл ажиллагааны дарааллын бүтэц” /Work Breakdown Structure/ аргачлалын дагуу эмхтгэн цэгцлэв.

Мэдээллийг эмхтгэн цэгцлэхдээ үйл ажиллагааны дарааллын дагуу “Phase-Activity-Task-Subtask” гэсэн хүснэгтийн загварыг ашиглан “Ажлын хүснэгт” боловсруулсан. Энэхүү ажлын хүснэгт дэх мэдээллийг үндэслэн өнгөрсөн хугацаанд хийсэн ажлын ололт, амжилт, алдаа оноо, цаашид сайжруулах саналыг боловсруулсан болно.

Мэдээлэл цуглуулан, эмхлэн цэгцлэхдээ дараах загварыг ашигласан болно.

Сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн мэдээлэл цуглуулах загвар (PDCA)



Мэдээллийг эмхлэн цэгцлэх “Үйл ажиллагааны дарааллын бүтэц”

Phase - Activity - Task			Хүрэх үр дүн	Хариуцагч	Хамтрагч	Хүний тоо	Ажлын хугацаа	Хаана	Хэрэглэгдэхүүн
Phase 1									
	Activity 1								
	Task 1								
	Task 2								
	Task 3								
	Task 4								

Тайлбар:

Мэдээллийг эмхтгэн цэгцлэх явцад тухайн үед ажиллаж байсан “хэрэгжилтийн баг”-ийн гэрээ дууссан тул хэрэгжилтийн багийн хийж гүйцэтгэсэн ажлын тухай мэдээллийг тухайн багийн ажлын тайлангаас авсан болно. Мөн “үнэлгээний баг”-т ажиллаж байсан гишүүд уг тайлан бичих үйл явцад оролцоогүйг тэмдэглэх нь зүйтэй. “Үнэлгээний баг”-ийн тайлан, мэдээлэл хангалттай олдоогүйн улмаас Боловсролын үнэлгээний төв дээр хийгдсэн ажлын мэдээлэлд үндэслэсэн болно.

1 БҮЛЭГ

СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАХ БИЧИГ БОЛОВСРУУЛАХ

Р1.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, СУРАЛЦАХҮЙН УДИРДАМЖ БОЛОВСРУУЛАХ

Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих хандлага, үзэл баримтлал болон Монгол улсын боловсролын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн үзэл санааг тусган боловсролыг шинэчлэх хэрэгцээ, шаардлага бий болсон. Боловсрол, шинжлэх ухааны салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөрт “Зан чанар, хандлагыг төлөвшүүлэх, мэдлэг эзэмших, чадвараа хөгжүүлэх” гэдгийн тэнцвэрийг хадгалж, төлөвшсөн хувь хүн, өрсөлдөх чадвартай хүний нөөц, аз жаргалтай гэр бүлийг дэмжих зорилт тавин ЕБС-ийн сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулсан.

Р1.1.А1. Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулах бэлтгэл ажлыг хангах

Сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд БШУ-ы яамны дэргэд боловсролын шинэчлэлийг дэмжин ажиллах үндэсний зөвлөл, менежментийн баг байгуулагдан, гадаад улс орнуудын сургалтын хөтөлбөрийг орчуулах, харьцуулсан судалгаа хийх, бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал, үзэл баримтлалыг боловсруулах, улмаар үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлтийн дагуу ажлын хэсгүүд ажилласан байна.

Р1.1.А1.Т1. Үндэсний зөвлөл, менежментийн баг болон судлагдахууны ажлын хэсэг байгуулах

Улсын Их Хурлын 2012 оны 37-р тогтоолоор баталсан “Эрдэм боловсролтой Монгол хүн” хөтөлбөр, 2013 оны 295 дугаар тогтоолоор “Зөв монгол хүүхэд” дэд хөтөлбөр батлагдсаныг үндэслэл болгон бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал боловсруулах баг, үндэсний шинэ стандарт, сургалтын хөтөлбөр, сурах бичиг зохиох ажлын хэсэг байгуулагдсан.

Бага, дунд боловсролын стандартад үнэлгээ хийх, үндэсний хөтөлбөр боловсруулах, түрших ажлыг зохион байгуулах тухай БШУ-ы сайдын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/180 дугаар тушаал батлагдсан. Уг тушаалын нэгдүгээр хавсралтаар бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад үнэлгээ хийх ажлын хэсгийг (6 хүн), хоёрдугаар хавсралтаар үндэсний зөвлөл (14 хүн) болон менежментийн багийн (12 хүн) бүрэлдэхүүнийг, гуравдугаар хавсралтаар бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх бодлогын удирдлага зохион байгуулалтыг баталжээ.


Бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад үнэлгээ хийх ажлын хэсэг нь хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлэх үзэл санаа хэрхэн туссан талаар дүгнэлт гаргах, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга технологийн талаар санал зөвлөмж боловсруулах зорилго тавин ажилласан байна. Хүүхдийн хөгжлийн үзүүлэлтийг ерөнхий байдлаар а.Бие бялдрын хөгжил, б.Танин мэдэхүйн хөгжил, в.Нийгэмшихүйн хөгжил гэж үзсэн бөгөөд үүнээс үндэслэн хүүхдийн хөгжил гэдэг нь “хүүхдийн бие бялдар, оюун ухаан, зан чанар, хандлага, харьцаанд гарч байгаа эерэг өөрчлөлт, үйл явц” гэснийг, “Хүүхэд бүрийг хөгжүүлэх гэдэг нь зорилгын хувьд хүүхэд бүрийн онцлогийг тусгасан, агуулга нь хүүхэд бүрийн хэрэгцээг харгалзсан, арга зүй хэрэглэгдэхүүн нь хүүхэд бүрийн сонирхлыг татсан, үнэлгээ нь өөртөө итгэх итгэлийг хүүхэд бүрт төрүүлж байх утга илэрхийлнэ” гэснийг эш үндэс болгон боловсролын стандартын үзэл баримтлал, агуулга, арга зүй, үнэлгээний хэсэг тус бүрээр дүгнэлт гарган, хүүхэд залуучуудын авьяас, чадварыг хөгжүүлэх үзэл онолыг дэвшүүлсэн байна. Үнэлгээний баг нь олон улсын боловсролын шинэчлэлийн чиг хандлага, тухайлбал ЮНЕСКО-ийн “Хүүхэд бүрийн сурах хэрэгтэй зүйлс”, Бангкок дахь ERI-Net судалгааны төвөөс 2013 онд гаргасан 21-р зууны суралцагчийн эзэмших чадвар зэрэг баримт бичиг, судалгааны үр дүнд үндэслэн “Хүүхэд бүрийн хөгжих боломжийг бүрдүүлэх сургалтын арга зүй, технологи”-ийг сургалтын цөм хөтөлбөр боловсруулах үзэл баримтлалын үндэслэл болгохыг танилцуулсан байна.

Менежментийн баг нь бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал, үзэл баримтлалын дагуу сургалтын цөм хөтөлбөр боловсруулах, сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх төсвийн төлөвлөлт, дэд баг, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн боловсруулсан бүтээгдэхүүний төсөл, сургалтын хөтөлбөрийн туршилтын явц, үр дүнг хянан хэлэлцэж сайжруулах үүрэг даалгавар өгч ажилласан. Менежментийн баг нь бүтээгдэхүүний чанарт анхаарч, сард 2 удаа судлагдахууны багийн өргөтгөсөн уулзалтыг зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал:

- 2013-2014 онд нийт 24 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг
- 2014-2015 онд нийт 18 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг
- 2015-2016 онд 19 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байна.

Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх бодлогын удирдлага, зохион байгуулалтыг дараах зураглалын дагуу зохион байгуулахаар баталсан.

Зураг 1.1.1. Бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх бодлогын удирдлага зохион байгуулалт



БШУ-ы сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглалыг; хоёрдугаар хавсралтаар Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалыг; гуравдугаар хавсралтаар Бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр шинэчлэх (102), Боловсролын үнэлгээ (6), Багшийн мэргэжил дээшлүүлэх (6), Сурах бичиг, сургалтын орчин (6), Боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх (6) багийн бүрэлдэхүүнийг баталсан.

Зураг 1.1.2. Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал

2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Бэлтгэх:		Үндэсний түвшинд нэвтрүүлэх:			Үнэлэх:	
Бага, дунд боловсролын сургалтын агуулгын талаар баримтлах бодлого боловсруулах		I-V анги	VI-IX анги	X-XII анги	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх	Сургалтын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах
I-X ангийн математик, I-V ангийн байгалийн шинжлэл, V-X ангийн англи хэл, VI-X ангийн физик, хими, биологийн шинэчилсэн сургалтын хөтөлбөрийг лаборатори 31 сургуулийн I-X ангид турших		Шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг VI-XII ангид турших	Шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг X-XII ангид турших			
Нийслэлийн 4-р сургуулийн бага ангид хүүхэд бүрийг хөгжүүлдэг сургалтын шинэ технологи, арга зүй турших		VI-IX ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном хэвлэх	X-XII ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном хэвлэх			
XI-XII ангийн физик, хими, биологи, математик, англи хэлний болон бусад ангийн монгол хэл, уран зохиол, түүх зэрэг үндэсний стандарт, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, сурах бичиг, багшийн ном бүтээх		I-V ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном хэвлэх				
Сургуулийн удирдлага, багш нарын сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн арга зүйгээр давтан бэлтгэх						

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд боловсролын чанарын шинэчлэлийг дараах үндсэн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

1. Бага, дунд боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, стратегитэй уялдуулан шинэчлэн боловсруулах;
2. Хүүхэд бүрийн хөгжих боломжийг бүрдүүлсэн сургалтын арга зүй, технологийг хөгжүүлэх;
3. Бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бий болгох;
4. Нийгмийн захиалга, хөгжлийн хэрэгцээ, шаардлага хангасан багш бэлтгэх болон тэдний төлөвшил, тасралтгүй хөгжлийн шинэ тогтолцоог бүрдүүлэх;
5. ЕБС-ийн сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний стандартыг шинээр боловсруулж, хэрэгжүүлэх арга зүй, менежментийг шинэчлэх;
6. Боловсролын бүх шатны байгууллагыг чадавхжуулан, хамт олон, ажилтны бие даасан бүтээлч үйл ажиллагааг дэмжих зэрэг багтана.

Энэхүү шинэчлэлийг боловсролын салбарын мэргэжлийн байгууллага, багш бэлтгэдэг сургуулиудын манлайлалд тулгуурлан хэрэгжүүлнэ гэж заасан байв.

БШУ-ы сайдын 2013 оны А/155 тушаалын гуравдугаар хавсралтаар бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр шинэчлэх багийг 96 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна. (Монгол хэл 14, уран зохиол 6, математик 11, физик 6, хими 6, биологи 6, байгаль шинжлэл 6, мэдээлэл зүй 5, гадаад хэл 7, түүх нийгмийн ухаан 9, хөгжим 5, технологи 7, биеийн тамир, эрүүл мэнд 8)

Ерөнхий боловсролын үндэсний шинэ стандарт, хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэхтэй холбоотой арга хэмжээний хэрэгжилтийг чанаржуулах зорилгоор БШУ-ы сайдын 2013 оны 08 сарын 27-ны өдрийн А/326 дугаар тушаал, 2014 оны 07-р сарын 09-ны А/306, БХ-гийн захирлын 2014 оны 10-р сарын 02-ны өдрийн 50 дугаар тушаал (суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах баг), БШУ-ы сайдын 2015 оны 10-р сарын 22-ны А/424, 2016 оны 02-р сарын 23-ны өдрийн А/60 дугаар тушаалаар бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан байна. Эдгээр тушаалуудад үндэслэн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад 400 орчим судлаач, эрдэмтэн, их дээд ба ЕБС-ийн багш, ТББ-ын төлөөлөл оролцож ажилласан байна. Сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад оролцсон дээрх хүмүүс үндсэн ажлын зэрэгцээ давхар ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан.

Хүснэгт 1.1.1. Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн бүрэлдэхүүн

Боловсролын түвшин	Боловсруулсан сургалтын хөтөлбөрийн тоо	Сургалтын хөтөлбөр боловсруулахад ажилласан хүний тоо
Бага боловсрол	8 хичээл судлагдахууны хөтөлбөр 3 сургалтыг дэмжих үйл ажиллагааны зөвлөмж	80
Суурь боловсрол	9 багц судлагдахууны хөтөлбөр 3 сургалтыг дэмжих үйл ажиллагааны зөвлөмж	148
Бүрэн дунд боловсрол	15 хичээл судлагдахууны хөтөлбөр	171

Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн бүрэлдэхүүний 12.2 хувийг судлаач, 6.2 хувийг арга зүйч, мэргэжилтэн, 45 хувийг их, дээд сургуулийн багш, 22.3 хувийг ЕБС-ийн багш, 1.8 хувийг хэрэгжилтийн баг, 0.9 хувийг төрийн бус байгууллагын төлөөлөл бүрдүүлсэн байна.

Хүснэгт 1.1.2. Сургалтын хөтөлбөр боловсруулах багийн гишүүдийн бүрэлдэхүүн (хувиар)

Багийн гишүүдийн бүрэлдэхүүн	Бага боловсрол	Суурь боловсрол	Бүрэн дунд боловсрол
Судлаач	17.7%	11.4%	7.6%
Арга зүйч, мэргэжилтэн	0.4%	14.8%	3.5%
Их, дээд сургуулийн багш	34.3%	45.9%	55%
Хэрэгжилтийн баг	0.5%	0.5%	4.5%
ЕБС-ийн багш	36.4%	18.2%	12.3%
ТББ-ын төлөөлөл	0.2%	0.3%	2.3%

Мөн 2013 онд оюуны бэрхшээлтэй суралцагчийн I-V ангийн монгол хэл, математик, дүрслэх урлаг, нийгэм ахуйн баримжаа 4 хичээлийн хөтөлбөр боловсруулахад 16, 2017 онд сонголын бэрхшээлтэй суралцагчийн I ангийн бэлтгэл, I-V ангийн монгол хэл, математик, яриа бичиг, биет зүйл, айзамт хөдөлгөөнт дасгал хичээлийн хөтөлбөр боловсруулахад 37, хос хэлний сургалттай сургуулийн бага боловсролын казак хэлний хөтөлбөр боловсруулахад 15, тува хэл, уран зохиолын хөтөлбөр боловсруулахад 7 судлаач, эрдэмтэн, мэргэжилтэн, багш нар ажилласан байна.

Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн ахлагч, гишүүдийг сонгохдоо БХ-гийн нөөцөд бүртгэлтэй мэргэжилтэн, багш, арга зүйчдэд хамтран ажиллах хүсэлтийг илгээж ажилласан байна. Үүний дагуу сонгогдсон багийн ахлагч, гишүүдтэй БХ-гийн захирал ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар багийн гишүүдийн ажлын чиг үүрэг тодорхой болсон. Гэрээний дагуу багууд үйл ажиллагааны төлөвлөлттэй ажилласан ба гадаад, дотоодын сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний талаар мэдээлэл цуглуулж, харьцуулсан судалгаанд үндэслэн сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах, хүлээлгэн өгөх ажлуудыг гүйцэтгэсэн.

P1.1.A1.T2. Гадаад улс орнуудын сургалтын хөтөлбөрийг орчуулах, харьцуулсан судалгаа хийх

Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд гадаад улс орнуудын сургалтын хөтөлбөрийг орчуулж, харьцуулсан судалгаа хийсэн байна.

Монгол Улсын боловсролын салбарт бүтэц зохион байгуулалтын томоохон өөрчлөлт 1990-ээд оноос эрчимтэй хөгжиж, шинэчлэгдэж ирсэн. 2004 онд цогц чадамжид суурилсан боловсролын стандартыг боловсруулж, үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн. 2005 оноос 10 жилийн тогтолцооноос 11 жилийн тогтолцоонд, 2008 оноос 11 жилийн тогтолцооноос 12 жилийн тогтолцоонд шилжсэн. Энэхүү боловсролын шинэчлэлийг даган сургалтын хөтөлбөрт дараах өөрчлөлт, шинэчлэлүүдийг тусган хэрэгжүүлж ирсэн байна. Үүнд:

- Боловсролын стандартыг хэрэгжүүлэх 11 жилийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (2006-оноос)
- 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөр (2008 оноос)
- Сургалтын цөм хөтөлбөр (2014 оноос) зэрэг болно.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд 2010 онд явуулсан “ТИМСС/ПИРЛС-2011”-ийн туршилтын судлагааны IV, VIII ангийн суралцагчдын математик, байгалийн ухааны хичээлийн үнэлгээний дундаж тус бүр 39,6 буюу 25,8 хувь байгааг үндэслэл болгон танилцуулсан байна. Энэ нь 2008 онд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартад үнэлгээ хийснийг эс тооцвол, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа мөн суралцагчийн сурлагын амжилтыг үнэлсэн, түүнд дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлан, нэгтгэл

хангалтгүй байгааг нотолж байна. Үндэсний хэмжээнд хөтөлбөрийн хэрэгжилтийн болон суралцагчийн сурлагын амжилтын судалгааг хөгжүүлэх, даалгаврын найдвартай байдал, тохирц, тавилыг сайжруулан даалгаврын сан бүрдүүлэх, үнэлгээний бодит үр дүнг дээшлүүлэх нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үндэс суурь болно.

2013 онд БХ-гийн бүтэц өөрчлөгдөж, сургалтын хөтөлбөрийн судалгааны сектор байгуулагдсан нь сургалтын хөтөлбөр судлалыг хөгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх орон тооны эрдэм шинжилгээний ажилтантай болсон давуу талтай ч, цаашид судалгаа хийх төсөв, санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгааг анхаарах хэрэгтэй.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглалыг хэрэгжүүлэх зорилгоор 2012 оноос зарим гадаад улс орнуудын боловсролын амжилт, стандарт, хөтөлбөрийг орчуулах агуулга, аргазүй, үнэлгээний чиглэлээр харьцуулсан судалгааны ажлууд хийсэн байна. Тухайлбал:

- Монгол-Кембрижийн Боловсролын шинэчлэл төслийн хүрээнд Англи (Кембриж)-ийн суурь, бүрэн дунд боловсролын математик, хими, физик, биологи, англи хэлний нийт 5, бага боловсролд англи хэл, математик нийт 2 судлагдахууны сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж
- Япон улсын бага боловсролын математик, байгалийн ухаан, урлаг, технологийн сургалтын хөтөлбөр
- Финланд улсын боловсролын хөтөлбөр, амжилтаас. 3,3 х.х
- Сингапур улсын боловсролын амжилтаас 4,6 х.х зэрэг материалуудыг тус тус орчуулжээ.

БХ-гийн сургалтын хөтөлбөрийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтнууд бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалын дагуу сургалтын шинэ хөтөлбөрийг боловсруулахын тулд 2012-2013 онд дараах чиглэлээр судалгаа хийж, сургалтын шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээг тодорхойлон сургалтын хөтөлбөрийн бүтэц, тавигдах шаардлагыг тусган удирдамж боловсруулсан байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөрийг олон улсын сургалтын хөтөлбөртэй харьцуулан судалсан
- Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн бага боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийг судалсан.
- Бага, суурь бүрэн дунд боловсролын судалгаат хичээлийг зохион байгуулсан
- Ерөнхий боловсролын 11,12-р ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх хэрэгцээг судалсан
- Олон улсын бага, дунд боловсролын сургалтын цаг, сургалтын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа хийж, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөг боловсруулж, сургууль багш нараар хэлэлцүүлэх, боловсруулах зэрэг ажил хийгдсэн байна.

Хүснэгт 1.1.3. Сургалтын төлөвлөгөөний харьцуулсан үр дүн

Боловсролын түвшин	Сургалтын төлөвлөгөө батлагдсан тушаал	Сургалтын төлөвлөгөөний бүтэц	Анги	Судлах хичээлийн тоо		Жилд судлах нийт цаг	Долоо хоногийн ачаалал	Өдрийн ачаалал
				Судлагдахуун	СДҮА			
Бага боловсрол	БШУ-ы сайдын 2014 оны 06-р сарын 03-ны өдрийн А/240 дугаар тушаал	Судлагдахууны цаг-89.4% Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг- 10.6%	I	6+1(бэлтгэл)	2	736	22.7	4.5
			II	6	2	736	23	4.6
			III	6	2	759	23	4.6
			IV	7	3	792	24	4.8
			V	7	3	891	27	5.4
Суурь боловсрол	БШУ-ы сайдын 2015 оны 06-р сарын 10-ны өдрийн А/220 дугаар тушаал	Судлагдахууны цаг-91% Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг- 9%	VI	9 багц, 14 хичээл	3	1015	29	5.8
			VII	9 багц, 17 хичээл	3	1225	35	7.0
			VIII	9 багц, 17 хичээл	3	1225	35	7.0
			IX	9 багц, 16 хичээл	3	1225	35	7.0

Бүрэн дунд боловсрол	БСШУ-ы сайдын 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн А/275 дугаар тушаал	Заавал судлах цаг-60%	X	8	35 кредит буюу 1225 цаг	35	7.0
		Заавал сонгон судлах цаг-29%		6			
		Сонгон гүнзгийрүүлж судлах цаг- 11%		3-4			
		Заавал судлах цаг-56%	XI	8	36 кредит буюу 1260 цаг	36	7.2
		Заавал сонгон судлах цаг-19%		6			
		Сонгон гүнзгийрүүлж судлах цаг- 25%		3			
		Заавал судлах цаг-27%	XII	3	34 кредит буюу 1190 цаг	34	6.8
		Заавал сонгон судлах цаг-29%		6			
		Сонгон гүнзгийрүүлж судлах цаг- 44%		3			

P1.1.A1.T3. Үйл ажиллагааны зардлын тооцоо хийх

Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад шаардагдах үйл ажиллагааны зардлын тооцоог гаргаж, БШУЯ-ны ТНБД-ын тушаалаар баталгаажуулсан.

ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөг үндэслэн бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөр боловсруулах багийн 2013-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлагдсан.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн ажлыг хэрэгжүүлэх зорилгоор менежментийн багийн ахлагч, БХ-гийн захирал, хэрэгжилтийн багийн ахлагч нар ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, БШУ-ы яамны ТНБД баталгаажуулсан байна. Уг гэрээнд бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөр боловсруулах багийн 2013-2015 оны ажлын төлөвлөгөө, 2013-2014 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, сургалтын цөм хөтөлбөр боловсруулах багийн 2013-2015 оны төсвийг тусган баталсан байна.

Сургалтын төлөвлөгөөг үндэслэн 7 хоногт 1 цаг ордог хичээлийн сургалтын цөм хөтөлбөрийг 3 хэвлэлийн хуудсаар тооцож, олон улсын хөтөлбөрийг орчуулан боловсруулж, түршсан судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах ажлын хөлсийг 1 хэвлэлийн хуудсыг нэг сая төгрөг, бусад судлагдахууны сургалтын цөм хөтөлбөр боловсруулах ажлын хөлсийг 1 хэвлэлийн хуудсыг нь нэг сая таван зуун мянган төгрөгөөр тооцож ажлын хөлс олгох төсөв хийсэн байна. Сургалтын цөм хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх багийн ажлын хөлсийг 1 хэвлэлийн хуудас бүтээгдэхүүний ажлын хөлсний 10%-иар тооцож ажлын хөлс олгох төсөв хийж, гэрээ байгуулсан байна.

Мөн сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах явцад хөтөлбөр боловсруулагчид, лаборатори сургуулийн багш нарыг Япон улсад хичээлийн ажиглалт, судалгаанд оролцуулахаас гадна олон улсын зөвлөх түр хугацаагаар ажиллуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж байсан.

P1.1.A1.T4. Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, сургалтын цөм хөтөлбөр боловсруулах удирдамжийг танилцуулах, хэлэлцэх (багийн гишүүдийн сургалт, үүлзалт)

БСШУ-ы сайдын 2013 оны 155 дугаар тушаалаар батлагдсан “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд”-д үндэслэн бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах явцад БХ сургалтын цөм хөтөлбөр боловсруулагчдыг чадавхжуулах, лаборатори сургуулийн багш, үндэсний болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сургалтын багт зөвлөн туслах чиг үүрэгтэй ажилласан.

БХ-гийн боловсролын хөтөлбөрийн судалгааны сектороос бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх удирдамжийг боловсруулан хөтөлбөр боловсруулагчид, хэрэгжүүлэгч сургуулийн багш нар, үнэлгээний даалгавар боловсруулагчдад сургалт явуулж, үүлзалт хэлэлцүүлгийг тогтмол, давтамжтай хийж ирсэн байна.

БХ дараахь 3 үндсэн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг зохион явуулсан байна. Үүнд:

1. Сургалтын цөм хөтөлбөр боловсруулагчдыг чадавхжуулах
2. Лаборатори сургуулийн багш нар ба үндэсний, орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх

3. Үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сургалтын багт зөвлөн туслах

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулагчдыг хэд хэдэн удаагийн сургалтад хамруулж, бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр боловсруулах удирдамж, сургалтын шинэ арга зүйг танилцуулахын зэрэгцээ агуулгын шинжилгээ хийх, үнэлгээний даалгавар боловсруулах, даалгаварт шинжилгээ хийх чиглэлээр чадавхжуулсан байна.

Сургалтын цөм хөтөлбөр боловсруулах судлагдахууны багийн гишүүд үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу сард 2-3 удаагийн уулзалт хийж байсан нь агуулгын залгамж холбоо, өргөсөл, гүнзгийрэл, арга зүй, үнэлгээний талаар нэгдсэн ойлголтод хүрч ажиллахад нөлөөлсөн. Гэвч үндсэн ажлын цагтай давхцах бэрхшээлүүд гарч байсан тул шаардлагатай үед буюу багуудын нэгдсэн уулзалт, сургалтуудад БСШУЯ-ны хүсэлтээр ажлаас нь чөлөөлж, оролцуулж ирсэн байна.

Үндэсний 40 лаборатори сургуулийн 200 гаруй бага ангийн багш, удирдлагуудыг, суурь боловсролын 160 гаруй багш, нийгмийн ажилтныг, бүрэн дунд боловсролын 236-598 орчим мэргэжлийн багшийг сургалтад хамруулан, сургалтын шинэ хөтөлбөрийг таниулах, хичээлийн судалгаа, хэлэлцүүлэг хийх, тодорхой сэдэв, агуулгыг түрших, “Сайн хичээл” үйл ажиллагааг зохион байгуулахад зөвлөн тусалж ажилласан.

Сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд нэвтрүүлэх үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ирсэн байна. Тухайлбал:

- Бага боловсролын 136 үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэн, бага ангийн 13817 багшид таниулах сургалтыг зохион байгуулсан.
- Суурь боловсролын 433 үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэн, дунд ангийн 19249 багшид таниулах сургалтыг зохион байгуулсан.
- Бүрэн дунд боловсролын X ангийн 236, XI ангийн 598, XII ангийн 324 үндэсний болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэн ахлах ангийн 14926 багшид сургалтын цөм хөтөлбөрийг таниулах сургалтыг 3 жилийн давтамжтайгаар зохион байгуулсан байна.



Давуу тал

- БШУ-ы сайдын 2012 оны А/180 дугаар тушаалаар үнэлгээний ажлын хэсэг, үндэсний зөвлөл, менежментийн багийг байгуулан, бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх бодлогын удирдлага, зохион байгуулалтын зураглалыг гаргасан нь үндэсний баг, мэргэжлийн байгууллага, ажлын хэсгийн ажлын чиг үүргийг тодорхой болгосон.
- БШУ-ы сайдын 2013 оны А/155 дугаар тушаалаар бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал, үзэл баримтлалыг баталж, бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх ажлын хэсгийн ажиллах эрх зүйн орчин бүрдсэн.
- БШУ-ы сайдын 2012 оны А/179 дүгээр тушаалаар БХ-д бүтцийн өөрчлөлт хийж, сургалтын хөтөлбөрийн судалгааны сектор байгуулагдсан нь сургалтын хөтөлбөр судлалыг судалгааны үндэслэлтэй хөгжүүлэх үндэс тавигдсан.
- Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн чанарын шинэчлэлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэхийн тулд олон улсын болон үндэсний сургалтын төлөвлөгөөний харьцуулсан судалгаанд үндэслэн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөнд багц хичээлийн цаг, сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг, ахлах ангид сонгон судлах хичээлийн цагийг тусгасан нь танхимд судалсан агуулга, арга зүйг үйл ажиллагааны цагаар дэмжин хөгжүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох боломжийг бүрдүүлсэн.
- Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг боловсруулахад Олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүд (Азийн хөгжлийн банк, НҮБ-ийн Хүүхдийн сан, Монгол-Кембрижийн Боловсролын Шинэчлэл төсөл, Дэлхийн банк гэх мэт)-ийн дэмжлэг, зөвлөн туслах үйлчилгээ, санхүүгийн дэмжлэг түслалцааг авч ажилласан.
- БХ-гийн сургалтын хөтөлбөрийн судалгааны сектор бэлтгэл ажлын хүрээнд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах үзэл баримтлал, удирдамжийг танилцуулах багийн уулзалт, хэлэлцүүлэг, сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг дэмжиж ажилласан.



Сул тал

- Менежментийн баг нь 2013-2016 онд сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан боловч гэрээний хугацаа дуусгавар болсон тул цаашид ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй.
- Судалгаа, нотолгоонд суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах нөхцөл учир дутагдалтай байсан. Тухайлбал:
 - Орчин үеийн хөтөлбөр судлалын судалгааны үр дүн, тайлан дутмаг
 - Өмнө хэрэгжсэн сургалтын стандарт, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл явцын судалгааны мэдээллийг эмхлэн цэгцэлсэн нэгтгэл байхгүй
 - Сурагчийн сурлагын амжилтын судалгааны үр дүнд хийсэн шинжилгээ зэрэг нь хангалттай бус
- Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай төсвийг урьдчилан төлөвлөж, улсын төсөвт тусгах эрх зүйн орчин бүрдээгүй учир зарим үйл ажиллагаа төлөвлөлтийн дагуу хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байсан.
- Сургалтын цөм хөтөлбөр боловсруулахад оролцсон 400 орчим эрдэмтэн, судлаачдын 30 орчим хувь нь үндсэн ажлынхаа хажуугаар давхар ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж, нэг болон хэд хэдэн судлагдахуун, мөн түүнчлэн 3-5 ангийн сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд боловсруулсан нь бүтээгдэхүүний чанарт нөлөөлсөн.



Санал

- Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний дэргэд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үрт (10 жилийн) болон дунд, богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөлтүүдийг уялдуулан, тогтвортой хэрэгжүүлэх үндэсний зөвлөл, менежментийн баг ажиллах хууль, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх
- Суралцагчийн сурлагын амжилтын судалгаа, судлагдахуун судлал, нийгмийн хөгжлийн судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулагчид, сургууль, багш нарыг нэгдсэн ойлголтод хүрэхэд дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийн шинэчлэл, хэрэгжилтийн үр дүнг олон нийтэд нээлттэй мэдээллэж байх
- Сургалтын хөтөлбөрийн судалгаа үнэлгээ, сурах бичиг боловсруулах чиглэлээр мэргэшсэн шинжээч бэлтгэх үндэсний хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг үрт хугацааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх
- Боловсролын бодлогын шинэчлэл хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулахад шаардлагатай санхүүгийн нөөц, төсвийг урьдчилан тооцоолж, улсын төсөвт суулгах

P1.1. A2. Сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж боловсруулах

Бага, дунд боловсролын түвшин бүрээр сургалтын хөтөлбөр боловсруулах баг ажиллаж, сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийн төслийг боловсруулан, хөндлөнгийн үнэлгээг үе шаттай хийлгэж, сайжруулсан байна.

P1.1.A2.T1. Бага, дунд боловсролын судлагдахууны хөтөлбөр, зөвлөмж боловсруулах

Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн ерөнхий зураглал, төлөвлөлтийн дагуу 2013-2014 онд бага боловсролын 8 судлагдахуун, 2013-2014 онд суурь боловсролын 9 багц судлагдахуун, 2014-2015 онд бүрэн дунд боловсролын 15 судлагдахууны хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулсан байна.

Зураг 1.1.3. Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал

Он	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Бэлтгэх	Бага, дунд боловсролын сургалтын агуулгын талаар баримтлах бодлого боловсруулах			Ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлого боловсруулах			
Боловсруулах, турших		I-V ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг боловсруулах, турших	VI-IX ангид турших шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг боловсруулах, турших	X-XII ангид турших шинэчилсэн хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг боловсруулах, турших			
	Сургуулийн удирдлага, багш нарыг шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн арга зүйгээр бэлтгэх						
Үндэсний түвшинд нэвтрүүлэх		I-V ангийн сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	VI-IX ангид турших шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх	X-XII ангид турших шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх			
	Сургуулийн удирдлага, багш нарыг шинэчилсэн сургалтын хөтөлбөрийн арга зүйгээр даатан бэлтгэх						
Үнэлэх						Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх	Сургалтын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд оруулах

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд нийгмийн амьдралын таатай орчин, хэм хэмжээг бий болгох, түүнд дасан зохицож амьдрах чадвартай, иргэншсэн монгол хүнийг төлөвшүүлэх, хүүхдийн сүрч боловсрох хүсэл сонирхол, хийж бүтээх тэмүүллийг боловсролын түвшин бүрт дэмжиж ажиллахыг боловсролын зорилго болгон дэвшүүлсэн.

БШУ-ы салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөрт “Бага, суурь боловсролын түвшинд хүүхэд бүрийн авьяас, сонирхол, чадвар, хувь шинжийг нээдэг, түүнийг хөгжүүлдэг, дэмждэг, хүүхэд бүртэй ажилладаг арга технологи, сургалтын зохион байгуулалтыг бий болгож нэг ч хүүхдийг орхигдуулахгүйгээр сургах тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, БШУ-ы салбарын чанарын шинэчлэлийн хөтөлбөрт үндэслэн боловсролын түвшин бүрийн сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулсан байна. Тухайлбал: Боловсролын түвшин бүрийн сургалтын хөтөлбөр боловсруулах багууд үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу дараах нийтлэг ажлуудыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Зөвлөлдөх уулзалтуудад оролцож, сургалтын цөм хөтөлбөр боловсруулах үзэл баримтлал, удирдамж, лаборатори сургуулийн сургалтын төлөвлөгөөтэй танилцан, нэгдсэн ойлголттой болох
2. Тухайн судлагдахууны чиглэлээр гарсан гадаад улс орнуудын болон өөрийн улсын өмнөх сургалтын цөм хөтөлбөрийн агуулгад шинжилгээ хийсэн судалгааны үр дүнтэй танилцах, сургалтын цөм хөтөлбөрийн агуулгын хүрээ, залгамж холбоог боловсруулах
3. Сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийн төслийг үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгасан хугацаанд бичиж боловсруулах
4. Багийн уулзалтуудыг хийж, ажлын явц, үр дүнгээ хэлэлцэх
5. Зарим судлагдахууны агуулгыг лаборатори сургуулиудад заах турших, сайн хичээл үйл ажиллагаанд оролцож багш нарт зөвлөн туслах, хичээлийн ажиглалт, судалгаанд оролцох, хэлэлцүүлэг хийх
6. Сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг дахин сайжруулах, засварлах
7. Гэрээнд заасан хугацаанд бүтээгдэхүүнийг хүлээлгэн өгөх зэрэг болно.

Бага боловсрол

Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх бага боловсролын зорилгод нийцүүлэн 1-5 дугаар ангийн 8 судлагдахуун, 3 сургалтыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулан улирал бүр лаборатори сургуульд туршин, сургууль, багш нараас саналыг авч, тусган сайжруулсан.

Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 80 хүний бүрэлдэхүүнтэй баг боловсруулсан.

Хүснэгт 1.1.4. Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тодорхойлсон чадваруудыг хөгжүүлэх хичээл, үйл ажиллагаа

Хичээл /Судлагдахуун/		Сургалтыг дэмжих үйл ажиллагаа
I - III анги	IV- V анги	Иргэний боловсрол (ёс суртахуун) Хичээлээс гадуурх үйл ажиллагаа Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа
Монгол хэл		
Математик		
Хүн ба орчин	Хүн ба байгаль	
	Хүн ба нийгэм	
Урлаг / хөгжим Дүрслэх урлаг, технологи		
Биеийн тамир		
	Англи хэл	

Математик, хүн ба байгаль, англи хэлний олон улсын сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулийн бага ангид туршсан үр дүнд үндэслэн, үндэсний сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсруулсан.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай хэрэгцээг нь харгалзан, тэдэнд оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадамжийг эзэмшүүлэх, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 4 сургуулийн 1878 хүүхдэд зориулсан 4 судлагдахууны хөтөлбөрийг боловсруулан гаргасан байна.

Хос хэлээр сургалт явуулдаг ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн бага боловсролын сургалтын төлөвлөгөө, казах, тува хэлний сургалтын цөм хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх зөвлөмж/суралцахуйн удирдамжийг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр боловсруулан 500 хувь хэвлүүлж, багш нарт хүргэсэн байна.

БСШУ-ы сайдын 2017 оны А/226 дугаар тушаалаар ЕБС-ийн нэгдүгээр ангийн “Бэлтгэл” сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Бэлтгэл сургалтын хөтөлбөрийг нэг талаас суралцахуйн онолын гурван айг харгалзсан, нөгөө талаас хөтөлбөр нь суралцагчдыг сургууль, сурах үйл ажиллагаанд дасан зохицож эхлэхэд дэмжлэг болох онцлогтойгоор боловсруулсан байна.

Суурь боловсрол

Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх суурь боловсролын зорилгод үндэслэн VI-IX ангийн 9 багц судлагдахуун, 3 сургалтыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөр, зөвлөмж/ суралцахуйн удирдамжийг боловсруулан лаборатори сургуульд туршин, сургууль, багш нараас саналыг авч тусган сайжруулсан.

Хүснэгт 1.1.5. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тодорхойлсон чадваруудыг хөгжүүлэх хичээл, үйл ажиллагаа

Багц судлагдахуун	Хичээл /Судлагдахуун/	Сургалтыг дэмжих үйл ажиллагаа
Монгол хэл, бичиг	Монгол хэл	Иргэний боловсрол (ёс суртахуун) Хичээлээс гадуурх үйл ажиллагаа Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа
	Уран зохиол	
	Монгол бичиг	
Математик		
Мэдээллийн технологи		
Байгалийн ухаан	Биологи	
	Физик	
	Хими	
	Газарзүй	
Нийгмийн ухаан	Түүх	
	Нийгэм судлал	

Урлаг	Дүрслэх урлаг	Иргэний боловсрол (ёс суртахуун) Хичээлээс гадуурх үйл ажиллагаа Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа
	Хөгжим	
Дизайн, технологи	Технологи/зураг зүй	
Биеийн тамир, эрүүл мэнд	Биеийн тамир	
Гадаад хэл	Англи хэл	
	Орос хэл	

2014-2015 оны хичээлийн жилд суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах, түрших, сайжруулах ажлыг 3 үе шаттайгаар зохион байгуулахаар үйл ажиллагааны төлөвлөгөө гарсан байна.

Хүснэгт 1.1.6. Үйл ажиллагааны төлөвлөгөө

үйл явц	№	Үйл ажиллагаа	Хугацаа													
			2014					2015								
			VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	
Судалгаа хийх	1.4	Суурь боловсролын сургалтын хөтөлбөрт гарч буй өөрчлөлт, шинэчлэлийн олон улсын харьцуулсан судалгаа хийх														
	1.5	Хөтөлбөр боловсруулахад хэрэглэгдэх "Сургалтын хөтөлбөрийн хөгжил" материалыг орчуулах														
	1.6	Гадаад улсад туршлага судлах														
	1.7	Суурь боловсролын онол, арга зүйн судалгаа хийх														
	1.8	Сургалтын орчны өнөөгийн байдлын судалгаа хийх														
Боловсруулах	1.9	Монгол хэл, Математик, Байгалийн ухааны хичээлийн суурь боловсролын стандартын төсөл боловсруулах														
	1.10	Суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулж хэлэлцүүлэх														
	1.11	Суурь боловсролын түвшний судлагдахуун тус бүрийн агуулгын хүрээ гаргах														
	1.12	Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулах														
	1.13	Суурь боловсролын математик, биологи, хими, физик, англи хэлний сургалтын хөтөлбөр боловсруулах														
	1.14	Суурь боловсролын бусад судлагдахууны хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах														
	1.15	Суурь боловсролын түвшинд тусгай хэрэгцээт боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах														
Бэлтгэх	2.1	Туршилт зохион байгуулах багийн бүрэлдэхүүнийг томилж, баталгаажуулах														
	2.2	Туршилтын багийн хийх ажлыг танилцуулах, чиглүүлэх, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах														
	2.3	Суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, бусад материалыг турших ажлын удирдамж, төсөв, төлөвлөгөө гаргах														
Түрших	2.4	Суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, цөм болон судлагдахууны хөтөлбөр турших														
	2.5	Суурь боловсролын түвшний сурагчдын мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх аргачлал, зөвлөмжийг турших														
	2.6	Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн туршилтын судалгаа хийх														
Сайжруулах	3.2	Суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичиг, багшийн ном, бусад материалыг сайжруулах														
	3.3	Суурь боловсролын агуулгын хүрээ, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр бусад материалд эксперт хийх														
	3.4	Суурь боловсролын судлагдахуун, анги тус бүрийн агуулгын хүрээ, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг эцэслэх														

Бүрэн дунд боловсрол

БСШУ-ы сайдын 2015 оны 08 сарын 12-ны А/320 дугаар тушаал болон ерөнхий боловсролын лаборатори сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөний төсөл батлагдсаны дагуу мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх бүрэн дунд боловсролын зорилгод нийцүүлэн 15 сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулж эхэлсэн байна.

БСШУ-ы сайдын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/424 дүгээр тушаалаар бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэн боловсруулах ажлыг БХ, МУИС, МУБИС-иар гүйцэтгүүлэх шийдвэр гарсан.

Хүснэгт 1.1.7. Бүрэн дүнд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тодорхойлсон чадваруудыг хөгжүүлэх хичээл, үйл ажиллагаа

Хичээл /судлагдахуун/ ба үйл ажиллагаа		
А.Заавал судлах		
X	XI	XII
Монгол хэл, бичиг, уран зохиол		
Математик		
Монголын түүх, нийгэм судлал		
Газарзүй		
Биологи		
Физик		
Хими		
Англи хэл/Орос хэл		
Б.1. Сонгон судлах		
Судлагдахуун	Чиглэл	Сургуулийн мэдлийн цаг
Бизнес судлал	Хувь хүний болон өрхийн санхүү	Амьдрах чадвар /хөтөлбөр сонгох/
	Бизнес судлал	
Дизайн технологи	Техникийн зураг зүй	
	Дизайн	
	Техник, технологи	
Мэдээллийн технологи	Программ хангамж	
	Техник хангамж	
	Мультимедиа технологи	
Урлаг	Хөгжим	
	Бүжиг	
	Дүрслэх урлаг	
Спорт, эрүүл мэнд	Спорт тоглоом ба эрүүл мэнд	
	Спортын бусад төрөл ба эрүүл мэнд	
Б.2. Сонгон гүнзгийрүүлж судлах		
Хэл	Монгол хэл, бичиг	
	Уран зохиол	
	Англи хэл	
	Орос хэл	
Математик	Математик	
Байгалийн ухаан	Биологи	
	Физик	
	Хими	
Нийгмийн ухаан	Түүх	
	Газарзүй	
	Нийгэм судлал	
	Бизнес судлал	

Дизайн технологи	Дизайн, зураг зүй	
	Дүрслэх геометр	
	Механик ба электроник	
	Хувцасны загвар зохион бүтээлт	
Мэдээллийн технологи	Мэдээлэл харилцаа холбооны технологи	
	Програмчлал	
Урлаг, спорт	Төрөл сонгох	

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр боловсруулагчдын 40 орчим хувь нь хоёр ба түүнээс дээш сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцож, давхар ажил гүйцэтгэсэн байна. Үүнээс гадна эдгээр хүмүүс сурах бичиг, багшийн ном зохиох багт ажилласан байна. Иймээс хөтөлбөр боловсруулах, сурах бичиг, багшийн ном зохиох мэргэжлийн туршлагатай хүний нөөц маш их дутагдалтай байгааг харуулж байгаа төдийгүй цаашид бэлтгэх, төлөвлөлт бодлогын шийдэл, хэрэгцээ байгааг харуулж байна.

P1.1.A2.T2. Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх

Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийн төслийг хөндлөнгийн шинжээч (эксперт)-ээр уншуулж дүгнэлт гаргуулан, туршилтын үр дүнг тусган сайжруулсан.

Сургалтын хөтөлбөр боловсруулах багуудын боловсруулсан судлагдахууны хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжид эксперт хийх багийг БХ-гийн нөөцөд бүртгэлтэй мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, их, дээд болон ЕБС-ийн багш, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллөөс сонгон шалгаруулж, хамтран ажиллах хүсэлтийг илгээсэн байна. Хүсэлтийг зөвшөөрсөн экспертүүдтэй БХ-гийн захирал ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажилласан.

Хүснэгт 1.1.8. Экспертийн санал авсан мэдээлэл

Боловсролын түвшин	Эрх зүйн үндэслэл	Экспертийн тоо	Уншиж санал өгсөн	Тайлбар
Бага боловсрол	БХ-гийн захирлын 2013 оны 07 сарын 30 өдрийн 32 дугаар тушаал	23	2 удаа	Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах явцад томилогдсон экспертүүд
Суурь боловсрол	БХ-гийн захирлын тушаал	34	2 удаа	дараах чиглэлээр уншиж, сайжруулах саналыг судлагдахууны багуудад хүргүүлж байсан байна.
Бүрэн дунд боловсрол	БХ-гийн захирлын 2016 оны 05 сарын 02-ны өдрийн А/04 дүгээр тушаал, МУБИС-ийн захирлын 2016.05 сарын 03-ны өдрийн А/100 дугаар тушаал, МУИС-ийн захирлын 2016 оны 05 сарын 02-ны өдрийн А/107 дугаар тушаал	32	2 удаа	Үүнд: тухайн судлагдахууны хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, тэдгээрийн залгамж холбоо, хэрэгжүүлэх арга зүй, сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээ

Экспертүүдийн өгсөн санал, дүгнэлтийн дагуу багууд хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг сайжруулсан. Экспертийн санал дүгнэлтийг тусган 2 дахь удаагийн уншилт хийлгэж, лаборатори сургуулиудад турших бэлтгэл хангагдсан.



Давуу тал

- Сургалтын хөтөлбөр боловсруулах ажлыг богино хугацаанд (Боловсролын түвшин бүрт 1 жил) төлөвлөсөн хэдий ч нэгдсэн зохион байгуулалт, менежментийн багийн зохицуулалт, дэмжлэг, багуудын хамтын ажиллагаа, зохион байгуулалтын үр дүнд төлөвлөсөн хугацаанд сургалтын хөтөлбөр, зөвлөмж/ суралцахуйн удирдамжийг боловсруулсан.
- Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах явцад лаборатори сургуулиудад зарим агуулга, арга зүйг турших, багш нараас санал авах, мэргэжлийн байгууллагын арга зүйч, мэргэжилтэн, их дээд сургуулийн тэнхим, багш нараар хэлэлцүүлж, хөндлөнгийн үнэлгээг жилд 2 удаа хийж сайжруулсан.
- Судлагдахууны сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хөндлөнгийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг сонгоход боловсролын бүх шатны байгууллагын төлөөллийг хамруулсан.



Сул тал

- Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах, бүтэц, дизайныг хэлэлцэх хугацаа бага байсан нь сургалтын хөтөлбөр боловсруулагчид хүрэх үр дүнг тодорхойлох, харилцан ойлголцож хамтарч ажиллахад бэрхшээл гарч байсан. Тухайлбал: хичээл хоорондын агуулгын залгамж холбоо, хичээл судлагдахууны хөтөлбөрт тусгах цөм агуулга, тэгш хамран сургах агуулга, арга зүй, үнэлгээний талаар ойлголтын зөрөөтэй байсны улмаас сургалтын хөтөлбөрийн суралцахуйн зорилт, үнэлгээний шалгуурыг харилцан адилгүй тодорхойлсон байна.



Санал

- Судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл хэрэгцээгээ тодорхойлох, үзэл баримтлал боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх, саналыг тусган сайжруулах, сургалтын хөтөлбөр боловсруулах зэрэгт зарцуулах хүний нөөц болон, цаг хугацаа, санхүүгийн нөөцийг оновтой төлөвлөх
- Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах, хөндлөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн экспертийг шинэ сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, бүтцийн талаар нэгдсэн ойлголттой болгох сургалтыг урт хугацааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх, гүйцэтгэсэн ажлын үр дүнгээр ажлын хөлсийг олгодог механизмыг бүрдүүлэх

P1.1. А3. Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмжийг туршин сайжруулах

Хөндлөнгийн шинжээчийн санал, дүгнэлтийн дагуу сайжруулсан сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийн төслийг лаборатори сургуульд хүргэж, туршсан бөгөөд туршилтын үр дүнд тулгуурлан дахин сайжруулалт хийн, хэвлэлийн эхийг бэлтгэж хянасан болно.

P1.1.А3.Т1. Сургалтын цөм хөтөлбөрийг лаборатори сургуулиудад турших, сайжруулах

Лаборатори сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг баталж, сургалтын цөм хөтөлбөрийг туршин сайжруулах ажлыг хийв.

Хүснэгт 1.1.9. Бага, суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн түршилтын төлөвлөгөө

	2012-2013	2013-2014	2014-2015	2015-2016
Үндэсний сургалтын цөм хөтөлбөр	I-V ангийн математик, байгалийн шинжлэлийн хөтөлбөрийг лаборатори 40 сургуулийн бага ангид турших	I-XI ангийн байгалийн ухаан, математик, англи хэлний сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудад турших	Ахлах ангийн математик, байгалийн ухаан, англи хэлний сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудад турших	Х-XI ангийн математик, байгалийн ухаан, англи хэлний сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудад турших
	Нийслэлийн 4 сургуулийн бага ангид хүүхэд бүрийг хөгжүүлдэг сургалтын шинэ технологи, арга зүй турших	I-V ангийн сургалтын шинэ хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг турших	VI-IX ангийн сургалтын шинэ хөтөлбөр, сурах бичиг, багшийн номыг турших	

Сургалтын цөм хөтөлбөрийг турших, сайжруулах ажлын хүрээнд дараах үйл ажиллагааг хийсэн байна. Үүнд:

- Сургалтын цөм хөтөлбөрийг турших лаборатори сургуулиудыг сонгох
- Түршилт хичээл зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөр хэлэлцүүлж, санал авах
- Сургалтын хөтөлбөрийг сайжруулах

Хүснэгт 1.1.10. Сургалтын хөтөлбөрийн түршилт

Боловсролын түвшин	Эрх зүйн үндэслэл	Туршсан сургуулийн тоо	Туршсан хугацаа
Бага боловсрол	БШУ-ы сайдын 2013 оны 08 сарын 16-ны А/311 тушаалын долоодугаар хавсралт	31/40	2013-2014
Суурь боловсрол	БШУ-ы сайдын 2014 оны 08 сарын 26-ны өдрийн А/335 дугаар тушаал	41	2014- 2015
Бүрэн дунд боловсрол	БСШУ-ы сайдын 2015 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/320 дугаар тушаал	41	2015-2016

Бага боловсрол

2012 оны 07 сарын 04-ны өдрийн А/387 дугаар тушаалаар батлагдсан лаборатори 31 сургуулийн жагсаалтыг 2013 оны 06 сарын 14-ны А/229 дүгээр тушаалаар нийслэлийн болон сумын өөрийн онцлогтой хөтөлбөр хэрэгжүүлдэг 9 сургуулийг нэмж 40 сургууль болгон нэмэлт өөрчлөлт оруулж баталсан байна.

БШУ-ы сайдын 2013 оны 05 сарын 08 өдрийн А/155 дугаар тушаалаар түршилтыг зохион байгуулах 23 хүний бүрэлдэхүүнтэй багийг томилсон. Энэ баг нь цааш өргөжин үндэсний хэмжээний сургалтын хөтөлбөрийн түршилт, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.


Орон нутгийн 24, нийслэлийн 16 лаборатори сургуульд бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг турших явцад сургуулиуд судалгаат хичээлүүдийг зохион байгуулах, сургалтын цөм хөтөлбөр, сурах бичгийн тохирц, агуулгын багтаамж, суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохирч буй байдлыг судлах ажлуудыг хийж байсан.

Сургалтын хөтөлбөрийн түршилт (хэрэгжилт)-ын ажлыг хариуцан ажилласан баг улирал бүр ЕБС-ийн багш нараас санал, дүгнэлтийг авч сургалтын хөтөлбөрийг сайжруулах саналыг нэгтгэн хөтөлбөр боловсруулагчдад хүргүүлж байсан. Хөтөлбөр боловсруулагчид түршилт (хэрэгжилт)-ын багийн тайланд үндэслэн сургалтын цөм хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг сайжруулан боловсруулж байсан.

Суурь боловсрол

БШУ-ы сайдын 2014 оны 08 сарын 26-ны өдрийн А/335 дугаар тушаалаар 2014-2015 оны хичээлийн жилээс лаборатори сургуульд мөрдөх сургалтын төлөвлөгөөг баталж, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг туршсан байна.

Зураг 1.1.4. Сургалтын хөтөлбөрийн туршилтын үйл ажиллагаа



Энэхүү туршилтын үйл явцыг суурь боловсролын түвшинд хэрэгжилтийн багаар дамжуулан мэргэжлийн байгууллагууд хамтран зохион байгуулсан.

VI-IX ангид судлах хичээлийн төрөл, тэдгээрийн агуулга, цагийн багтаамж, ачаалал, суралцагчдын нас, бие сэтгэхүйн онцлогийн тохирцыг шинжлэн тогтоох, үр дүнг тооцоход туршилтын үйл ажиллагаа чиглэж байсан байна. Үүнд:

1. VI-IX ангийн нэгж хичээл, хичээлийн жилийн үргэлжлэх хугацааны тохирц
2. Туршилтын ангид судлах хичээлүүдийн агуулгын хэрэгжилтийн явц, үр дүн
3. Туршилтын хугацаанд мөрдөх сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал
4. Туршилтын ба хяналтын ангид хичээл зааж байгаа багш нарын арга зүйн өөрчлөлт, хандлага
5. Хүүхдийн хөгжилд сургалтын орчны үзүүлэх нөлөө
6. Суралцагчдын чадвар, мэдлэг, төлөвшлийн үнэлгээний өөрчлөлт, нөлөө

Бүрэн дүнд боловсрол

БСШУЯ-ны сайдын 2015 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/320 дугаар тушаалаар 2015-2016 оны хичээлийн жилээс мөрдөх ЕБС-ийн лаборатори сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг, БСШУ-ы сайдын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн А/424 дүгээр тушаалаар ЕБС-ийн ахлах ангийн сургалтын цөм хөтөлбөрийг турших чиглэлийг баталснаар бүрэн дүнд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн туршилт эхэлсэн.

А/320 дугаар тушаалыг хэрэгжүүлэхэд ЕБС-ийн хувьд Х ангийн суралцагчид сонголт хийх, суралцагчдын сонголтонд суурилан сургалт, үйл ажиллагаа, хүний нөөцийг төлөвлөх зэрэгт бэлтгэл, ойлголт хангалтгүй, кредит цагийг хэрэглэх, багшийн цаг илүүдэх, дутах зэрэг шалтгааны улмаас сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг дахин судалж зохицуулалт хийх шийдвэр гарсан.

БСШУС-ын сайдын 2016 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн А/22 дугаар тушаал гарч Х ангийн сургалтын төлөвлөгөөний "Заавал сонгон судлах" Б1 хэсгийн хэрэгжилтийг түр хойшлуулах зохицуулалтыг хийж, сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, цаашид Х ангийн хичээл сургалтыг хэвийн явуулахтай холбогдуулан авах арга хэмжээний талаар дүгнэлт, санал ирүүлэх чиглэлийг ЕБС-ийн захирал, төв, орон нутгийн боловсролын мэргэжлийн байгууллагын удирдлагуудад өгсөн. Өгсөн чиглэлийн хүрээнд дараах нөхцөл байдлын судалгаа шинжилгээг хийсэн байна. Үүнд:

1. ЕБС-ийн Х ангийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдалд ахлах ангитай ЕБС бүр дүн шинжилгээ хийж санал, дүгнэлт гаргах, сургуулийн дүн шинжилгээ, санал, дүгнэлтийг аймаг, нийслэл, улсын түвшинд нэгтгэх ажил 2016 оны 9 дүгээр сарын 5-наас 10 дугаар сарын 20 -ны хугацаанд зохион байгуулагдсан.
2. БХ, БМДИ 21 аймаг, 9 дүүргийн сургуулиудаас санамсаргүй сонголт, төлөөлөх зарчмаар сонгогдсон 87 сургуулийн Х ангийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлын болон кейсийн судалгаа хийж, дүгнэлт гаргажээ.

ЕБС-ийн Х ангийн сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар хийгдсэн судалгааны тайлан болон эрдэмтэн, судлаачид, ЕБС-ийн багш нараас бүрдсэн ажлын хэсгийн дүгнэлтэд үндэслэн БСШУС-ын сайдын 2016 оны 11-р сарын 02-ны өдрийн 103-р тушаалаар ЕБС-ийн Х ангийн сургалтын төлөвлөгөөг, 2017 оны 07-р сарын 04-ны өдрийн А/61 дүгээр тушаалаар ЕБС-ийн XI ангийн сургалтын төлөвлөгөөг баталж, зохицуулалт хийсэн.

P1.1.A3.T2. Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хянах, хэвлэх

БХ судлагдахууны багийн боловсруулсан хөтөлбөрүүдийг нэгтгэн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн төслийг БСШУЯ-нд хүлээлгэн өгсөн. БСШУЯ сургалтын цөм хөтөлбөрийн төслийг хянан баталж, хэвлэлийн эхийг бэлтгэн агуулгын болон техник редакторын санал, дүгнэлтийг тусган сайжруулж сургууль, багш нарт түгээсэн байна.

Сургалтын цөм хөтөлбөрийг хянах, хэвлэх ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа хийгдсэн. Үүнд:

- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хянан батлах
- Хэвлэлийн эх бэлтгэх
- Бэлтгэсэн хэвлэлийн эхэд агуулгын болон техник редактор хийх
- Сургалтын цөм хөтөлбөрийг хэвлэх
- Сургалтын цөм хөтөлбөрийг сургууль, багш нарт түгээх

Бага боловсролын сургалтын төлөвлөгөө, сургалтын цөм хөтөлбөрийг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны 06 сарын 03 өдрийн А/240 дугаар тушаалаар, суурь боловсролын сургалтын төлөвлөгөөг БСШУ-ы сайдын 2015 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн А/220, сургалтын хөтөлбөрийг БСШУ-ы сайдын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/302 дугаар тушаалаар баталсан. ЕБС-ийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг БСШУ-ы сайдын 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн А/275 дугаар тушаалаар, сургалтын хөтөлбөрийг БСШУ-ы сайдын 2016 оны 06-р сарын 27-ны өдрийн А/277 дугаар тушаалаар тус тус баталсан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.10, 3.2.14, 3.2.15-ийг үндэслэн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрт хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний бахархалтай иргэн болгож төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох үүднээс БСШУС-ын сайдын 2018 оны 07-р сарын 09-ны өдрийн А/453 дугаар тушаал гарч бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, зарим сургалтын хөтөлбөрт өөрчлөлт оруулсан.

Багуудын боловсруулсан бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг эмхтгэн, агуулгын болон техник редактор хянаж, хэвлэх тоо, зардлын тооцоог үндэслэн бага ангийн сургалтын цөм хөтөлбөрийг 15000 ширхэг, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 19000 ширхэг, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 16000 ширхэгийг хэвлүүлэн үндэсний хэмжээний бүх сургууль, хичээл заадаг бүх мэргэжлийн багш нарт түгээсэн нь анхны тохиолдол байсан байна.

**Давуу тал**

- Сургалтын хөтөлбөрийг сайжруулах туршилтыг лаборатори сургуулиудад хэрэгжүүлсэн нь хэрэглэгч болох багш нараас санал авах боломжийг бүрдүүлсэн үйл ажиллагаа болсон. Олон улсын хөтөлбөртэй үялдуулан шинэчлэн боловсруулсан бага ангийн математик, англи хэл, суурь, бүрэн дунд боловсролын математик, физик, хими, биологи, англи хэлний судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийг лаборатори сургуулиудад туршсан нь тухайн мэргэжлийн багш нар сургалтын цөм хөтөлбөрийг ойлгож, хүлээн авах, хэрэгжүүлэхэд дэмжлэг болсон.
- Мэргэжлийн байгууллагууд, сургалтын хөтөлбөр боловсруулагчид, хэрэгжилтийн баг, лаборатори сургуулийн багш нар хамтран ажилласан нь хөтөлбөр боловсруулах, хэрэгжих, үнэлэх цогц үйл ажиллагааг үялдуулан харах, ойлгох боломжийг бүрдүүлсэн.
- Боловсролын хүрээлэн, Кембрижийн зөвлөх баг лаборатори сургуулийн багшийг чадавхжуулах, үнэлгээний сургалтыг зохион байгуулсан, мөн сургалтын хөтөлбөр боловсруулагч мэргэжлийн байгууллага, хэрэгжилтийн баг, БСГ болон лаборатори сургуулийн төлөөлөл бүхий нийт 328 багш нарыг Япон улсад туршлага судлах, хичээлийн ажиглалт, судалгаанд оролцуулсан зэрэг нь сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болсон.



Сул тал

Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах туршилтын үеийн удирдамж, аргачлалыг оновчтой боловсруулж, хэрэгжүүлж чадаагүй. Тухайлбал:

- 40 лаборатори сургуулийн бүх хичээл, ангийг хамруулснаар багш, сурагчдын ачаалал нэмэгдсэн.
- Сургалтын хөтөлбөр боловсруулах, турших, сайжруулах хугацаа богино хугацаанд хийгдсэн нь боловсруулагчдад ажлын ачаалал их үүсч байсан.
- Туршилтын багийн 23 гишүүн 40 лаборатори сургуулийн бүх багшаас мэдээлэл цуглуулах ажлыг богино хугацаанд хийх боломжгүй байсан учраас хөтөлбөр сайжруулах саналыг боловсруулагчдад хүргэхэд хангалттай бүс байжээ.
- Сургалтын шинэ хөтөлбөрийг турших явцад сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт орсон, ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийсэн зэрэг нь сургалтын хөтөлбөрийг сайжруулан эцэслэхэд цаг хугацааны болон хүний нөөцийн хувьд бэрхшээл үүсгэсэн.



Санал

- Сургалтын хөтөлбөрийг турших шаардлагатай гэж үзвэл лаборатори сургуулийн бүх анги, хичээлийг хамруулах байдлаар биш, тодорхой хичээл, агуулга, арга зүй, үнэлгээг турших нь туршилтын үр дүнг сургалтын хөтөлбөрт тусган сайжруулах
- Сургалтын хөтөлбөрийн туршилтыг мэргэжлийн байгууллагууд сургуультай хамтран зохион байгуулах нь илүү үр дүнтэй тул нэгдсэн төлөвлөлтөд тусган санхүү болон орчин хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх


Р1.1. А4. Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг танилцуулах, түгээх

Бага, суурь, бүрэн дунд боловсролын батлагдсан сургалтын төлөвлөгөө, сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээний бүх ЕБС-ийн багш нарт танилцуулж түгээсэн.

Р1.1.А4.Т1. Сургагч багш бэлтгэх

БХ нийслэл болон орон нутгийн боловсролын байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, бүх шатны боловсролын байгууллагад сургалт, судалгаа, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиг үүргийн дагуу лаборатори сургуулийн багшийг чадавхжуулах, үндэсний болон орон нутгийн сургагч багшийг бэлтгэх, сургууль багш нарт зөвлөн туслах чиглэлээр мэргэжлийн багууллага, сургалтын цөм хөтөлбөр боловсруулсан багтай хамтран ажилласан.

Зураг 1.1.5. Сургагч багш бэлтгэх, багшийг чадавхжуулах үйл ажиллагаа



Хүснэгт 1.1.11. Сургагч багш бэлтгэх сургалт

Түвшин	Сургалт	Сургалтын зорилго	Оролцогчдын тоо	Сургалт явагдсан хугацаа
Бага боловсрол	“Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр” сургалтын модуль боловсруулах арга зүй сургалт	Үндэсний сургагч багш бэлтгэх	45	2014 оны 08-р сарын 03-05
	Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сургалт	Орон нутгийн сургагч багш бэлтгэх	91	2014 оны 08-р сарын 06-09
	Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн сургалт	ЕБС-ийн бага ангийн багш нарыг чадавхжуулах	13817	2014 оны 08-р сар
Суурь боловсрол	Суурь боловсролын сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сургалт	Лаборатори сургуулийн багш нарыг чадавхжуулах	160	2014 оны 09-р сарын 19
	Суурь боловсролын математик, байгалийн ухаан, англи хэлний сургалтын хөтөлбөрийг түрших арга зүй сургалт	Лаборатори сургуулийн мэргэжлийн багш нарыг чадавхжуулах	255	2014 оны 11-р сарын 07-08
	Хүүхдийн хөгжил-суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр” үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын модуль боловсруулах сургалт	Үндэсний болон орон нутгийн сургагч багшыг бэлтгэх	433	2015 оны 08-р сарын 03-24
	Хүүхдийн хөгжил-суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх орон нутгийн сургалт	ЕБС-ийн дунд ангид хичээл заадаг мэргэжлийн багш нарыг чадавхжуулах	19249	2015 оны 08-р сарын 25-29
Бүрэн дунд боловсрол	Математик, байгалийн ухаан, англи хэлний олон улсын сургалтын хөтөлбөрийг түрших арга зүй сургалт	БДБ-ын X ангид хичээл заах мэргэжлийн багш нарыг чадавхжуулах	236	2015 он
	Ахлах сургуулийн сургалтын цөм хөтөлбөрийн түршилт, хэрэгжилтийн бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлэх сургалт	Мэргэжлийн байгууллагын төлөөллийг чадавхжуулах	54	2016 оны 03-р сарын 28
	“Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт” хэлэлцүүлэг, сургалт	Лаборатори сургуулийн захирал, сургалтын менежер, БСГ, үнэлгээний байгууллагын төлөөллийг чадавхжуулах	38	2016 оны 06-р сарын 13-14
	Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй I	Үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх	236	2016 оны 08-р сарын 15-18
	Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй II	Үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх	13259	2017 оны 07-р сараас 08-р сар
	Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй III	Үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх	324	2018 оны 08-р сарын 20-23
	Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сургалт	ЕБС-ийн ахлах ангид хичээл заах мэргэжлийн багш нарыг чадавхжуулах	14926	2016 оноос 2018 он

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 756-798 сургуулийн, мэргэжлийн бүх багш нарт түгээсэн байна.



Давуу тал

- БХ чиг үүргийнхээ дагуу мэргэжлийн байгууллагуудтай хамтран лаборатори сургуулийн мэргэжлийн багш нар, үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан нь сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг ойлгоход дэмжлэг болсон.
- Сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд ажиллаж байгаа бага ангийн болон мэргэжлийн багш, байгууллагын мэргэжилтэн бүрт хүртээмжтэй тоогоор хэвлэж түгээсэн.



Сул тал

- Үндэсний болон орон нутгийн сургагч багш нараар дамжин сургууль, багш нарт мэдээлэл ижил түвшинд хүрч чадахгүй байна. Өөрөөр хэлбэл сургагч багш нарын үүрэг хариуцлагыг тодорхой болгох, гэрээ байгуулах, сургалт, сурталчилгаа явуулсан үр дүнгээ тайлагнадаг, эргэх холбоог бий болгох механизм бүрдээгүй байна.
- Сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад, нөхөн хангалтаар дахин хэвлэж, түгээх ажил хийгдээгүй.



Санал

- 2014-2018 онуудад үндэсний болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх сургалтуудыг зохион байгуулж ирсэн ч өнөөдөр үндэсний түвшний бүх багш нарт сургалтын шинэ хөтөлбөрийн талаар хангалттай ойлголтод хүрч чадахгүй байна. Цаашид багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт “хөтөлбөр судлал”-ын судлах цагийг нэмэгдүүлж, сургалтын чанарт анхаарах, үндэсний болон орон нутгийн сургагч багштай гэрээ байгуулж, гэрээнд заасан чиг үүргээ биелүүлсэн багшид сургагч багшийн батламж олгох, урамшууллыг бүрдүүлэх шаардлагатай.
- Сургалтын шинэ хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжихэд сургууль, багшид сургалтын материаллаг орчин, мэргэжил арга зүйн дэмжлэгийг тогтмол үзүүлэх шаардлагатай.

Р1.2. СУРАХ БИЧИГ, БАГШИЙН НОМ ЗОХИОХ

Р1.2. А1. Сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу сурах бичиг, багшийн ном зохиох бэлтгэл ажлыг хангах

ЕБС-ийн сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор I-XII ангийн бүх судлагдахууны 125 нэрийн сурах бичиг, 100 нэрийн багшийн номын эхийг шинээр зохиох ажлын бэлтгэл хангасан.

Р1.2. А1.Т1. Сурах бичиг, багшийн номын жагсаалт гаргах, эх зохиох баг бүрдүүлэх

Шинээр зохиох 2013 онд I-V ангийн 32 нэрийн сурах бичиг, 38 нэрийн багшийн ном, 2015 онд VI-IX ангийн 29 нэрийн сурах бичиг, 48 нэрийн багшийн ном, 2016 онд VI-XI ангийн 44 нэрийн сурах бичиг, X-XII ангийн сонгон судлах хичээлийн 14 нэрийн багшийн ном, 2018 онд VI-XII ангийн 20 нэрийн сурах бичгийн жагсаалт гаргаж, эх зохиох багийн бүрэлдэхүүнийг баталсан.

Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай БШУ-ы сайдын 2013 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/155 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар сурах бичиг, сургалтын орчны баг (СБСОБ) 6 гишүүнтэйгээр батлагдсан. СБСОБ нь сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу сурах бичгийг зохиох, түрших, сайжруулах, сургалтын хэрэглэгдэхүүн, орчны судалгаа хийх, сургалтын орчны стандартын төсөл боловсруулах ажлыг давхар гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгасан. Уг багийн үйл ажиллагаанд мэргэжлийн туслалцаа үзүүлэх зорилгоор хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж менежментийн багаас шийдвэрлэсэн.

Үүний дагуу СБСОБ-ийг мэргэжлийн арга зүйч, судлаач, бага ангийн сурах бичиг, багшийн номын эх зохиох багийн ахлагч нараар өргөтгөсөн 22 (Боловсролын хүрээлэн, Их дээд сургууль, Ерөнхий боловсролын сургууль, Нийслэлийн боловсролын газар, Стандарт хэмжил зүйн газар зэрэг байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүн, бага ангийн 10 судлагдахууны сурах бичиг, багшийн номыг зохиох багийн ахлагч) хүнтэй багийг БШУ-ы сайдын 2013 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/326 дугаар тушаалаар баталсан. Ингэснээр сурах бичиг, сургалтын орчны багийн үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчин бүрдсэн.

Сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хэрэглэх I-V ангийн 8 судлагдахууны 32 нэрийн сурах бичиг, тэдгээрийг дагалдсан 10 судлагдахууны 38 нэрийн багшийн номын жагсаалт гаргаж, техникийн тодорхойлолтыг боловсруулсан. Эдгээрийн эхийг зохиолгохоор математик, байгалийн ухааны судлагдахууны хувьд БШУ-ы сайдын 2012 оны А/370 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан ерөнхий боловсролын лаборатори сургуулийн суралцагчийн болон багшийн гарын авлага боловсруулах багийн бүрэлдэхүүнийг, бусад судлагдахууны хувьд өмнө сурах бичиг зохиож байсан ажлын түршлага зэргийг харгалзан багийг бүрдүүлсэн. Улмаар СБСОБ 2013 оны 07 дугаар сард бага ангийн сурах бичиг, багшийн ном зохиох 10 багийн ахлагчтай БШУЯ ажил гүйцэтгэх гэрээ байгуулснаар эх зохиох ажлын эрх зүйн орчин бүрдсэн.

Бага ангийн сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу шинээр зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалтыг хүснэгт 1.2.1а-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.1а. I-V ангийн сурах бичиг

№	Сурах бичгийн нэр	Анги				
		I	II	III	IV	V
1	Монгол хэл	+ (18)	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)
2	Математик	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)
3	Хүн ба орчин	+ (8)	+ (8)	+ (8)		
4	Хүн ба байгаль				+ (8)	+ (10)
5	Хүн ба нийгэм				+ (6)	+ (8)
6	Хөгжим	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)
7	Дүрслэх урлаг, технологи	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)
8	Иргэний боловсрол (Ёс суртахууны унших эх)	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)
Нийт		328 хэвлэлийн хуудас бүхий 32 нэрийн сурах бичиг				

Хүснэгт 1.2.1б. I-V ангийн багшийн ном

№	Багшийн номын нэр	Анги				
		I	II	III	IV	V
1	Монгол хэл	+ (18)	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)
2	Математик	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)
3	Хүн ба орчин	+ (8)	+ (8)	+ (8)		
4	Хүн ба байгаль				+ (8)	+ (10)
5	Хүн ба нийгэм				+ (6)	+ (8)
6	Хөгжим	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)
7	Дүрслэх урлаг, технологи	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)
8	Иргэний боловсрол (Ёс суртахууны унших эх)	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)
9	Биеийн тамир	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)
10	Англи хэл					+ (12)
Нийт		370 хэвлэлийн хуудас бүхий 38 нэрийн багшийн ном				

+ (тоо)

БСШУ-ы сайдын 2009 оны 131 дүгээр тоот тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ын 1.2-д тухайн жилд шинээр зохиох сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага (БСШУСЯ) батлах, 2.2-д боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага (БХ)-ын саналыг үндэслэн сурах бичгийн эх зохиох багийн бүрэлдэхүүнийг яамнаас томилохоор зохицуулсан байдаг. Энэ журмын дагуу БХ-ээс тухайн жилд шинээр зохиох шаардлагатай сурах бичиг, багшийн номын жагсаалт, эх зохиох багийн бүрэлдэхүүний саналыг БСШУСЯ-д хүргүүлдэг. 2013-2014 оны хичээлийн жилд шинээр зохиож, турших бага ангийн сурах бичиг, багшийн номын эх зохиох багийн бүрэлдэхүүнийг ТНБД, БХ-гийн захирал, менежментийн багийн ахлагч нар хамтран СБСОБ-ийн ахлагчтай байгуулсан гэрээний хавсралтаар баталсан. Туршилтын дараа үндэсний хэмжээнд хэрэглэж эхлэхтэй холбоотойгоор сайдын тушаалаар батлах шаардлага гарсан тул БШУ-ы сайдын 2014 оны 05 дугаар сарын 22-ны А/222 дугаар тушаалаар 2014-2015 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн I-V ангид хэрэглэх сурах бичиг, багшийн номын эх зохиох 107 зохиогчтой 10 багийн бүрэлдэхүүнийг баталсан байна.

БСШУ-ы Сайдын “Суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, турших тухай” 2014 оны А/306 тоот тушаалд уг ажлыг БХ гүйцэтгэхээр заасан. Төрийн нарийн бичгийн даргын баталсан “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх ажлын удирдамж”-д суурь боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээ боловсруулсан мэргэжлийн баг сурах бичиг, багшийн ном зохиох, түүний дидактик шийдэл, арга зүйг БХ-гийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, боловсруулахаар заасан. Улмаар суурь боловсролын VI-IX ангийн шинээр зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалтыг БСШУЯ-д хүргүүлсэн. Санхүү, хүний нөөц, цаг хугацааны хязгаарлагдмал байдал болон өмнө нь боловсруулсан сурах бичигт үнэлгээ хийж шаардлагатай эсэхийг тодорхойлон сурах бичиг, багшийн номыг шинээр зохиох жагсаалт гарган баталсан.

Иймд өмнө нь олон улсын хөтөлбөртэй дүйцүүлэн сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулж эхэлсэн математик, физик, биологи, хими, англи хэлний сурах бичгүүд, дээр нь нэмээд сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалтай нийцүүлж шинээр зохиох зайлшгүй хэрэгцээтэй гэж үзэн мэдээллийн технологи, түүх, дизайн технологийн сурах бичгүүдийг зохиохоор шийдвэрлэсэн. Бусад судлагдахууны хувьд өмнө хэрэглэж байсан 12 жилийн үндэсний хөтөлбөрийн сурах бичгүүдийг хэрэглэхээр шийдвэрлэсэн. Харин багшид шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөмж хэрэгцээтэй гэж үзэн багшийн номыг боловсруулах жагсаалт гаргасан. БСШУ-ы сайдын 2014 оны 12 дугаар сарын 30-ны А/494 тоот тушаалаар лаборатори сургуулиудад батлагдсан сургалтын төлөвлөгөөг үндэслэн 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх VI-IX ангийн 29 сурах бичиг, 48 багшийн номын жагсаалтыг баталжээ. Уг жагсаалтыг хүснэгт 1.2.2-т үзүүлэв.

Хүснэгт 1.2.2а. VI-IX ангийн сурах бичиг

№	Сурах бичгийн нэр	Анги			
		VI	VII	VIII	IX
1	Математик	+ (18)	+ (16)	+ (16)	+ (16)
2	Мэдээллийн технологи	+ (6)	+ (6)	+ (6)	+ (6)
3	Байгалийн ухаан	+ (15)			
4	Хими		+ (8)	+ (13)	+ (15)
5	Биологи			+ (13)	+ (15)
6	Физик			+ (13)	+ (15)
7	Түүх	+ (9)	+ (13)	+ (12)	+ (13)
8	Англи хэл	+ (15)	+ (15)	+ (15)	+ (15)
9	Орос хэл			+ (15)	+ (15)
10	Дизайн технологи			+ (8)	+ (15)
11	Дүрслэх урлаг			+ (8)	
Нийт		365 хэвлэлийн хуудас бүхий 29 нэрийн сурах бичиг			

Хүснэгт 1.2.26. VI-IX ангийн багшийн ном

№	Багшийн номын нэр	Анги			
		VI	VII	VIII	IX
1	Монгол хэл, уран зохиол	+ (16)	+ (16)	+ (16)	+ (16)
2	Монгол бичиг		+ (16)		
3	Математик	+ (18)	+ (16)	+ (16)	+ (16)
4	Мэдээллийн технологи	+ (6)	+ (6)	+ (8)	+ (8)
5	Байгалийн ухаан	+ (15)			
6	Орос хэл		+ (10)	+ (15)	+ (15)
7	Англи хэл	+ (15)	+ (15)	+ (15)	+ (15)
8	Биологи		+ (8)	+ (13)	+ (14)
9	Хими		+ (8)	+ (13)	+ (14)
10	Физик		+ (6)	+ (13)	+ (14)
11	Газарзүй		+ (6)	+ (8)	+ (10)
12	Түүх	+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)
13	Нийгмийн ухаан		+ (14)		
14	Дүрслэх урлаг	+ (12)	+ (12)		
15	Дизайн технологи	+ (12)	+ (8)	+ (8)	
16	Хөгжим	+ (12)	+ (12)		
17	Иргэний боловсрол	+ (8)	+ (8)		
18	Биеийн тамир	+ (12)			
Нийт		566 хэвлэлийн хуудас бүхий 48 нэрийн багшийн ном			

Суурь боловсролын сургалтын хөтөлбөр, арга зүй, үнэлгээ боловсруулсан мэргэжлийн багийн гишүүдийн оролцоотойгоор сурах бичиг, багшийн номын эх зохиох багийг бүрдүүлэхээр МУБИС, МУИС, БМДИ, БҮТ, НБГ-т албан тоот илгээж, өмнө сурах бичиг зохиож байсан түршлага бүхий их дээд сургуулийн болон ЕБС-ийн багш, бусад мэргэжлийн байгууллагуудын судлаач, арга зүйч, мэргэжилтнүүдийн төлөөллөөр өргөтгөн бүрдүүлсэн. БСШУ-ы сайдын 2015 оны 01 дүгээр сарын 06-ны А/03 тоот тушаалаар 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн VI-IX ангид хэрэглэх тодорхой судлагдахууны сурах бичиг, багшийн номын эхийг зохиох 193 гишүүнтэй 19 багийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Ингэснээр суурь боловсролын сурах бичиг, багшийн номын зохиогчийн багийн ажиллах эрх зүйн орчин бүрдсэн.

2017-2018 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуульд шинээр хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг гаргахдаа өмнөх жилд зохиогдоогүй үлдсэн дунд ангийн зарим сурах бичиг, бүрэн дунд боловсролын сургалтын шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхтэй холбоотойгоор X, XI ангийн заавал судлах хичээлийн сурах бичгийг тус тус шинээр зохиох жагсаалт гаргасан. БСШУС-ын сайдын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/174 тоот тушаалаар 2017-2018 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх ЕБС-ийн VI-IX ангийн 19 нэрийн, X, XI ангийн заавал судлах хичээлийн 22 нэрийн, сонгон судлах хичээлийн 1 нэрийн, нийт 42 нэрийн сурах бичиг, 2018-2019 оны хичээлийн жилд шинээр хэрэглэх X-XII ангийн сонгон судлах хичээлийн 14 нэрийн багшийн номын жагсаалтыг баталсан. Сурах бичиг, багшийн номын жагсаалтыг хүснэгт 1.2.3-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.3а. VI-XI, X, XI ангийн сурах бичиг

№	Сурах бичгийн нэр	Анги					
		VI	VII	VIII	IX	X	XI
1	Монгол хэл			+ (12)	+ (12)	+ (12)	+ (6)
2	Уран зохиол			+ (12)	+ (12)	+ (6)	+ (6)
3	Үндэсний бичиг			+ (12)	+ (12)	+ (12)	+ (12)
4	Математик					+ (18)	+ (18)
5	Хими					+ (12)	+ (12)

6	Биологи		+ (12)			+ (12)	+ (12)
7	Физик		+ (12)			+ (12)	+ (12)
8	Газарзүй			+ (8)	+ (8)	+ (12)	+ (12)
9	Түүх					+ (6)	+ (6)
10	Нийгэм судлал		+ (8)	+ (8)	+ (8)	+ (8)	
11	Англи хэл					+ (18)	+ (18)
12	Орос хэл		+ (12)			+ (18)	+ (18)
13	Дизайн технологи	+ (12)	+ (12)				
14	Бизнес судлал (сонгон судлах)					+ (15)	+ (6)
15	Дүрслэх урлаг		+ (12)				
16	Хөгжим		+ (12)		+ (12)		
	Нийт	507 хэвлэлийн хуудас бүхий 44 нэрийн сурах бичиг					

Хүснэгт 1.2.36. X-XII ангийн багшийн ном

№	Багшийн номын нэр	Анги	XI	XII
		X		
1	Монгол хэл, бичиг		+ (20)	
2	Уран зохиол		+ (20)	
3	Орос хэл		+ (20)	
4	Англи хэл		+ (20)	
5	Математик		+ (20)	
6	Мэдээллийн технологи		+ (20)	
7	Биологи		+ (20)	
8	Хими		+ (20)	
9	Физик		+ (20)	
10	Газарзүй		+ (20)	
11	Дизайн технологи		+ (20)	
12	Монголын түүх		+ (20)	
13	Нийгэм судлал		+ (20)	
14	Бизнес судлал			+ (15)
	Нийт	275 хэвлэлийн хуудас бүхий 14 нэрийн багшийн ном		

Дээрх хүснэгтэд үзүүлсэн багшийн номыг ЕБС-ийн X-XII ангид гүнзгийрүүлэн судлахаар сонгосон суралцагчдад хичээл заах багшид зөвлөмж болгож боловсруулсан.

Өмнө дурдсан 131 дүгээр журамд зааснаар сурах бичиг, багшийн номын эх зохиох багийг БХ өдөр тутмын хэвлэлээр дамжуулан зар түгээж, сурах бичиг, багшийн ном зохиохоор хүсэлтээ ирүүлсэн багуудаас бүрдүүлсэн. Зохиогчийн багийг 5-аас доошгүй тооны бөгөөд тухайн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн, тухайн боловсролын агуулга, арга зүй, дидактикаар мэргэшсэн, сурах бичгийг сургалтын практикт ашигладаг гишүүнтэй байхыг шаарддаг. Эх зохиох баг шалгаруулах үйл ажиллагааг БХ-гийн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулсан. Сонинд нийтлүүлсэн зарын дагуу багуудын ирүүлсэн битүүмжилсэн материал:

- зохиогчийн багийн гишүүдийн анкет
- боловсролын болон мэргэжлийн зэргийг гэрчлэх баримт бичиг
- тухайн боловсролын болон ЕБС-ийн сурах бичиг, сургалтын чиглэлээр гаргасан бүтээлийн жагсаалт зэрэгт үндэслэн урьдчилан гаргасан үзүүлэлтийн дагуу оноо өгч, дүгнэсэн.

Улмаар сурах бичгийн эх зохиох багийн бүрэлдэхүүний нэрсийг БСШУЯ-д албан бичгээр хүргүүлсэн. Дээрх хүснэгт 1.2.3-д үзүүлсэн сурах бичгийн эх зохиох багийн бүрэлдэхүүнийг БСШУС-ын сайдын 2017 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/85 тоот тушаалаар баталснаар тэдний ажиллах эрх зүйн орчин бүрдэв.

2017-2018 оны хичээлийн жилд XII ангид суралцсан суралцагчид 12 жилийн үндэсний сургалтын хөтөлбөрөөр хичээллэж төгссөн. Харин 2018-2019 оны хичээлийн жилд XII ангид элсэн суралцах суралцагчид сургалтын цөм хөтөлбөрөөр хичээллэх тул энэ ангийн заавал судлах хичээлийн сурах бичгийг шинээр зохиох шаардлага гарсан. Нэмээд өмнөх жилүүдэд шинээр зохиох сурах бичгийн жагсаалтад багтаагүй VI-VII ангийн монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг, VII ангийн газарзүйн сурах бичгийг шинээр зохиох болсон. Өөрөөр хэлбэл энэ хичээлийн жилд ЕБС-ийн I-XII ангийн бүх судлагдахууны сурах бичгийг шинээр зохиох ажил дуусгавар болох юм. Сурах бичгийн жагсаалтыг БСШУС-ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/120 тоот тушаалаар баталсан. Жагсаалтад VI ангийн 3 нэрийн, VII ангийн 4 нэрийн, X ангийн 2 нэрийн, XI ангийн 3 нэрийн, XII ангийн 8 нэрийн сурах бичиг, нийт 20 сурах бичиг багтсан. Сурах бичиг, багшийн номын жагсаалтыг хүснэгт 1.2.4-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.4. VI-XI, X-XII ангийн сурах бичиг

№	Сурах бичгийн нэр	Анги				
		VI	VII	X	XI	XII
1	Монгол хэл	+ (16)	+ (12)			+ (12)
2	Уран зохиол	+ (10)	+ (12)			+ (10)
3	Үндэсний бичиг	+ (10)	+ (10)			+ (10)
4	Математик					+ (20)
5	Мэдээллийн технологи			+ (12)	+ (12)	+ (12)
6	Газарзүй		+ (8)			
7	Нийгэм судлал				+ (16)	
8	Англи хэл					+ (20)
9	Орос хэл					+ (20)
10	Дизайн технологи			+ (16)	+ (16)	+ (16)
Нийт		270 хэвлэлийн хуудас бүхий 20 нэрийн сурах бичиг				

131 дүгээр журмын 2.2, БШУЯ-ны БХЗГ-ын даргын “Сурах бичиг боловсруулах ажлыг зохион байгуулах тухай” 2018 оны 03 сарын 19-ний өдрийн 4/2412 тоотыг үндэслэн сурах бичгийн эх зохиох баг бүрдүүлэх ажлыг зохион байгуулсан. Сурах бичгийг зохиоход оролцох үрилгыг “Зууны мэдээ” сонины 2018 оны 3 сарын 21-ний №58(5765) “Өнөөдөр” сонины 2018 оны 03 сарын 23-ны, №054(6347) дугаарт тус тус нийтлүүлсэн. Эх зохиох баг бүрдүүлэх 24 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг БХ-гийн захирлын 2018 оны 03 сарын 30-ны өдрийн А/07 дугаар тушаалаар баталсан байна. Материал хүлээн авах хугацааг 21 хоног байхаар төлөвлөсөн. Эх зохиох баг бүрдүүлэх үйл ажиллагааг өмнөх жилийнхтэй ижлээр зохион байгуулсан. Харин энэ удаа сурах бичгийн тодорхой нэг сэдвийн боловсруулалт хийж ирүүлэх саналыг багуудад санал болгосон бөгөөд түүнийг хэрхэн дүгнэхийг ажлын хэсэг дэх БХ-гийн эрдэм шинжилгээний ажилтнууд урьдчилан хэлэлцсэн. Материал ирээгүй хоёр сурах бичгийн эхийг өмнөх ангийн зохиогчоор ажилласан багийн бүрэлдэхүүнээр зохиолгохоор шийдвэрлэсэн. Улмаар сурах бичгийн эх зохиох багийн бүрэлдэхүүний саналыг БХ-гийн 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 66 тоот албан бичгээр БСШУСЯ-д уламжилсан. Бүрэлдэхүүнийг БСШУС-ын сайдын 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/263 тоот тушаалаар баталснаар эх зохиох багийн ажиллах эрх зүйн орчин бүрджээ.

P1.2.A1.T2. Ажлын төлөвлөгөө гаргах, үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн зардлыг тооцоолох

Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор зохиогчийн багийн сурах бичиг, багшийн номын эх зохиох ажлын төлөвлөгөө боловсруулж, шаардагдах санхүүгийн эх үүсвэр, зардлын тооцоог гаргаж, батлуулах ажлыг хийсэн.

“Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал”-д ЕБС-ийн I-XII ангид хэрэглэх сурах бичиг, багшийн номыг зохиох, турших, сайжруулах, хэвлэх ажлыг төлөвлөсөн байдаг. Төлөвлөгөөг хүснэгт 1.2.5-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.5. БДБЧШ-ийн ерөнхий зураглал дахь эх зохиох, түрших, хэвлэх төлөвлөгөө

Түвшин	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017
Бага	I-V ангийн сурах бичиг, багшийн ном зохиох, турших, хэвлэх	I-V ангийн сурах бичиг, багшийн номыг үндэсний хэмжээнд хэрэглэх		
Дунд		VI-IX ангийн сурах бичиг, багшийн ном зохиох, турших, хэвлэх	VI-IX ангийн сурах бичиг, багшийн номыг үндэсний хэмжээнд хэрэглэх	
Ахлах			X-XII ангийн сурах бичиг, багшийн ном зохиох, турших, хэвлэх	X-XII ангийн сурах бичиг, багшийн номыг үндэсний хэмжээнд хэрэглэх

БШУЯ-ны төрийн нарийн бичгийн даргын баталсан менежмент багийн ахлагч, БХ-гийн захирал, СБСОБ-ийн ахлагч нартай хамтран байгуулсан гэрээнд СБСОБ нь ЕБС-ийн сурах бичиг, багшийн ном болон сургалтын орчны стандартыг боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэхээр тусгасан. Уг гэрээний нэгдүгээр хавсралтаар СБСОБ-ийн ажлын төлөвлөгөөг баталсан бөгөөд түүнд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, дэлхийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны онцлогийг харгалзан

- сурах бичиг, сургалтын орчны судалгаа хийх
- сурах бичгийн бодлого, зохицуулалтын баримт бичиг боловсруулах
- сурах бичиг болон түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах гэсэн 3 үндсэн чиглэлийн ажлыг гурван хичээлийн жилийн хугацаатайгаар төлөвлөсөн. Төлөвлөгөөг хүснэгт 1.2.6-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.6. СБСОБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Хэтийн зорилго: Сурах бичиг, сургалтын орчны тогтолцоог боловсронгуй болгох, сурах бичиг судлалыг хөгжүүлэх, хүний нөөцийг чадавхжуулах, судлаачдыг чадваржуулах					
2013-2014 оны зорилго: - Сурах бичиг, орчны талаар судалгаа хийх - Сурах бичгийн талаар баримтлах бодлого зохицуулалтын баримт бичгийн төсөл боловсруулах - Бага ангийн сурах бичиг зохиох				2014-2015 оны зорилго: - Дунд ангийн сурах бичиг зохиох - Сургалтын хэрэглэгдэхүүн, орчны талаар судалгаа хийх, туршлага судлах, тавигдах шаардлагын төсөл боловсруулах - Бага ангийн сурах бичигт чанарын үнэлгээ хийх	
Зорилт 1: Бага дунд боловсролын сурах бичгийн үзэл баримтлалын төсөл боловсруулах	Зорилт 2: ЕБС-ийн сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх, журмын шинэчилсэн төсөл боловсруулах	Зорилт 3: Сургалтын орчинд тавигдах шаардлага, зохицуулалтын баримт бичгийн төсөл боловсруулах	Зорилт 4: Бага ангийн сурах бичиг зохиох	Зорилт 5: Багийн чадавхийг дээшлүүлэх	2015-2016 оны зорилго: - Ахлах ангийн сурах бичиг зохиох - Сургалтын орчны стандарт эцэслэн боловсруулах - Дунд ангийн сурах бичигт чанарын үнэлгээ хийх

БДБЧШ-ийн ерөнхий зураглалын дагуу 2013-2014 оны хичээлийн жилд бага ангийн сурах бичиг, багшийн номын эх зохиох, түрших, сайжруулах, эцэслэх ажлыг шаталсан байдлаар төлөвлөснийг Хүснэгт 1.2.7-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.7. Бага ангийн сурах бичиг, багшийн ном зохиох ажлын төлөвлөгөө

[illegible]

БДБЧШ-ийн зураглалд СБСО-ны шинэчлэлийн хүрээнд сургалтын орчны стандарт шинээр боловсруулах, энэхүү стандартаар ЕБС-ийн гадаад, дотоод орчинд тавигдах шаардлага, үзүүлэлтийг тодорхойлохоор заасан. Улмаар хүлээлгэж өгөх бүтээгдэхүүнд дунд ангийн сурах бичиг, багшийн ном дээр нэмээд, сургалтын хэрэглэгдэхүүний судалгааны тайлан, сургалтын орчны шаардлага, стандартын төсөл гэж тодорхойлсон байна. Мөн сурах бичиг, багшийн ном зохиох бэлтгэл ажлын хүрээнд гадаад улс орнуудын болон өөрийн орны сурах бичиг, багшийн ном, сургалтын

хэрэглэгдэхүүн, орчин, тэдгээрийн бүтэц, агуулга, өөр хоорондын уялдаа холбоог судлах судалгааны ажлын арга зүй боловсруулах, судалгаа хийх, тайлан бичихээр төлөвлөсөн ч цаг хугацаа, хүний нөөц, санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэн эдгээр ажил хийгдээгүй.

VI-IX ангийн 29 нэрийн сурах бичиг, 48 нэрийн багшийн номын эх зохиох багийг 2015 оны 1 дүгээр сард сайдын тушаалаар томилсон ч эх зохиох, хянах, эх бэлтгэх, хэвлэх зардлын эх үүсвэр тодорхойгүй, санхүүгийн нөөц хязгаарлагдмал байсан тул зохиогчийн багуудтай гэрээ байгуулах боломжгүй байдал үүссэн. Гэрээ байгуулаагүй ч эх зохиох ажлыг таслалгүй явуулж байх хүсэлтийг зохиогчийн багт уламжилж байв. Улмаар 2015 оны 6 дугаар сард БСШУЯ-ны ТНБД-ын “Зардал батлах тухай” А/209 тоот тушаал батлагдсан тул зохиогчийн багуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Энэ оны 9 дүгээр сард хичээлийн шинэ жил эхлэхэд сурах бичиг, багшийн номыг бэлэн болгосон байхын тулд маш бага хугацаанд эх бэлтгэх, хэвлэх, түгээх ажлыг хийх шаардлага гарсан. Иймд богино хугацааны төлөвлөгөө боловсруулсан бөгөөд үүнийг Хүснэгт 1.2.9-д үзүүлэв.

2017-2018 оны хичээлийн жилд шинээр хэрэглэж эхлэх сурах бичиг, багшийн номын эх зохиох, эх бэлтгэх, хүлээлгэж өгөх ажлын төлөвлөгөөг Хүснэгт 1.2.9-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.9. Ажлын төлөвлөгөө

№	Гүйцэтгэх ажил	2017 он																			
		IV	V	VI				VII				VIII				IX				X	
				1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2
1	Сурах бичгийн эх зохиох																				
2	Сурах бичгийн эх хянах, засах (I)																				
3	Сурах бичгийн эх хянах, засах (II)																				
4	Сурах бичгийн зохиогчийн эхийг бэлэн болгох																				
5	Сурах бичгийн эхийг бэлтгэх																				
6	Хэвлэлийн эхийг хянах																				
7	Засвар хийх																				
8	Дахин хянах, засвар хийх																				
9	Сурах бичгийн хэвлэлийн эхийг бэлэн болгох																				
10	БСШУЯ-д хүлээлгэн өгөх																				
11	Багшийн номын эх зохиох																				
12	Багшийн номын эх хянах																				
13	Багшийн номын засвар хийх																				
14	Дахин хянах, засвар хийх																				
15	Багшийн номын зохиогчийн эхийг бэлэн болгох																				

2018-2019 оны хичээлийн жилд шинээр зохиож, хэрэглэж эхлэх сурах бичиг, багшийн номын эх зохиох, эх бэлтгэх, хүлээлгэж өгөх ажлын төлөвлөгөөг Хүснэгт 1.2.10-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.10. Сурах бичгийн эх зохиох ажлын хуваарь

№	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн	Хугацаа
1	Сурах бичгийн эх зохиох	Зохиогчийн баг, Боловсролын хүрээлэн	2018.05.15-08.15
2	Сурах бичгийн эхийг хянуулах		2018.07.15-08.01
3	Сурах бичгийн эх зохиолыг засах, Боловсролын хүрээлэнд эх зохиолыг хүлээлгэн өгөх		2018.08.01-08.15
4	Сурах бичгийн хэвлэлийн эх бэлтгэгчтэй хамтран ажиллах	Зохиогчийн баг Хэвлэлийн компани	2018.08.15-09.15

Дээрх хүснэгтээс харахад сурах бичгийн эх зохиох хугацаа улам багассан байна. Үүнтэй холбоотойгоор БСШУЯ,

БХ, зохиогчийн багийн ахлагч нарын хамтарсан үүлзалт зохион байгуулж, эх зохиох ажлын ерөнхий төлөвлөгөөг хэлэлцсэн. Мөн сурах бичгийн хэвлэлийн эхийг хичээлийн жил эхлэхэд online хэлбэрээр байршуулж, редактор болон ЕБС-ийн багш нарын санал, шүүмжийг хүлээн авах, тусгах үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

P1.2.A1.T3. Сурах бичгийн үзэл баримтлал, бодлого зохицуулалтын журмын төсөл боловсруулах

Сурах бичгийн талаар авч хэрэгжүүлэх бодлого зохицуулалтыг боловсронгуй болгох, талууд хоорондын харилцааг зохицуулахуйц журмын төслийг боловсруулж БСШУЯ-д хүргүүлсэн.

СБСОБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд БДБ-ын сурах бичгийн үзэл баримтлал, ЕБС-ийн сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх, журам боловсруулахаар тусгасан. Энэ ажлын хүрээнд зарим гадаад улс орнуудын сурах бичгийн талаар баримталж буй бодлого зохицуулалтын бичиг баримтыг орчуулж, судалсан. Өөрийн орны сурах бичгийн талаар төрөөс баримталж буй эрх зүйн баримт бичгүүдийг судалж, дүн шинжилгээ хийв. Сурах бичгийн чанарыг дээшлүүлэхэд хэрэглэгч төвтэй, олон нийтийн оролцоонд тулгуурласан сурах бичгийн хяналтын, нээлттэй тогтолцоог тусгасан үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулсан.

Мөн одоо мөрдөгдөж буй бодлого зохицуулалтын баримт бичгийг судалж, дүн шинжилгээ хийсэн. Улмаар БШУ-ы сайдын 2009 оны 131 дүгээр тушаалаар баталсан “ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ыг судалгааны үндэслэлтэйгээр шинэчлэн боловсруулж, АХБ-ны сурах бичгийн түрээсийн тогтолцооны талаар үнэлгээ хийж буй төслийн ажилтан, зөвлөхүүд, БХ-гийн эрдмийн зөвлөлийн гишүүдийн оролцоотойгоор хэлэлцүүлсэн бөгөөд журмын төслийг БШУЯ-ны СБТГ-т хүргүүлсэн. Журмын төсөлд шинээр зохиох сурах бичгийн жагсаалтыг хэрэглэж эхлэхээс 2 жилийн өмнө гаргах, эхийг зохиохоос эхлэн хэвлэх хугацаа нь арван найман сараас доошгүй байх гэх мэт хугацаатай холбоотой заалтыг тусгаж өгсөнөөрөө онцлог байлаа.

Багийн гурван жилийн ажлын ерөнхий төлөвлөгөөнд сургалтын хэрэглэгдэхүүн, орчны судалгаатай холбоотой ажлыг дараах байдлаар төлөвлөсөн байв.

Хүснэгт 1.2.11. СБСОБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө

№	Хичээлийн жил	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
1	2013-2014 он	- Сурах бичиг, орчны талаар судалгаа хийж сурах бичгийн талаар баримтлах бодлого, зохицуулалтын баримт бичгийн төсөл боловсруулах
2	2014-2015 он	- Сургалтын хэрэглэгдэхүүн, гадаад ба дотоод орчны талаар судалгаа хийх, түршлага судлах, судалгаа хийх, орчинд тавигдах шаардлагын төсөл боловсруулах Шинээр гарсан баримт бичигт болон бага ангийн сурах бичигт чанарын үнэлгээний судалгаа хийх
3	2015-2016 он	- Сургалтын орчны стандарт эцэслэн боловсруулах Дунд ангийн сурах бичигт чанарын үнэлгээний судалгаа хийх

Сургалтын орчны судалгаа хийх, түүнд тавигдах шаардлага, стандартын төсөл боловсруулах, шинээр зохиож хэрэглэх бага, дунд ангийн сурах бичигт чанарын үнэлгээ хийх ажил хийгдээгүй.

- 2013 оны 05 дугаар сард БДБЧШ-ийн үзэл баримтлал, ерөнхий зураглал, түүнийг хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн батлагдсанаар СБСОБ-ийн ажиллах эрх зүйн орчин бүрдсэн. 2013-2014 оны хичээлийн жил эхлэхэд лаборатори 40 сургуулиудад түрших бага ангийн сурах бичиг багшийн номын I улирлын түршилтын хувилбарыг бэлэн болгохын тулд эх зохиох ажлыг яаралтай эхлүүлэх шаардлага гарсан. Улмаар 2013 оны 6 сард СБСОБ-ийн ажлын төлөвлөгөө боловсруулах, санхүүгийн зардлыг тооцоолох, шинээр зохиох бага ангийн сурах бичиг, багшийн номын жагсаалт гаргах, тэдгээрийг зохиох баг бүрдүүлэх, багуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулахын зэрэгцээ менежментийн багт хүлээлгэж өгөх бүтээгдэхүүнийг тодорхойлох, тэдгээрт тавих шаардлага боловсруулах гэх мэт ажлуудыг хийсэн. Мөн оны 7 дугаар сараас эхлээд сурах бичгийн эх зохиох ажил эхэлсэн. Иймд өмнө хэрэглэж байсан сурах бичгийг судалж, шинэчлэх сайжруулах зүйлсийг тодорхойлох, өөрийн болон бусад улс орны сурах бичгийн үзэл санаа, бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээний зарчим, дасгал даалгавар, зохиомж, дүрслэл зэргийг харьцуулсан судалгаа хийхэд цаг хугацаа, хүний нөөц дутагдалтай байв. Иймд шинээр зохиох сурах бичиг, багшийн номын дидактик шийдлийг гаргах ажлыг сурах бичиг боловсруулах үйл явцад тодорхой болгож байв.
- Хөтөлбөр боловсруулах үйл явцад хөтөлбөрт орж буй агуулгын хүрээний өөрчлөлтийн хувь, анализ дүгнэлтийг үндэслэн шинэчлэх шаардлагатай, шаардлагагүй сурах бичгийг тодорхойлж жагсаалтыг гаргасан. Тухайлбал: БДБЧШ-ийн зураглалд суурь боловсролын бүх судлагдахууны сурах бичиг, багшийн номыг 2014-2015 оны

хичээлийн жилд шинээр зохиохоор төлөвлөсөн. Гэвч VI-IX ангийн 17 судлагдахууны 55 нэрийн сурах бичгийг гурван хичээлийн жил дамжин шинэчилж байна. Үүнийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1.2.12

№	Суурь боловсролын бүх судлагдахууны сурах бичиг		
	2015-2016 он	2017-2018 он	2018-2019 он
1		Монгол хэл VIII-IX	Монгол хэл VI-VII
2		Уран зохиол VIII-IX	Уран зохиол VI-VII
3		Үндэсний бичиг VIII-IX	Үндэсний бичиг VI-VII
4	Математик VI-IX		
5	Мэдээллийн технологи VI-IX		
6	Түүх VI-IX		
7		Нийгэм судлал VII-IX	
8	Байгалийн ухаан VI		
9	Биологи VIII-IX	Биологи VII	
10	Хими VII-IX		
11	Физик VIII-IX	Физик VII	
12		Газарзүй VIII-IX	Газарзүй VII
13	Англи хэл VI-IX		
14	Орос хэл VIII-IX	Орос хэл VII	
15	Дизайн технологи VIII-IX	Дизайн технологи VI-VII	
16	Дүрслэх урлаг VIII	Дүрслэх урлаг VI-VII	
17		Хөгжим VI-IX	
	Нийт 29 сурах бичиг	Нийт 19 сурах бичиг	Нийт 7 сурах бичиг

Одоо мөрдөгдөж буй бодлого зохицуулалтын баримт бичигт тухайн жилд шинээр зохиох сурах бичгийн жагсаалт батлах, баг бүрдүүлэхтэй холбоотой цаг хугацааны ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй байдаг. Эндээс үүдэн шинээр зохиох сурах бичгийн жагсаалт батлагдахгүй хүлээгдэх, багийн бүрэлдэхүүнийг сонгоход цаг хугацааны хувьд яаралтай байдал үүсэх зэрэг хүндрэлүүд гардаг. Сурах бичгийн эх зохиох баг бүрдүүлэх үйл ажиллагааг ямар хугацаанд хэрхэн зохион байгуулахыг тодорхой болгох шаардлагатай. Тухайлбал, бага, дунд ангийн сурах бичгийн эх зохиох багийг мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн бүрдүүлсэн. 2017 онд сонгон шалгаруулалтыг 1 сарын хугацаатайгаар зарлаж, эх зохиох багийг бүрдүүлсэн бол 2018-2019 оны хичээлийн жилд сонгон шалгаруулалтыг 1 сараас богино (21 хоног) хугацаанд зохион байгуулж, багийг бүрдүүлсэн. Учир нь шинээр зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалт 2018 оны 3 сард батлагдсан. Эх зохиох ажлыг яаралтай эхлэх шаардлагатай байсан тул өмнөх жилийнхээс бага хугацаанд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Үүнийг олон нийтийн оролцоог хаасан, эрхийг хязгаарласан үйлдэл гэж зарим төлөөлөл үзэж байна.

Сурах бичгийг төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэж чадахгүй байгаагийн нэг шалтгаан бол сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг сурах бичиг, багшийн номын эх зохиох ажилтай зэрэгцүүлж төлөвлөсөн явдал юм. Энэ нь хүний нөөцийг зөв тооцоолох хэрэгтэйг сануулж байна. Хүснэгт 1.2.13-д тухайн жилд шинээр зохиосон сурах бичиг, багшийн номын тоо, тэдгээрийн эхийг зохиосон зохиогчдын тоо, сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон зохиогчдын тоо, хувийг үзүүлэв.

Хүснэгт 1.2.13

№	Хугацаа	2013-2015 оны хичээлийн жил	2015-2016 оны хичээлийн жил	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил
1	Сурах бичгийн тоо	32 (328 х.х)	29 (365 х.х)	44 (507)	20 (270)
2	Багшийн номын тоо	38 (370 х.х)	48 (566 х.х)	14 (275 х.х)	-
3	Зохиогчийн тоо	107	179	191	1107
4	Хөтөлбөр боловсруулахад оролцсон хүний тоо буюу эзлэх хувь	52 буюу зохиогчдын 48.5 хувийг эзэлнэ.	74 буюу зохиогчдын 41.3 хувийг эзэлнэ.	92 буюу зохиогчдын 48.1 хувийг эзэлнэ.	42 буюу зохиогчдын 38.1 хувийг эзэлнэ.



Давуу тал

- Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор байгуулагдсанаараа сурах бичиг судлалыг хөгжүүлэх, сурах бичиг, сургалтын орчны бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, сурах бичиг боловсруулагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах мэргэжлийн баг бүрдэх суурь бий болсон.
- Сургалтын хөтөлбөр, сурах бичиг, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний шинэчлэлийн бодлогыг цогцоор нь хэрэгжүүлэх оролдлого хийсэн. Тухайлбал: Сургалтын орчин, хэрэглэгдэхүүний судалгаа хийх, тухайн түвшний сурах бичгийг сургалтад хэрэглэж эхэлснээс 1 жилийн дараа түүнд чанарын үнэлгээ хийхээр СБСОБ-ийн 3 жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө (Хүснэгт 1.2.6.)-д тусгасан.
- I-V ангийн бүх судлагдахууны сурах бичгийг нэгэн зураг боловсруулж эхэлсэн нь анги хоорондын болон судлагдахуун хоорондын агуулгын залгамж холбоог нийтэд нь авч үзсэнээр түүнийг сайжруулах боломж бүрдсэн.
- Бага ангийн бүх сурах бичгийг дагалдуулж “Багшийн ном” боловсруулж, багшид арга зүйн зөвлөмж өгснөөрөө сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бодитой дэмжлэг болж байлаа.
- ЕБС-ийн сурах бичгийн талаар баримтлах үзэл баримтлалын төсөл, сурах бичиг зохиох баг шалгаруулахаас эхлээд хэвлэсэн сурах бичгийг түгээж ашиглах хүртэл бүхий л үйл явцыг зохицуулах журмын төсөл боловсруулсан.
- Сурах бичиг, багшийн ном зохиох багт БХ, БМДИ, НБГ, зарим ТББ, Их, дээд сургууль болон ЕБС гэх мэт боловсролын бүх шатны байгууллагын төлөөллийг хамруулсан.



Сул тал

- ЕБС-ийн I-XII ангийн бүх судлагдахууны сурах бичгийг шинээр зохиох, турших, хэрэглэх, сургалтын орчны стандарт, түүнд тавигдах шаардлага боловсруулах ажлын нэгдсэн зураглал хийсэн боловч хүний нөөц, санхүүгийн боломжоос хамаарч СБСОБ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд өөрчлөлт орсон.
- Лаборатори 40 (нийслэлийн 9 дүүргийн 16, аймгийн төвийн 21, сумын төвийн 3 сургууль) сургуулийн I-V ангийн 38000 орчим сурагч, 1100 орчим багш туршилтад хамрагдсан. Туршилтад хамрагдсан сургууль, багш, сурагчийн тоонд суурилан зөвлөн туслах мэргэжлийн хүний нөөц хангалтгүй байсан.
- Нэгдсэн төлөвлөлтөд хүний болон санхүүгийн зардлыг бүрэн гүйцэд тусгах, санхүү хөрөнгөө бодитой тооцоолоход анхаарах шаардлагатай. Нэг багш бүх хичээл (I анги-6, II анги-6, III анги-6, IV анги-7, V анги-7)-ийн сурах бичиг, багшийн номыг турших нь арга зүй агуулгын нэгдмэл байдлыг хангах сайн талтай хэдий ч багшийн ажлын ачаалал нэмэгдэх, хэвлэх, түгээх зардал их гарч байв.



Санал

- Сурах бичиг, багшийн номын эхийн зохиогчдын 43-45 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон байна. Өөрөөр хэлбэл зохиогчдоос ойролцоогоор хоёр хүний нэг нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахаар давхар ажилласан байна. Аль ч түвшний сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулаад, баталгаажуулсны дараа сурах бичгийг шинээр зохиох ажлыг эхлүүлэх нь хүний нөөцийг зөв тооцсон, бодитой төлөвлөлт хийх боломж бүрдэнэ.
- Сурах бичгийг шинээр зохиохын өмнө хэрэглэж байгаа сурах бичгээ судлах, судалгааны үндсэн дээр асуудлыг тодорхойлох, шийдэх арга замыг хэлэлцэх ажлын нарийвчилсан төлөвлөлт хийх хэрэгтэй. Сурах бичгийн талаар баримтлах бодлого, зохицуулалтын баримт бичигт шинээр зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалтыг эх зохиохоос 1-2 жилийн өмнө батлах, улмаар эх зохиох багийг бүрдүүлэх зохион байгуулалт, үйл ажиллагааны хугацаа, баримтлах зарчмыг журмаар зохицуулалт хийх нь төлөвлөлт хийхэд тустай байх болно.

P1.2.A2. Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, сайжруулах

ЕБС-ийн I-XII ангийн 103 нэрийн сурах бичиг, 100 нэрийн багшийн номын эхийг шинээр зохиож, хэрэглэж эхэлсэн. 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх 20 нэрийн сурах бичгийн эхийг шинээр зохиож байна.

P1.2.A2.T1. Сурах бичиг, багшийн номын эх зохиох багийн үүлзалт, сургалт зохион байгуулах

Бага, дунд ангийн сурах бичгийн эхийг сайжруулах, нэгтгэх сургалтыг тус бүр 3-5 өдрийн хугацаатайгаар зохион байгуулсан.

2013 оны 08 дугаар сарын 08-ны өдөр бага ангийн сурах бичиг, багшийн ном зохиогчдын багуудын үүлзалт, семинар зохион байгуулсан. Семинараар бага ангийн суралцагчдын сэтгэл зүйн онцлогийн талаарх судалгаа, II ангийн суралцагчдын сурах арга барилын талаарх судалгааны үр дүнг зохиогчдод танилцуулах, сургалтын хөтөлбөр боловсруулах багийн ажлын өнөөгийн байдал, цаашдын ажлын төлөвлөгөөний талаар мэдээлэл өгсөн. Улмаар анги бүрийн сурах бичгийн үялдаа холбоог сайжруулах, багшийн номын нэгдсэн загвар гаргах дадлага ажил хийсэн.

СБСО-ны багаас зохиогчийн багийн ахлагч нартай үүлзалт зохион байгуулж, бага ангийн сурах бичиг, багшийн номын эх зохиох, турших, сайжруулах ажлын ерөнхий төлөвлөгөө, сурах бичиг, багшийн номын бүтэц, түүнд тавигдах шаардлага, хянах шалгуур үзүүлэлтийг танилцуулж, дэд багийн цаашдын ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.

2014 оны 03 дугаар сарын 24-28-ны хооронд дөрвөн улирлаар зохиож туршсан сурах бичиг, багшийн номыг нэгтгэх, сайжруулах, туршилтын үр дүнг сурах бичиг, багшийн номд тусгах зорилготой үүлзалт сургалтыг зохион байгуулсан. Үүлзалт сургалтаар сургалтын хөтөлбөр сурах бичиг, анги болон судлагдахуун хоорондын үялдааг сайжруулах, улирал бүрээр зохиосон сурах бичгийг нэгтгэх, сайжруулахад санал солилцож, хэлэлцүүлэг хийсэн. Мөн сурах бичиг, багшийн ном зохиох дэд багуудын туршлага солилцох 200 гаруй хүний бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулжээ.

2014 оны 05 дугаар сарын 10-ны өдөр бага ангийн сурах бичиг, багшийн номын зохиогчдын баг, агуулга болон техникийн редактор, хэвлэлийн газрын эх бэлтгэгч, дизайнеруудын нэгдсэн үүлзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг үүлзалтаар Боловсролын хүрээлэнгийн СБСОСС-оос боловсруулсан ЕБС-ийн сурах бичиг, багшийн номд тавигдах тусгай шаардлага, шалгуурыг зохиог, редакторуудаар хэлэлцүүлж, зарим тодорхой саналыг авсан. Судлагдахуун бүрийн зохиогчид эх бэлтгэгч нар хамтран сурах бичиг, багшийн номын техникийн шаардлагуудыг ярилцаж, судлагдахууны онцлогоос шалтгаалсан тэмдэглэгээ, бүлэг сэдэв, дэд сэдвийн гарчиг зэргийн боловсруулалт, таних тэмдэг, тэмдэглэгээ, өнгө дизайны талаар хэлэлцэж, нэг ойлголтод хүрсэн. Улмаар сурах бичиг, багшийн номын тодорхой нэг сэдвийн дизайн, загвар гаргасан байна.

Суурь боловсролын сурах бичиг, багшийн номын зохиогчийн эхийг сайжруулах зорилгоор 2015 оны 03 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд багийн үүлзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Үүнтэй холбоотой зохиогчийн багийн гишүүдэд зар түгээх, БСШУЯ-тай хамтран зохиогчийн багийн гишүүдийг ажлаас чөлөөлөхийг хүссэн албан тоот хүргүүлэх, багийн үүлзалт, хэлэлцүүлгийн хөтөлбөр боловсруулах зэрэг бэлтгэл ажлуудыг хийсэн. Багийн үүлзалт, хэлэлцүүлгийн үр дүнд зохиогчид сурах бичгийн агуулга, арга зүйг сургалтын хөтөлбөр, суралцахуйн зорилтод нийцүүлэх, нэгдсэн ойлголттой болж, сурах бичиг, багшийн номын жишиг бүтцийг гаргасан.

2017 оны 05 дугаар сарын 16-ны өдөр суурь, бүрэн дунд боловсролын сурах бичиг зохиох 28 багийн 242 зохиогчид хамрагдсан сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус сургалт, хэлэлцүүлэг нь суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичгийн агуулга, арга зүйн онцлог, сурах бичгийн дизайнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг таниулах, “Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн дэх жендерийн асуудал” сэдвээр илтгэл сонсох, багийн ажлын явцтай танилцах, тулгамдсан асуудлыг хэлэлцэх, арга зүйн зөвлөмжөөр хангах зорилгоор зохион байгуулагдсан байна.

P1.2.A2.T2. Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, сайжруулах

Сурах бичиг, багшийн номын эх зохиох зохиогчийн багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.

“ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ын 2.4-д Боловсролын хүрээлэн нь зохиогчийн багийг агуулга, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана гэж заасан байдаг. Эх зохиох ажлын хүрээнд сурах бичиг, багшийн номын хэвлэлийн хуудасны хэмжээ, техникийн үзүүлэлтийг боловсруулахаас гадна ерөнхий бүтэц гаргах, түүнд тавигдах шаардлага, хянах шалгуур үзүүлэлт бүхий редакторын шалгах хуудсыг боловсруулдаг.

2013-2014 оны хичээлийн жилд бага ангийн сурах бичиг, багшийн номын эхийг лаборатори сургуулиудад туршихтай холбоотойгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бага ангийн сурах бичиг, багшийн номын эхийг дөрвөн улиралд хуваан зохиох, хэвлэх зардлын тооцоо хийх, баталгаажуулах
- Лаборатори сургуулиудад I-V ангид суралцах суралцагч, хичээл заах багшийн тоо гаргах /туршилтын сурах бичиг, багшийн номыг хэвлэх тоо/
- Улирал бүрийн туршилтын эхийг сургуулиудад өгөх эсэхэд дүгнэлт гаргах мэргэжлийн үнэлгээний баг байгуулах, ажиллуулах
- Туршилтын хувилбарын талаар багш, суралцагч, эцэг эхээс санал авах асуулга боловсруулах
- Улирал бүрийн туршилтын эхийг хэвлэх хэвлэлийн газрыг тодруулах, гэрээ байгуулах, хэвлүүлэх, түгээх

I-V ангийн 32 нэрийн сурах бичиг, 38 нэрийн багшийн номын эхийг дөрвөн улиралд хуваан зохиож, лаборатори 40 сургуульд турших, туршилтын дүнд сайжруулах үйл ажиллагааг төлөвлөсний дагуу техникийн тодорхойлолтод заасан хэвлэлийн хуудсаар судлагдахуун бүрийн сурах бичиг, багшийн номын нийт нүүрний хэмжээг тооцоолсон. Улирал бүр судлах цагийг баримжаалан 4 хувааж, нэг улиралд судлах туршилтын хувилбарын нүүрний тоо, хэмжээг гаргасан. Бага ангийн сурах бичиг, багшийн номуудаас доод тал нь 8, дээд тал нь 18 хэвлэлийн хуудастай. Үүнийг хувааж, улиралд гарсан туршилтын хувилбар нь судлагдахунаас хамаарч 20-45 нүүртэй байв. Урьдчилан төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу улирал бүрийн туршилтын хувилбарыг зохиож, хэвлэлийн эхийг бэлтгэсэн. Туршилтын сурах бичиг, багшийн номын эх бэлтгэлийг зохиогчид өөрсдөө хариуцаж ажилласан. Туршилтын хувилбарын эх бэлтгэлийг зохиогчид хариуцаж ажиллаж байсан тул тэдэнд эх зохиохоос гадна эх бэлтгэгч хайх, хамтарч ажиллах зэрэг ажлуудыг давхар гүйцэтгэж байв. Ялангуяа бага ангийн сурах бичиг зураг, дүрслэл ихтэй тул эх бэлтгэгчээс гадна зураач давхар ажиллах шаардлага гарч байв.

Туршилтын хувилбарын эхийг СБСОБ-д хүлээлгэж өгөхөд БХ-гийн захирлын 2013 оны 13 тоот тушаалаар батлагдсан мэргэжлийн үнэлгээний багийн гишүүд (23 гишүүн) уншиж, сайжруулах саналын хамт туршилтад өгөх боломжтой эсэхэд дүгнэлт өгч ажилласан. Саналын дагуу эх зохиолыг сайжруулж, хэвлэлд өгсөн. Туршилтын хувилбарыг хэвлэх хэвлэлийн газраас үнийн санал авах, хамгийн бага үнийг санал болгосон хэвлэлийн газартай гэрээ байгуулах, эхийг хэвлүүлэх, түгээх ажлыг удирдан зохион байгуулсан. Туршилтын хувилбарын талаар багш, суралцагч, эцэг эхээс санал авах асуулгыг арын нүүрт хэвлэсэн.

Бага ангийн сурах бичиг, багшийн номын эх зохиох, турших, туршилтын дүнд сайжруулсан хугацааг хүснэгт 1.2.14-д үзүүлээ.

Хүснэгт 1.2.14. Сурах бичиг, багшийн номыг туршиж, сайжруулсан хугацаа

Хийсэн ажил	2013								2014						
	VII	VIII	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI	VII	VIII	
Туршилтын хувилбарын эх зохиох, эх бэлтгэх, дүгнэлт өгөх	I		II		III										
Туршилтын хувилбарыг хэвлэх, түгээх		I		II		III				IV					
Туршилтын эхийг турших			I		II			III			IV				
Туршилтын эхийг нэгтгэх, сайжруулах, хянах															
Нэгтгэсэн эхийг бэлтгэх															
Хэвлэх, түгээх															

Бага ангийн сурах бичиг, багшийн номын зохиогчдын 34.3 хувийг их, дээд сургуулийн багш, 28.3 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш, 28.3 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, мэргэжилтэн, 9 хувийг бусад төрийн бүс байгууллагын төлөөлөл эзэлж байна.

Нэгээс илүү тооны бага ангийн сурах бичиг, багшийн номд ажилласан зохиогчдын тоог хүснэгт 1.2.15-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.15. Бага ангийн сурах бичиг, багшийн номын зохиогчийн тоо

№	Сурах бичиг/ багшийн ном	Тоо	х.х	Зохиогч	1 ба түүнээс дээш тооны номд ажилласан зохиогчийн эзлэх хувь				
					5	4	3	2	1
1	Монгол хэл I-V	5/5	82/82	20	5%/7%	1%/1%	16%/15%	23%/22%	55%/55%
2	Математик I-V	5/5	80/80	14					
3	Хүн ба орчин I-III	3/3	24/24	12					
4	Хүн ба байгаль IV-V	2/2	18/18	11					
5	Дүрслэх урлаг I-V	5/5	40/40	12					
6	Иргэний боловсрол I-V	5/5	30/30	11					
7	Хүн ба нийгэм IV-V	2/2	14/14	6					
8	Хөгжим I-V	5/5	40/40	9					
9	Биеийн тамир	0/5	0/30	8					
10	Англи хэл	0/1	0/12	4					
	Нийт	32/38	328/370	95/107	Нэг сурах бичиг, багшийн номд дунджаар 5-6 хүн ажилласан.				

Хүснэгтээс харахад бага ангийн нэг сурах бичигт 5-6 хүн зохиогчоор ажилласан, нийт 95 зохиогчдын 45 хувь нь нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан байна. Эдгээр зохиогчийн 52 нь буюу 54.7 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон байна. Өөрөөр хэлбэл нийт зохиогчдын хоёр хүн тутмын нэг нь сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулахад давхар ажиллажээ.

БШУ-ы сайдын 2014 оны А/306 дугаар тушаалаар суурь боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, түрших ажлыг Боловсролын хүрээлэнгээр гүйцэтгүүлэхээр баталсны дагуу өмнө ажиллаж байсан СБСО-ны багийн үйл ажиллагааг Боловсролын хүрээлэнгийн СБСОСС (Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор) гүйцэтгэх болсон. ТНБД-ын баталсан 2014 оны “Суурь боловсролын сургалтын хөтөлбөр шинэчлэх ажлын ерөнхий төлөвлөгөө, удирдамж”-д сурах бичиг, сургалтын орчны баг суурь боловсролын сурах бичиг, багшийн ном зохиох, сургалтын орчны шаардлага боловсруулах ажлыг хийхээр заасан байна. Өмнөх жилийн бага ангийн сурах бичгийн хувьд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас ялгаатай нь суурь боловсролын сурах бичгийг улирлаар түршихгүйгээр шийдвэрлэсэн байна.

Харин эх зохиох багийн бүрэлдэхүүнийг 2015 оны 01 дүгээр сард баталсан боловч төсөв, зардал батлагдаагүй шалтгаанаар багуудтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулаагүй. Энэ нь зохиогчдод тодорхойгүй байдал үүсгэж эх зохиох ажлыг удаашруулж байлаа. 2015 оны 06 дугаар сард ТНБД-ын А/209 тоот тушаалаар дээрх сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянахад шаардагдах зардлын төсвийг баталсан бөгөөд улмаар зохиогч, редакторын багтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан.

Хичээлийн жил эхлэхэд сурах бичиг, багшийн номыг хэвлэсэн байхын тулд богино хугацааны төлөвлөлт хийж ажиллах шаардлагатай болсон. Уг төлөвлөлтийг хүснэгт 1.2.16-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.16. Эх бэлтгэх, хянах, хүлээлгэж өгөх ажлын төлөвлөгөө

№	Сар	VI		VII				VIII	
	Долоо хоног	3	4	1	2	3	4	1	
1	Хийх ажил	Зохиогчийн эхийг хүлээн авах		VI.15-VI.25					
2		Агуулгын редактор хянах			VI.22-VI.25		VII.16-VII.22		VII.25-VIII.01
3		Техникийн редактор хянах							
4		Зохиогчийн эхийг сайжруулах			VI.25-VII.01			VII.26-VIII.01	
5		Хэвлэлийн эх бэлтгэх				VII.01-VIII.01			
6		Хэвлэлтэд хүлээлгэж өгөх		VII.30-VIII.05					

Сурах бичгийн зохиогчийн эхийг агуулгын редактороор хянуулах, засварлахад хагас сар, эх бэлтгэхийн зэрэгцээ агуулга ба техникийн редактораар тус бүр 2 удаа хянуулахад 1 сар, редакторуудын уншилтад 5 хоног төлөвлөсөн байна. Гэвч бодит байдалд энэ төлөвлөгөөний дагуу ажиллаж хүндрэл үүссэн. Сурах бичиг 8 сарын 25-нд хэвлэлтэнд, багшийн ном 10 сард тус тус хэвлэлтэд шилжиж дууссан.

VI-IX ангийн сурах бичиг, багшийн номын зохиогчдын 48.3 хувийг их, дээд сургуулийн багш, 25.4 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш, 18 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, мэргэжилтэн, 8.3 хувийг бусад төрийн бус байгууллагын төлөөлөл бүрдүүлсэн байна.

Нэгээс илүү тооны дунд ангийн сурах бичиг, багшийн номд ажилласан зохиогчдын тоог хүснэгт 1.2.17-д үзүүлэв

Хүснэгт 1.2.17. Дунд ангийн сурах бичиг, багшийн номын зохиогчийн тоо

№	Сурах бичиг/ багшийн ном	Тоо	х.х	Зохиогч	1 ба түүнээс дээш тооны номд ажилласан зохиогчийн эзлэх хувь			
					4	3	2	1
1	Математик VI-IX	4/4	66/66	15/15	12%/13%	4%/12%	16%/24%	68%/51%
2	Мэдээллийн технологи VI-IX	4/4	24/28	12/10				
3	Түүх VI-IX	4/4	47/32	19/18				
4	Байгалийн ухаан VI	1/1	15/15	14/12				
5	Биологи VII-IX	2/3	28/35	16/15				
6	Хими VII-IX	3/3	36/35	10/7				
7	Физик VII-IX	2/3	28/33	12/10				
8	Англи хэл VI-IX	4/4	60/60	9/8				
9	Дизайн технологи VI-IX	2/3	16/28	14/12				
10	Орос хэл VII-IX	2/3	30/40	7/7				
11	Дүрслэх урлаг VI-VIII	1/2	12/24	9/9				
12	Монгол хэл, уран зохиол VI-IX	0/4	0/64	0/15				
13	Газарзүй VII-IX	0/3	0/24	0/6				
14	Хөгжим VI-IX	0/2	0/24	0/6				
15	Иргэний боловсрол VI-IX	0/2	0/16	0/9				
16	Үндэсний бичиг VI-IX	0/1	0/16	0/4				
17	Биеийн тамир VI-IX	0/1	0/12	0/8				
18	Нийгмийн ухаан VIII-IX	0/1	0/14	0/8				
		29/48	362/566	137/179	Нэг сурах бичигт дунджаар 7-8 хүн, багшийн номд 6-7 хүн ажилласан.			

Хүснэгтээс харахад дунд ангийн нэг сурах бичигт 7-8, багшийн номд 6-7 хүн зохиогчоор ажилласан байна. Нийт 137 зохиогчдын 32 хувь нь нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан байна. Эдгээр зохиогчийн 75 нь буюу 54.7 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон байна. Өөрөөр хэлбэл бага ангийнхтай адил нийт зохиогчдын хоёр хүн тутмын нэг нь сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулахад давхар ажилласан байна. Энэ нь сургалтын хөтөлбөр боловсруулсан багаас сурах бичиг зохиох багт заавал ажиллуулах бодлого зарчим баримталсан байна. Үүний учир нь сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, агуулга, арга зүй, үнэлгээ, суралцахуйн зорилтын үзэл санааг сурах бичигтэй нэгдмэл байхад онцгойлон анхаарсан байна.

2017-2018 оны хичээлийн жилд шинээр зохиож, хэрэглэх сурах бичиг, багшийн номын зохиогчдын 56.7 хувийг их, дээд сургуулийн багш, 24.4 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш, 13.3 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, мэргэжилтэн, 5.6 хувийг бусад төрийн бус байгууллагын төлөөлөл бүрдүүлсэн байна. Нэгээс илүү тооны сурах бичиг, багшийн номд ажилласан зохиогчдын тоог хүснэгт 1.2.18-д үзүүлэв

Хүснэгт 1.2.18. Сурах бичиг, багшийн номын зохиогчийн тоо

№	Сурах бичгийн нэр	Тоо	х.х	Зохиогч	1 ба түүнээс дээш тооны номд ажилласан зохиогчийн эзлэх хувь		
					3	2	1
1	Математик X-XI	2	36	14	3%	40%	57%
2	Монгол хэл VIII-XI	4	42	15			
3	Уран зохиол VIII-XI	4	36	12			
4	Үндэсний бичиг VIII-XI	3	36	8			
5	Монголын түүх X-XI	2	12	9			
6	Нийгэм судлал VII-X	4	32	21			
7	Биологи VII, X-XI	3	36	19			
8	Хими X-XI	2	24	7			
9	Физик VII, X-XI	3	36	18			
10	Англи хэл X-XI	2	36	12			
11	Дизайн технологи VI-VII	2	24	12			
12	Орос хэл VII, X-XI	3	48	5			
13	Дүрслэх урлаг VI-VII	1	12	6			
14	Хөгжим VI-IX	2	24	9			
15	Газарзүй VIII-XI	4	40	17			
16	Бизнес судлал XI	1	6	7			
		42	480	191	Нэг сурах бичигт 7-8 хүн ажилласан.		

Хүснэгтээс харахад нэг сурах бичигт 7-8 хүн зохиогчоор ажилласан байна. Нийт 191 зохиогчдын 43 хувь нь нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан. Эдгээр зохиогчийн 94 нь буюу 49.2 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон. Өөрөөр хэлбэл өмнөх жилүүдийнхтэй адил нийт зохиогчдын хоёр хүн тутмын нэг нь сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулахад давхар ажилласан.

Мөн сонгон судлах хичээлийн X-XII ангийн 14 нэрийн багшийн номын эх боловсруулах ажил хамт хийгдсэн. Сурах бичгийн эх зохиохын зэрэгцээ багшийн номын боловсруулалтад давхар ажилласан хүмүүсийн эзлэх хувийг хүснэгт 1.2.18-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.19

№	Багшийн номын нэр	Тоо	х.х	Зохиогч	Сурах бичгийн зохиогчоор давхар ажилласан		
					3 сурах бичиг	2 сурах бичиг	1 сурах бичиг
1	Математик X-XII	1	20	14		100%	
2	Мэдээллийн технологи X-XII	1	20	7			
3	Монгол хэл, бичиг X-XII	1	20	9		22.2%	77.8%
4	Уран зохиол X-XII	1	20	7		28.6%	42.9%
5	Монголын түүх X-XII	1	20	9		100%	
6	Нийгэм судлал X-XII	1	20	7			57.1%
7	Биологи X-XII	1	20	15		26.7%	66.7%
8	Хими X-XII	1	20	7		100%	
9	Физик X-XII	1	20	10	10%	40%	40%
10	Англи хэл X-XII	1	20	12		100%	
11	Дизайн технологи X-XII	1	20	11		18.2%	27.3%
12	Орос хэл X-XII	1	20	5	80%	20%	
13	Газарзүй X-XII	1	20	11		54.5%	45.5%
14	Бизнес судлал XI	1	15	7			100%
		14	275	131	6.4%	43.6%	32.7%

Багшийн ном боловсруулах багийн бүрэлдэхүүний 82.7% нь сурах бичгийн эх зохиох ажлыг давхар гүйцэтгэсэн байна. 2018-2019 оны хичээлийн жилд шинээр хэрэглэх тодорхой нэр бүхий 20 сурах бичгийг зохиосноор ЕБС-ийн I-XII ангийн бүх судлагдахууны сурах бичгийг шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрийн дагуу шинэчлэх ажил дуусгавар болох юм. Энэ удаагийн сурах бичиг, багшийн номын зохиогчдын 57 хувийг их, дээд сургуулийн багш, 29.6 хувийг ерөнхий боловсролын сургуулийн багш, 10.4 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, арга зүйч, мэргэжилтэн, 3 хувийг бусад төрийн бус байгууллагын төлөөлөл бүрдүүлсэн байна.

Нэгээс илүү тооны сурах бичиг, багшийн номд ажилласан зохиогчдын тоог хүснэгт 1.2.19-д үзүүлэв

Хүснэгт 1.2.20. Сурах бичиг, багшийн номын зохиогчийн тоо

№	Сурах бичгийн нэр	Тоо	х.х	Зохиогч	1 ба түүнээс дээш тооны номд ажилласан зохиогчийн эзлэх хувь		
					3	2	1
1	Монгол хэл VI-VII, XII	3	40	15	7%	10%	83%
2	Уран зохиол VI-VII, XII	3	32	15			
3	Үндэсний бичиг VI-VII, XII	3	30	15			
4	Математик XII	1	20	9			
5	Мэдээллийн технологи X-XII	3	36	7			
6	Газарзүй VII	1	8	5			
7	Нийгэм судлал XI	1	16	11			
8	Англи хэл XII	1	20	5			
9	Орос хэл XII	1	20	5			
10	Дизайн технологи X-XII	3	48	23			
		20	270	110	Нэг сурах бичигт 6-7 хүн ажилласан.		

Хүснэгтээс харахад нэг сурах бичигт 6-7 хүн зохиогчоор ажилласан байна. Нийт 110 зохиогчдын 17 хувь нь нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан байна. Эдгээр зохиогчийн 43 нь буюу 39 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулахад оролцсон байна. Өөрөөр хэлбэл нийт зохиогчдын гурван хүн тутмын нэг нь сурах бичиг, сургалтын хөтөлбөр боловсруулахад давхар ажилласан байна. Үүнийг өмнөх жилүүдийнхтэй харьцуулбал сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулахад давхар ажилласан хүний тоо буурсан байна.

Сонгон гүнзгийрүүлж судлах хичээлийн 14 нэрийн багшийн номын эх зохиох, хянах зардлыг 2017 оны төсөвт, эх бэлтгэх, хэвлэх зардал 2018 оны төсөвт тус тус хуваагдаж туссан тул эдгээр багшийн номын эх бэлтгэх, хэвлэх ажил нь 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх сурах бичгийн эх зохиох ажилтай хамт хийгдэж байна. Багшийн номын эх боловсруулах багийн бүрэлдэхүүний 40% нь сурах бичгийн эх зохиох ажлыг давхар гүйцэтгэж байна.

Эдгээр сурах бичиг, багшийн номоос гадна тусгай хэрэгцээт боловсролын, үндэстний цөөнхөд зориулсан сурах бичиг, багшийн номыг жил бүр тодорхой тоогоор зохиож байна. Одоогийн байдлаар I-V ангийн бүх сурах бичгийг казах хэл рүү хөрвүүлэн хэрэглэж байна. Харин VI-IX ангийн "Казах хэл, уран зохиол" 3 нэрийн сурах бичиг, тусгай хэрэгцээт боловсролын бага ангийн 4 төрлийн 11 нэрийн сурах бичиг, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдтэй ажиллах багшийн номыг сургалтад хэрэглэж байна. 2018-2019 оны хичээлийн жилд нэмээд 3 нэрийн сурах бичиг (казах, тусгай), 1 нэрийн багшийн ном (тусгай)-ыг хэрэглэж эхлэхээр зохиож байна. Тусгай сургуулийн бага ангийн суралцагчдын сурах бичиг, багшийн номыг хүснэгт 1.2.20-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.21

№	Сурах бичгийн нэр	Анги				
		I	II	III	IV	V
1	Монгол хэл (оюуны бэрхшээлтэй суралцагчдын)	+	+	+	+	+
2	Монгол хэл (сонсголын бэрхшээлтэй суралцагчдын)				+	+
3	Математик (оюуны бэрхшээлтэй суралцагчдын)	+	+	+	+	+
4	Дүрслэх урлаг	+				
5	Нийгэм ахуйн баримжаа (Багшийн ном)	+				
6	Хэл засал (Багшийн ном)	+				



Давуу тал

- Бага ангийн сурах бичиг, багшийн номыг түршсанаар зохиох, сайжруулах шатанд хэрэглэгчдийг оролцуулж, тэдний үнэлгээ, дүгнэлт саналыг тусган улмаар сурах бичгийн чанарыг сайжруулах боломжтой болсон.
- Сурах бичгийг сайжруулахын хамт сурах бичиг, багшийн номыг улирлаар хэвлэн практикт хэрэглэж сайжруулах арга зүй, менежментийг давхар түршсан.
- Лаборатори сургууль дээр сурах бичиг, багшийн номыг түршиж, сайжруулснаар эх зохиох хугацааг уртасч чанартай сурах бичиг хэрэглэгчдийн гарт очих боломжтой болсон.
- Тусгай хэрэгцээт боловсролд шаардлагатай сурах бичиг, багшийн номыг хэвлэж хэрэглэж байна.
- Үндэстний цөөнхөд зориулсан бага ангийн бүх сурах бичгийг казах хэл рүү орчуулан хэвлэснээр сурагчдад өөрсдийн эх хэлээр бага боловсрол эзэмших боломжтой болсон. Мөн дунд ангийн казах хэл, уран зохиолын сурах бичигт Монголын яруу найраг, утга зохиолын дээжээс түүвэрлэн оруулж боловсруулсан бөгөөд энэ нь сурагчдад өөрсдийн эх хэлээр Монгол үндэстний соёлын өв, уран зохиолыг судлах боломж олгож байна.



Сул тал

- Түршилтын сурах бичиг хэвлэх зардлыг улсын төсөв болон тодотголд батлуулах үйл явц, гүйцэтгэгч шалгаруулах гэрээ хийх зэргээс хамаарч санхүүжилт хүлээгдэж хэвлэлийн компаниудтай хамтарч ажиллахад хүндрэл үүсч байв. Жишээлбэл: I улирлыг сурах бичгийг хэвлэсэн хэвлэлийн компанийн санхүүжилт хийгдээгүйн улмаас II улирлын сурах бичиг хэвлэх үйл явц оройтож II улирлын хичээл эхэлснээс хойш 7-10 хоногийн дараа багш, сурагчдын гарт хүргэгдсэн.



Санал

- Сурах бичгийн эх зохиох ажлын зохицуулалтыг дүрэм журмын баримт бичигт хугацаа болон хариуцагчийн талаар зохицуулалтыг тусгаж өгөх шаардлагатай. Жишээ нь: Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг баталгаажуулсны дараа шинээр зохиох сурах бичгийн жагсаалт батлах, жагсаалт батлагдсанаас хойш 1-2 жилийн дараа эх зохиох ажил эхлэх, эхийг 2-оос доошгүй жилийн хугацаагаар зохиох, хянах зэрэг зохицуулалт хийх гэх мэт. Судлагдахууны сурах бичиг, багшийн номыг шинээр зохиох, хэвлэхэд шаардлагатай хугацаа, санхүүгийн эх үүсвэрийг харгалзсан урт хугацааны болон дунд хугацааны бодитой төлөвлөлт хийх шаардлагатай байна.
- Сурах бичгийн агуулга, дизайн, арга зүйд дүгнэлт хийх мэргэжлийн үнэлгээний багийн зардлыг төсөвт төлөвлөж байх.
- 2013 оноос хойш өнөөг хүртэл сурах бичиг, багшийн номын эх зохиоход зарцуулсан хугацааг авч үзвэл дунджаар 5-6 сар байна. Хүний нөөцийн ажиллах чадвар, санхүү хөрөнгийн боломж зэргийг харгалзан үзэж, тухайн жилд шинээр зохиох сурах бичиг, багшийн номын тоог бодитойгоор гаргах зайлшгүй шаардлага байна.
- Сурах бичгийн эхийг шинээр зохиоход шинэ хөтөлбөрийн үзэл санааг хэрхэн тусгах, сурах бичгийн эх зохиох болон хэвлэлтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох шаардлагатай. Мөн сурах бичиг судлалыг хөгжүүлэхэд бодит төлөвлөлт гаргах.

Р1.2.А3. Сурах бичиг, багшийн номын эх бэлтгэх, хянах, хэвлэх

1470 хэвлэлийн хуудас бүхий 125 нэрийн сурах бичиг, 1211 хэвлэлийн хуудас бүхий 100 нэрийн багшийн номын эхийг зохиогчийн баг, хэвлэлийн газрын менежер, эх бэлтгэгч, дизайнертай хамтран бэлтгэж, хэвлэлд хүлээлгэж өгөв.

Р1.2.А3.Т1. Сурах бичиг, багшийн номын эх бэлтгэх, хянах, хэвлэх, түгээх

Бага ангийн түршилтын сурах бичиг, багшийн номын эхийг 4 улирлаар хуваан хянах, хэвлэх, лаборатори сургуулиудад түгээх, түршилтын үр дүнг зохиогчдод уламжлах ажлыг гардан хийсэн. Бусад сурах бичиг, багшийн

номын хувьд эхийг туршихгүйгээр хянах, бэлтгэх, хэвлэлд хүлээлгэж өгөх ажлыг зохион байгуулав.

БХ-гийн захирлын 2013 оны 34 тоот тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан БХ болон СБСО-ны хэрэгжилтийн багийн гишүүдээс бүрдсэн үнийн хороо бага ангийн сурах бичиг, багшийн номын туршилтын хувилбарыг хэвлэх нэр бүхий 6 хэвлэлийн газрыг харьцуулсан тендерийн аргаар шалгаруулав. I улирлын туршилтын сурах бичгийг түгээх зардал төсөвт батлагдаагүй тул хэрэгжилтийн баг, лаборатори сургуулиуд өөрсдийн нөөц боломжийг дайчлан хүргэлт хийгдсэн болно. II улирлаас түгээх зардал төсөвт батлагдсан. 2013 оны 7 дугаар сараас 2014 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаанд сурах бичиг, багшийн номын туршилтын хувилбарыг зохиох, эх бэлтгэх, хэвлэх, түгээх ажил хийгдсэн.

Хэрэгжилтийн багийн гишүүд улирал бүрийн туршилтын сурах бичиг, багшийн номын агуулга, арга зүй, үнэлгээ, асуулт, дасгал даалгавар зэрэг нь суралцагчдын нас сэтгэхүйн онцлогт хэрхэн нийцэж байгааг "тохирц"-ын баримтын судалгаа, мэдээллийг зохиогчдын багт уламжилж байсан. Туршсан сурах бичиг, багшийн номын зохиогчийн эхийг засан сайжруулах зорилгоор улирал бүрээр хийгдсэн сурах бичиг, багшийн номыг нэгтгэх, сургалтын хөтөлбөр сурах бичиг багшийн номын уялдаа холбоог сайжруулах шаардлага гарч ирсэн бөгөөд зохиогчдын багийн гишүүдийг хамруулсан 4 өдрийн уулзалт, workshop зохион байгуулсан. Энэ хүрээнд сургалтын хөтөлбөр, сурах бичгийн уялдаа холбоог анхаарч орхигдсон суралцахуйн зорилт, чадварыг тодорхойлж тусгах, тохирцын мэдээнд анализ хийж саналыг сурах бичигт тусгах ажил хийсэн.

Сурах бичиг, багшийн номын анги ба сэдэв хоорондын агуулгын залгамж холбоо, сургалтын хөтөлбөртэй нийцтэй байдал, арга зүйн дасгал даалгаврын боловсруулалтыг хянах агуулга, зураг дүрслэл, зохиомж, хэл найруулга, зөв бичих дүрмийн алдаагүй эсэхийг хянах техникийн редакторын шалгах хуудсыг боловсруулсан.

Дээр дурдсан журмын 2.7-д сурах бичгийн эхийг MNS 5418:2008 "Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага" стандарт болон сургалтын хөтөлбөрт нийцүүлэн хянах ажлын хэсгийг байгуулна гэж заасны дагуу Боловсролын хүрээлэнгийн захирлын 2014 оны 25 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар эх хянах редакторын багийн бүрэлдэхүүнийг баталсан бөгөөд тэд сурах бичгийн зохиогчийн эхийг нэг удаа, хэвлэлийн эхийг 2-3 удаа уншиж, шалгуур хуудасны дагуу санал, зөвлөмжийг өгч ажилласан. Мөн БХ-гийн захирлын 2014 оны 31 тоот тушаалаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх багийг томилж, бага ангийн сурах бичиг, багшийн номыг уншиж, сайжруулах саналыг өгсөн. БШУЯ-наас сурах бичигт олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор хөндлөнгийн үнэлгээний баг байгуулж, ажилласан. БШУ-ы сайдын тушаалаар баталгаажуулсан уг баг нь сурах бичгийг агуулга, арга зүй, техникийн гэсэн 3 чиглэлээр уншиж, санал зөвлөмжийг өгсөн. Дээрх багуудын өгсөн санал, зөвлөмжийг тусган сурах бичиг, багшийн номын эхийг сайжруулсан. Сурах бичиг, багшийн номын эх хянах багийн ажлын зардлын тооцоог хийж, БШУЯ-д хүргүүлэн, зардлыг батлуулсан. Дараах хүснэгтэд бага ангийн сурах бичиг, багшийн номд ажилласан редактор ба мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн хүмүүсийн тоог хүснэгт 1.2.21-д үзүүлэв.

Хүснэгт 1.2.22

№	Сурах бичгийн нэр	Тоо	Редактор	МА33	Багшийн номын нэр	Тоо	Редактор	МА33	Нийт
1	Монгол хэл I-V	5	10	5	Монгол хэл I-V	5	10	5	12
2	Математик I-V	5	10	5	Математик I-V	5	10	5	14
3	Хүн ба орчин I-III	3	7	3	Хүн ба орчин I-III	3	7	3	8
4	Хүн ба байгаль IV-V	2	5	2	Хүн ба байгаль IV-V	2	5	2	6
5	Хүн ба нийгэм IV-V	2	4	2	Хүн ба нийгэм IV-V	2	4	2	5
6	Хөгжим I-V	5	10	5	Хөгжим I-V	5	10	5	12
7	Дүрслэх урлаг I-V	5	10	5	Дүрслэх урлаг I-V	5	10	5	11
8	Иргэний боловсрол I-V	5	10	5	Иргэний боловсрол I-V	5	10	5	10
9					Биеийн тамир I-V	5	10	5	11
10					Англи хэл V	1	3	1	3
	Нийт	32	66	32	Нийт	38	79	38	92

Хүснэгтээс харвал нэг сурах бичиг, багшийн номд 3, нийт давхардсан тоогоор 215 редактор, МА33 ажилласан байна.

БШУЯ-наас сурах бичгийн эх бэлтгэх хэвлэлийн газрыг сонгон шалгаруулснаар сурах бичгийн эх бэлтгэгч тодорхой болсон бөгөөд зохиогчдын баг, редактор, эх бэлтгэгч, дизайнеруудын хамтарсан сурах бичиг, багшийн номын бүтэц, дизайныг жигдлэх, сурах бичгийн форматад нийцүүлэх, тэмдэг тэмдэглэгээг жигдлэх, өнгө загвараа сайжруулах зорилготой уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

Зохиогч болон СБСО-ны хэрэгжилтийн багийнхан хэвлэлийн газрын менежер, эх бэлтгэгчтэй хамтран сурах бичиг,

багшийн номын эхийг бэлтгэсэн. Эцэст нь 2014 оны 08 дугаар сард бага ангийн 10 хичээлийн 698 хэвлэлийн хуудас бүхий 32 нэрийн сурах бичиг, 38 нэрийн багшийн номын хэвлэлийн эхийг БШУЯ-д хүлээлгэн өгсөн.

Суурь боловсролын 29 нэрийн сурах бичиг, 48 багшийн номын эхийг хянах агуулга болон техникийн редакторын багийн бүрэлдэхүүнийг Боловсролын хүрээлэнгийн захирлын 2015 оны 06 дугаар сарын 15-ны 17 тоот тушаалаар баталсан. Хүснэгт 1.2.22-д сурах бичиг, багшийн номд ажилласан редакторын тоог үзүүлэв.

Хүснэгт 1.2.23

№	Сурах бичгийн нэр	Тоо	Редактор	Багшийн номын нэр	Тоо	Редактор	Нийт
1	Математик VI-IX	4	8	Математик VI-IX	4	8	7
2	Мэдээллийн технологи VI-IX	4	8	Мэдээллийн технологи VI-IX	4	8	8
3	Түүх VI-IX	4	8	Түүх VI-IX	4	8	7
4	Байгалийн ухаан VI	1	2	Байгалийн ухаан VI	1	2	3
5	Биологи VIII-IX	2	4	Биологи VII-IX	3	6	4
6	Хими VII-IX	3	6	Хими VII-IX	3	6	6
7	Физик VIII-IX	2	4	Физик VIII-IX	3	6	5
8	Англи хэл VI-IX	4	8	Англи хэл VI-IX	4	8	5
9	Дизайн технологи VIII-IX	2	4	Дизайн технологи VI-IX	3	6	5
10	Орос хэл VIII-IX	2	4	Орос хэл VII-IX	3	6	5
11	Дүрслэх урлаг VIII	1	2	Дүрслэх урлаг VI-VIII	2	4	4
12				Монгол хэл, уран зохиол VI-IX	4	8	6
13				Газарзүй VII-IX	3	6	4
14				Хөгжим VI-IX	2	4	2
15				Иргэний боловсрол VI-IX	2	4	4
16				Үндэсний бичиг VI-IX	1	2	2
17				Биеийн тамир VI-IX	1	2	2
18				Нийгмийн ухаан VIII-IX	1	2	2
	Нийт	29	58	Нийт	48	96	81

Энд давхардсан тоогоор 154 редактор сурах бичиг, багшийн номын эхийг хянасан бөгөөд санхүү, хөрөнгө, цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас үүдэн хөндлөнгийн үнэлгээний баг, мэргэжил арга зүйн зөвлөлийн баг ажиллаагүй.

Суурь боловсролын 29 нэрийн сурах бичиг, 48 багшийн номыг нийт 193 гишүүнтэй 19 зохиогчийн баг зохион, хэвлэлийн компани эхийг бэлтгэж хэвлэхэд бэлтгэсэн. Эх бэлтгэлийг 07 дугаар сарын 01-ээс 08 дугаар сарын 01-нд хийхээр, 08 дугаар сарын 05 гэхэд хэвлэлтэнд хүлээлгэж өгсөн байхаар төлөвлөж ажилласан боловч хэвлэх хугацаа сурах бичиг 08 дугаар сарын 30, багшийн ном 10 дугаар сарын 15 хүртэл хойшлогдсон байна.

2017-2018 оны хичээлийн жилд шинээр хэрэглэх 42 нэрийн сурах бичиг, 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэглэх 14 нэрийн багшийн номын эхийг хянах агуулга болон техникийн редакторын багийн бүрэлдэхүүнийг Боловсролын хүрээлэнгийн захирлын 2017 оны 05 дугаар сарын 17-ны А/12 тоот тушаалаар баталсан. Хүснэгт 1.2.23-д сурах бичиг, багшийн номд ажилласан редакторын тоог үзүүлэв.

Хүснэгт 1.2.24

№	Сурах бичгийн нэр	Тоо	Редактор	Багшийн номын нэр	Тоо	Редактор	Нийт
1	Математик X-XI	2	4	Математик X-XII	1	2	3
2	Монгол хэл VIII-XI	4	8	Монгол хэл, бичиг X-XII	1	2	8
3	Уран зохиол VIII-XI	4	8	Уран зохиол X-XII	1	2	5
4	Үндэсний бичиг VIII-XI	3	6				
5	Монголын түүх X-XI	2	4	Монголын түүх X-XII	1	2	4
6	Нийгэм судлал VII-X	4	8	Нийгэм судлал X-XII	1	2	9
7	Биологи VII, X-XI	3	6	Биологи X-XII	1	2	4
8	Хими X-XI	2	4	Хими X-XII	1	2	2
9	Физик VII, X-XI	3	6	Физик X-XII	1	2	4
10	Англи хэл X-XI	2	4	Англи хэл X-XII	1	2	5
11	Дизайн технологи VI-VII	2	4	Дизайн технологи X-XII	1	2	6
12	Орос хэл VII, X-XI	3	6	Орос хэл X-XII	1	2	3
13	Дүрслэх урлаг VI-VII	1	2				
14	Хөгжим VI-IX	2	4				
15	Газарзүй VIII-XI	4	8	Газарзүй X-XII	1	2	4
16	Бизнес судлал XI	1	2	Бизнес судлал XI	1	2	2
17				Мэдээллийн технологи X-XII	1	2	1
	Нийт	42	84	Нийт	14	28	60

2018-2019 оны хичээлийн жилд шинээр хэрэглэх 20 нэрийн сурах бичгийн эхийг хянахаар 40 гишүүнтэй агуулга болон техникийн редакторын баг ажиллаж байна. Боловсролын хүрээлэн БСШУСЯ-д сурах бичиг, багшийн номын эхийг хүлээлгэж өгөхөд яам түүнийг хэвлэх хэвлэлийн газрыг шалгаруулах, хамтран ажиллах гэрээ байгуулах, хэвлэлийн явцыг хянах, түгээх хуваарь гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулдаг. Хэвлэлийн газрууд сурах бичиг, багшийн номыг хэвлэж, яамнаас өгсөн хуваарийн дагуу нийслэл болон орон нутагт түгээдэг.



Сүл тал

- БСШУСЯ-тай эх бэлтгэлийн гэрээ байгуулсан хэвлэлийн газартай зохиогчийн баг хамтран сурах бичиг, багшийн номын эхийг бэлтгэдэг. Хэвлэлийн эхийг бэлтгэх явцад тулгардаг асуудлын нэг бол эх бэлтгэгч нарын ажлын үр чадвар, гүйцэтгэлийн чанар харилцан адилгүй байсаар байна. Математик, физик, химийн сурах бичиг нь шинжлэх ухааны томъёо, нарийн хэмжээс бүхий график диаграммтай, үндэсний бичгийн сурах бичиг нь тусгай font шаарддаг, газарзүйн сурах бичиг нь нарийвчилсан масштаб бүхий газрын зурагтай, хөгжмийн сурах бичиг тусгай ноотны программ дээр ажиллаж сурах бичгийн эхийг бэлтгэдэг онцлогтой учраас эх бэлтгэгчээс мэргэжлийн өндөр үр чадвар, хугацаа их шаарддаг.



Санал

- Сурах бичгийн зохиогчийн эх шаардлага хангасан, түүнийг хянан баталгаажуулсан, хэвлэлтэнд ямар нэгэн алдаагүй эхийг бүрэн шилжүүлэх хүртэлх үе шат, хугацааг бодитой тооцож, төлөвлөлт хийж хэрэгжүүлэх.
- Сурах бичгийн онцлогт тохируулан эх бэлтгэх хугацаа, эх бэлтгэгчийн үр чадварыг сонгон шалгаруулалтын бичиг баримт гэрээнд тусгайлан тодорхой зааж өгөх. Математик, байгалийн шинжлэх ухааны сурах бичгийн эх бэлтгэл тухайн эх бэлтгэгчээс шинжлэх ухааны талаарх мэдлэг шаарддаг хэвлэлийн компаниуд мэргэжлийн зөвлөх авч ажиллуулах талаар гэрээнд заах.
- Сурах бичиг, багшийн номын эх бэлтгэх, хэвлэх бүхий л үе шатанд үүрэг, хариуцлагын тогтолцоо бүрдүүлэх. Эх бэлтгэх, хэвлэх газрыг нэг байгууллага байхаар зохицуулалт хийх. Сурах бичиг, багшийн номыг хэвлэгдсэний дараа техникийн тодорхойлолтын дагуу хэвлэсэн эсэх, түгээлтийн гүйцэтгэлийг хянах зохицуулалт хийх.

P1.2.A4. Сурах бичгийг танилцуулах, хангах, ашиглах

Тухайн хичээлийн жилд шинээр гарч байгаа сурах бичгийг багш нарт зориулсан сургалтаар танилцуулж байсан байна.

P1.2.A4.T1. Сурах бичгийн танилцуулга хийх, хангах, ашиглах

Хичээлийн жилийн эхэнд БСШУСЯ, БХ, БМДИ хамтран аймаг нийслэлийн боловсрол соёлын газрын мэргэжилтэн, багш нарт зохион байгуулдаг сургалтаар тухайн жилд шинээр зохиосон сурах бичиг, багшийн номын агуулга, арга зүй, үнэлгээний онцлог, дасгал даалгаврын тавил зэргийг хэрхэн боловсруулсан, сайжруулсныг танилцуулдаг.

2009 онд Засгийн газрын шийдвэрээр ЕБС-ийн бага ангийн суралцагчдын 100 хувь, дунд ахлах ангийн суралцагчдын 40 хувийг сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичгээр үнэ төлбөргүй хангах ажлыг зохион байгуулж эхэлсэн. Ингэснээр бага ангийн бүх хүүхэд, дунд, ахлах ангийн бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн, 3 буюу түүнээс дээш тооны хүүхэд нь ЕБС-д суралцдаг өрхийн хүүхдийн сурах бичгийг төрөөс үнэ төлбөргүй хангах тогтолцоо бий болсон. Ингэснээр улсын төсвийн хөрөнгөөр бага ангийн бүх суралцагчдад, дунд, ахлах ангийн суралцагчдын 40 хувьд сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичгийг үнэ төлбөргүй хэрэглүүлж, хичээлийн жилийн төгсгөлд хураан авдаг байна. Үлдсэн 60 хувь нь өөрсдөө зах зээлээс сурах бичгээ худалдаж авах зохицуулалт бий.

ЕБС-ийн анги бүрийн бүх хичээлийн сурах бичгийн нийт үнийн дүнг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1.2.25 Сурах бичгийн үнэ

Анги	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Нийт сурах бичгийн тоо	12	15	17	15	15	13	10
Багцын үнэ	32550	36600	39450	36700	45200	44600	28400
Дундаж	37600 төгрөг						

Дунд, ахлах ангийн суралцагч нэг хичээлийн жилд дунджаар 37600 төгрөгөөр бүх сурах бичгээ худалдаж авдаг.

Багш, суралцагчид сурах бичгийг анги танхимд, гэрт хэрхэн ашиглаж буйг, сургалтыг дэмжих хэрэглэгдэхүүний хувьд суралцагчийг сурах үйлд хөтөлж чадаж буй эсэх, сурах бичгийн чанар ямар байгааг судлах хэрэгтэй байна. Жишээ нь: Сурах бичгийн хуудасны тоо, хэмжээг хэвлэлийн хуудсаар тодорхойлдог. Тэгвэл хэдэн хэвлэлийн хуудас сурах бичгийг нэг хичээлийн жилд судлах боломжтойг анги, судлагдахуунаас хамааруулан бодитой тодорхойлох шаардлага бий. 2011 оноос ЕБС-ийн сурагчид хичээлийн жилийн эхэнд шаардлагатай багц сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан түрээсээр авч ашиглаад, хичээлийн жилийн төгсгөлд буцаан хүлээлгэж өгөх түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан хэрэгжиж эхэлсэн нь сурагчдад сурах бичгийг 2 дахин бага үнээр хэрэглэх боломж олгосон. Түрээсийн тогтолцоо нь сурах бичгийн хүртээмжийг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд 45 хүртэлх хувь нэмэгдүүлж байсан нь "сурах бичиггүйгээс хичээлд оролцдоггүй, гэрийн даалгавар хийдэггүй байдлыг багасгаж, сургалтын үр дүнд ахиц гарсан гэж багш нар үзсэн" бөгөөд эцэг, эхэд ч сурах бичгийг нэг дороос түрээслэн авах, санхүүгийн хувьд ч хөнгөлөлт, дэмжлэг болж байлаа. Гэтэл энэ түрээсийн тогтолцоо-эргэлтийн сангийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалт бүрэн хийгдээгүйн улмаас сүүлийн 3-4 жилийн хугацаанд түрээсийн сурах бичгээр хангах явдал зогссон байна. Сурах бичиг, багшийн номын хангалт, хүртээмжийн талаар илүү сайн менежмент зохион байгуулалт хийх шаардлагатай байна. Магадгүй багшийн номыг багш өөрөө хөнгөлөлттэй үнээр худалдаж авдаг байх зохицуулалт хийж болох юм.



Сул тал

- Шинээр боловсруулагдан хэвлэгдсэн сурах бичиг, багшийн номын агуулга, арга зүйн онцлог, үнэлгээний арга барил, дасгал даалгаврын тавил болон холбогдох мэдээллийг багш нарт хүргэх сургалт, үйл ажиллагааний давтамж цөөн байна.
- Сурах бичгийн хангалт, хүртээмжийн талаар хийсэн судалгаа хангалтгүй.
- Дунд, ахлах ангийн сурагчдын 60 хувийг хангах сурах бичгийг хэвлэх тоо хэмжээ, түгээх тогтолцоо, түүний хяналтын талаар нэгдсэн мэдээлэл судалгаа хийгдээгүй.
- Сурах бичгийг худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ байхгүй тул хэрэглэгч алслагдсан аймаг сумдын суралцагчид сурах бичгээ худалдаж авах боломж хангалтгүй.
- Бага ангид үнэ төлбөргүй сурах бичиг хэрэглэсэн сурагч цаашид дунд, ахлах ангид орох үед сурах бичгээ худалдан авах соёл хандлага, ойлголт эцэг эх, асран хамгаалагчид төлөвшөөгүй, түүнийг шийдвэрлэх талаар арга хэмжээ тодорхойгүй байна.
- Сурах бичгийн түрээсийн тогтолцоо-эргэлтийн сангийн үйл ажиллагааны хууль, эрх зүйн зохицуулалтгүй байна.



Санал

- Багшийн номыг багш нарын тоогоор хэвлэх төлөвлөлт судалгаа тооцоог тодорхойлж жил бүрийн төсөвт тусгаж байх.
- Багшийн номын агуулга, бүтэц, шаардлага, шалгуур үзүүлэлт, хэрэглээ, ашиглалтын талаар судалгааг үе шаттай эргэх холбоотойгоор авдаг байх тогтолцоог бүрдүүлэх.
- Сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээ, даалгавар, дизайн зохиомж, багтаамж нь сургалтын хөтөлбөр, сурагчийн хэрэгцээ сонирхолд нийцсэн эсэх, хүүхдийн сурах арга барил, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, дэмжлэг болж буй эсэх талаар судалгаа хийж, сурах бичигт тавих шаардлага болон шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох хэрэгтэй байна. Одоогийн байдлаар сурах бичигт тавигдах ерөнхий шаардлага, шалгуур үзүүлэлт байдаг хэдий ч цаашид судлагдахууны онцлог болон тусгай хэрэгцээт боловсролд тохирсон тусгай шаардлага, шалгуур шаардлагатай байна.
- Нэг сурах бичгийн ашиглалтын хугацааг хэвлэлийн газартай байгуулах гэрээний техникийн тодорхойлолтод 4 жил гэж тодорхойлсон байдаг. Гэвч багш, эцэг эхийн зүгээс хүүхдийн эрүүл мэндэд халтай, ариун цэврийн шаардлага хангахгүй, хэт хуучин түрээсийн сурах бичгийг хэрэглэж байна гэсэн шүүмжлэл гарсаар байна. Иймд сурах бичгийн ашиглалтын хугацааг судалгааны үндсэн дээр бодитой тодорхойлох шаардлага байна.
- Сурах бичгийн чанарыг дээшлүүлэхэд хэрэглэгч төвтэй олон нийтийн оролцоонд тулгуурласан хяналтын нээлттэй тогтолцоог бий болгох, сурах бичгийг хэрхэн ашиглах тухай сургалтыг үе шаттай зохион байгуулах.
- Сурах бичиг, багшийн номын хангалт, хүртээмжийн талаар илүү сайн менежмент зохион байгуулалт хийх.



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

Р2.1. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ

Р2.1. А1. Бүтэц, зохион байгуулалт, төлөвлөлт

Менежментийн багийн дэд баг болох ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгохтой холбоотой боловсруулах, түрших, сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх үүрэг бүхий багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын багийг байгуулж, ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулсан ба ажил гүйцэтгэх гурван талт гэрээ байгуулсан.

Р2.1.А1.Т1. "Багшийн мэргэжил дээшлүүлэх баг" байгуулах

Менежментийн багийн дэд баг болох багшийн мэргэжил дээшлүүлэх багийг 6 хүний бүрэлдэхүүнтэй, судлагдахуун бүрийн дэд багуудыг нийт 66 хүний бүрэлдэхүүнтэй Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд түшиглэн байгуулсан.

БШУ-ы сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын 3-р хавсралтаар менежментийн 6 баг байгуулсаны нэг нь "Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын баг" байсан ба БМДИ-ийн дэд захирлаар ахлуулж, БХ-гийн эрдэм шинжилгээний ажилтан, БМДИ-ийн сургалтын албаны дарга, МУБИС-ийн болон лаборатори сургуулийн багш, боловсрол судлалын албаны ажилтан зэрэг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагджээ.

Энэхүү багийг өргөтгөн бага боловсролын 8 судлагдахууны чиглэлээр багшийн мэргэжил дээшлүүлэх дэд багуудыг БМДИ-ийн захирлын 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн А/44 дүгээр тушаалаар 66 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх дэд багуудын бүрэлдэхүүнд БМДИ-ийн арга зүйчид, албаны дарга нар, БШУЯ-ны мэргэжилтэн, БХ, МУБИС, МУИС-ийн багш нар, БСШУЯ-ны дэргэд байгуулагдсан хэрэгжилтийн багийн гишүүд, үндэсний лаборатори сургуулийн бага боловсролын багш нарын төлөөллөөс түс түс оролцсон байна.

БШУ-ы сайдын 2013 оны 08 сарын 27-ны өдөр багийн бүрэлдэхүүнийг шинэчлэх, зардал батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай А/326 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар, "Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үзэл, баримтлал, бодлого чиглэл боловсруулах баг"-ийг 12 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн батлав. Мөн энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар "Ерөнхий боловсролын лаборатори /40/ сургуулиудад хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалтын шинэ технологи, арга зүйг түрших баг"-ийг 23 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталжээ.

Р2.1.А1.Т2. "Багшийн мэргэжил дээшлүүлэх баг"-ийн ажлын төлөвлөгөө боловсруулах, гэрээ байгуулах

2014 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Менежментийн баг нь /төлөөлж МБ-ийн ахлагч/ Боловсролын хүрээлэн, /төлөөлж БХ-гийн захирал/, БМДИ /төлөөлж дэд захирал/-тэй ажил гүйцэтгэх гурвалсан гэрээг байгуулав.

БШУЯ-ны ТНБД-аар батлуулсан түс гэрээгээр "Багшийн мэргэжил дээшлүүлэх баг"-ийн үүргийг "Багшийн мэргэжил дээшлүүлэх баг нь ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгохтой холбоотой боловсруулах, түрших, сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэнэ" гэсэн байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх баг нь дараах бүтээгдэхүүнийг гэрээ байгуулагч Менежментийн багт хүлээлгэн өгөхөөр гэрээнд тусгажээ. Үүнд:

- ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэхэд мөрдөж байгаа бодлогын баримт бичгийн шинжилгээ, үлс орнуудын

багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцооны харьцуулсан судалгааны тайлан

- Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааны тайлан

- ЕБС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэхэд баримтлах үзэл баримтлал, чиглэл зэрэг багтжээ.

“Багшийн мэргэжил дээшлүүлэх баг”-ийн ажлын төлөвлөгөөг 2013 оны 06-08 дугаар сард боловсруулан ТНБД-аар 2013 оны 08 дугаар сард батлуулав. Ажлын төлөвлөгөөнд бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгжилтийн багаас зохион байгуулах үйл ажиллагаа /судалгаа, шинжилгээ, сургалт зөвлөгөөн/, хугацаа, хамтран ажиллах байгууллагууд, үйл ажиллагаанд шаардагдах төсөв зэргийг тусгажээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх баг, дэд багууд 2013 оны нэгдүгээр сараас 12 дугаар сар хүртэл нийт 30 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг хийсэн нь бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд багшид шаардлагатай дэмжлэгийг тодорхойлж, сургалтуудыг төлөвлөн, мэргэжил дээшлүүлэх төрөлжсөн сургалтын хөтөлбөр, арга зүйн зөвлөмж боловсруулахад чиглэсэн. Тухайлбал лаборатори сургуулиудын удирдлага, багш нар болон аймаг, нийслэлийн боловсролын газрын удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтуудын хөтөлбөрүүдийг боловсруулсан нь дээрх уулзалтуудын үр дүн байсан.

2014 оны 08 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан гэрээ нь 2013 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон тул 2014 оны нэгдүгээр сарын 02-ны өдөр Менежментийн баг ба Багшийн мэргэжил дээшлүүлэх багууд ажил гүйцэтгэх гэрээг шинэчлэн байгуулж, 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд хийх ажлын чиглэл, төлөвлөгөөний хамт, БСШУЯ-ны ТНБД-аар баталгаажуулжээ. Энэхүү гэрээнд БМДБ-ийн гүйцэтгэх дараах ажлуудыг тусгасан байна. Үүнд:

- 2.1.1 “Бага боловсролын шинэ цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтын хөтөлбөр боловсруулан сайжруулах
- 2.1.2 “Бага боловсролын шинэ цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг туршилтын 40 сургуулийн бага ангийн нийт 1316 багшид 2 удаа зохион байгуулах, үр дүнг тооцох
- 2.1.3 Лаборатори сургуулийн нийт 120 удирдах ажилтанд “Бага боловсролын шинэ цөм хөтөлбөрт суурилсан, сургуулийн өөрийн онцлогтой бодлого, төлөвлөлтийг боловсруулах, сургуульд суурилсан багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх арга зүй” сургалт зохион байгуулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх
- 2.1.4 Үндэсний түвшинд “Бага боловсролын шинэ цөм хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд лаборатори сургуулийн түшиглэн нийт бага ангийн 7785 багшид 2 удаа сургалт зохион байгуулах, зөвлөн туслах
- 2.1.5 Лаборатори сургуулийн дунд ангийн багш нарыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр боловсруулан сайжруулах, сургалт зохион байгуулах
- 2.1.6 Үйл ажиллагааны явцын болон үр дүнгийн тайлан бичиж, эрх бүхий байгууллагад тайлагнах



Давуу тал

- Багшийн мэргэжил дээшлүүлэх институт дахин байгуулагдсан нь хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бүрдүүлсэн.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх баг нь институтэд түшиглэн байгуулагдаж, менежментийн багтай гэрээ байгуулж, ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй болсоноор шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хүний нөөцийг өргөтгөсөн.
- Менежментийн багт буюу яаманд хүлээлгэн өгөх бүтээгдэхүүнийг гэрээнд тусган албажуулсанаар бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх явцад багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд хийх ажлууд, нийлүүлэх бүтээгдэхүүнийг төлөвлөж, эзэнжүүлсэн, шаардлагатай төсөв, хугацааг тодорхойлсон.



Сул тал

- Багшийн мэргэжил дээшлүүлэх багийн төлөвлөгөө болон менежментийн багийн төлөвлөгөөнд хөтөлбөрийн шинэчлэлийг таниулах сургалтууд, тэдгээрийн хөтөлбөр боловсруулах талаар төлөвлөсөн ч багшид зориулсан арга зүйн зөвлөмж, таниулах материалуудыг боловсруулах, түгээх талаар тодорхой тусгаагүй байна. Үүний улмаас хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад нийт багш, сургуулийн удирдах ажилтнуудад арга зүйн зөвлөмж, жишиг хичээлийн төлөвлөлт зэрэг материал дутагдалтай байсан.
- БШУ-ы сайдын 2013 оны А/326 тушаалаар, 2013 оны А/155 дугаар тушаалаар батлагдсан менежментийн дэд багуудыг өмнөх нэршлээр бүрэлдэхүүнийг шинэ боловч, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын багийн оронд “Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үзэл, баримтлал, бодлого чиглэл боловсруулах баг” байгуулсан, тус тушаалын үндэсний зөвлөлтэй холбоотой хэсгийг хүчингүй болгосон байна. Эндээс харахад багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын багийн чиг үүрэг өөрчлөгдсөн ба бүрэлдэхүүний хувьд өргөтгөсөн гэж харагдаж байна. Гэсэн хэдий ч менежментийн багтай 2013 оны 08 дугаар сард хийсэн гэрээг өмнөх нэршлээр байгуулсан, ажил гүйцэтгэх гэрээнд судалгаа хийх, үзэл баримтлал боловсруулах тухай тусгасан байна. Харин 2014 оны нэгдүгээр сарын 02-ны өдөр шинэчлэн байгуулсан гэрээнд лаборатори сургуулийн бага боловсролын багш, нарын сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах талаар тусгажээ. Ийнхүү богино хугацаанд багийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэлийг өргөжүүлж байсан нь үйл ажиллагаа тасралтгүй, тогтвортой үргэлжлэх нөхцөл бүрдээгүй, цаг үеийн шинжтэй үйл ажиллагааг богино хугацаанд төлөвлөн хэрэгжүүлж байсныг харуулж байна.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгжилтийн баг нь судлагдахууны чиглэлээр дэд багуудад хуваагдсан боловч дэд багуудын ажлын төлөвлөгөө тодорхой бүс байсан. Дэд багийн гишүүдтэй гэрээ байгуулаагүй, гишүүдийн эрх үүрэг, урамшуулах хөшүүрэг, хариуцлага тодорхой бүс, үндсэн ажлын ачаалал дээр нэмэгдэж байсан тул гишүүдийн оролцоо жигд бүс байх асуудал гарч байсан.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх баг болон судлагдахууны дэд багуудын гишүүдийн хувьд шаардлагатай үр чадвар, хөгжүүлэх чиглэл, сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг нарийн төлөвлөөгүй.



Санал

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллагууд (БХ, БМДИ, БҮТ, хэрэгжилтийг дэмжих багууд, аймаг, нийслэлийн боловсролын байгууллагууд)-ын хамтын ажиллагааг уялдаа холбоотойгоор нэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтаар хангах
- Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх багийн гишүүдийг сонгон шалгаруулах шалгуур, журмыг боловсруулан баг бүрдүүлэхэд мөрдөх, чадавхжуулах үйл ажиллагааг тасралтгүй, уялдаа холбоотой тодорхой төлөвлөх
- Сургалтын хөтөлбөр таниулах үйл ажиллагааг зөвхөн сургалтаар хязгаарлахгүй, таниулах материалууд, арга зүйн зөвлөмжүүдийг боловсруулан түгээх хөрөнгө, санхүү, хугацаа, хүний нөөцийг оновчтой тооцоолон нэгдсэн төлөвлөгөөнд тусган, дунд хугацааны төлөвлөлтийг тодорхой хийх.

P2.1.A2. Багшийн хөгжих хэрэгцээ, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны чиглэл, үзэл баримтлалыг боловсруулах

Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ чиглэл тодорхойлох судалгаа хийж, Монголын багш нарын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, чиглэлийг тусгасан судалгааны тайлан боловсруулав.

P2.1.A2.T1. Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, чиглэл тодорхойлох судалгаа хийх

“Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны хөгжих, мэргэжил дээшлүүлэх хэрэгцээг тодорхойлох, багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хэрэгцээ шаардлагуудыг хангах арга замыг тодорхойлох судалгааг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн хамтран зохион байгуулав.

Бага, дунд боловсролын хөтөлбөрийг шинэчлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагаатай цаг хугацааны хувьд зэрэгцэн боловсролын чанарын шинэчлэлийн дэд хөтөлбөр болох “Багшийн хөгжил” хөтөлбөрийг БШУ-ы сайдын 2012 оны 11 дүгээр сарын 22 ны А/136 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багш төлөвшүүлэх, тэргүүн түршлагыг түгээх, нэр хүндийг өсгөхөд оршино” хэмээсэн байдаг.

Энэхүү хөтөлбөрийн 4.1.1-д бүх шатны боловсролын байгууллагын багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг тогтмолжуулах, багшийг хөгжүүлэх чиг хандлага, эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт зохион байгуулах, 4.1.4-д Багшийн мэргэжил үр чадвараа дээшлүүлэх хэрэгцээний судалгаанд үндэслэн түвшин бүрд (багш өөрийгөө хөгжүүлэх, сургууль, орон нутаг, үндэсний) тохирсон урт, богино хугацааны сургалтуудын хувилбарт хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зэрэг зорилтууд тусгагдсан байна. Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэх, “Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын үзэл, баримтлал, бодлого чиглэл боловсруулах баг”-ийн ажлын төлөвлөгөө, гэрээний биелэлтийг хангах үүднээс тус судалгааны ажлыг БМДИ, БХ, БМД баг хамтран зохион байгуулсан.

2013 оны 05 дугаар сард БМДИ-ийн захирлын тушаалаар “Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, чиглэл тодорхойлох судалгааны баг”-ийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, багийн ахлагчтай гэрээ байгуулсан ба тус баг нь багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, чиглэл тодорхойлох судалгааг дараах үе шатаар хийж гүйцэтгэжээ.

Судалгааны арга зүй боловсруулах, 2013 оны 05-06 дугаар сард

Судалгааны арга зүйг хэлэлцэж сайжруулах, 2013 оны 05-06 дугаар сар

Судалгааны удирдамж боловсруулах, 2013 оны 06 дугаар сар

Судалгааг зохион байгуулах, 2013 оны 06-11 дүгээр сар

Судалгааны үр дүнг боловсруулж, тайлан бичих 2013 оны 11 дүгээр сараас 2014 оны 01 дүгээр сар

Монголын багш нарын мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ, чиглэлийг тодорхойлсон судалгааны тайлан, дүгнэлтийг сургалт, үйл ажиллагааны хөтөлбөр, арга зүйг боловсруулахад ашиглажээ. Тухайлбал багш нар мэргэжил дээшлүүлэх хамгийн үр өгөөжтэй арга зам нь ажлын байран дахь сургалт, зөвлөн туслах үйл ажиллагаа гэж үзсэн тул тэдэнд ажлын байранд нь зөвлөн туслах, сургалт зохион байгуулах, онлайнар зөвлөмж түгээх, багш нарын хамтын ажиллагаанд суурилсан хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулжээ.

P2.1.A2.T2. Багшийн хөгжил, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо, үйл ажиллагааны чиглэлээр олон улсын харьцуулсан судалгаа хийх

Багшийн мэргэжил дээшлүүлэх баг, БСШУЯ, хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх менежментийн баг, МУБИС хамтран Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны чиглэлээр олон улсын харьцуулсан судалгаа хийв. Үүнд:

1. Багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр олон улсын харьцуулсан судалгаа хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 2013 оны 08 дугаар сард БМДИ-ийн захирлын тушаалаар 4 хүний бүрэлдэхүүнтэй томилсон.
2. Олон улсын түршлагүүдээс материал цуглуулах, сонголт хийж, орчуулав. Үүнд:
 - Багш боловсролын мэдээлэл харилцааны технологийг ашиглах нь: Африкийн зарим их сургуулийн жишээн дээр
 - Багшийн сургалтад зайны сургалтыг ашиглаж буй Бразилийн түршлага
 - Нээлттэй болон зайны сургалтаар багшийн боловсролыг дэмжих бодлого ба боловсролын зарчмууд
 - Сургагч багшийн мэргэжлийн тодорхойлолт
 - Мэргэжил дээшлүүлэх сургалтын үнэлгээ
3. Судалгааны арга зүй боловсруулах /2013 оны 08 дугаар сард/
4. Судалгааны арга зүйг хэлэлцэж, сайжруулах /2013 оны 08-10 дугаар сар/
5. Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн бодлого, үйл ажиллагааны талаарх мэдээлэл цуглуулах, харьцуулалт хийх

/2013 оны 08-11 дүгээр сар/, Үүнд:

- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил: Олон улсын чиг хандлага, түршлагын харьцуулалт
- Мэргэжлийн тасралтгүй хөгжлийн бодлого, үйл ажиллагааны харьцуулалт (Тайвань, Англи, Хятад, Япон, Хонконг, АНУ-ын жишээн дээр)

6. Судалгааны үр дүнд боловсруулалт хийх, тайлан бичих

2013 оны 08-11 дүгээр сард БМДБ нь БСШУЯ, менежментийн баг, НБГ зэрэг байгууллагатай хамтран Монгол улсад багшийн ажил үүрэг, оролцоог зохицуулсан хүчин төгөлдөр мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилтэд судалгаа хийсэн. Үүнд:

1. ЗГ-ын тогтоол 4
2. Хамтарсан тушаал 2
3. БСШУ-ы сайдын тушаал 10, нийт 13 баримт бичигт түс түс шинжилгээ хийв.

P2.1.A2.T3. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлал боловсруулах

Өмнө хийсэн олон улсын харьцуулсан судалгаа, баримт бичгийн шинжилгээ, Монгол улсын багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр явуулж ирсэн үйл ажиллагааны түршлага, сургамжид үндэслэн Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлалыг Багшийн мэргэжил дээшлүүлэх баг, БМДИ, БХ хамтран боловсруулсан.

2013 оны 10-12 дугаар сард БМДХБ нь БСШУСЯ, МБ-тай хамтран Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлал боловсруулах ажлыг 13 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн хийсэн. Энэхүү ажлыг өмнө хийсэн олон улсын харьцуулсан судалгаа, баримт бичгийн шинжилгээ, Монгол улсын багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих чиглэлээр явуулж ирсэн үйл ажиллагааны түршлага, сургамжид үндэслэн дараах үе шатаар хийж гүйцэтгэжээ. Үүнд:

1. Үзэл баримтлалын төсөл боловсруулах
2. Үзэл баримтлалыг хэлэлцүүлэх
3. Үзэл баримтлалыг эцэслэн сайжруулж, хүлээлгэн өгөх

P2.1.A2.T4. Үзэл баримтлал, судалгааны тайланд хөндлөнгийн хяналт хийлгэх, хүлээлгэн өгөх

2013 оны 12 дугаар сард хийсэн судалгаа, шинжилгээний тайлан, багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлалд экспертийн дүгнэлт хийх ажлыг БСШУЯ, Менежментийн багтай хамтран хийсэн

Үүнд 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллаж дүгнэлт гаргасан байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгаа, мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлал зэргийг БСШУЯ-нд хүлээлгэн өгөв.

Багшийн хөгжих хэрэгцээ, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны чиглэл, үзэл баримтлалыг боловсруулах ажлын хүрээнд дараах бүтээгдэхүүнийг БСШУЯ-нд хүлээлгэн өгсөн. Үүнд:

1. Судалгааны тайлан, үзэл баримтлал:
 - Багшийн мэргэжил дээшлүүлэх эрх зүйн баримт бичиг, түүний хэрэгжилтэд хийсэн судалгаа-4 х.х
 - Багш мэргэжлийн тасралтгүй хөгжил: Олон улсын чиг хандлага, түршлагын харьцуулсан судалгаа-10х.х
 - СӨБ, ЕБС-ийн бага ангийн багш нарын хөгжих хэрэгцээний судалгааны тайлан -10х.х
 - Багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлал-2 х.х
2. Орчуулга:
 - Багш таны мэргэжлийн хөгжлийн удирдамж, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжил-14 х.х
 - Мэргэжил дээшлүүлэх сургалтын үнэлгээ-4 х.х.
 - Багшийн мэргэжил дээшлүүлэхэд нээлттэй болон зайны сургалт ашиглах нь-10 х.х
 - Багш мэргэжлийн тодорхойлолт-2х.х

**Давуу тал**

- Бага, дунд боловсролын хөтөлбөрийн шинэчлэл хийх үйл явцын өмнө багшийн хөгжлийн олон улсын чиг хандлагыг харьцуулан судалж, багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлалыг өөрийн орны онцлогт нийцүүлэн боловсруулсан.
- Багшийн хөгжих хэрэгцээ болон хөгжлийг дэмжих үр дүнтэй арга замуудыг тодорхойлсон.
- Багшийн хөгжлийн чиглэлээр Монгол улсад хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдэд шинжилгээ хийж, шинэчлэх шаардлагатай зарим дүрэм, журмуудыг шинэчлэх төсөл боловсруулан хэлэлцүүлж баталгаажуулан мөрдсөн.
- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл явцад дэмжлэг үзүүлэхдээ сургууль, багш нарт ажлын байранд нь зөвлөн туслах, сургалт зохион байгуулах, онлайнаар зөвлөмж түгээх, багш нарын хамтын ажиллагаанд суурилсан хичээлийн судалааны арга зүйг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаануудыг зохион байгуулж ирсэн.
- Онлайн сургалтын хэлбэрийг Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын бүтцэд нэвтрүүлэн хэрэгжүүлж эхэлсэн.

**Сул тал**

- Дээрх судалгааны ажлуудын үр дүнгийн тайланг тухайн үед менежментийн багт хүлээлгэн өгсөн, эрх зүйн баримт бичгүүдийг шинэчлэхэд ашиглагдсан хэдий ч мэргэжлийн байгууллагуудад болон ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багш, мэргэжилтнүүд, олон нийтэд дэлгэрэнгүй танилцуулж, хэвлэн нийтлэгдээгүй.

**Санал**

- Багш мэргэжлийн хөгжлийн талаар хийсэн судалгааны үр дүнг хэвлэн нийтлэх, хэлэлцүүлэх, онлайн орчинд нээлтэй байршуулах, мэргэжлийн байгууллагууд, багш, удирдах ажилтнуудад танилцуулах
- Багш, удирдах ажилтны ажлын төлөвлөлт, үнэлгээг сургуулийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах ажилтай нягт уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх. Үүний тулд мэргэжлийн байгууллагууд хамтран судалгаанд үндэслэн багшийн ажлын үнэлгээний журмыг шинэчлэн боловсруулах
- Сургуулийн удирдах ажилтнуудын манлайллыг сайжруулах, сонгон шалгаруулалт, томилгоог тогтвортой, боловсролын хөгжлийн бодлогод нийцүүлэн оновчтой зохион байгуулах

P2.1.A3. Бага боловсролын цөм хөтөлбөрийн сургалтыг аймаг нийслэлийн БСГ-ын мэргэжилтэн, лаборатори сургуулийн багш, удирдах ажилтнуудад зохион байгуулах

Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд, лаборатори сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд бага, дунд боловсролын хөтөлбөрийг шинэчлэх, түрших, хэрэгжүүлэх ерөнхий зураглал, шинэчлэлийн гол чиглэл, байгууллагуудын оролцоо, чиг үүрэг зэргийг таниулах сургалт, лаборатори сургуулийн бага боловсролын багш нарт бага боловсролын шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүйг таниулах сургалтыг тус тус зохион байгуулав.

P2.1.A3.T1. Сургалтын бэлтгэл хангах

Сургалт зохион байгуулах төлөвлөгөө, зохион байгуулалтын зураглал боловсруулан, үндэсний сургагч 120 хүнийг сургалтад хамруулж, багийн зохион байгуулалт хийсэн. Бэлтгэл ажлын хүрээнд үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсруулан өгч, холбогдох гарын авлагыг хэвлэснээр болон электрон хэлбэрээр өгөв.

Лаборатори 40 сургуулийн багш нар болон аймаг, нийслэлийн БСУГ-ын мэргэжилтнүүдэд бага боловсролын

сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлыг дараах үе шатаар зохион байгуулсан. Үүнд:

Хүснэгт 2.1.1. Сургалтын бэлтгэл ажил

Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хариуцагч	Хамтран ажиллагч	Эхэлсэн	Дууссан
Сургалт зохион байгуулах баг бүрдүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө хийх	Багшийн гишүүдийн нэрсийн жагсаалт, үйл ажиллагааны төлөвлөгөө	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	2013.07	2013.08
Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, боловсруулах, хэлэлцүүлэх, сайжруулах, баталгаажуулах	Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	2013.07	2013.08
Орон нутгийн БСГ-ын мэргэжилтэн, лаборатори сургуулийн удирдлагын сургалтын хөтөлбөр боловсруулах	3 өдрийн сургалтын хөтөлбөр	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	2013.08	2013.08
Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Үндэсний сургагч багш бэлтгэгдсэн	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2013.08	2013.08
Оролцогчдын нэрс гаргах, сургалтын зураглал дизайн боловсруулах	Сургалтад оролцох багшийн тоо, бүсийн сургалтын зохион байгуулалтын зураглал, төлөвлөлт, сургалт зохион байгуулах тухай албан тоот	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2013.07	2013.08
Сургалтын төсөв тооцоог гаргах	Сургалтын төсөв	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2014.07	2014.08
Сургалтын хөтөлбөрийг орон нутгийн БСГ-т урьдчилан илгээх, бэлтгэл ажлыг хангуулах	Албан тоотоор сургалтын зохион байгуулалт, хөтөлбөрийн мэдээлэл хүргэж, бэлтгэл хангуулсан	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2014.07	2014.08

Р2.1.А3.Т2. Сургалт зохион байгуулах

Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд, лаборатори сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө, шинэчлэлийн гол чиглэл, байгууллагуудын оролцоо, чиг үүрэг зэргийг таниулах сургалт, лаборатори сургуулийн бага боловсролын багш нарт бага боловсролын шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүйг таниулах сургалтыг тус тус зохион байгуулав.

Тус сургалтад үндэсний сургагч багшийн багт БМДИ-ээс 22, БХ-гээс 8, түршилтын менежмент багийн 27, лаборатори 4 сургуулиас 26 багш, НБГ-аас 3, бусад сургууль, байгууллагаас 10 хүн сургагч багшаар ажилласан байна.

Хүснэгт 2.1.2. Сургалт зохион байгуулах төлөвлөгөө

№	Үйл ажиллагаа	Хариуцагч	Хамтран ажиллагч	Хамрагдсан хүний тоо	Эхэлсэн	Дууссан
1	Аймаг нийслэлийн БСГ-ын мэргэжилтнүүд болон лаборатори сургуулийн удирдах ажилтнуудад сургалт зохион байгуулах	БМДБ	БСШУ, МБ, ХБ	516	2013.08	2013.08
2	Аймгуудын лаборатори сургуулийн бага ангийн багш нарт сургалт зохион байгуулах	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	774	2013.09	2013.09
33	Нийслэлийн лаборатори сургуулийн бага ангийн багш нарт сургалт зохион байгуулах	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	493	2013.09	2013.09

Р2.1.А3.Т3. Сургалтын үр дүнг тайлагнах

Дээрх сургалт бүрийн тайланг нэгтгэн боловсруулж, сургалтын үр дүн, дараагийн сургалтад болон хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагаанд тусган сайжруулах саналыг сургагч багш, сургалтад оролцогчдын харах өнцгөөс

дүгнэн дэвшүүлсэн саналуудыг нэгтгэж, БМДИ болон яамны хэмжээнд тайлагнав.

Сургалтын үр дүнг сургалт зохион байгуулагчид болон сургалтад оролцогчдоос авсан сэтгэл ханамжийн асуулга, судалгаагаар үнэлж, дүгнэлт гаргаж байжээ.

Хүснэгт 2.1.3. Сургалтын үр дүнг тайлагнах

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хариуцагч	Тайлан, дүгнэлтэй танилцсан
1	Сургалтын үр дүнг нэгтгэх	Сэтгэл ханамжийн үнэлгээний дүн	БМДБ, БМДИ	БСШУЯ, МБ, ХБ
2	Санхүүгийн тооцоо хийх	Санхүүгийн тайлан	БМДБ, БМДИ	БСШУЯ, МБ, ХБ
3	Сургалтын тайлан бичих	Үйл ажиллагааны тайлан	БМДБ БМДИ	БСШУЯ, МБ, ХБ



Давуу тал

- Аймаг нийслэлийн БСГ-ын мэргэжилтнүүд болон лаборатори сургуулийн удирдах ажилтнууд, бага боловсролын багш нарт хөтөлбөрийн шинэчлэлийг танилцуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсанаар хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл хангахад дэмжлэг үзүүлсэн.
- “Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг зөвхөн багшаар хязгаарлаагүй, лаборатори сургуулийн удирдах ажилтнуудад зохион байгуулж байсан нь хөтөлбөрийг сургуулийн менежменттэй үялдуулан хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй байсан.



Сул тал

- Сургалтын шинэ хөтөлбөрийг үндэсний хэмжээнд таниулах хугацаа харьцангуй бага (1-2 сар) байсан учраас сургууль, багш нарын сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлэн байдал хангагдаагүй.
- Сургагч багш нарыг чадавхжуулах хөрөнгө нөөцийг хангалттай төлөвлөөгүй тул сургагч багш нарыг богино хугацаанд бэлтгэсэн.
- Зарим судлагдахууны сурах бичиг, багшийн ном хэвлэгдээгүй, сургуулиуд хэвлэгдсэн сурах бичгийг татан авч амжаагүй байсан нь сургалтын үр дүнд нөлөөлсөн.
- Шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах сургалтын орчин (лаборатори, туршилтын багаж, материал) сургуулиудад хангалттай бүс байсан.



Санал

- Багш нарт сургалт зохион байгуулах, хөтөлбөр хэрэгжүүлэхээс өмнө сурах бичиг, багшийн ном хэвлэгдэн түгээгдсэн байх зохицуулалтыг хангах, үүний тулд нэгдсэн төлөвлөлтөд хүний болон санхүүгийн нөөцийг оновчтой тусгах
- Сургалтын хөтөлбөр боловсруулагдан батлагдсаны дараа, хэрэгжихийн өмнө шилжилт, шилжилтийн бэлтгэл хугацааг нэг жилээс доошгүй байхаар гаргаж, энэ хугацаанд сургагч багш нарыг бэлтгэх, танилцуулах сургалтуудыг зохион байгуулах, сургалтын орчныг шинэ хөтөлбөрт нийцүүлэн сайжруулах тогтолцоо бүрдүүлэх
- Шинэ хөтөлбөрт шилжихийн өмнөх бэлтгэл шатанд таниулах сургалтын материалууд, багшид зориулсан зөвлөмж зэргийг боловсруулах, хэвлэх, түгээх үйл ажиллагааг санхүүгийн болон хүний нөөцийг төлөвлөх

Р2.1.А4. Бага боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах

Багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгжилтийн баг /БМДИ/ нь бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг нийт 762 сургуулийн 13187 багшид зохион байгуулав. Үүнд:

P2.1.A4.T1. Сургалтын бэлтгэл хангах

Сургалтад оролцогчдын тоо, сургагч багш, сургалтын төсвийн тооцоог гаргаж, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтын талаар аймаг, нийслэлийн боловсролын газруудад мэдээлэл хүргэх, сургагч багш нарын семинар зохион байгуулах зэрэг бэлтгэл ажлыг зохион байгуулав.

Хүснэгт 2.1.4. Бага боловсролын цөм хөтөлбөрийн сургалтын бэлтгэл ажил

Үе шат	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хариуцагч	Хамтран ажиллагч	Эхэлсэн	Дууссан
Сургалтын бэлтгэл ажил	Оролцогчдын тоо, судалгаа гаргах, сургалтын зураглал дизайн боловсруулах	Сургалтад оролцох багшийн тоо, бүсийн сургалтын зураглал, төлөвлөлт, албан тоот		БСШУЯ, МБ, ХБ	2014.06	2013.07
Сургалтын бэлтгэл ажил	Сургалт зохион байгуулах баг бүрдүүлэх, үйл ажиллагааны төлөвлөгөө хийх	Багийн гишүүдийн нэрсийн жагсаалт, үйл ажиллагааны төлөвлөгөө	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	2013.07	2013.08
	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, модуль боловсруулах, хэлэлцүүлэх, сайжруулах, баталгаажуулах	Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр	БМДБ	БСШУЯ, МБ, ХБ	2013.07	2013.08
	Сургалтын төсөв тооцоог гаргах	Сургалтын төсөв	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2014.07	2014.08
	Сургалтын хөтөлбөрийг орон нутгийн БСГ-т урьдчилан илгээх, бэлтгэл ажлыг хангуулах	Албан тоотоор сургалтын зохион байгуулалт, хөтөлбөрийн мэдээлэл хүргэж, бэлтгэл хангуулсан	БМДИ	БСШУЯ, МБ, ХБ	2014.07	2014.08
	Сургагч багш нарын багийн хуваарь, билет захиалга, ажлын чиглэл, удирдамж	Багийн ажлын төлөвлөгөө гарч, орон нутагт сургалт зохион байгуулах бэлтгэл хангагдсан	БМДИ	ХБ, БХ	2014.08	2014.08
	Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх	Сургалтын материал, хэрэглэгдэхүүн боловсруулагдсан	БМДИ	ХБ, БХ	2014.08	2014.08
	Сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	762 сургуулийн нийт багш нарт хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулах сургагч багш нарыг бүрдүүлсэн.	БМДИ	ХБ, БХ	2014.08	2014.08

Дээрх бэлтгэл ажлуудын ихэнх нь сургалтын төсөв, зохион байгуулалтын ажил байгаа бөгөөд хичээлийн жилийн турш хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас гадна үндэсний сургагч багш нарт 3 өдрийн сургалтаар нэгдсэн мэдээлэл хүргэсэн байна. Сургагч багш нар нь мэргэжлийн байгууллагуудын арга зүйч, мэргэжилтнүүдээс гадна, лаборатори сургуулийн багш нараас бүрдсэн.

P2.1.A4.T2. Бага ангийн багш нарт сургалт зохион байгуулах

Улсын хэмжээний нийт 762 сургуулийн 13187 багшид бага боловсролын шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүйн шинэчлэлийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулав.

Хүснэгт 2.1.5.Бага боловсролын багш нарын сургалт зохион байгуулсан үе шат

Үе шат	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	Хариуцагч	Хамтран ажиллагч	эхэлсэн	дууссан
Сургалт зохион байгуулах	21 аймаг, 9 дүүргийн 7 бүсэд сургалт зохион байгуулах	Нийт бага ангийн багш нар үндэсний хэмжээнд хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэлтэй болсон.	БМДБ	ХБ, БХ	2014.08	2014.08
Сургалтын үр дүнг үнэлэх, тайлагнах	Сургалтын үр дүнг нэгтгэх	Сэтгэл ханамжийн үнэлгээний дүн	БМДБ	БМДИ, БХ	2014.09	2014.09
	Санхүүгийн тооцоо хийх	Санхүүгийн тайлан	БМДБ	БМДИ, БХ		
	Үйл ажиллагааны тайлан бичих	Үйл ажиллагааны тайлан	БМДИ	БМДИ, БХ		



Давуу тал

- Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч бүх талын оролцоог хангаж, хичээлийн жилийн түрш сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан тул багш нар нэгдсэн мэдээлэлтэй болж, хамтран ажиллах суурь нөхцөл бүрдсэн.
- Сургагч багш нарыг бэлтгэх багт хөтөлбөр боловсруулагч, түршин хэрэгжүүлсэн багш, сурах бичгийн зохиогчдын төлөөлөл оролцсон тул сургалтын агуулга, арга зүйг бодитой хүргэх боломжтой байсан.
- Хичээлийн жил эхлэхээс өмнө шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүйн онцлог, зөвлөмж мэдээллийг нийт багш нарт нэгэн зэрэг хүргэсэн тул үндэсний хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн бэлтгэл хангагдсан.
- Сургалтыг бүсчлэн зохион байгуулснаар богино хугацаанд санхүүгийн хэмнэлттэйгээр үндэсний нийт багш нарын сургалтыг зохион байгуулсан.



Сул тал

- Үндэсний сургагч багш нарыг бэлтгэх хугацаа богино байсан.
- Сургагч багшийг бэлтгэх сургалтаас өмнө зарим багшийн ном, сурах бичиг хэвлэгдэж амжаагүй байсан тул багшид арга зүйн санаа болохуйц зөвлөмж, материалууд дутагдаж байсан /сургалтын дараах асуулга, сургалтын тайланд тэмдэглэгдсэн багш нарын санал/.
- Орон нутгийн БСУГ-ын мэргэжилтнүүдийг бага боловсролын судлагдахуун бүрийн хөтөлбөрийн агуулга, арга зүйн сургалтад оролцуулж, чадавхжуулах үйл ажиллагаа хангалттай хийгдээгүй. Үүний улмаас сургууль, багш нарт зөвлөн туслахад орон нутгийн боловсролын газрын мэргэжилтнүүдийн чадавх дутагдаж байгааг мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагааны явцад багш нар дурдаж байсан.



Санал

- Сургалтын хөтөлбөрийн шилжилтийн бэлтгэл, шилжилтийн хугацааг хангалттай тусгаж, энэ хугацаанд сургагч багш нарыг давтан бэлтгэж, чадавхжуулах
- Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалт, зөвлөгөөнийг орон нутгийн БСГ-ын мэргэжилтнүүдэд тодорхой давтамжтай зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад сургууль багш нарт зөвлөн туслах аргачлал, зөвлөмжөөр хангах, үүнд шаардагдах хугацаа, хөрөнгө санхүү, хүний нөөцийг тодорхой төлөвлөх
- Багш нарыг сургалтын шинэ хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга зүйн сургалтад хамруулахаас гадна багшид зориулсан зөвлөмж, хичээлийн жишиг төлөвлөлт арга зүйн санаа зэргийг боловсруулан, орон нутаг болон сургуулийн түвшинд дэмжлэг үзүүлэх, сургалт үйл ажиллагааг үе шаттай, үялдаа холбоотойгоор төлөвлөн зохион байгуулах

P2.1.A5. Суурь боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах

Суурь боловсролын шинэ хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх, үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх орон нутгийн хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор “Суурь боловсролын сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сургалтыг аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд, үндэсний лаборатори сургуулийн суурь боловсролын 1897 багш, нийт 760 гаруй сургуулийн 19816 багшид тус тус үе шаттайгаар зохион байгуулав.

Сургалтыг БСШУЯ, БМДИ, БХ, Хэрэгжилтийн баг хамтран зохион байгуулсан бөгөөд сургагч багшаар БМДИ-ийн арга зүйчид, хэрэгжилтийн баг, суурь боловсролын шинэ хөтөлбөр боловсруулж буй багийн гишүүд 113 хүн ажилласан байна.

P2.1.A5.T1. Лаборатори сургуулийн дунд ангийн багш нарт сургалт зохион байгуулах

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг лаборатори сургуулиудад туршин хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, орон нутгийн хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор, 40 лаборатори сургуулийн дунд ангийн багш нарт зориулсан сургалтыг 2016 оны нэгдүгээр сард зохион байгуулав.

Үндэсний сургагч багш нарын семинарийг 2015 оны 01 дүгээр сарын 06 аас 11-ний өдрүүдэд зохион байгуулж, хөтөлбөр сурах бичгийн баг, БМДИ-ийн арга зүйч нар, лаборатори сургуулийн багш нарын бүрэлдэхүүнтэй 120 сургагч багшийн баг бүрдүүлсэн. Энэхүү баг нь 21 аймаг, нийслэлийн лаборатори сургуулиудад судлагдахуун бүрийн шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 01 дүгээр сарын 19-26-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Тус сургалтад лаборатори сургуулийн суурь боловсролын хичээл заадаг багш нараас гадна зарим аймгийн боловсролын газрын суурь боловсрол хариуцсан мэргэжилтнүүд нийт 1897 хүн хамрагджээ. Иймд энэхүү сургалтаар лаборатори сургуулийн дунд ангид хичээл зааж буй багш нарт шинэ хөтөлбөрийн агуулга, арга зүйн онцлог, нэгж хичээл төлөвлөх, заах, үнэлгээний даалгавар боловсруулах арга зүйг ойлгуулах зорилготой дадлагуудыг хөтөлбөрт тусган төлөвлөж, хэрэгжүүлсэн.

P2.1.A5.T2. Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах

Аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, суурь боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн онцлог, хэрэгжүүлэх үе шатыг танилцуулах сургалтыг зохион байгуулав.

2015 оны 04 дүгээр сарын 08-наас 10-ны өдрүүдэд “Бага, дунд боловсролын чанарын шинэчлэл, бодлогын хэрэгжилт - Сургуулийн өмнөх, суурь боловсролын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулав. Тус сургалтад аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга, СӨБ, бага, суурь боловсрол хариуцсан мэргэжилтнүүд, нийт 260 хүн оролцсон. Сургалтаар 2015-2016 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхлэх суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн шинэчлэлийн онцлог, хэрэгжүүлэх үе шат, байгууллагуудын үүрэг оролцоог танилцуулсан.

P2.1.A5.T3. Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах

Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх сургагч багш бэлтгэх сургалтыг БСШУЯ, Хэрэгжилтийн баг, БМДИ, БХ хамтран зохион байгуулав.

“Хүүхдийн хөгжил-Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг 2015 оны 08 дугаар сарын 03-наас 06-ны өдрүүдэд зохион байгуулж, суурь боловсролын бүх судлагдахууны болон сургалтыг дэмжих үйл ажиллагааны чиглэлээр үндэсний сургагч багш нарыг бэлтгэсэн. Тус сургалтад хөтөлбөр, сурах бичиг боловсруулсан багийн гишүүд, БМДИ-ийн арга зүйч, лаборатори сургуулийн багш нар, аймаг, нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүд нийт 462 хүн оролцсон байна.

P2.1.A5.T4. Суурь боловсролын нийт багш нарт сургалт зохион байгуулах

Нийслэл, 21 аймгийн 760 гаруй сургуулийн 17,755 багш, сургуулийн удирдах ажилтнуудад “Хүүхдийн хөгжил-Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулав.

Сургалтын зохион байгуулалтын хувьд, 21 аймаг, 9 дүүргийг 7 бүсэд хуваарилан, үндэсний сургагч багш нарын 20-25 хүнтэй нэг баг, 2 аймаг, 1 дүүрэгт сургалтыг зохион байгуулсан. Суурь боловсролын 15 судлагдахуун, сургалтыг дэмжих 3 үйл ажиллагааг сургуулийн түвшинд хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэгийг нийт багш нарт үзүүлсэн.

Оролцогчид болон сургагч багш нарын зүгээс сургалттай холбоотой дараах анхаарах зүйл, саналуудыг дэвшүүлсэн байна. Сургалтын тайланд тэмдэглэгдсэн саналуудаас дурдвал:

- Байгалийн ухааны зарим мэргэжлийн залуу багш нарын мэргэжлийн мэдлэг, чадвар харилцан адилгүй байгаа нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.
- Сургалтын бэлтгэх хангах, хэрэглэгдэхүүний санхүүжилтийг яамнаас бүрэн гүйцэд шийдвэрлэх хэрэгтэй байна. Сургалтын материал, суралцахуйн удирдамжийг хэвлэх, хувилж олшруулахад цаас, төхөөрөмж дутмаг байлаа.
- Байгалийн ухаан, биеийн тамир, технологи, дүрслэх урлагийн хичээлийн кабинет, тоног төхөөрөмжөөр сургуулиудыг хангах шаардлагатай байна.
- Багш нарын заах арга зүй, мэдээллээ солилцох сүлжээ бий болгож, мэдээллийн нэгдсэн сантай болох хэрэгцээтэй байна гэжээ.



Давуу тал

- Сургалтад суурь боловсролын багш нараас гадна, сургуулийн удирдах ажилтнуудыг хамруулан сургалтын цөм хөтөлбөр, сургалтыг дэмжих үйл ажиллагааг сургуулийн түвшинд хэрэгжүүлэх арга зүйд дэмжлэг үзүүлсэн.
- Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах зүйлсийн талаар багш нарын санал, хүсэлтийг нэгтгэн БСШУЯ-нд танилцуулсан.
- Сургалтын цөм хөтөлбөрийг хэвлүүлж, бүх багшид түгээсэн.



Сул тал

- Хичээлийн шинэ жил эхэлж байхад зарим сурах бичиг хэвлэгдэж гараагүй байсан нь цаашид сургалтын хөтөлбөрийг сургуулийн түвшинд хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэсэн.



Санал

- Сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн өмнөх бэлтгэл, шилжилтийн хугацааг хангалттай төлөвлөж, дараах бэлтгэл ажлуудыг хангасан байх. Үүнд:
 - Сурах бичиг, багшийн зөвлөмжийг боловсруулан түгээхэд нэг жилээс доошгүй хугацааг төлөвлөх
 - Хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийн судалгаа, тооцоог гаргаж, түүндээ үндэслэн хөрөнгө санхүү, түгээлтийг хариуцах хүний нөөц зэргийг тооцоолон төлөвлөх, сургуулиудад нийлүүлэх
 - Сурах бичгийг хэвлэх компаниудын хүчин чадал, боломжийг судалж, сонгон шалгаруулах журмыг тодорхой болгох

P2.1.A6. Бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалт зохион байгуулах

"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг 14,573 багш, сургуулийн удирдах ажилтнуудад үндэсний хэмжээнд зохион байгуулав.

P2.1.A6.T1. Сургалтын бэлтгэл хангах

"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах бэлтгэл хангав.

Дараах үе шатын дагуу бэлтгэл ажлыг зохион байгуулсан. Үүнд:

Хүснэгт 2.1.6. Бүрэн дунд боловсролын шинэ хөтөлбөрийн арга зүйн сургалтын бэлтгэл ажил

№	Үйл ажиллагаа	Үр дүн	Хариуцсан	Хамтран ажилласан	Эхэлсэн	Дууссан
1	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах	Сургалтын бэлтгэл ажлын төлөвлөгөө, үйл ажиллагааны чиглэл хариуцах эзэн тодорхойлогдсон	БМДИ	БСШУЯ, БХ, ХББ	2016.05	2016.05
2	Үндэсний хэмжээнд ажиллаж буй бүрэн дунд боловсролын багш нарын бүртгэл, судалгааг гаргах	Сургалтад хамрагдах хөдөө орон нутгийн 14515 багш, 1596 удирдах ажилтны тоон судалгаа мэргэжил бүрээр гарсан	БМДИ	БСГ, НБГ	2016.05	2016.06
3	"Үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтын хөтөлбөрийн цөм багийг бүрдүүлэх, нэрсийн жагсаалт гаргах	Сургалтын хөтөлбөр боловсруулахад гол үүрэг гүйцэтгэж буй-119 хүний баг бүрдсэн	БМДИ	ХББ	2016.06	2016.06
4	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах сургагч багш нарын баг бүрдүүлэх, нэрсийн жагсаалт гаргах	Үндэсний хэмжээнд сургалт зохион байгуулах 289 хүний нэр гарсан	БМДИ	ХББ	2016.05	2016.05
5	БСШУЯ, БМДИ, БХ-гийн төлөөлүүдийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах	Сургалтын зохион байгуулалт, хугацаа, агуулгын ерөнхий чиглэл боловсруулагдсан	БМДИ	БСШУЯ, БХ, МУИС, ХБ	2016.06	2016.06
6	Нийт сургалтуудын төсөв тооцоо, гаргах, батлуулах	4 шатны сургалтын төсөв	БМДИ	БСШУЯ	2016.05	2016.05
7	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтын зураглал, дизайн гаргах	БДБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын үе шат-дизайн	БМДИ	БСШУЯ	2016.05	2016.06
8	Орон нутгийн БСГ-ын удирдлага, хамт олонтой видео хурал хийх, чиглэл өгч, бэлтгэл хангуулах	БДБ-ын сургалтын цөм хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлын эхлэл, төлөвлөлттэй танилцаж, туршлага хуваалцсан	БСШУЯ	БМДИ, БХ, БҮТ, МУИС, МУБИС, ХББ, ХБ, БСГ, НБГ, ДБХ	2016.05	2016.05
9	Хөдөө орон нутагт сургалт зохион байгуулах бэлтгэл хангуулах албан тоот, боловсруулах, илгээх	Албан тоотоор сургалтын зохион байгуулалт, хөтөлбөрийн мэдээлэл хүргэж, бэлтгэл хангуулсан	БСШУЯ	БМДИ, БСГ, НБГ, ДБХ	2016.06	2016.06
10	"Үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтын хөтөлбөрийн цөм багийн семинарын хөтөлбөр боловсруулах, хэлэлцүүлэх, сайжруулах, баталгаажуулах	"Үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтын хөтөлбөрийн цөм багийн семинарийн хөтөлбөр	БМДИ	БСШУЯ, БХ	2016.06	2016.06
11	Сургалтын хөтөлбөрийн цөм багийн семинарын хүрэх үр дүнг тодорхойлох, гарах бүтээгдэхүүний жагсаалт гаргах	Судлагдахуун тус бүрийн үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, дадлагын удирдамж, ажлын хуудас	БМДИ	БСШУЯ, БХ	2016.06	2016.06
12	"Үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтын хөтөлбөрийн цөм багийн семинар зохион байгуулах	Үндэсний сургагч багш бэлтгэгдсэн -119 хүн	БМДИ	БСШУЯ, БХ, ХББ	2016.06	2016.06

13	"Үндэсний сургагч багш бэлтгэх" сургалтын хөтөлбөрийн цөм багийн семинарын үр дүнгийн талаарх хэлэлцүүлэг хийх	Үндэсний сургагч багш бэлтгэх сургалтад анхаарах, асуудал, хэрэгжүүлэх шинэ санаа, туршлага	БСШУЯ	БМДИ, БХ, ХББ	2016.06	2016.06
14	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах сургагч багш нарт зохион байгуулах сургалтын хөтөлбөр боловсруулах, хэлэлцэх, сайжруулах, баталгаажуулах	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтын үндэсний сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөр: Судлагдахуун тус бүр-17, сургуулийн менежмент-1, Сургуулийн мэдлийн цаг-1, Ажил мэргэжлийн чиг баримжаа-1	БМДИ	БСШУЯ, БХ, ХББ	2016.08	2016.08
15	"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах	Үндэсний сургагч 289 багш бэлтгэгдсэн	БСШУЯ	ХББ	2016.08	2016.08
16	Сургалтын хөтөлбөрийг урьдчилан илгээх, орон нутгийн сургалтын бэлтгэл ажлыг хангуулах	Сургалтын хөтөлбөр, аймаг нийслэлийн БСГ-т илгээсэн албан тоот	БСШУЯ	ХББ	2016.08	2016.08
17	Сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх	Дадлагын удирдамж, ажлын хуудас, санал асуулга, үнэлгээний хуудас	БСШУЯ	ХББ	2016.08	2016.08

Р2.1.А6.Т2. "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй" үндэсний хэмжээний сургалт зохион байгуулах

2016 оны 08 дугаар сард "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зүй" сэдэвт 3 өдрийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид хичээл заадаг багш нар, сургуулийн удирдах ажилтнууд, нийт 14573 хүнд зохион байгуулсан.

Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх бэлтгэл хангах, багш, удирдах ажилтнуудад онол, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой тус сургалтыг аймаг, нийслэлд тус бүр 4 өдрөөр зохион байгуулав.

Энэ удаагийн сургалтаар БДБ-ын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд сургуулийн удирдах ажилтнуудад сургуулийн менежментийн сургалт зохион байгуулахаар төлөвлөснөөрөө өмнөх сургалтуудаас онцлогтой байв. Учир нь сургалтын төлөвлөгөөнд сонгон судлах хичээлийн цаг нэмэгдсэн, сургуулийн онцлогоос шалтгаалан суралцагчдын хичээл сонголтод зөвлөн туслах, сонголтоор бүлэг үүсгэн хичээллүүлэхтэй холбоотой олон асуудал үүсэхээр байсан. Энэ асуудлуудыг шийдэх зарим хувилбарыг сумын, аймгийн төвийн, цогцолбор, олон, цөөн бүлэгтэй сургуулиудад хэрхэн хэрэгжүүлж болох, сонгон судлах болон сургууль зохицуулах хөтөлбөрүүдийг хэрхэн боловсруулж, хэрэгжүүлэх талаар сургуулийн менежментийн зөвлөмж боловсруулан удирдах ажилтнуудад сургалтаар дамжуулан хүргэсэн.

Р2.1.А6.Т3. Сургалтын үр дүнг тайлагнах, дүгнэх

"Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх арга зүй" сэдэвт сургалтын тайланг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт хариуцан нэгтгэн боловсруулж, сургалтын явцад багш, удирдах ажилтан, сургагч багш нараас хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой дэвшүүлсэн санал, дүгнэлтийг тайланд тусган БСШУСЯ, мэргэжлийн байгууллагуудын хүрээнд танилцуулав.

Сургалтын дараах асуулгаар оролцогч багш, ажилтнууд дараах саналуудыг гаргасан нь сургалтын тайланд тэмдэглэгджээ. Үүнд:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин нөхцөл бүрдүүлэх тал дээр онцгой анхаарах, сурах бичиг, мэргэжлийн ном, сургалтын материал, шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах
- Орон нутгийн БСГ-ын мэргэжилтнүүд арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг тасралтгүй зохион байгуулж байх

/жишээ нь: хүндэвтэр сэдвээр улирал тутамд сургалт явуулах/, Лаборатори сургуулийн багш нарын туршлагыг хуваалцах, зөвлөн туслах, сургалтуудыг лаборатори сургуульд түшиглэн орон нутагт тасралтгүй зохион байгуулж байх

- Мэргэжлийн багшийн хүрэлцээ хангамжид анхаарах /орон нутгийн БСГ нь багшийн мэдээллийн нэгдсэн сантай болж, сургуулиудад мэдээлэл өгдөг байх/
- ЕБС, их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрүүдийн уялдаа, залгамж холбоог анхаарах
- Багш бэлтгэдэг их дээд сургуулийн чанарыг сайжруулах, элсэгчдийн босго оноог дээшлүүлэх, төгсөгчдийн чанарт анхаарах гэжээ.

P2.1.A6.T4. "Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын мониторинг хийх, зөвлөн туслах

Бүрэн дунд боловсролын 10 дугаар ангийн шинэ хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, сургалтын хөтөлбөр, арга зүй, менежментийн чиглэлээр зөвлөн туслах ажил зохион байгуулав.

Дээрх зорилгоор БМДИ-ийн 25 арга зүйч, Боловсролын хүрээлэнгийн 5 мэргэжилтэн, Их дээд сургуулийн 4 багш, Ерөнхий боловсролын сургуулийн 2 багш нийт 36 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2016 оны 09 сарын 26-аас 10 сарын 04 хүртэл 21 аймаг, 9 дүүргийн нийт 90 сургууль дээр зөвлөн тусалж ажиллалаа.

Дээрх тоон үзүүлэлтээс харвал судалгаанд хамрагдсан нийт сургуулиас 40 сургуульд Х ангид суралцаж буй хүүхдийн тоо 25-аас доош байжээ. БСШУ-ы сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2007 оны 307/91/237 дугаар тушаалаар баталсан "Цэцэрлэг ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоох багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам"-д заасан "ахлах ангийн мэргэжлийн болон сонгон судлах хичээлийг нэг бүлэгт 25-30 суралцагчтай байхаар зохион байгуулна" гэсэн заалт нь БСШУ-ы сайдын А/275 дугаар тушаалаар батлагдсан бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөөгөөний сонгон судлах хичээлийн бүлгийн зохион байгуулалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэж, олон суралцагчдын сонгон судлах ба гүнзгийрүүлэн судлах хичээлийн сонголт хэрэгжих боломжгүй болж, олонхийг дагасан сонголтоор хичээллэсэн байна.

- Сургуулиудын ихэнх нь математик, нийгмийн ухаан, англи хэл, монгол хэл, физик зэрэг хичээлүүдийг сонгон гүнзгийрүүлж судлуулахаар шийдвэрлэсэн байна. Бусад хичээлүүдийг гүнзгийрүүлэн судлах боломж цөөн бүлэгтэй сургуулийн хувьд хязгаарлагдмал байна.
- Хими, газарзүй, биологи, дизайн технологи, мэдээллийн технологи зэрэг хичээлийг сонгож буй суралцагчдын эрх ашиг хөндөгдөх, цаашилбал анагаах ухаан, биологи, газарзүй, технологийн чиглэлээр мэргэжил эзэмших нөхцөл бүрдэхгүй байх сул талыг дагуулж байна.
- Сумын сургуулиудад мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэжлээ сонгоход нь туслах зорилгоор суралцагчид болон эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалтыг зохион байгуулж байгаа хэдий ч эцэг эхчүүдийн оролцоо хангалтгүй, хүүхдэдээ зөвлөх мэдлэг чадвар сул, сургууль багш нарын хувьд хичээл сонголт, мэргэжил сонголтод зөвлөх туршлага, мэдээлэл дутмаг байна.
- Суралцагчдын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, түүндээ үндэслэн амьдрах ухааны чадвар олгоход чиглэсэн хөтөлбөр боловсруулахад багш нарт арга зүйн дэмжлэг хэрэгтэй байна.
- Сурах бичиггүй, суралцахуйн удирдамжаар хичээллэж байгаа тул хуучин хэрэглэж байсан сурах бичгүүд, цахим орчноос мэдээлэл авах зэргээр багш өөрийн туршлагадаа тулгуурлан сургалтыг зохион байгуулж байна.
- Сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой техник хэрэгслийн /технологи, спорт тоглоом, программ хангамж/ хүрэлцээ хангалтгүй, одоо байгаа нь шаардлага хангахгүй байна.
- Журналд үнэлгээ ирцийн хуудас нэг, үндсэн үйл ажиллагаа бичих хүснэгтийн зай бага, журналын хуудас хүрэлцдэггүйгээс багш нар хувийн болон албан гэсэн хоёр журнал хөтөлж байна.
- Дээрх асуудлууд нь бүрэн дунд боловсролын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл хангалттай бүрдүүлээгүйтэй холбоотой үүссэн байна.



Давуу тал

- БДБ-ын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх сургалтыг багш нарт зохион байгуулахаас гадна сургуулийн удирдах ажилтнуудад сургуулийн менежментийн сургалт зохион байгуулахаар төлөвлөсөн нь өмнөх сургалтуудаас онцлогтой байв.
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаа (сургуулийн мэдлийн цаг)-аар ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөмжийг багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулан боловсруулсан ба анги удирдсан багш нарт сургалт зохион байгуулж, зөвлөмжийг түгээсэн.
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөлмөр эрхлэх үр чадварыг бэхжүүлэх төсөл”-өөс математик, байгалийн ухааны багш нарын сургалтын санхүүжилтийг шийдвэрлэж, багш нарт зориулсан сургалтын модуль, гарын авлага хэвлүүлэн түгээсэн.
- Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх үед сургуулиудад үүсч буй асуудал бэрхшээлийг илрүүлэх, зөвлөн туслах ажил зохион байгуулж, мэдээлэл цуглуулан яам, мэргэжлийн байгууллагуудын хэмжээнд авч үзэж, зарим шийдлийг гаргасан. Тухайлбал БСШУ-ны сайдын А/275 дугаар тушаалаар батлагдсан ахлах ангийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл хангалттай бүрдээгүйтэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх үүднээс шилжилтийн сургалтын төлөвлөгөөг баталж хэрэгжүүлсэн байна.



Сул тал

- Үндэсний сургагч багш нарыг 4 өдрийн сургалтаар бэлтгэсэн нь хангалттай хугацаа биш байсан.
- Хичээлийн шинэ жил эхэлж байхад зарим сурах бичиг хэвлэгдээгүй байсан нь цаашид сургалтын хөтөлбөрийг сургуулийн түвшинд хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал үүсгэсэн.
- Сургагч багшийн ажлын хөлс, оролцогчдын томилолт, замын зардал бүрэн шийдэгдээгүй нь сургалтын зохион байгуулалтад хүндрэл учруулж байсан. Энэ нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх урт, дунд хугацааны төлөвлөлтийг тодорхой хийгээгүй, хөрөнгө, санхүүгийн нөөцийг урьдчилан шийдвэрлээгүйтэй холбоотой.
- Орон нутаг, сургуулийн онцлог, эрх зүйн орчин болон сургуулийн санхүүгийн нөөцтэй холбоотойгоор ахлах ангийн сурагчдын хичээл сонголтыг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байсан.
- Байгалийн ухааны сургалтын хэрэглэгдэхүүн, сорил, түршилт хийх нөхцөл хангагдаагүй байсан нь сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэрхшээл болж байсан.
- Мониторинг, зөвлөн туслах ажлын хамрах хүрээ, хүртээмж хязгаарлагдмал буюу үндэсний хэмжээнд аймаг бүрээс 3, дүүрэг бүрээс 4 сургуулийг түүвэрлэн, нэг сургуульд 2 судлагдахууны чиглэлээр арга зүйн зөвлөмж өгсөн нь хүний болон санхүүгийн нөөц дутмаг байсантай холбоотой.
- Нийт сургуулиудад сургуулийн менежмент болон хичээлийн арга зүйн санаа боловсруулан хүргэх зэргээр эргэх холбоог хангах ажил үргэлжлэн хийгдээгүй.



Санал

- Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцад мониторинг хийж, зөвлөн туслах үйл ажиллагааны төсөв, хүний нөөцийг хэрэгжилтийн нэгдсэн төлөвлөлтөд тусгах
- Мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагааны эргэх холбоог хангаж, мониторингоор илрүүлсэн асуудлуудаар мэргэжлийн байгууллагууд хамтран шийдэл, арга зүй, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагуудад хүргэх тогтолцоо бүрдүүлэх

Р2.2. СУРГУУЛИЙН ТҮВШИНД СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ

БДБ-ын шинэчлэлийн бүтцийн нэг бүрэлдэхүүн (А/155 тушаал) болох хэрэгжилтийн баг нь сургалтын шинэ төлөвлөгөө, хөтөлбөр, сурах бичгийг бүх сургуульд хэрэгжүүлэх арга зүй удирдлагаар хангах үүрэгтэй ажиллаж мэргэжлийн байгууллага болон орон нутгийн боловсролын газар, лаборатори сургуулиудтай хамтран төрийн өмчийн 756 сургуулиас 617 сургуульд шууд, бүх сургуультай шууд бус аргаар хүрч ажилласан байна. 2013-2016 онд хэрэгжилтийн баг нь доорхи чиглэлээр ажилласан байна. Үүнд:

- Хэрэгжилтийн багийн бүтэц, зохион байгуулалт, төлөвлөлт
- Сургуулийн удирдлага, багш нарт зөвлөх үйлчилгээ үзүүлэх
- Туршлага судлах (гадаад болон дотоод)
- “Сайн хичээл, үйл ажиллагаа” улсын зөвлөлгөөн зохион байгуулах
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх
- Хэрэгжилтэд тулгамдсан асуудлыг илрүүлэх судалгаа хийх зэрэг юм.

Сургалтын хөтөлбөр, сурах бичиг турших, сайжруулах ажлыг БХ, хөтөлбөрийн баг, лаборатори сургуулийн багш, удирдлагатай хамтран шинэ хөтөлбөр, сурах бичгийг таниулах, түгээн дэлгэрүүлэх ажлыг БМДИ, болон үндэсний сургагч багш, орон нутгийн боловсролын газар, лаборатори сургуультай хамтран зохион байгуулсан ба эдгээр ажлуудын тухай 1.1, 2.1 бүлгээс танилцана уу.

Р2.2.А1. Бүтэц, зохион байгуулалтыг төлөвлөх

БСШУЯ нь бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхэд сургуулийн түвшинд дэмжлэг үзүүлэх зорилготой “туршилтын” ба “хэрэгжилтийн” багтай гэрээ байгуулан ажилласан байна. Үүнд:

- Бага боловсролын хөтөлбөр, сурах бичгийг туршин сайжруулах үйл явцад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй “туршилтын баг” нь 2013-2014 оны хичээлийн жилд 23 хүний бүрэлдэхүүнтэй
- Бага, суурь боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих үүрэгтэй “хэрэгжилтийн баг” нь 2014-2015, 2015-2016 оны хичээлийн жилд 34 хүний бүрэлдэхүүнтэй гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэсэн байна.

Эдгээр багууд нь мэргэжлийн байгууллагыг түшиглэн байгуулаагүй бие даасан бүтэцтэй, ТББ-ын статустай байсан боловч БДБ-ын шинэчлэлийн нэг бүрэлдэхүүн болж БСШУЯ-тай байгуулсан гэрээний дагуу сургуулиудад хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор дараах бүтцээр ажилласан байна.

Р2.2.А1.Т1. Хэрэгжилтийн баг (туршилтын баг) бүрдүүлэх, ажлын төлөвлөгөө боловсруулах, батлуулах

Туршилтын баг

Туршилтын баг нь 2013 оны 8 сарын 27-ны А/326 тушаалын хоёрдугаар хавсралтаар “Ерөнхий боловсролын лаборатори /40/ сургуулиудад хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалтын шинэ технологи, арга зүйг турших багийн бүрэлдэхүүн”-ээр батлагдсан. 2013 оны 8 сарын 30-нд Менежментийн баг /БСШУЯ-ыг төлөөлж/, Боловсролын хүрээлэн /гүйцэтгэгч/, Туршилтын баг /хамтран гүйцэтгэгч/ гурвалсан гэрээ байгуулсаныг БСШУЯ-ны ТНБД баталгаажуулсанаар ажиллах эрх зүйн орчин бүрдсэн байна.

Туршилтын баг нь лаборатори сургуулиуд дээр шинэчлэн боловсруулж буй бага боловсролын хөтөлбөр, сурах бичиг турших ажлыг Менежментийн багийн нэгдсэн удирдлага дор зохион байгуулсан ба энэ үйл ажиллагаанд хөтөлбөр, сурах бичиг боловсруулагч, мэргэжлийн байгууллага болон орон нутгийн боловсролын газрын мэргэжилтэн зэрэг 300 гаруй хүн мөн үндэсний лаборатори сургуулиудын 1-5 дугаар ангийн 29800 суралцагчид, 1260 бага ангийн багш, 138 бага ангид мэргэжлийн хичээл заадаг багш нар хамтран гүйцэтгэсэн.

Туршилтын багийн гишүүн нь лаборатори сургууль дээр биечлэн байрлаж хөтөлбөр, сурах бичиг сайжруулах саналыг багш нараас авч нэгтгэн БХ болон хөтөлбөр боловсруулагч нарт өгөх, лаборатори сургуулийн багш болон удирдлагад хөтөлбөр таниулах, дэмжин туслах ажлыг сургууль дээр зохион байгуулсан байна.

Хэрэгжилтийн баг

Туршилтын багийн үүрэг, ажиллах хүрээг өргөтгөн, 11 хүнийг нэмж 34 гишүүний бүрэлдэхүүнтэй хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах чиг үүрэг бүхий “Сургалтын төлөвлөгөө, цөм

хөтөлбөрийг нийт бүх боловсролын сургуульд хэрэгжүүлэх арга зүй удирдлагаар хангах хэрэгжилтийн баг"-ийг БСШУ-ы сайдын 2014 оны А/240 дүгээр тушаалаар батлав. Ийнхүү хэрэгжилтийн баг нь бага болон дунд боловсролын түвшинд бүх сургуульд зөвлөн туслах үүрэгтэйгээр ажиллав.

Уг тушаалыг үндэслэн хэрэгжилтийн багийн гишүүдийг эрхэлж буй ажлаас нь түр чөлөөлсөнөөр хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх багийн үйл ажиллагаа эхлэх эрх зүйн орчин бүрдсэн. Багийн ахлагч гишүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулсанаар багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын төлөвлөгөө, гишүүдийн чиг үүрэг, тодорхой болсон байна. Хэрэгжилтийн баг нь улс орон даяар бүх сургуулиудад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулахын тулд бүсийн зохион байгуулалтаар ажиллах "дэд баг"-уудад хуваагдан ажлын төлөвлөгөө гарган, тухайн хариуцсан бүсийн сургууль, багшийн тухай мэдээлэл цуглуулжээ.


Бага боловсролын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зураглалыг гарган, зорилго, зорилтоо дараах байдлаар томъёолсон байна.

Зорилго: Бага боловсролын түвшинд сургалтын цөм хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх, сургуулийн түвшинд хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх

Зорилт:

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн бэлтгэл ажил хангах
2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааг эхлүүлэх, зөвлөн туслах, сайжруулах
3. Мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих, бэхжүүлэх
4. Явцын үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх

Зураг 2.2.1 Удирдлага, бүтэц, зохион байгуулалт, зураглал



Хэрэгжилтийн багийн бүтэц, зохион байгуулалт

Хэрэгжилтийн баг нь боловсролын мэргэжлийн байгууллагуудаас өгсөн чиглэл, зөвлөмжийн дагуу орон нутгийн боловсролын газартай хамтран сургуулиудад чиглэл өгч ажиллахдаа дараах бүтэц зохион байгуулалттай ажилласан байна.

Монголын газар нутгийн байршлыг харгалзан 6 бүсэд хувааж, бүс түс бүрт нийслэлийн 1-2 дүүрэг, 3-4 аймаг хуваарилсан байна. Нийт 756 сургуулиас 617 сургуулийн 23989 багшид хүрч ажилласан ба багийн нэг гишүүн дунджаар 18 сургуулийн 705 багштай ажиллах шаардлага гарсан байна.

Сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэхдээ каскад загварыг ашиглажээ. Аймаг нийслэлийн үндэсний лаборатори сургуулиуд нь сургалтын үндсэн бааз болох ба 3-4 орон нутгийн бүсийн түшиц сургууль, түүнийг тойрсон сүлжээ сургуулиуд байхаар зохион байгуулалтанд орж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах зөвлөх үйлчилгээ үзүүлсэн байна.

Зураг 2.2.2 Цөм хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэх бүтэц, зохион байгуулалт



Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд баг бүрдүүлж, ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулахтай холбоотой дараах үйл ажиллагаа хийгдсэн байна. Үүнд:

- Боловсролын шинэчлэлийн менежментийн бүтэц, зохион байгуулалтыг үндэслэн хэрэгжилтийн баг байгуулах шийвэр гаргах
- Хэрэгжилтийн багийн ахлагч, гишүүд сонгох
- Багийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, төсөв боловсруулах, батлуулах
- Багийн ахлагч гишүүдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах
- Багийн бүтэц, зохион байгуулалт, ажлын нарийвчилсан төлөвлөгөө батлуулах
- Дэд багууд ажлын төлөвлөгөө гаргах, бүсийн сургуулиудын мэдээлэл цуглуулах

Хэрэгжилтийн баг нь 34 хүний бүрэлдэхүүнтэйгээр мэргэжлийн болон сургалтын байгууллага, лаборатори 40 сургуулиудтай хамтарч богино хугацаанд нийт улсын сургуулийн 80 хувь, нийт багш нарын 75 хувийн төлөөлөлд зөвлөн түсэлж, хамтран ажилласан байна.



Давуу тал

- Хэрэгжилтийн баг байгуулсан нь боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, үйл ажиллагаа БСГ, сургууль, багш нарт богино хугацаанд шууд хүрэх боломж бүрдэж, цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн.
- Хэрэгжилтийн баг нь 2013-2014 оны хичээлийн жилд лаборатори сургуулиуд дээр хөтөлбөр, сурах бичгийг түрших, багш нарт сургалтын цөм хөтөлбөрийн талаар таниулах, хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажилласан нь богино хугацаанд олон сургуульд хөтөлбөрийн үзэл баримтлалыг таниулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн эхэн үе болон явцад тулгамдаж буй бодит бэрхшээл, сайн туршлага зэргийг илрүүлэн, тайлагнаж байсан нь эрх зүй, бодлого, хэрэгжилтийн шийдвэрийг бодитой гаргах, сайжруулах арга хэмжээ авахад дэмжлэг болсон.
- Хэрэгжилтийн багийн гишүүд 21 аймаг, 9 дүүргийн лаборатори сургуулиудыг түшиглэн бүсчилсэн байдлаар зохион байгуулж, БСГ-ын арга зүйч нартай хамтран зөвлөн түсэх, загвар хичээл, үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх замаар ерөнхий боловсролын сургуулиудад хүрч ажилласан.
- Хэрэгжилтийн баг нь БХ, БМДИ, БҮТ зэрэг мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаагаа уялдуулан, цаашид хийх шаардлагатай ажлуудыг тухай бүр нь зөвшилцөн, харилцан бие биенээ дэмжин, хамтран ажиллах соёл тодорхой түвшинд бий болсон.
- Орон нутгийн засаг захиргааны байгууллага, Боловсролын газрын дарга, мэргэжилтнүүд, лаборатори сургуулиудын захирал, менежер, багш нартай хичээлийн бодит туршлага, кейс дээр суурилан хамтран ажиллаж, харилцан суралцсан.



Сул тал

Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх баг байгуулах, төлөвлөгөө боловсруулах, гэрээ байгуулах ажил хийгдэж эрх зүйн орчин бүрдсэн боловч бүтэц болон төлөвлөлтийн хувьд дараах асуудлууд үйл ажиллагааны явцад тулгамдсан асуудал болж байв. Үүнд:

- Мэргэжлийн байгууллагууд хэрэгжилтийн багтай харилцан ойлголцож, хүлээн зөвшөөрч, хамтран ажиллахад эхэн үед хүндрэл үүсч байсан байна. Багийн бүрэлдэхүүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тодорхойлон сонгон шалгаруулалт хийгдсэн хэдий ч сургууль багш нарыг удирдан ажиллах түршлага, зөвлөн туслах, судалгаа тандалт хийх мэргэжлийн үр чадвар чадамж дутагдах байдал тулгарч байв.
- “Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал”-д шинэ хөтөлбөр боловсруулан, баталж, үндэсний хэмжээнд хэрэгжилтийг эхлэхээр төлөвлөсөн нь цаг хугацааны хувьд шахуу байсан учир сургуулиуд бэлтгэл хангах, шилжилтийн үеийн зохицуулалт хийх чадамж харилцан адилгүй, хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж хангалтгүй байсан.
- Хичээлийн жилийн түрш боловсруулалт, түршилт, хэрэгжүүлэлтийн явцад сайжруулан батлуулсан хэдий ч хөтөлбөр, сурах бичгийн “боловсруулалт”, “хэрэгжилт”-ийн хооронд бэлтгэл хангах хугацаа хангалтгүй байв.
- Хүний нөөцийн түршлага, үр чадвар, ойлголтын зөрөөгээс хамааран багш нарын сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй, үялдаа холбоо бага байх тохиолдол гарч байсан нь багш нарт “өөр, өөр юм ярьдаг” гэсэн тодорхойгүй байдал үүсгэх нөхцөл болж байсан.
- Хэрэгжилтэд шилжих, бэлтгэл хангах цаг хугацаа хангалтгүйн улмаас орон нутгийн боловсролын газар сургуулиудад хэрхэн дэмжлэг үзүүлэх төлөвлөлт бүрэн хийгдээгүй, тогтолцоо тогтвортой бүс учир санхүүгийн нөөц хязгаарлагдмал, хүний нөөцийн хөгжил тасралтгүй хөгжих боломжгүй байв.



Санал

- Сургуулийн удирдлага, багш нарт бодлого, хөтөлбөрийн үзэл санааг ойлгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх тогтолцоог бэхжүүлэхийн тулд:
 - Судалгаанд суурилсан, бодитой үндэслэл бүхий хөтөлбөрийн хэрэгжилтийн бэлтгэл хангах болон хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх урт бөгөөд дунд хугацааны төлөвлөгөө боловсруулах, төсөв батлуулах
 - Дунд хугацааны төлөвлөгөөнд үндэслэсэн хэрэгжилтийг дэмжих баг, мэргэжлийн болон боловсролын байгууллага төлөвлөгөө боловсруулах, батлуулах
 - Хүний нөөцийг чадавхижуулах, байгууллага, баг, ажлын хэсгийн чиг үүргийг тодорхой болгох зэрэг эрх зүйн зохицуулалтыг сайжруулах,
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үйл явцын мониторингийн тайланд дүн шинжилгээ хийж хэрэгжилтийг тасралтгүй сайжруулах эргэх холбоог бий болгож, сургууль, багш, сурагч, эцэг, эх, холбогдох олон нийтэд мэдээлэл хүргэх, хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэх.
- Орон нутгийн боловсролын байгууллагын чадавхыг бэхжүүлэх, нэгдсэн удирдамж чиглэлийн дагуу мэргэжлийн байгууллагууд болон сургуулиудтай хамтарч ажиллах нөхцөл бололцоог хангах.
- Сургууль, багш нарын мэргэжил, үр чадварыг дэмжих гарын авлага, зөвлөмж, зайн сургалтын материал, боловсруулж зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах.

P2.2.A2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих зөвлөх үйлчилгээ үзүүлэх

Хэрэгжилтийн баг нь БМДИ, орон нутгийн боловсролын газартай хамтран 13817 багшид хичээл, үйл ажиллагаа зохион байгуулах талаар зөвлөгөө өгсөний зэрэгцээ 28804 эцэг, эхэд (бага боловсролд 11519, суурь боловсролд 16285), 174 орон нутгийн удирдлага, 296 Боловсролын газрын мэргэжилтэн, удирдлагад уулзалт, ярилцлага хийн шинэ хөтөлбөрийн талаар танилцуулсан байна.

Сургуулийн түвшинд багшийн зааж буй хичээлд ажиглалт хийн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд:

1. Бага боловсролын 13421, дунд боловсролын 8620 хичээл ажиглаж, зөвлөгөө өгсөн
2. Бага боловсролын 25094 багш, дунд боловсролын 39638 багш, сургуулийн удирдлага 6138, БСГ-ын 400 мэргэжилтэнд /давхардсан тоо/ сургалт зохион байгуулсан
3. Боловсролын газрын мэргэжилтэн 538, орон нутгийн удирдлага 277, эцэг, эхийн төлөөлөл 19234 хүнд /давхардсан тоо/ уулзалт ярилцлага хийсэн байна.

P2.2.A2.T1. Зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангах

Хэрэгжилтийн баг нь зөвлөх үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлын хүрээнд шинэ хөтөлбөрийн үзэл баримтлал, чиг хандлага, хэрэгжүүлэх зарчим зэргийг ойлгуулах, хамтын ажиллагаа сайжруулах зорилгоор нийслэл, аймгийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтэс, лаборатори сургуулиудын удирдлага, холбогдох хүмүүстэй уулзалт зохион байгуулжээ. Мөн аймаг, дүүрэгтэй ажлын төлөвлөгөөгөө үялдуулах, хамтран ажиллах бүтцээ тогтох, суурин ажиллах сургуулиа сонгох зэрэг ажлыг хамтран гүйцэтгэсэн байна. Харин, багийн ахлагчийн удирдлаган дор зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургуулийн хэрэгцээг тодорхойлох, удирдамж боловсруулах, хэрэглэгдэхүүний бэлтгэл хангах, ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэг ажлыг гүйцэтгэсэн болно.

- Зөвлөн туслах ажлын бэлтгэл ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа хийгдсэн байна. Үүнд:

Орон нутгийн боловсролын газар, лаборатори сургуулиудын хүрээнд

- Хамтран ажиллах чиглэл тодорхойлох уулзалт зохион байгуулах
- Ажлын төлөвлөгөө үялдуулах
- Ажиллах бүтэц, зохион байгуулалтаа тогтох
- Хамтарч ажиллах сургуулиа сонгох

Зөвлөн туслах багийн бэлтгэл ажлын хүрээнд

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх сургуулийн хэрэгцээг тодорхойлох
- Зөвлөх үйлчилгээний удирдамж боловсруулах
- Зөвлөх үйлчилгээний бэлтгэл, хэрэглэгдэхүүний бэлтгэл хангах
- Орон нутаг, сургуультай ажиллах төлөвлөлт боловсруулах

Хэрэгжилтийн багийн гишүүд хариуцсан дүүргийн Боловсролын хэлтсийн дарга, мэргэжилтэнтэйгээ уулзан, аймгийн Боловсролын газартай холбогдон тус хичээлийн жилд хэрхэн хамтран ажиллах төлөвлөгөөгөө танилцуулан, түүнийгээ дүүргийн ажилтай үялдуулан, сургуулиуд дээр хэрхэн, яаж ажиллах хуваарь гарган сургуулиудад хүргэжээ. Багийн гишүүдийн тухайн дүүрэгт байрлах ажлын байрны асуудлыг шийдэн, ажиллах нөхцлөөр хангах асуудлыг шийдсэн байна.

P2.2.A2.T2. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх (Сургууль дээр ажиллах)

Хэрэгжилтийн баг нь багш нарын ажлын байран дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор биечлэн болон онлайнаар, гарын авлага, цахим хэрэглэгдэхүүнээр гэх мэт олон хэлбэрээр зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна. Хэрэгжилтийн багийн зөвлөх туслах үйл ажиллагаа, мониторинг хийх онцлог нь зөвхөн нэг удаа сургууль, багштай танилцах бүс тэдэнтэй эргэх холбоотой тасралтгүй хамтран ажиллаж, тулгамдсан асуудлыг шийдэхэд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлсэн болно. 2013-2014 оны хичээлийн жилд бага боловсролын 1920 хичээлд ажиглалт хийснээс 610 удаагийн хэлэлцүүлэг хийж 192 хичээлийн хамтран сайжруулсан байна. 2014-2015 онд нийт 20121 хичээлд ажиглалт (бага -11501, дунд-8620) хийснээс 7782 хичээлд хэлэлцүүлэг хийн зөвлөгөө өгч, 945 хичээлийн төлөвлөгөөг тухайн багштай хамтран сайжруулсан байна.

Сургууль дээр зөвлөн туслах ажлыг хийхдээ дараах чиглэлийн хүрээнд ажилласан байна. Үүнд:

- Сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт (агуулга, арга зүй, хичээлийн технологи, хэрэглэгдэхүүн, үнэлгээ)
- Сайн хичээл/үйл ажиллагаа (судлагдахууны баг, хичээлийн бэлтгэл, хичээл ажиглалт, хэлэлцүүлэг)
- Сургуулийн менежментийн шинэ загварын хэрэгжилт (сургалтын төлөвлөгөө, эрх зүйн зохицуулалт, сургуулийн зорилго, төлөвлөлт, эцэг эх, олон нийтийн оролцоо, багшийн хөгжил)
- Сургуулийн соёл, дэг зэрэг үйл ажиллагааны явцтай танилцан зөвлөн тусалж хамтран ажиллах

Лабортари сургууль дээр суурилан нийт сургуулиудын хичээлд ажиглалт хийж, хэрэгжилтийн багийн гишүүд өөрсдөө хичээл зааж үзүүлэн, хамтдаа төлөвлөлтөө сайжруулсан нь бодит байдал дээр арга зүйн тулгамдсан асуудлыг шийдэхэд дэмжлэг болсон байна. Мөн багш нартай ажиллахын зэрэгцээ сургуулийн удирдлага, боловсролын газрын мэргэжилтэн, эцэг эхчүүдэд сургалт, үүлзалт зохион байгуулсан байна.

Сургууль дээр хийгдсэн үйл ажиллагааг тоймловол:


- Хичээлд ажиглалт хийх хуваарь гаргах
- Хичээл ажиглах
- Хичээлийн дараах хэлэлцүүлэг хийх
- Зөвлөх багийн гишүүн хичээл заах /үзүүлэх хичээл/
- Багшид зөвлөн туслах, хамтран ажиллах
- Сургуулийн удирдлагад зөвлөн туслах, хамтран ажиллах
- Эцэг, эх олон нийтэд шинэчлэлийн бодлогыг ойлгуулах
- Сургагч багшид /орон нутгийн/ зөвлөн туслах, хамтран ажиллах

Р2.2.А2.Т3. Зөвлөх үйлчилгээний үр дүнг тооцох

Хэрэгжилтийн баг нь БМДИ болон орон нутгийн боловсролын газар, дүүргийн хэлтэстэй хамтран зөвлөх үйлчилгээний үр дүнг нэгтгэн дүгнэж сургалтын үйл ажиллагааг сайжруулах санал боловсруулан дараагийн ажилд тусгах ажлыг улиралд нэг удаа тогтмол хийсэн байна. 2014-2015 оны хичээлийн жилд зөвлөн туслах үйлчилгээг нийслэлд 250, орон нутагт 276 нийтдээ 526 сургуульд үзүүлсэн байна.

Цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэл, удирдамжид боловсролын хэлтэс, газрууд болон бусад мэргэжлийн байгууллагууд, сургуулийн захирал, сургалтын менежерүүдэд хүүхэд бүрийн хөгжлийн үр дүн, ахиц амжилттай өөрийн биеэр танилцаж, хичээл, үйл ажиллагаанд тогтмол оролцон зөвлөн туслах үүргийг тусгасан байдаг. Эдгээр субъектууд тус үүргээ дараах байдлаар хэрэгжүүлсэн байна .

Зураг 2.2.3 Багшийн хичээлд ажиглалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байдал



Сургалтын үйл ажиллагааг сайжруулах эргэх холбоог бий болгох зорилгоор зөвлөх үйл ажиллагааны үр дүнг сургуулиудад танилцуусан байна. Мөн зөвлөх үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор сургууль, багш нараас санал хүсэлт цуглуулан тайланг нэгтгэн БСШУЯ болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад танилцуулснаар үйл ажиллагаандаа тусгаж сайжруулалжээ.

Зөвлөн туслах үйл ажиллагааны үр дүнг тайлагнах ажлын хүрээнд дараах үйл ажиллагаа хийгдсэн байна. Үүнд:

- Сургууль багш нартай уулзаж, зөвлөх үйлчилгээний үр дүн танилцуулах
- Зөвлөх үйлчилгээний талаар санал авах
- Зөвлөх үйлчилгээний тайланг нэгтгэж хүлээлгэж өгөх
- Тайланд үндэслэж холбогдох байгууллагад танилцуулах, хэлэлцүүлэг хийх
- Дараагийн үйл ажиллагааны төлөвлөлт хийхэд уялдуулах

P2.2.A2.T4. Онлайнаар зөвлөн туслах

Багш нарт богино хугацаанд мэдээлэл өгөх, солилцох зорилгоор онлайн орчин бүрдүүлж ажилласан. Зөвлөн туслах хэрэгцээг тодорхойлсон судалгааны үр дүнг үндэслэн багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр судлагдахуун бүрээр зөвлөхүүд админ болж, 17 судлагдахуун, 3 үйл ажиллагаагаар фэйсбүүкийн хаалттай групп үүсгэн орон зай, цаг хугацаанаас үл хамааран багш бүрт зөвлөн туслах ажлыг цахим хуудсаар дамжуулан (онлайнаар) хэрэгжүүлсэн. Нийт 16 фэйсбүүк групп, 1 блог нээж ажиллуулсан ба 2016 оны 05 сарын эхний байдлаар 17345 гишүүнтэй болж (6246 идэвхтэй, 5495 идэвх сул, 5242 идэвхгүй) 2529 файл байршуулж, олны хүртээл болгосон байна.

Агуулгыг төрөлжүүлэн авч үзвэл нэгж болон ээлжит хичээлийн төлөвлөлтийн тухай мэдээлэл 1430, хэрэглэгдэхүүний мэдээлэл 715, үнэлэх арга, хэрэгслийн тухай мэдээлэл 220 байгаагаас үзэхэд хүүхэд бүрийн хөгжлийг дэмжихийн тулд хүүхдээ оношлон түүнд үндэслэн нэгж, ээлжит хичээлээ хэрхэн нарийвчлан төлөвлөх, ямар хэрэглэгдэхүүн ашиглах, үнэлэх арга хэрэгслээ хэрхэн оновчтой төлөвлөх, ашиглах зэрэг нь илүү эрэлт хэрэгцээтэй, мөн тулгамдсан асуудал байсан байна.

Энэ үйл ажиллагааны хүрээнд дараах ажлууд хийгджээ. Үүнд:

- Гишүүдээ бүртгэх
- Асуулга авч хэрэгцээтэй мэдээлэлийг тодорхойлох
- Мэдээ, мэдээлэл байршуулах, зөвлөлгөө өгөх
- Хэлэлцүүлэг хийх
- Үр дүн, туршлага байршуулах, хуваалцах
- Багш нарыг орон нутгийн боловсролын газар болон мэргэжлийн байгууллагуудтай холбох
- Блог нээж ажиллуулах

Хүснэгт 2.2.1 Зөвлөн туслах ажиллагааны дүн

Үйл ажиллагаа		Давтамж	2014 он	2015 он	
			Бага боловсрол (туршилт)	Бага боловсрол (хэрэгжилт)	Суурь боловсрол (туршилт, хэрэгжилт)
Хичээл, үйл ажиллагаанд зөвлөн туслах (багшид)	Ажиглалт хийсэн хичээлийн тоо		1920	11501	8620
	Хэлэлцүүлэг хийсэн хичээлийн тоо		610	4522	3260
	Хамтран сайжруулсан хичээл		192	515	430
	Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт гарын авлага		“Хүүхэд бүрийг хөгжлийг дэмжих сургалтын арга зүй” зөвлөмж 1260 багшид		“Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт” гарын авлага 2034 багшид
	Сайн хичээл, үйл ажиллагааны DVD бичлэг		8 багц 24 хичээл		8 багц 20 хичээл

Сургалт зохион байгуулах	Багшийн тоо	1-2	13859	11235	39638
	Сургуулийн удирдлагын тоо	2	1364	2046	2728
	БСГ дарга арга, зүйчдын тоо	2	60	60	280
Уулзалт, ярилцлага, лекц хийсэн	БСГ дарга арга, зүйчдын тоо	2	60	236	242
	Орон нутгийн удирдлагын тоо	2	29	174	74
	Эцэг эхчүүдийн тоо	2	5432	11519	2283



Давуу тал

- БСШУЯ-тай хийсэн гэрээний дагуу Хэрэгжилтийн баг нь Боловсролын газрын мэргэжилтэн, сургуулийн захирал, сургалтын менежерүүдтэй хамтран сургуулийн үйл ажиллагаа, багш нарт тулгамдаж буй асуудлыг шийдэхэд зөвлөн туслах соёлыг төлөвшүүлэх ажлыг удирдан ажилласан.
- Багш нарын мэргэжил дээшлүүлэх, хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг сайжруулах чиглэлээр БСШУЯ, мэргэжлийн байгууллагуудын бодлого үйл ажиллагааг үндэсний түвшинд сургууль бүрт хүргэн, зөвлөн туслах, хөгжлийн хэрэгцээг судалж, сайн туршлага, хамтын ажиллагааг дэмжин ажилласан.
- Зөвлөн үйлчилгээний үр дүнг холбогдох байгууллагуудад танилцуулж байсан нь тайланг эргэлтэд оруулж асуудлаа илрүүлэх, шийдэх, сайжруулах саналыг сургууль, багш нарт өгөх эргэх холбооны эхлэл болсон байна.
- Зөвлөх үйлчилгээг онлайн хэлбэрээр өгсөн нь богино хугацаанд олон хүн хамрах, шинэ санаа, туршлага солилцох, хэлэлцүүлэг хийх, судалгааны өгөгдөл цуглуулахад үр дүнтэй байсан байна.
- Зөвлөх үйлчилгээний явцад багш нарт тулгамдаж буй асуудлыг илрүүлэн “суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны гарын авлага” боловсруулсан нь эргэх холбоог бүрдүүлэх оролдлого болсон байна.
- Шинэ хөтөлбөр, сурах бичгийн үзэл баримтлалыг эцэг, эх, орон нутгийн удирдлагад танилцуулсан нь шинэлэг бөгөөд олон нийтийн оролцоог дээшлүүлэхэд үр дүнтэй ажил болжээ.
- Хэрэгжилтийн баг нь боловсролын газартай хамтран нийт сургуулийн 80%-д очиж хэрэгцээнд нь суурилсан зөвлөн тусалсан нь “яамны төлөөлөл сургууль дээр очсон урам өгсөн, дэмжлэг үзүүлсэн” үйл ажиллагаа байлаа.



Сул тал

- Зөвлөн туслах удирдамж, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын боловсруулалт нь хүний нөөцийн чадамж бэлтгэлээс хамааран харилцан адилгүй, хангалтгүй байх шалтгаан болж байсан.
- Цөм хөтөлбөрийн хэвлэгдсэн гарын авлагаас өөр дорвитой шинэ хөтөлбөрийн үзэл санаа, агуулга, аргачлалын талаар багш нарт дэмжлэг, зөвлөмж болохуйц ном, материал хангалтгүй байсан.
- Хичээлд ажиглалт хийж зөвлөгөө өгөхөд хөтөлбөрийн үзэл баримтлал болон “сайн хичээл”-ийн талаар ойлголтын зөрөөтэй байдал нь бэрхшээл үүсгэж байв.



Санал

- Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас үл хамааран шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах ажлын төлөвлөгөөг үндэсний болон орон нутгийн түвшинд баталж, төсөвт суулгах.
- Сургууль дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үүрэг, гүйцэтгэх ажлыг мэргэжлийн байгууллага болон орон нутгийн боловсролын байгууллагын чиг үүрэгт тодорхой тусган, эрх зүйн орчинг сайжруулах.
- Үндэсний болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтаар хангаж, зөвлөн туслах, туршлага солилцох ажлын үр дүнд шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах, эргэх холбоо бүхий тогтолцоо бүрдүүлэх.
- Сургуулийн захирал, Боловсролын газрын дарга ажлын чиг үүрэгт зөвлөн туслах, туршлага солилцох, сургалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг албажуулах.
- Мэргэжлийн болон боловсролын байгууллагын зөвлөх үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн чадавхыг тогтмол дээшлүүлэх энэ чиглэлийн хамтын ажиллагааг дэмжих
- Багш нарт тулгамдаж буй асуудлыг нь шийдэх хичээл төлөвлөлт, үнэлгээний асуудлаар мэргэжлийн байгууллагууд зөвлөмж, гарын авлага боловсруулах.

Р2.2.А3. Туршлага судлах

Менежментийн баг нь БДБ-ын шинэчлэлийн хүрээнд ажилласан багийн гишүүдийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор гадаадад туршлага судлах чиглэл, зөвлөмж өгсөний дагуу хэрэгжилтийн баг нь Япон улсад мэргэжлийн байгууллагын төлөөлөл, ялангуяа сургуулийн удирдлага, багш нарыг явуулах ажлыг зохион байгуулсанаар 2013-2016 онд 292 хүн Япон улсад туршлага судлахаар явсан байна.

Шинэ хөтөлбөр хэрэгжүүлж буй сайн жишээг түгээн дэлгэрүүлэх, туршлага судлах ажлыг БСШУЯ-ны СБТГ-аас удирдан “Сайн хичээл, үйл ажиллагаа” улсын зөвлөгөөн зохион байгуулахыг бүх сургууль, боловсролын газар, мэргэжлийн байгууллагуудад чиглэл, удирдамж өгч ажилласан. Үүний зэрэгцээ сургууль хооронд, аймаг, дүүрэг хооронд туршлага судлах ажлыг сургууль, боловсролын газрууд өөрсдөө санаачлан зохион байгуулж ажиллажээ.

Р2.2.А3.Т1. Гадаадад туршлага судлах

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих шинэ санаа илрүүлэх, сайн туршлагаас суралцах зорилгоор сургуулийн удирдлага, багш, лаборатори 40 сургуулийн бага боловсролын менежерүүд, мэргэжлийн байгууллагын төлөөлөл Япон улсад туршлага судлах ажлаар 5-60 хоногийн хугацаатай явсан байна.

Нэг удаа 15-20 орчим хүн ажлын 5 хоногийн хөтөлбөрт сургууль дээр очиж хичээлд ажиглалт хийх, багшлах, суралцах үйл явцыг бодитоор үзэх зорилготой байсан байна. Японы 6 бага сургуулийн сургалтын үйл ажиллагаа, орчин, сургуулийн менежмент, сургалтыг дэмжих үйл ажиллагаа болох Амьдрах чадварт суралцах, Ёс суртахуун, Хичээлээс гадуурх үйл ажиллагаа болон бусад судлагдахууны хичээлд ажиглалт хийж багш, сургуулийн удирдлагатай уулзан, тухайн мэргэжлийн хүмүүсийн лекц, зөвлөгөөг сонссон байна.

Р2.2.А3.Т2. Дотоодын туршлага солилцох

Үндэсний лаборатори сургуулийг түшиглэсэн туршлага хуваалцах, суралцах ажиллагаа

Хэрэгжилтийн баг дотооддоо бүсийн зохион байгуулалтаар ажилласан. Бүс бүр өөр өөрийн онцлогтойгоор туршлага хуваалцах ажлаа зохион байгуулан, сургууль багш нар сургуулийн менежмент, сургалтын цөм хөтөлбөрийн мөн чанарыг ойлгох, өөрийн онцлогийн харгалзан, менежментийн арга барилыг аль болох бэрхшээл багатай зохион байгуулахад чиглүүлсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн сайн туршлага солилцох үйл ажиллагааг БСШУЯ-наас баталсан удирдамжийн дагуу аймаг, нийслэл, сумын сургууль хооронд зохион байгуулагдсан.

**Давуу тал**

- Олон хүнийг богино хугацаанд гадаадад үр дүнтэй, зардал багатай туршлага судлах загвар болохуйц үйл ажиллагаа болсон байна
- Хамарсан хүрээ нь тогтолцооны шинжтэй байсан нь /мэргэжлийн байгууллага, хэрэгжилтийн баг, их дээд сургуулийн багш, ерөнхий боловсролын сургуулийн захирал, менежер, багш/ сайн туршлагыг цогц байдлаар нэвтрүүлэх, ялангуяа “сайн хичээл, үйл ажиллагаа” улсын зөвлөгөөн хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой болжээ.
- Сургууль багш нар үралдах биш хамтран ажиллаж, харилцан суралцах соёл төлөвшиж, маш идэвхтэй хол ойр үл хамааран туршлага солилцож хамтран ажилласан.
- Лаборатори сургуулийн бага боловсролын 40 менежер туршлага судалж ирсэн нь сургуулийн менежмент, сургалтын талаар нэгдсэн ойлголттой болж, бага боловсролын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн чухал арга хэмжээ болжээ.

**Сул тал**

- Гадаадад туршлага судлах төсөв хангалтгүй байсан учраас тухайн сургууль, багш өөрсдөө тодорхой хэмжээний зардал төлсөн, энэ нь санхүүгийн боломжтой байгууллага, багш хамрагдах, зорилтот сургуулийн багш, төлөөлөл хамрагдахгүй байх эрсдэлтэй
- Туршлага судлаад сурсан зүйлээ түгээн дэлгэрүүлэх, сургалт үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлж, үр дүнг үнэлэлдэг байх

**Санал**

- Гадаадад болон дотоодод туршлага судлах ажлыг нэгдсэн төлөвлөгөөнд суулгаж, төсөв батлуулах.
- Туршлага судлах үйл ажиллагааг тодорхой төлөвлөгөөтэй, шалгууртай, ажлын үр дүнг үнэлдэг тогтолцоотой болох, мэргэжлийн болон боловсролын байгууллагын чиг үүрэгт тодорхой тусгах.
- Онлайн сургалтын материалыг туршлага судлах, туршлага солилцох үйл ажиллагаанд үр дүнтэй ашиглах.

P2.2.A4. Сайн хичээл, үйл ажиллагааны зөвлөгөөн зохион байгуулах

Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, тэргүүн туршлага солилцох, арга зүй, технологийг сайжруулах, судалгааны үр дүн, тайлан, илтгэл хэлэлцүүлэх зөвлөлгөөн 2013-2014, 2014-2015 оны хичээлийн жилийн турш зохион байгуулсан. Энэхүү зөвлөлгөөнд 4310 хичээл, 292 туршлага, судалгааны үр дүнгийн сан бүрдэж 25179 багш, мэргэжилтнүүдийн /давхардсан тоо/ хүрээнд зохион байгуулагдсан. Уг үйл ажиллагаанд 4320 эцэг, эх, 257 орон нутгийн удирдлагууд оролцсон.

P2.2.A4.T1. Зөвлөгөөний бэлтгэл, зохион байгуулалт, төлөвлөлт

Мэргэжлийн байгууллагууд болон хэрэгжилтийн баг нь орон нутгийн боловсролын газруудтай хамтран “Сайн хичээл, үйл ажиллагаа” зөвлөлгөөнийг улс орон даяар зохион байгуулах бэлтгэл ажлыг тухайн жилийн 8 сараас эхлэн 11 сар хүртэлх хугацаанд гүйцэтгэсэн. БСШУЯ-аас 2014 оны 11 сар, 2015 оны 8 сард “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сайн хичээл, үйл ажиллагааны удирдамж”-ийг батлан орон нутгийн боловсролын газруудад албан тоотоор хүргүүлсэн. Зохион байгуулалтыг дараах түвшнээр хийсэн. Үүнд:

- Үндэсний хэмжээнд зохион байгуулах бүсийн төлөвлөгөө, зураглал
- Аймаг, дүүргийн бүсийн хэмжээнд зохион байгуулах төлөвлөгөө /21 аймаг, 9 дүүргийн 90 бүс/
- Сургуулийн түвшинд зохион байгуулах төлөвлөгөө /756 сургууль бүрт 4 баг, баг бүрт 3 гишүүн/

P2.2.A4.T2. Сайн хичээл, үйл ажиллагааны зөвлөгөөнийг орон нутагт зохион байгуулах

Сургууль, аймаг, дүүрэг тус бүр дээр ажлын хэсэг зохион байгуулагдаж энэ үйл ажиллагааг хэрэгжилтийн баг, орон нутгийн боловсролын газар, дүүргийн хэлтэстэй хамтран зохион байгуулж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Сургуулийн сайн хичээл, үйл ажиллагаа: 756 сургуулийн бага, дундын 28760 багш 11 төрлийн хичээл, үйл ажиллагааг багаар хамтран зохион байгуулсан
2. Бүсийн сайн хичээл, үйл ажиллагаа: 21 аймаг, 9 дүүргээс дунджаар 3 бүс /багийн гишүүн-8/-ийн багш нар 990 сайн хичээл, үйл ажиллагааг зохион байгуулахад 3910 багш оролцсон.
3. Улсын хэмжээнд 21 аймаг, 9 дүүргээс шалгарсан 4 багц үйл ажиллагаа, 330 хичээл, үйл ажиллагаа уралдаанд танилцуулсан. 2425 багш энэ үйл ажиллагаанд оролцсон.

Дээрх үйл ажиллагаа нь хичээлийн жилийн түрш буюу 9 сараас эхлэн 5 сард дууссан бөгөөд, сургуулийн түвшинд 9 сараас 11 сар хүртэл, бүсийн түвшинд 11-12 саруудад, үндэсний түвшинд 3-4 саруудад зохион байгуулагдсан байна.

P2.2.A4.T3. Улсын зөвлөгөөн зохион байгуулах

2014-2015 оны хичээлийн жилийн түрш сургууль, бүс, дүүрэг, аймаг, нийслэл, улсын гэсэн 5 түвшинд хүүхэд бүрийг хөгжүүлэх тэргүүн түршлага солилцох үр дүнг сайжруулах, арга зүй, технологи, судалгааны үр дүн тайлан илтгэл хэлэлцүүлэх сайн хичээл үйл ажиллагааны зөвлөгөөн анх удаа зохион байгууллаа. Энэ зөвлөгөөнөөр 4310 сайн хичээл, 292 сайн түршлага, судалгааны үр дүнгийн сан бүрдэж, 4310 удаагийн хэлэлцүүлэг 25179 багш, мэргэжилтнүүдийн хүрээнд амжилттай зохион байгуулсан. Энэ үеэр 4320 эцэг эх, 257 орон нутгийн удирдлагууд сайн хичээл үйл ажиллагаанд оролцон ажиглалт хийжээ.

2015 оны 5 сарын 15-нд сайн хичээл, үйл ажиллагаа үндэсний зөвлөлгөөн нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулагдаж улсын хэмжээнд шалгарсан шилдэг 60 хичээл, 30 илтгэл тавигдаж 5 телевизээр орон даяар шууд дамжуулагдсан байна.

Уг ажлыг зохион байгуулахад БСШУЯ-ны СБТГ-ын удирдлаган дор мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 10 хүний бүрэлдэхүүнтэй “Ажлын хэсэг” байгуулагдсан ба Хэрэгжилтийн баг, БМДИ нь уг үйл ажиллагааг хамтран зохион байгуулжээ. Орон нутгаас шалгарч ирсэн сайн хичээл, үйл ажиллагаа, илтгэлийг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажилд 150 орчим хүн оролцсон ба уг зөвлөлгөөнд 620 хүн хамрагдаж доорх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:

- ❖ БСШУЯ-аас ажлын хэсэг, ажлын төлөвлөгөө, төсөв батлах
- ❖ Бэлтгэл ажил хангах
 - Хичээл, үйл ажиллагааны чиглэл гаргах
 - Зөвлөлгөөн зохион байгуулах сургууль сонгох
 - Сэдвийг сургууль, багш нарт хүргэх
 - Хичээл үйл ажиллагааны төлөвлөлт цуглуулах
 - Төлөвлөлтөд мэргэжлийн зөвлөгөө өгөх
 - Оролцогчдын нэрс гаргах
- ❖ Зөвлөлгөөн зохион байгуулах
 - Тухайн байгууллага, сургууль зохион байгуулалатын бэлтгэл ажлыг хангах
 - Сайн хичээл, үйл ажиллагааг явуулах, видео бичлэг хийх
 - Хэлэлцүүлэг хийх, мэргэжлийн зөвлөлгөө өгөх
 - Шилдэг илтгэл тавих, сонсох
 - Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын илтгэл тавих – БСШУЯ
- ❖ Зөвлөлгөөний дараах эргэх холбоо
 - Зөвлөлгөөний үр дүнгийн талаар санал асуулга авах
 - Тайланг мэргэжлийн байгууллагуудад танилцуулах
 - Зөвлөлгөөнийг сайжруулах саналыг нэгтгэн дараагийн төлөвлөлтөд тусгах

P2.2.A4.T4. Сайн хичээл үйл ажиллагааны бичлэгүүдийг dvd болгож түгээх

Хэрэгжилтийн баг нь сайн хичээл, үйл ажиллагааг сонгон DVD болгон олны хүртээл болгох, сургуулиудад түгээх зорилгоор бичлэгийн компанитай гэрээ хийн 8 багцийн 24 хичээлээр бичлэг хийв. Хичээл, үйл ажиллагаа, илтгэл сонгоход БМДИ, БХ, орон нутгийн БСГ, дүүргийн боловсролын хэлтэс хамтран оролцсон. Үйл ажиллагааны хувьд:

- ✧ Сайн хичээл, үйл ажиллагаа, илтгэл сонгох
- ✧ Бичлэгийн компани сонгох, гэрээ хийх
- ✧ Бичлэг хийх, монтажлах, редакторлах
- ✧ Шторк, хавтас хийх
- ✧ DVD хөрвүүлэх, хувилах
- ✧ Сургууль багш нарын хүртээл болгох

P2.2.A4.T5. Сайн хичээлүүдийг ном хэлбэрт оруулах, түгээх

DVD-д ороогүй сайн хичээл, үйл ажиллагаа, илтгэлийг ном болгон хэвлэж 33634 багшид хүргэсэн. Үйл ажиллагааны хувьд:

- ✧ Сайн туршлага цуглуулах (БМДИ, БХ, БСГ, Боловсролын хэлтэс хамтран)
- ✧ Туршлагаа төрөлжүүлэх
- ✧ Эмхтгэлийн эхийг бэлтгэх
- ✧ Хэвлэлийн компани сонгох
- ✧ Хэвлэлийн эхийг бэлтгэх
- ✧ Хэвлэх, хуваарилах
- ✧ Сургууль багш нарын хүртээл болгох

Зөвлөгөөний үр дүнг түгээн дэлгэрүүлэх, зохион байгуулалт болон үр дүнг сайжруулах санал авах зэрэг нь хэрэгжилтийн үйл явцад эргэх холбоог бэхжүүлэх ач холбогдолтой байлаа.

**Давуу тал**

- “Хүүхэд бүрийг хөгжүүлэх сайн хичээл, үйл ажиллагаа”-ны зөвлөгөөн нь багш багштайгаа, багш мэргэжлийн байгууллагатай, багш, удирдлага, олон нийт, эцэг эхчүүд хамтран ажиллах, харилцан суралцах бололцоог олгож үндэсний хэмжээнд зохион байгуулагдсан.
- БСШУЯ-аас баталсан зөвлөгөөн зохион байгуулах удирдамжинд (2014 оны 11 сарын А/330, 2015 оны 9 сарын А/371) нэгжээс эхлээд бүхий л оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг, учир шалтгаан, зорилго, оролцоо, үр дүнг тодорхойлсон нь үндэсний хэмжээнд амжилттай хэрэгжих нөхцөл бүрдүүлсэн.
- Багшийн үр чадвар, сургалтын үнэлгээ, арга зүй, хэрэглэгдэхүүн, сэтгэлзүй болон үйлийн орчний давуу болон сул талыг тодорхойлох, сайн туршлага хуваалцах, сайжруулах зүйлсийг илрүүлэхэд бодит дэмжлэг болсон.
- Багш нарын баг, ЗАН, сургууль, бүс, дүүрэг, аймаг, нийслэл, мэргэжлийн институт, төрийн захиргааны төв байгууллагын түвшинд буюу “нэгжээсээ бодлого боловсруулах хүртэл хамтарч ажилласан” үйл ажиллагаа байв.
- Сайн буюу давуу тал дээр суурилан хөгжих хамтын ажиллагааны соёл, хүүхэд бүрийг хөгжүүлэхэд хичээл бүр сайн байх сургуулийн менежмент тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай үйл ажиллагаа болсон.
- Багш нар багаараа бэлтгэж зохион байгуулсан сайн хичээлийн видео бичлэг, хичээлийн төлөвлөлт, сайн туршилгын илтгэлийг гарын авлага болгон хэвлэж, сургууль бүрийн тоогоор хүргэсэн нь оролцогчид болон нийт сургуулиудад ашиглах жишиг материал болсон.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох 5 телевизийн сувгаар 7 өөр багшийн хичээлийг орон даяар шууд дамжуулсан эцэг эхчүүд олон нийтэд зөв ойлголт өгөх боломж болжээ.



Сул тал

- Сайн хичээл, үйл ажиллагааг зохион байгуулахад хүн хүч, санхүү, цаг хугацааны нөөцийн төлөвлөлтийг сургуулийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулах, мөн мэргэжлийн болон техникийн зөвлөмж дэмжлэг сургуулиудад чухал шаардлагатай байв.
- БСШУЯ-аас баталсан удирдамжийн дагуу 2014-2015, 2015-2016 оны хичээлийн жилд уг зөвлөгөөн зохион байгуулагдсан хэдий ч 2016-2017 оны хичээлийн жилд хийгдсэнгүй.
- Хичээл, сургалтын чанарыг сайжруулахад шаардлагатай багш нарын багаар ажиллах, хүүхэд төвтэй сургалтыг дэмжих, сургуулийн менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой үйл ажиллагаа нь зарим орон нутгийн болон сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгагдаагүй тохиолдол байсан.



Санал

- Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх бодитой, үр дүнтэй хэрэгжсэн энэхүү улсын зөвлөмжөөнийг тогтвортой, тасралтгүй хэрэгжүүлэх
- Жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, үндэсний болон орон нутгийн төсөвт суулгах.
- Мэргэжлийн болон боловсролын байгууллагыг чадавхижуулж, ойлголтын зөрөөг багасгаж бодит дэмжлэг үзүүлэх гарын авлага боловсруулах, багш судалгааны ажил хийхийг дэмжих.
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, тэдний дэмжлэгтэй асуудал шийдэх.
- Сургуулиуд өөрсдийн сургалт, судалгааны нэгдсэн төлөвлөлтийн дагуу хичээл, үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах тогтолцоо бүрдүүлэх.

Р2.2.А5. Мониторинг зохион байгуулах (нийслэл болон орон нутгийн сургуульд)

Р2.2.А5.Т1. Мониторингийн баг байгуулах, төлөвлөлт хийх

БСШУЯ-аас жилд нэг удаа сургуулийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийсэн бөгөөд мэргэжлийн байгууллагуудтай хамтран чиглэл, төлөвлөгөө гарган хэрэгжилтийн баг зохион байгуулжээ.

Зорилго: Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжих бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж бодит байдлыг тодорхойлох, сургалт зохион байгуулах, цаашид сайжруулах санал зөвлөмжөөр хангах явдал юм.

Зорилт:

1. Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилт, суралцахуйн зорилт ээлжит хичээлийн уялдаа холбоо, зорилгод хүрч буй эсэхийг ажиглах, сайжруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө, сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах,
2. Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн явцтай танилцаж бодит үр дүнд үндэслэн зөвлөн туслах, сургалт зохион байгуулах
3. Сургуулийн менежментийн хэрэгжилтийн бодит үр дүнтэй танилцах, зөвлөн туслах, сургалт хийх (сургалтын төлөвлөгөө, сургуулийн зорилго, зорилт, төлөвлөлт, соёл, эцэг эх олон нийтийн оролцоо, манлайлал, хяналт шинжилгээ)
4. “Боловсролын чанарын шинэчлэлд эцэг эхийн оролцоо” сэдвээр нутгийн засаг захиргаа, орон нутгийн иргэд, эцэг эхчүүдэд лекц, хэлэлцүүлэг зохион байгуулах
5. Суралцагч, багш, сургуулийн амжилт, туршлагын сантай танилцах, бүртгэх, цуглуулах

Мониторингийн бэлтгэл ажлын хүрээнд:

- БСШУЯ-аас мониторингийн зорилго, үйл ажиллагааны чиглэл батлах
- Багийн гишүүдийг БМДИ, БХ болон бусад байгууллага, сургуулиас сонгож, баталгаажуулах
- Багийн гишүүдийг мониторингоор явах хугацаанд эрхэлж буй ажлаас чөлөөлөх тухай байгууллагаас хариу мэдэгдэл авах
- Багийн гишүүдийн бүртгэл хийж томилолтын зардал олгох
- Ажлын чиглэл, хөтөлбөр, удирдамж боловсруулах
- Батлагдсан төсвийн хэмжээнд төсвийн тооцоо хийх
- Мониторинг хийх аймаг, сургуулийн жагсаалт гаргах, зураглал маршрут хийх
- Сонгогдсон аймаг, сургуультай холбоо барин мэдээлэл өгөн бэлтгэл хангуулах

Бага боловсролын түвшинд 130, дунд боловсролын түвшинд 160 хүний бүрэлдэхүүнтэй мониторингийн баг байгуулсан. Мониторингийн баг нь мэргэжлийн байгууллагын төлөөллөөс гадна хөтөлбөр боловсруулагч МУИС, МУБИС-ийн багш нараас бүрджээ.

P2.2.A5.T2. Мониторингийн мэдээлэл цуглуулах хэрэгсэл боловсруулах /арга зүй/

Мониторингийн хийх бэлтгэл ажлын хүрээнд

- Мониторингийн арга зүйн талаар нэгдсэн ойлголттой болох зорилгоор БХ нь БМДИ, хэрэгжилтийн багийг судалгааны арга зүйг боловсруулах чиглэлээр зөвлөх
- Мониторингийн баг нь мэдээлэл цуглуулах хэрэгсэл боловсруулах, бэлтгэх
- Судалгааны түүвэр болох сургууль, судлагдахуун, багш, суралцагчийг харгалзан материалаа бэлдэх

P2.2.A5.T3. Багийн гишүүдэд сургалт зохион байгуулах

БХ болон хөтөлбөр боловсруулагч нар нь 130 /бага/, 160 /дунд/ гишүүдэд сургалт зохион байгуулан мониторингийн хөтөлбөр, удирдамж боловсруулсан.

P2.2.A5.T4. Мониторинг зохион байгуулах (мэдээлэл цуглуулах)

Мониторинг хийн мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд:

- Сургуулийн удирдлагад ажлын удирдамжаа танилцуулах, ажиллах хуваарь гаргах
- Хичээлд ажиглалт хийх, ажиглалтын хуудас бөглөх
- Хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хичээлийг болон төлөвлөлтөө сайжруулах, дахин заалгах, хэлэлцэх
- Мэргэжлийн багш нартайгаа уулзалт, ярилцлага хийх, сургалт зохион байгуулах (сургалтын хөтөлбөр, сурах бичиг, суралцахуйн зөвлөмжийн талаар)
- Сургуулийн менежмент, сургуулийн хөтөлбөртэй танилцах, ярилцлага хийх, зөвлөгөө өгөх
- Сургалтын орчинтой танилцах, түршлага судлах, мэдээлэл цуглуулах
- Эцэг эхчүүдэд, иргэдэд зориулсан лекц зохион байгуулах
- Нийт багш, удирдлагад ажлын үр дүнг танилцуулах, зөвлөмжлөх

Эдгээр үйл ажиллагааны үр дүнд

- Хичээлд ажиглалт хийх арга барилд суралцах
- Хэлэлцүүлэг хийх арга барилд суралцах
- Хичээлийн төлөвлөлтөө хэрхэн хийх, сайжруулах арга барил эзэмших
- Асуудал, бэрхшээлээ илрүүлэн шийдэх арга замаа мэдэж авах
- Сургуулийн хөтөлбөр боловсруулах чиглэлтэй болох
- Амжилт, түршлагын сантай болох
- Эцэг, эх хэрхэн хувь нэмэр оруулах ойлголттой болох
- Сургуульд өгөх зөвлөмж боловсруулах

P2.2.A5. T5. Мэдээлэлд боловсруулалт хийх, үр дүнг тайлагнах, танилцуулах

- ✧ Цуглуулсан мэдээллээ эмхлэн нэгтгэх
- ✧ Мэдээлэлдээ дүн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах
- ✧ Зөвлөмжийг нэгтгэх
- ✧ Тайланг нэгтгэсэн загварын дагуу судлагдхууны, бүсийн, үндэсний хэмжээнд боловсруулах
- ✧ Хэрэгжилтийн бүс хариуцсан ахлагч хэрэгжилтийн багт тайлагнаж, хэлэлцүүлэх
- ✧ БСШУЯ, мэргэжлийн байгууллагуудад танилцуулах



Давуу тал

- БСШУЯ жилд нэг удаа мониторинг хийсэн нь сургууль дээр тулгамдаж буй асуудлыг шийдэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чухал арга хэмжээ болсон байна.
- Мониторингийн багт мэргэжлийн болон боловсролын байгууллага хамтран оролцсон нь ойлголтын зөрөөг арилгах, багш нарт бодит зөвлөгөө үзүүлэх эхлэлийг тавьсан байна.
- Хэрэгжилтийн баг нь мониторингийн үр дүнг Яам, мэргэжлийн байгууллагуудад танилцуулсан нь тулгамдсан асуудлыг яаралтай шийдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Мониторингийн гишүүд тухайн боловсролын газар, сургууль, багшийг хянах шалгахыг зорилго болгох бүс тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, холбогдолтой мэдээлэл цуглуулах, зөвлөгөө өгөх зорилготой ажилласан байна.
- Мониторингийн үр дүнд анализ хийж тулгамдсан асуудлыг илрүүлсэнээр багш нарт зөвлөмж боловсруулах зорилготой судалгаа хийсэн байна.
- Энэхүү судалгааны үр дүнд хэрэгжилтэд тулгамдаж буй асуудлыг шийдэхэд туслах зөвлөмж боловсруулсан нь мониторингийн үр дүнг эргэх холбоонд оруулсан жишээ болсон байна.



Сул тал

- БСШУЯ, холбогдох удирдлагууд хөтөлбөрийн хэрэгжилтийн мониторингийн болон бусад тайлан, цуглуулсан мэдээллийг архивт цаасаар болон онлайнаар хадгалах тогтолцоо бүрдээгүй.
- Хэрэгжилтийн баг нь яаманд сар, улирлаар ажлын үр дүнгээ тайлагнадаг байсан боловч энэ мэдээлэлд дүгнэлт хийн цаашид авах арга хэмжээ, асуудлыг хэрхэн шийдсэн зэрэг мэдээлэл боловсролын газар, сургуулиудад очоогүй нь “мэдээллийн үрсгал”-ын тогтолцоо бэхжээгүйтэй холбоотой.



Санал

- Мониторингийн үр дүнд анализ хийдэг, тулгамдсан асуудлыг хэрхэн шийдсэнийг танилцуулдаг, мэдээ баримтыг хадгалдаг, холбогдох газруудад дамжуулдаг “мэдээллийн үрсгал” бүхий эргэх холбооны тогтолцоог бүрдүүлэх, бэхжүүлэх
- Мониторинг хийхдээ сурагчдын сурлагын амжилт, сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судлах судалгааны мэдээлэл цуглуулахад анхаарах
- Судалгаа, шалгалтын үр дүнд шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг тодорхойлдог байх
- Сургуулийн шатанд сурагчдын шалгалтын дүнд шинжилгээ хийж тухайн сурагчид дэмжлэг үзүүлэх, багшийн заах аргыг сайжруулах, сургуулийн зорилго, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг байх

Р2.2.А6. Судалгаа хийх

Р2.2.А6.Т1. Судалгааны ажлын бэлтгэл хангах

2013-2015 оны хичээлийн жилд "Сургалтыг дэмжих үйл ажиллагаа"-г (СДҮА) ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд хичээлтэй адилтган үзэж нийт 3 цагаар орохоор сургалтын төлөвлөгөөнд тусгасан. Мөн эдгээр үйл ажиллагааг удирдан хэрэгжүүлэхэд сургууль багш нарын баримтлах хөтөлбөр, санал зөвлөмж боловсруулах хэрэгцээг үндэслэн уг судалгааг 2015-2016 оны хичээлийн жилд хэрэгжилтийн баг, БХ-тэй хамтран зохион байгуулсан.

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд судалгааны арга зүйг боловсруулсан байна.

Судалгааны зорилго: Суурь боловсролын түвшинд СДҮА-ны өнөөгийн нөхцөл байдал, суралцагчдын хөгжилд үзүүлж буй нөлөөллийн талаар хоёр үе шаттай мэдээлэл цуглуулж үр дүнг шинжлэх, санал зөвлөмж боловсруулах

I шатны зорилго: Суурь боловсролын түвшинд "Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цаг", "Иргэний боловсрол", "Амьдрах чадвар"-ын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах, боловсруулах, тулгамдсан асуудлыг илрүүлж, сургууль, багш нарт зөвлөх

II шатны зорилго: Нэг хичээлийн жилд СДҮА-ны хөтөлбөрийг хэрэгжүүлсэн үр дүнг тандаж, санал зөвлөмж боловсруулах

Зорилт:

- "СДҮА-ны өнөөгийн нөхцөл байдал"-ыг шинжлэхэд шаардлагатай харьцуулагдахуйц, давтан ашиглахуйц судалгааны арга зүйг боловсруулах;
- Түүвэрлэж авсан ЕБС болон сонирхлын бүлгүүдээс хоёр үе шаттайгаар мэдээлэл цуглуулж, дүгнэлт гаргах;
- Гарсан үр дүнд суурилж санал, зөвлөмж боловсруулж, оролцогч талуудад хүргүүлэх.

Анхаарал хандуулах үндсэн асуудлууд:

1. СДҮА-нд хандах байдал, сонирхол
2. СДҮА-ны хүрээнд суралцагчдад хөгжүүлэх чадвар, хандлага
3. Багш нарын СДҮА-г удирдан зохион байгуулахад бэлэн байдал
4. Сургуулийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд СДҮА-г авч үзэж буй байдал

Судалгааны баг байгуулах

- Судалгааны арга зүй, түүврээ боловсруулах
- Туршилт хийх, сайжруулах

Р2.2.А6.Т2. Мэдээлэл цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх

- Сургуулиас мэдээлэл цуглуулах
- Мэдээллээ оруулах
- Чанарын болон тоон мэдээлэлд шинжилгээ хийх
- Мэдээллээ нэгтгэх, дүгнэлт гаргах

Хүснэгт 2.2.2 Судалгааны хүрээ

Цуглуулах мэдээллийн агуулга, хүрээ	Ашиглах асуултын чиглэл	Илрүүлэх арга							
		Асуулга			Ярилцлага			Б/ бичиг	Ажиглалт
		С	Б	ЭЭ	СУ	Бүл	Ганц		
СДҮА-нд хандах байдал, сонирхол	Сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг яагаад хэрэгтэй вэ?	+	+	+	+	+	+	+	
	Энэ цаг бусад хичээлийн цагаас ямар ялгаатай байх ёстой вэ? Хоорондын холбоо нь юу байх ёстой гэж та үзэж байна вэ?					+	+		
	СДҮА-нд нар хэрхэн хандаж байна гэж та үздэг вэ? Яагаад?	+	+	+	+	+	+		

СДҮА-ны хүрээнд суралцагчдад хөгжүүлэх чадвар, хандлагын эзэмшилт	Суралцагчдын чадвар, хандлага ямар түвшинд байгаа вэ? Яагаад?	+	+	+	+	+	+		+	
	Хэрхэн хөгжүүлэх вэ? Хэрхэн дэмжих вэ?	+	+	+	+	+	+		+	+
	Үүнд ямар хүчин зүйл нөлөөлөх бол	+	+	+	+	+	+			
Багш нарын бэлэн байдал	СДҮА-г удирдан, зохион байгуулдаг арга, туршлага						+			+
	Тулгарч буй сорилт, бэрхшээл, тэдгээрийг шийдэж буй болон шийдэж болох арга зам					+	+			
Сургуулийн удирдлага, зохион байгуулалтын хүрээнд СДҮА-г авч үзэж буй байдал	Сургуулийн төлөвлөлтөд хэрхэн тусгадаг?								+	+
	Хэрэгжүүлэх чиглэлээр одоогоор хийгээд буй ажил, үйл ажиллагаа									
	Тулгарч буй сорилт, бэрхшээл, тэдгээрийг шийдэж буй болон шийдэж болох арга зам				+		+			

Тэмдэглэл: С-суралцагч, Б-багш, ЭЭ-эцэг, эх, СУ-сургуулийн удирдлага, Бүл-бүлэг, Ганц-ганцаарчилсан

P2.2.A6.T3. Тайлан боловсруулах, танилцуулах

- Тайлангийн эхний хувилбар боловсруулах
- Мэргэжлийн байгууллагад танилцуулж санал авах
- Эцсийн тайланг танилцуулах

Сургууль дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлсэн ажлыг нэгтгэвэл:

2013/2014, 2014/2015 хичээлийн жилд хэрэгжилтийн (туршилт) багийн шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хийсэн ажлыг нэгтгэсэн хүснэгтээс харахад хэрэгжилтийн баг нь

- Бага боловсролын түвшинд
 - Хөтөлбөрийн туршилт – 2013-2014
 - Хөтөлбөрийн хэрэгжилт – 204-2015
- Суурь боловсролын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх– 2014-2015 онд нийтдээ 180428 хүн/цаг ажиллаж (бага боловсролд 23 хүн 71070 хүн/цаг, суурь боловсролд 34 хүн 109358 хүн/ цаг) 78017 км зам явсан байна.

Хүснэгт 2.2.3 Хэрэгжилтийн багийн үйл ажиллагааны нэгтгэл

Үйл ажиллагаа		Давтамж	2014 он	2015 он	
			Бага боловсрол (туршилт)	Бага боловсрол хэрэгжилт	Суурь боловсрол (туршилт, хэрэгжилт)
Хичээл, үйл ажиллагаанд зөвлөн туслах (багшид)	Ажиглалт хийсэн хичээлийн тоо		1920	11501	8620
	Хэлэлцүүлэг хийсэн хичээлийн тоо		610	4522	3260
	Хамтран сайжруулсан хичээл		192	515	430
	Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт гарын авлага		“Хүүхэд бүрийг хөгжлийг дэмжих сургалтын арга зүй” зөвлөмж 1260 багшид		“Суралцахуйг дэмжсэн хичээл, үйл ажиллагааны төлөвлөлт гарын авлага” 2034 багшид
	Сайн хичээл, үйл ажиллагааны DVD бичлэг		8 багц 24 хичээл		8 багц 20 хичээл

Сургалт зохион байгуулах	Багшийн тоо	1-2	13859	11235	39638
	Сургуулийн удирдлагын тоо	2	1364	2046	2728
	БСГ дарга арга, зүйчийн тоо	2	60	60	280
Уулзалт, ярилцлага, лекц хийсэн	БСГ дарга арга, зүйчдийн тоо	2	60	236	242
	Орон нутгийн удирдлагын тоо	2	29	174	74
	Эцэг эхчүүдийн тоо	2	5432	11519	2283
Мониторинг (зөвлөн туслах)	Орон нутгийн сургууль	2	24	252	24
	Нийслэлийн сургууль	1	16	134	16
Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулалтад оролцох	Сургалтын хөтөлбөр	2	СДҮА		СДҮА
	Сурах бичиг	1	Иргэний боловсрол унших эх I-V анги Багшийн ном I-V анги		
	Зөвлөмж	2	Иргэний боловсрол Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, Хичээлээс гадуурх үйл ажиллагаа		Иргэний боловсрол, Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа, Хичээлээс гадуурх үйл ажиллагаа
Судалгаа хийх, Туршлага судлах	СДҮА ны нөхцөл байдлын судалгаа	1			СДҮА нөхцөл байдлын судалгаа хийсэн
	Туршлага судлах (Япон улсад)	4	65 багш, сургуулийн удирдлага, дээд сургуулийн багш	92 багш, БСГ, сургуулийн удирдлага	42 сургуулийн удирдлага, судлаач ЭША
Цахим хуудас ажиллуулах	Амжилтын сан туршлага хуваалцах /онлайн/	2 сайт	Багшийн хөгжил портал сайт Бага боловсролын хэрэгжилт, Лаборатори сургууль цэс ажиллаж байна.		17 судлагдахуун, 3 үйл ажиллагаагаар FACEBOOK групп, блог ажиллуулж байна.
Явсан зам, цаг	Ажилласан цаг		71070 хүн/цаг	109358 хүн/ цаг	
	Явсан км		13350 км	38097 км	26567 км



Давуу тал

- Зарим сургуульд менежментийн шинэчлэл амжилттай хийгдэх эхлэл тавигдаж, удирдлага багш нар, ажилчдын нэгдмэл зорилготой баг бий болсон байна.
- Сургуулийн зорилго, зорилтыг тодорхойлоход удирдлага, багш, сурагчид, ажилчид, эцэг эхчүүд бүгд оролцох хандлагын эхлэл тавигдсан. Үйл ажиллагааны төлөвлөлтүүд нь уялдаа холбоотой, сургуулийн нэгдсэн зорилгыг хангахад чиглэсэн хандлага зарим сургууль дээр эхэлж байна.
- Эцэг эхийн оролцоог сайжруулахад онцгойлон анхаарч, тэдний оролцоо нэмэгдэж, хандлага сайжирсан байна. Тухайлбал эцэг эх, олон нийтийн оролцоог сайжруулахад чиглэсэн олон үйл ажиллагааг тэдний оролцоотой зохион байгуулсанаар шинэчлэлийн онцлогийг мэдрэхэд давуу талтай байлаа.
- Сургууль бүр “Сайн хичээл, үйл ажиллагааны зөвлөгөөн”-ийг явуулсан нь багш нар хамтран ажиллаж, арга зүйн шинэчлэлийг хийн, ажлын байран дээр хөгжих бололцоотойг ойлгож байна.
- Бүс, дүүргийн судлагдахууны багийн зохион байгуулалтаар багш нар хамтран ажиллаж, харилцан туршлага солилцож, суралцах эхлэл тавигдсан байна.
- Багш нар хүүхдийн сонирхол хэрэгцээ, чадварт суурилж, тэдний бие даан суралцах арга барилыг хөгжүүлэхэд чиглэгдсэн арга зүйгээр хангахыг эрмэлзэж байна. Суралцагчийн үйлийн орчин нөхцлийг бүрдүүлэхийг чухалчилж, цахим хэрэглэгдэхүүн болон ашиглахад хялбар олдоцтой гарын доорх материалыг ашиглан сургалтын хэрэглэгдэхүүнээ бэлтгэж байна.
- Сургалтын үйл ажиллагаан дахь оролцоо ахиц амжилтыг сурах үйл ажиллагааг дэмжих, суралцах чадвар, арга барилыг хөгжүүлэхийг эрмэлзэж байгаа нь хичээл ажиглалтаас харагдаж байна. Хүүхдийн хэрэгцээ сонирхол, туршлага, чадварт суурилж, бие даан сурах арга барилыг хөгжүүлэхэд чиглэгдсэн, хичээл үйл ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөх оролдлого хийж байна.
- Багш хүүхдийн ялгаатай байдлыг харгалзан, асуултаар сурагчийн хөгжлийн дэмжих, үйлийн явцад хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлж заах гэхээсээ илүүтэйгээр дэмжих, түслах, зөвлөх гэдэг хандлагатай болж байна. Явцын үнэлгээний хэрэглэгдэхүүнийг хичээл сургалтандаа хэрэглэж буй үйл ажиллагаа харагдаж байна. Жишээ нь гэрлэн дохио, цагаан самбар, хуруу, оюуны зураглал гэх мэт. Эдгээрийг сургалтын үйл ажиллагаан дахь хүүхэд бүрийн оролцоо, ахиц амжилтыг дэмжих, сурах арга барилыг хөгжүүлэхэд чиглүүлж байлаа



Сул тал

- Сургуулийн зорилгыг хэрхэн тодорхойлох, сурагчдын бодит байдлыг хөгжлийн үр дүнг тодорхойлох аргачлал, зөвлөмж хангалтгүй.
- Суралцахуйн зорилгын дагуу хичээл төлөвлөхөд үнэлгээний шалгуур үзүүлэлт гаргах, даалгавар боловсруулах туршлага чадамж харилцан адилгүй.
- СДҮА-ны жил, нэгж, ээлжитийн төлөвлөлт хийхэд хүндрэлтэй байна.
- Хэрэглэгдэхүүний төсөв санхүү батлагддаггүй.
- Хөтөлбөрийн агуулгын зөрөөг нөхөх цаг хугацаа бага байсан.
- Суралцагчдын мэдлэг чадвар хандлага үнэлэх шалгалтын материал даалгаврын сан хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго зорилтоос ангид байх тохиолдол гарч байсан нь сургууль багш нарт ойлгомжгүй байдал үүсгэсэн.
- Суралцагчийн ялгаатай байдалд тохируулан даалгавар боловсруулахад хүүхдийн тоо их, бичиг хэргийн материалд гарах зардал байдаггүй бэрхшээл байна.



Санал

Сүргүүлийн түвшинд:

- Сүргүүлийн төлөвлөгөө нэгдмэл нэг үнэт зүйл, дэвшүүлсэн зорилго руу чиглэж, үйл ажиллагаанууд нь өөр хоорондоо хир үйлдсэн байна вэ? гэдэгт сүргүүлиуд дүгнэлт хийх
- Сүргүүлийн үйл ажиллагаанд бүх оролцогч талууд нэгдмэл зорилготой түүнд бүхий л үйл ажиллагаагаа чиглэсэн байх. (багшийн, сургалтын менежерийн, нийгмийн ажилтаны, номын санчийн, эмчийн үйл ажлын төлөвлөгөө хүүхэддээ төвлөрч харилцан үялдаатай байх)
- Сүргүүль бүр хөтөлбөрөө өөрийн онцлогтойгоор боловсруулан бодлого үйл ажиллагаагаа үялдуулан хэрэгжүүлэх эрх мэдлийг олгох эрх зүйн орчин бүрүүлэх
- Сүргүүлийн “Сайн хичээл, үйл ажиллагаа”-г сүргүүлийн төлөвлөгөөнд тусгаж тогтмол хийх, үр дүнг тооцох
- Судлагдахууны багийн үйл ажиллагааг дэмжих, арга зүйн зөвлөгөө үзүүлэх, бүс, дүүргийн багуудаас түршлага судлах, арга зүйн эзэмшилтэд хяналт тавих, сайжруулах
- Үнэлгээний зорилтод нийцсэн шалгуур үзүүлэлтийг гаргах, дасгал даалгавар, ажлын хуудсыг бэлдүүлэх
- Судлагдахууны босоо багаар (Заах Аргын Нэгдэл) ажиллаж мэдлэг, чадвар, агуулгын залгамж холбоо өргөсөл гүнзгийрлийг тодорхойлж байгааг сайжруулан улмаар суралцагчийн эзэмших суралцах арга барил, чадварын залгамж холбоог гаргах
- Байгаль орчин, нийгэмд хандах хандлагыг эерэгээр төлөвшүүлэх үйлийн орчин, дадлагын орчин бий болгоход анхаарч чиглүүлж ажиллах
- Багш, суралцагч, эцэг эхчүүдийг хянаж бүртгэх, шалгах гэх мэт удирдлагын ажлын арга барилаа зөвлөх, зааварчлан хийж хэвшихэд нь туслах, үлгэрлэх арга барилаар өөрчлөх
- Хүүхэд бүрийг зөв аргачлалаар үнэлэх, суралцагчдынхаа хөгжлийг дэмжих

Мэргэжлийн байгууллага, яамны түвшинд:

- Хөтөлбөрийн агуулгыг хүүхдийн насны онцлог, танин мэдэхүйн түвшинд тохируулан боловсруулах
- Сурах бичиг, багшийн номын хүртээмж, хангалт, чанарыг сайжруулах
- Сурах бичгийн агуулгыг шинэ хөтөлбөрийн дагуу боловсруулах, үг үсгийн алдаагүй хэвлэх
- Түршилттай хичээлүүдийн багаж хэрэгсэл, бодис гэх мэт шаардлагатай хэрэглэгдэхүүнээр хангах
- Үнэлгээний жишиг даалгавруудын загвар гаргаж багш нарт хүргүүлэх
- Үнэлгээ хийх арга, аргачлалын талаар сургалт явуулах
- Багш нарт арга зүйн сургалтыг тасралтгүй өгөх
- СДҮА-ны мэргэжил, арга зүйн зөвлөгөөг өгөх мэргэжлийн байгууллагуудын ажлыг хооронд нь үялдаа холбоотой болгох, нэгдсэн төлөвлөлтийн дагуу шинэчлэл хийх



СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ

РЗ.1. ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙГ БАЙГУУЛАХ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ

РЗ.1.А1. Үнэлгээг төлөвлөх

РЗ.1.А1.Т1. Үнэлгээний баг байгуулах

2013 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн А/155 тоот “Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтын 4.3 дахь хэсэгт Боловсролын үйлчилгээний үр дүнгийн үнэлгээний шинэчлэлийг тодорхойлж гаргасан байна. Тус тушаалын 3 дугаар хавсралтад Боловсролын үнэлгээний багийг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон боловч БШУ-ы Сайдын 2013 оны 08 дугаар сарын 27-ны А/326 тоот тушаалаар “Багийн бүрэлдэхүүн шинэчлэх, зардал батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “...Боловсролын үнэлгээний үзэл баримтлал, бодлого, чиглэл боловсруулах” багийг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр дахин шинээр байгуулсан.

Энэхүү баг нь:

- Боловсролын үнэлгээний чиглэлээр эрх зүйн болон сурлагын амжилтын үнэлгээний чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүнгийн нэгтгэлийн тайлан
- Боловсролын чанарын үнэлгээний шинэчлэлийн ерөнхий үзэл баримтлал
- Багшийн, сургуулийн үнэлгээний шинэ стандарт, зөвлөмж боловсруулах, сайжруулах
- Математик, Монгол хэл, Байгалийн ухааны хичээлүүдийн стандартын үнэлгээний шинэчлэлийг боловсруулах, сайжруулах
- Бага, дунд, ахлах боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ, аргачлал боловсруулах, сайжруулах үүргийг гэрээгээр хүлээсэн байна.

Гэрээгээр хүлээсэн үүргийнхээ хүрээнд 2013 болон 2014 онуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөнөөс, 2013 онд дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна.

1. Үнэлгээний эрх зүйн орчны шинжилгээ
2. Үнэлгээний стандарт хэрэгжилтийн судалгаа
3. Чанарын үнэлгээний шинэчлэл /ерөнхий, багшийн, суралцагчийн, сургуулийн үнэлгээний үзэл баримтлал/
4. Сургуулийн, багшийн үнэлгээний шинэ стандарт, зөвлөмж
5. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ /6 хичээл*5 анги/
6. Боловсролын чанарын үнэлгээний аргачлал, арга зүй
7. Бага ангийн багш нар үнэлгээний сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг;

Улмаар 2014 онд:

1. Боловсролын чанарын үнэлгээ хийх /5, 9-р анги/
2. Матемтик, БУ, Монгол хэлний стандартыг 3 түвшинд боловсруулах

3. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх аргачлал, зөвлөмж боловсруулах
4. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээний аргачлал боловсруулах
5. Багшийн журналын загвар боловсруулах, турших гэсэн ажлуудыг төлөвлөсөн байна.

Р3.1.А1.Т2. Эрхзүйн орчны шинжилгээ

Үнэлгээний чиглэлээр эрх зүйн орчны талаарх баримт бичгийн судалгаа хийсэн бөгөөд зорилго нь боловсролын сургалтын байгууллага болон багш, суралцагчийг үнэлж ирсэн шалгуурыг судлах улмаар Олон улсын үнэлгээний журамтай харьцуулах зорилготой байсан.

Р3.1.А1.Т3. Үнэлгээний үзэл баримтлал боловсруулах

А/326 тушаалаар байгуулагдсан үндэсний үнэлгээний баг нь “Боловсролын үнэлгээний үзэл баримтлал, бодлого, чиглэл боловсруулах”-аар байгуулагдсан.

Р3.1.А1.Т4. Үнэлгээний журам боловсруулах

Олон улсад, Ази, Европи, Америкийн нэгдсэн улсын муж бүрийн багш, сургууль, суралцагчийг үнэлэх үнэлгээний журам, шалгуурыг судлан түүнд үндэслэн БШУ-ы сайдын А/309 тоот тушаалаар Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалд нийцүүлэн “Ерөнхий боловсролын болон Боловсролын чанарыг үнэлэх журам”-ыг 5 бүлэгтэйгээр боловсруулан хүлээлгэн өгсөн.

Мөн БШУ-ы сайдын А/293 тоот тушаал болон түүний хавсралтуудыг боловсруулах

Багшийн үнэлгээний журмыг 2 хавсралттайгаар нийт 5 бүлэгтэйгээр боловсруулсан байна. Нэгдүгээр хавсралт нь ЕБС-ийн, хоёрдугаар хавсралт нь СӨБ-ын багш нарын ажлыг үнэлж дүгнэхээр боловсруулагдсан. Тэрхүү журамд багшийн ажлыг үнэлж дүгнэхдээ дараах шалгуураар үнэлэхээр заасан байна. Үүнд:

1. Төлөвшил
2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц амжилт
3. Авъяасыг нээн хөгжүүлсэн байдал
4. Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж
5. Эрүүл мэндийн байдал гэсэн 5 шалгууртайгаар тус бүр 20 оноо авахаар байна.

2013-2014 оны хичээлийн жилийн эхэнд зохион байгуулагддаг багш нарын бага хуралд танилцуулах сургалтын материалыг “Суралцагчийн болон багшийн үнэлгээний журам” гэсэн чиглэлээр боловсруулсан байна. Энэхүү сургалтын Улаанбаатар хотын хэмжээнд үндэсний сургагч багш нарыг бэлтгэх, тэдгээр багш нараар дамжуулан орон нутагт түгээн дэлгэрүүлэх сургалтын материалыг бэлтгэсэн бөгөөд сургалт нь үндэсний болон орон нутгийн сургагч багш нарыг бэлтгэх чиглэлээр 2 үе шаттай явагдсан. Орон нутгийн сургалтыг үндэсний болон орон нутгийн багш нар хамтран зохион байгуулсан бөгөөд СӨБ, ЕБС-ийн бүх багш нарт мэдээллийг хүргэсэн.



Давуу тал

- Үндэсний хэмжээнд бага, суурь боловсролын шинэчлэлтэй холбоотой үнэлгээний үзэл баримтлал боловсруулах багийг анх удаа тушаалаар байгуулсан.
- Багш болон суралцагчийг үнэлэх журмыг боловсруулан нийтээр дагаж мөрдөр шалгуур, үзүүлэлтүүдийг бий болгосон.
- Үндэсний хэмжээнд чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулах эрх зүйн орчныг бий болгосноор энэхүү үйл ажиллагаа тогтмолжих боломжтой болсон.



Сул тал

- Үнэлгээний багийн төлөвлөлт болон үйл ажиллагаа тодорхой бус байсан. Мөн мэргэжлийн байгууллагыг татан оролцуулаагүй. Төлөвлөсөн ажлуудаас тодорхой ажлууд хийгдсэн боловч чанарын хяналт сул байснаас бүх ажлаа хугацаанд гүйцэтгэж чадаагүй. Үнэлгээний багийн ажлын тайлан болон бусад бичиг баримт хаана хадгалагдаж буй талаар мэдээлэл хомс байна.
- Багшийн үнэлгээний журмыг боловсруулан гаргасан боловч төрийн болон төрийн бус өмчийн хэлбэрийн сургуульд жигд хэрэгжүүлэх нөхцөл нь хязгаарлагдмал байсан.
- Мөн анги удирдсан болон анги удирдаагүй багш нарын ажлын хүрээг тооцоолоогүйн улмаас нэгж дээр хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний бэрхшээлүүд үүсэж багш нарын бичиг цаасны ачааллыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн.

Р3.2. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГАА /5, 9, 12-Р АНГИД/

БШУ-ы Сайдын 2013 оны 08 дугаар сарын 16- ны өдрийн А/309 тоот тушаалын 4.2 дахь заалтад үндэслэн үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарт үнэлгээ хийх зорилгоор Боловсролын чанарын үнэлгээний судалгааг 2014 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд бага боловсролын түвшинд 3, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд тус бүр 4 шалгалт авахаар тус журмд зааж өгсөн байна.

Хүснэгт 3.1.1. Чанарын үнэлгээний судалгааны анги, хичээл

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын агуулга
Бага	V	Монгол хэл
		Математик
		Байгаль шинжлэл
Суурь	IX	Монгол хэл
		Математик
		Байгалийн ухаан
		Нийгмийн ухаан
Бүрэн дунд	XII	Монгол хэл, уран зохиол
		Математик
		Сонгосон агуулга
		Гадаад хэл

Р3.2.А1.Т1. Судалгаа зохион байгуулах бэлтгэлийг хангах

Судалгааны бэлтгэл ажлын хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, судалгааг зохион байгуулахтай холбогдох бичиг баримт боловсруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж бэлтгэх ажлуудыг 32 хүн 20 өдөрт хийж гүйцэтгэлээ.

- Чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж БҮТ-ийн захирлаар батлуулан мөрдөж ажилласан.
- 4-н төрлийн ажлын удирдамж боловсруулж БҮТ-ийн захирлаар баталгаажуулжээ. Үүнд:
 - » Судалгааны шалгалтын сэдэв даалгавар боловсруулах ажлын удирдамж
 - » Эксперт хийх ажлын удирдамж
 - » Судалгаа зохион байгуулах ажлын удирдамж
 - » Шалгалтын материалыг засаж үнэлэх ажлын удирдамж болно.
- Даалгавар боловсруулах багш нарын мэдээлэл цуглуулж 21 судлагдахууны сэдэв даалгавар боловсруулах 41 багшийг сонгон захирлын тушаалаар томилон ажиллуулаа.
- Даалгавар боловсруулах аргазүй, бюпринтийг хэрхэн баримтлах, шалгалтын үр дүнд тулгуурласан


даалгаврын анализ, түүнийг хэрхэн ашиглах тухай сургалтыг 41 багш, 16 экспертийн хүрээнд зохион байгуулсан.

- Чанарын үнэлгээний судалгааны асуулгыг дараах 4-н чиглэлээр 6-н төрлөөр боловсруулсан. Үүнд:
 - » Сургуулийн удирдлагын асуулга
 - » багшийн асуулга
 - » эцэг эхийн асуулга
 - » 5, 9, 12-р ангий тус бүрийн суралцагчийн асуулга
- Судалгааны асуулгыг сургуулийн удирдлагаас 100 хүн, 1600 багш, 1500 эцэг эх, судалгаанд хамрагдсан 5,9,12-р ангийн 14000 суралцагчаас авахаар төлөвлөсөн байна.
- Судалгааны асуулгыг төлөвлөсөн тоогоор хэвлэх, төрөлжүүлэн уутлаж битүүмжлэх ажлыг 10 хүн 3 өдөр хийж гүйцэтгэлээ.

Р3.2.А1.Т2. Даалгавар боловсруулах

Даалгавар боловсруулах ажлыг 339 хүн 39 өдрийн ажлаар хийж гүйцэтгэсэн байна. Энэхүү ажил нь дараах үе шаттайгаар зохион байгуулагддаг.

Зураг 3.1.1 Даалгавар боловсруулах үе шат



- » Чанарын үнэлгээний судалгааны 5, 9, 12-р ангийн 21 шалгалтын сэдэв даалгаврыг БҮТ-өөс гаргасан блюпринтийн дагуу 50-60 орчим багш 10 өдөрт боловсруулсан бөгөөд нийт 621 сонгох хариулттай даалгавар, 150 задгай хэлбэрийн (дотроо хэд хэдэн алхамд задарсан) даалгавар нийт 771 даалгавар боловсруулагдсан байна.
- » Боловсруулагдсан сэдэв даалгаварт шинжилгээ хийх экспертийн багийг 16 хүнээр бүрдүүлж, 2 өдөрт даалгаврын шинжилгээ хийлээ.
- » Сэдэв даалгаварт хийсэн экспертийн шинжилгээ, дүгнэлт хийсний дараа 1 өдрийн хугацаанд даалгавар боловсруулагч, эксперт нарын уулзалт хэлэлцүүлэг хийж даалгавраа сайжруулсан.
- » Сэдэв даалгавар турших шалгалтад 10 сургуулийн 3497 суралцагч хамрагдсан байна. Турших шалгалтын материалыг хэвлэж уутлан битүүмжлэх ажлыг 9 хүн 12 цаг ажиллаж гүйцэтгэсэн байна. Турших шалгалт авах ажлыг 12 хүн 2 өдөр гүйцэтгэсэн байна.
- » Турших шалгалтын материалыг шалгаж үнэлэх ажлыг 45 хүн 5 өдөрт хийж гүйцэтгэсэн байна.
- » Турших шалгалтын үр дүнгийн анализ, шинжилгээний өгөгдөлийг БҮТ-ийн 2 мэргэжилтэн 2 өдөрт боловсруулан


гаргаж даалгавар боловсруулагч нарт өгсөн байна.

- » Даалгаврыг турших шалгалтын үр дүнд тулгуурлан эцэслэн сайжруулах ажлыг даалгавар зохиогч нар, экспертийн багтай хамтран 5 өдрийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Р3.2.А1.Т3. Чанарын үнэлгээний судалгаа зохион байгуулах

Чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулахад 28 хоногт 545 хүн оролцон ажиллалаа. Энэхүү ажлын үйл явц нь дараах байдлаар зохион байгуулагдлаа.

Зураг 3.1.2. Судалгаа зохион байгуулах үйл явц




- » Судалгаанд хамрагдах 100 сургууль болон сургууль түс бүрээс судалгаанд хамрагдах суралцагчдыг түүвэрлэн, 5-р ангийн 4763, 9-р ангийн 4158, 12-р ангийн 4274 суралцагчийн нэрсийн жагсаалт гарган коджуулах ажлыг 2 хүн 4 өдөр хийж гүйцэтгэсэн байна.
- » Судалгааны шалгалтын 16 төрлийн дэвтэр, шалгалтын болон асуулгын гэсэн 2 төрлийн хариултын 20 хүн 3 өдөр хийсэн байна. шалгалтын материалыг шалгалтын төрөл, сургууль, анги танхимын суралцагчдын тоогоор уутлах, савлан битүүмжлэх ажлыг 12 хүн 7 өдөр хийж гүйцэтгэсэн байна. Мөн шалгалтын материалыг хүргэх, буцаан татах ажлыг 4 хүн 4 өдөр хийсэн байна.
- » Судалгааг 100 сургууль дээр зохион байгуулах комиссын 115 гишүүнийг сонгох, ажил гүйцэтгэх гэрээ байгуулах ажлыг 2 хүн 2 өдөр хийсэн байна.
- » Судалгаа зохион байгуулах комиссын гишүүдэд ажлын чиглэл, гүйцэтгэх үүрэг үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах тухай сургалтыг 2 хүн 1 өдөр зохион байгуулсан байна. Энэ ажлын хүрээнд комиссын ажлын чиглэл, хянагч багшийн гарын авлага, шалгалтад хамрагдах суралцагчдад зориулсан зөвлөмж зэрэг гарын авлагуудыг 2 хүн 5 өдөр боловсруулан, хэвлэж бэлтгэсэн байна.
- » Чанарын үнэлгээний судалгааг 100 сургууль дээр 4 өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаанд комиссын 115 гишүүнээс гадна 400 хянагч багш 4 өдөр ажилласан байна. Судалгаанд давхардсан тоогоор нийт 44773 суралцагч хамрагдсан байна.

Р3.2.А1.Т4. Үнэлж дүгнэх, үр дүнд шинжилгээ хийх

Судалгааны шалгалтын материалыг үнэлж дүгнэх ажил нь дараах хэсгүүдээс бүрддэг.

Зураг 3.1.3. Судалгааны материал дүгнэх ажлын дараалал



- » Чанарын үнэлгээний судалгааны үр дүнд шинжилгээ хийж тайлан боловсруулах ажлын хүрээнд удирдамж боловсруулах, асуулгын өгөгдлийн сан болон шалгалтын үр дүнг холбох, үр дүнд шийнжилгээ хийх, боловсруулах, нэгтгэн тайлан бичих үйл явцуудыг агуулж байна.
- » Судалгааны тайлан бичих ажлын удирдамж боловсруулан, БҮТ-ийн захирлаар баталгаажуулах ажлыг 2 хүн 1

өдөр хийлээ.

- » Судалгааны асуулгын сургуулийн удирдлага, багш, эцэг эхийн хариултын мэдээллийг шивж оруулахад 10 хүн 10 өдөр ажилласан.
- » Сургуулийн удирдах ажилтан, багш, эцэг эх, суралцагчдын хариултын мэдээллээс үүссэн дата өгөдлийг шалгалтын үр дүнтэй холбох ажлыг 2 хүн 5 өдөр хийж гүйцэтгэлээ.
- » Чанарын судалгааны шалгалтын бэлэн болсон өгөгдлийн сангийн мэдээлэлд боловсруулалт хийж тайлан бичих ажлыг 15 хүн 30 өдөр хийж гүйцэтгэлээ. Энэхүү тайлан нь 21 судлагдахуунаар бичигдсэн байна.
- » Чанарын үнэлгээний судалгааны нэгдсэн тайланг боловсруулан судлагдахуун тус бүрээр бичигдсэн тайланг хавсарган БСШУСЯ-д хүргүүлэхээр бэлтгэх ажлыг 2 хүн 14 өдөр гүйцэтгэсэн байна.
- » Ерөнхий тайланг боловсруулахдаа:
- » Судалгааны ерөнхий үр дүн /хот, хөдөөгийн бүс, боловсролын түвшин, хүйс, сургуулийн өмчийн хэлбэр, байршил гэх мэт/
- » Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болон үнэлгээний зорилт тус бүрийн гүйцэтгэлийн дундаж
- » Аймаг, дүүргийн гүйцэтгэлийн дундаж /судлагдахуун тус бүрээр/
- » Сургуулийн гүйцэтгэлийн дундаж, шалгалтын агуулга тус бүрийн сурлагын амжилтын мэдээлэл
- » Сурлагын амжилтад нөлөөлөх судалгааны үр дүн зэрэг мэдээллүүдийг багтаасан байна.



Давуу тал

- Анхны чанарын үнэлгээний судалгааг Кембрижийн зөвлөх багийнхантай хамтран зохион байгуулсан бөгөөд сэдэв, даалгавар боловсруулах, засах, үнэлэх, тайлагнах чиглэлээр шаталсан сургалтуудыг зохион байгуулж хүний нөөцийг чадавхжуулах боломж бий болсон.
- Даалгавар боловсруулах чиг хандлага өөрчлөгдсөн. Тодорхой тооны хүмүүсийг даалгавар боловсруулах чиглэлээр мэргэшүүлэх, чадавхжуулах боломж нэмэгдсэн.
- Сэдэв даалгаврыг түрших шалгалт зохион байгуулсан нь тохироцтой, найдвартай даалгавраар судалгааг явуулах боломжийг бий болгосон.
- Судалгааны үр дүнг БСШУСЯ-д хүргүүлснээр бодлого боловсруулагч нар нотолгоонд тулгуурлан бодлого боловсруулах боломжтой болсон.
- Мөн улсын хэмжээнд боловсролын чанар, суралцагчдын сурлагын амжилтыг үнэлж эхэлснээр хөтөлбөр, сурах бичгийн агуулга болон багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын төлөвлөлтийг сайжруулахад суурь мэдээлэл болж өгөх нөхцөл бүрдсэн.
- БҮТ-ийн даалгаврын санд түршигдсэн, үр дүнд шинжилгээ хийгдсэн даалгавруудаар баяжуулалт хийх суурийг бүрдүүлж өгсөн.
- Цаашид үндэсний хэмжээнд үнэлгээг тогтмол хийснээр олон улсын сурлагын амжилтын судалгаанд оролцох, дэлхийн бусад улс орнуудтай өөрийн орны хөтөлбөр, суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг харьцуулах боломжтой болж ирнэ.



Сул тал

- Даалгавар боловсруулагч, эксперт болон засах, үнэлэх багийн гишүүдийг бэлтгэх, тэдгээрийг нэгдсэн ойлголттой болгох шаардлагатай байсан.
- Мөн хөтөлбөр боловсруулагчид болон боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилчдын даалгавар боловсруулах, түүнд тавигдах шаардлагын талаар нэгдмэл ойлголтгүй байсан нь даалгавар боловсруулагчдад хүндрэлтэй байдал үүсгэх тохиолдол байсан.
- Кембрижийн зөвлөх багийн сургалтуудад хамрагдах багш нарын тоо хязгаарлагдмал, сонгогдсон багш нарын хувьд үндсэн ажлынхаа хажуугаар сургалтад бүрэн хамрагдахад хүндрэл үүсэж байсан.
- Судалгааны үр дүнг нийтэд таниулах, судлаачдад хуваалцах шаардлагатай хэдий ч мэдээлэлд сөрөг талаас нь шинжилгээ хийх, бусдыг буруутгах хандлага түгээмэл байна.

РЗ.3. УЛСЫН ШАЛГАЛТ /5, 9, 12-Р АНГИД/

БШУ-ы сайдын 2013 оны 08 дугаар сарын 16 ны өдрийн А/309 тоот тушаалын 4.1 болон 4.2 дахь заалтын дагуу үндэсний хэмжээнд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж буй суралцагчдын мэдлэг, чадварыг бодитойгоор үнэлэх зорилгоор улсын шалгалтыг 2014 оноос эхлэн БҮТ хариуцан ажиллаж эхэлсэн. Энэхүү ажилд БҮТ нь боловсролын түвшин болон шалгалтын агуулга тус бүрээр бюпринтийг боловсруулах, түүний дагуу сэдэв даалгавар боловсруулах, шалгалтын хугацааг товлон, зохион байгуулах удирдамж гаргах, түгээх, сэдэв даалгаврын нүүцлалыг хангах, ЕБС-дад хүргэх ажлыг хөндлөнгөөс зохион байгуулах хэлбэрээр оролцож байна.


Улсын шалгалтыг дор дурдсан агуулгаар зохион байгуулна.

Хүснэгт 3.1.2 Улсын шалгалтын агуулга

Боловсролын түвшин	Анги	Шалгалтын агуулга
Бага	V	Монгол хэл
		Математик
		Байгаль шинжлэл
Суурь	IX	Монгол хэл
		Математик
		Байгалийн ухаан
		Нийгмийн ухаан
Бүрэн дунд	XII	Монгол хэл, уран зохиол
		Математик
		Сонгосон агуулга
		Гадаад хэл

Улсын шалгалтын зохион байгуулалт нь дараах зураглалын дагуу явагддаг.

Зураг 3.1.4 Улсын шалгалтын зохион байгуулалт



Р3.3.А1.Т1. Шалгалтын бэлтгэл ажил

Шалгалтын бэлтгэл ажлын хүрээнд шалгалтыг зохион байгуулахтай холбогдох бичиг баримт боловсруулах, шалгалтын сэдэв даалгавар боловсруулах төсвийн тооцоо гаргах, багийн гишүүдийг бүрдүүлэх, томилох, гэрээ байгуулах зэрэг ажлыг 18 хүн 12 өдөрт хийж гүйцэтгэлээ.

- » Улсын шалгалт зохион байгуулах удирдамж боловсруулж БҮТ-ийн захирлаар баталгаажуулж бэлтгэлээ. Энэхүү удирдамжид шалгалтын сэдэв даалгаврыг бэлтгэх агуулга, шалгалтын хуваарь, шалгалтын комиссын бүрэлдэхүүн, шалгалтын үйл ажиллагаанд хамаарах байгууллага тус бүрийн ажлын үүрэг, харилцан хамаарлыг тусгасан байна. /2 хүн 3 өдөр/
- » Улсын шалгалт зохион байгуулах удирдамжийг аймаг нийслэлийн БСУГ, дүүргийн БХ-т шалгалт эхлэхээс 2 сарын өмнө хүргүүллээ. /1 хүн 1 өдөр/
- » Шалгалтын сэдэв даалгавар боловсруулах бюпринтийг шалгалт тус бүрээр боловсруулах ажлыг БҮТ-өөс хариуцан хийж гүйцэтгэлээ. /10 хүн 1 өдөр/
- » 2016 онд шалгалт зохион байгуулахтай холбогдох зардлын төсвийг тусгайлан боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулж байсан бол 2017 онд БҮТ-ийн жилийн төсөвт тооцуулан оруулж батлуулсан байна. /2 хүн 5 өдөр/
- » Шалгалтын сэдэв даалгаврыг 21 судлагдахуунаар боловсруулах 33 багшийг сонгон захирлын тушаалаар томилон гэрээ байгууллаа. /3 хүн 2 өдөр/

Р3.3.А1.Т2. Сэдэв даалгавар хүлээн авах экспертээр оруулах

Сэдэв даалгавар боловсруулах ажлыг 129 хүн 13 хоногт хийж гүйцэтгэсэн байна. Сэдэв даалгаврын нууцлалыг хангах зорилгоор даалгавар зохиох ажлыг богино хугацаанд хийсэн байна.

- » Шалгалтын сэдэв даалгаврыг эхний байдлаар боловсруулах ажлыг 33 хүн 3 өдөр хийсэн байна.
- » Шалгалтын сэдэв даалгаварт эксперт хийхээр 21 судлагдахуунаар 28 багшийг сонгон захирлын тушаалаар томилон гэрээ байгууллаа. /2 хүн 2 өдөр/
- » Сэдэв даалгавруудыг хянах, дүгнэлт гаргахаар 28 хүн 2 хоног ажилласан байна.
- » Экспертийн дүгнэлтийн дагуу даалгавар сайжруулах ажлыг хамтарсан багийн зохион байгуулалттайгаар 63 хүн 3 өдөр хийж гүйцэтгэсэн байна.
- » Сэдэв даалгаврыг эцэслэн хүлээн авах ажлыг 3 хүн 3 өдөр хийсэн байна.

Р3.3.А1.Т3. Сэдэв даалгаврыг хүргэх

Улсын шалгалтын сэдэв даалгаврыг бэлтгэх, сургуулиудад хүргэх ажлыг 13 хүн 4 хоногт хийж гүйцэтгэсэн байна.

- » Шалгалтын сэдэв даалгаврын 16 төрлийн эх файлыг бэлтгэх, нууцлалын код хийж тохируулах, CD-д хуулж олшруулах ажлыг 8 хүн 2 хоногт хийж гүйцэтгэсэн байна.
- » Шалгалтын сэдэв даалгавар хуулан бэлтгэсэн CD-г аймаг дүүргийн БСУГ/БХ-үүдэд хуваарилан савлаж хаяглах, хүргэх ажлыг 5 хүн 2 өдөр хийж гүйцэтгэсэн байна.

Р3.3.А1.Т4. Улсын шалгалт зохион байгуулах

Улсын шалгалтыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон сургуулийн улсын шалгалтын комисс шалгалт авах, шалгалтын материалыг үнэлж засах, зохион байгуулж, БСУГ/БХ шалгалтын явцад хяналт тавьж ажиллалаа.

Шалгалтын материалыг засаж үнэлэх ажлын явцад зөвлөн туслах ажлыг БҮТ-ийн 3 хүн 6 өдөр хийж гүйцэтгэсэн байна.

Р3.3.А1.Т5. Мэдээлэл цуглуулах, боловсруулах

Шалгалтад хамрагдсан суралцагчдын сонгосон хариулт, дүн оноог Боловсролын салбарын мэдээллийн системд шивж оруулахад бэлтгэх, шивж оруулах ажлыг гүйцэтгэхэд 3420 хүн 38 өдөр ажилласан байна.

- » Боловсролын салбарын мэдээллийн системд суралцагчдын дүн оноог шивж оруулахын тулд системд нэвтрэх нууц үгийг сургууль бүрийн тоогоор үүсгэх, БСГ-ын хяналтыг үүсгэхээр 2 хүн 7 хоног ажилласан байна.
- » Шалгалтын дүн оноо, суралцагчийн хариултын мэдээллийг системд шивж оруулах ажлыг 788 сургуулийн 3404 хүн 11 өдөр ажиллаж хийсэн байна. Энэхүү ажлыг гүйцэтгэхэд зөвлөн туслах, програм хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлыг 14 хүн 20 хоногт хийсэн байна.

Р3.3.А1.Т6. Үр дүнг тайлагнах, танилцуулах

Шалгалтын үр дүнгийн өгөгдлийн сан нь Боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд үүссэн байна. Энэхүү сангаас авсан мэдээллийн сангийн өгөгдлүүд нь тайлан бичих хэмжээнд байгаагүй тул ерөнхий статистик мэдээллийг боловсруулан БСШУСЯ болон БСУГ, НБГ /БХэлтэс/-т хүргүүлдэг.

**Давуу тал**

- Улсын шалгалтын нэгдсэн удирдлагаар хангаж улсын хэмжээнд ижил цаг хугацаанд зохион байгуулах боломжтой болсон.
- Бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж буй бүх суралцагчдаас хүндрэлийн түвшин ижил сэдвээр шалгалт авч эхэлсэн.
- Суралцагчдын гүйцэтгэлийн мэдээллийг боловсролын салбарын мэдээллийн системд шивж эхэлсэн нь сургуулиудын шалгалтын үйл ажиллагаанд хөндлөнгөөс хяналт тавих боломжтой болсон.

**Сул тал**

- Шалгалтын зохион байгуулалт, суралцагчдын гүйцэтгэлийн мэдээлэлд суурилсан дэлгэрэнгүй тайлан боловсруулах боломжгүй. Систем дэх мэдээллийн боловсруулалт хангалтгүй, шалгалтын үр дүнг татах, боловсруулалт хийх боломжгүй.
- Шалгалтын материалыг засаж үнэлэх үнэлгээний схем, заавар зөвлөмжийг нэгэн ижил өгсөн хэдий ч сурагчдын ажилласан шалгалтын материалыг нэг стандартаар засаж байгаа эсэхэд хяналт тавих боломжгүй.
- Улсын шалгалт нь нэгдсэн байдлаар шалгалтын сэдэв, даалгаврыг боловсруулах, зохион байгуулах зэрэг ажлыг хөндлөнгийн байгууллага удирдан чиглүүлж буй боловч засах, үнэлж дүгнэх ажил нь сургуулийн мэдэлд байгаа учраас бүрэн утгаараа хөндлөнгийн үнэлгээ болж чадахгүй байгаа болно.
- Үйл ажиллагааны бүхий л үе шат нь хөндлөнгийн байгууллагаас хамаарахгүй тул бүрэн утгаараа хөндлөнгийн үнэлгээ болж чадахгүй байгаа бөгөөд сургууль, багшийн зүгээс үнэлгээг бодитой бүс хийдэг нь эцсийн үр дүнгээс харагддаг.

4

БҮЛЭГ

ДҮГНЭЛТ, САНАЛ

4.1. Сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах

4.1.1. Сургалтын хөтөлбөр боловсруулах

Хүүхэд бүрийг хөгжүүлэх дэлхий нийтийн болон Монгол Улсын боловсролын хөгжлийн чиг хандлагын дагуу, бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг 2012 оноос эхлэн боловсруулж, 2014 оноос үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн.

Боловсролын шинэчлэлийн явц, сургалтын хөтөлбөр боловсруулах, үндэсний хэмжээний бүх сургуулиудад түгээн хэрэгжүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд зөвлөн түслах, багшийн арга зүйд дэмжлэг үзүүлэх, дахин сайжруулах үйл ажиллагааны талаарх мэдээлэлд дараах дүн шинжилгээг хийлээ.

Сургалтын хөтөлбөр боловсруулах бэлтгэл хангах

БШУ-ы сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглалд сургалтын цөм хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг 3 жилийн хугацаанд боловсруулж (түвшин бүрт 1 жил), боловсруулсаны дараах жилээс хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ цаг хугацаанд багтан сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг боловсруулсан хэдий ч, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа 2 жилээр хойшилж хэрэгжсэн байна.

БШУ-ы сайдын 2012 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/180 дугаар тушаалаар батлагдсан менежментийн баг нь Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал, үзэл баримтлалын дагуу сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг төлөвлөсөн хугацаанд багтаан боловсруулах үйл явцыг хянан, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан боловч 2015 онд гэрээнд заасан хугацаа дуусгавар болж, цаашид ажиллах эрх зүйн орчин бүрдээгүй учраас 2016 онд үйл ажиллагаа нь зогссон. Үүний улмаас сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үнэлэх, магадлан итгэмжлэлд оруулах зэрэг ажил мэргэжлийн байгууллагад шилжсэн байна.

Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглалд төлөвлөсний дагуу сургалтын хөтөлбөрийг боловсруулан, үндэсний лаборатори сургууль дээр түрших ажлыг 1 жилийн хугацаанд хийж, сайжруулан баталгаажуулж үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн байна. Тус төлөвлөлтөнд агуулгын зөрөөг арилгах шилжилтийн хугацааг төлөвлөөгүй байна.



Санал

- Сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах урт (10 жилийн) болон дунд, богино хугацааны үйл ажиллагааны төлөвлөлтүүдийг Боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон үндэсний зөвлөл, менежментийн баг тогтвортой хэрэгжүүлэх зохион байгуулалтыг хариуцан ажиллах
- Сургалтын хөтөлбөр боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд төлөвлөгдсөн судалгааг тогтмол явуулдаг байх. Энэхүү судалгаанд сурлагын амжилтын судалгаа, судлагдахуун судлал, нийгмийн хөгжлийн судалгааг хамруулах шаардлагатай бөгөөд эдгээр судалгааны үр дүнд тулгуурлан, баттай үндэслэлтэй сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг боловсруулах, улмаар сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг олон нийтэд нээлттэй мэдээлж, саналыг тусган сайжруулах

- Сургалтын хөтөлбөр боловсруулагчид, сурах бичиг, багшийн ном зохиогчид, сургалтын хэрэглэгдэхүүн, орчин нөхцлийг сайжруулах, хэрэгжүүлэх; сургууль, багш нар болон үнэлгээний мэргэшсэн шинжээч бэлтгэх сургалтуудыг урт хугацааны төлөвлөлтөд тусган хэрэгжүүлэх
- Боловсролын шинэчлэл хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулахад шаардлагатай санхүүгийн нөөц, төсвийг урьдчилан тооцоолж, 1 жилийн өмнө судалгаа боловсруулалт хийж бэлтгэн улсын төсөвт тогтмол тусгах

Сургалтын хөтөлбөр боловсруулах

Боловсролын хүрээлэнгийн сургалтын хөтөлбөрийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтнууд сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан бөгөөд хөтөлбөр судлалыг хөгжүүлэх, өөрийн орны болон гадаад улс орны сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээний шинэчлэлийн талаар харьцуулсан судалгаа хийх, хөтөлбөрийн шинэчлэлийн чиг хандлагыг тодорхойлж ажилласан байна. Гэвч сектор байгуулагдаад удаагүй, эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны ажлын түршлага нимгэн, хүний нөөц бага, цаг хугацаа, санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэж суурь судалгаа хийгдээгүй байна.

Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглалд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх 6 жилийн үйл ажиллагааг төлөвлөсөн боловч сургалтын хөтөлбөр боловсруулсны дараа агуулгын зөрөөг арилгах шилжилтийн хугацааг болон энэ хугацаанд багийн гишүүдийг чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг нэгдсэн төлөвлөлтөд тусгаагүй байна. Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, нэгдсэн төлөвлөлтийн дагуу 2013-2014 онд Бага боловсролын 8 судлагдахуун, 3 үйл ажиллагааны сургалтын хөтөлбөрийг, 2014-2015 онд суурь боловсролын 9 багц судлагдахуун, 1 багц сургалтыг дэмжих үйл ажиллагааны хөтөлбөрийг, 2015-2016 онд бүрэн дунд боловсролын 15 сургалтын хөтөлбөрийг боловсруулсан бөгөөд баримт бичгийн харьцуулсан судалгаанд үндэслэн сургалтын төлөвлөгөөнд сургалтыг дэмжих үйл ажиллагааны цаг, ахлах ангид сонгон судлах хичээлийн цагийг тусган оруулсан байна.

Сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулах явцад лаборатори сургуулиудад зарим агуулга, арга зүйг түрших, багш нараас санал авах, мэргэжлийн байгууллагын арга зүйч, мэргэжилтэн, их дээд сургуулийн тэнхим, багш нараар хэлэлцүүлж, хөндлөнгийн үнэлгээг жилд 2 удаа хийж сайжруулсан байна.

Судлагдахууны сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хөндлөнгийн үнэлгээ хийх багийн бүрэлдэхүүнийг сонгоход боловсролын бүх шатны байгууллагын төлөөллийг оролцуулсан боловч хөндлөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн экспертэйг ажиллуулах, санхүүгийн нөөцийг улсын төсөвт тусгаагүйгээс ажил гүйцэтгэх гэрээ байгуулахад хүндрэл үүсч байсан байна.



Санал

- Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн хэлэлцүүлэг эхлэх үед өмнөх хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн, суралцагчийн сурлагын амжилт зэрэг шаардлагатай судалгааг тодорхой хугацаанд, тогтмол хийж, нотолгоо цуглуулсан байх
- Судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл хэрэгцээг тодорхойлох, үзэл баримтлалыг олон нийтэд хэлэлцүүлэх, саналыг тусган сайжруулах
- Сургалтын хөтөлбөр боловсруулах хүний нөөцийг чадавхжуулах, цаг хугацаа, орчин хэрэглэгдэхүүн, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах

Сургалтын хөтөлбөрийг түршин сайжруулах

Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжийг боловсруулах, түрших хугацаа давхацсан, түршилтын удирдамжийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагууд тус тусын чиг үүргийн дагуу ажиллаж ирсэн боловч мэдээлэл солилцох, хамтын ажиллагаа дутагдалтай байсан байна.

Сургалтын хөтөлбөр боловсруулагчид үндсэн ажлын зэрэгцээ гэрээгээр 1-5 ангийн судлагдахууны хөтөлбөр боловсруулах, сурах бичиг, багшийн ном зохиох, түрших зэрэг хэд хэдэн ажлыг зэрэгцүүлэн гүйцэтгэсэн, лаборатори сургуулийн багш нар бүх ангид олон судлагдахууны хөтөлбөр түршсэн нь сургалтын хөтөлбөр боловсруулагчид

болон багш нарт ачаалал үүсгэсэн. Олон улсын хөтөлбөртэй үялдуулан шинэчлэн боловсруулсан бага боловсролын математик, байгалийн ухаан, суурь, бүрэн дунд боловсролын математик, физик, хими, биологи, англи хэлний судлагдахууны сургалтын цөм хөтөлбөрийг лаборатори сургуулиудад түршсан нь тухайн мэргэжлийн багш нар сургалтын цөм хөтөлбөрийг ойлгож, хүлээн авах, хэрэгжүүлэхэд нөлөөлсөн бөгөөд бусад судлагдахууны агуулга, арга зүйг тодорхойлоход түлхэц болж байсан. Лаборатори сургуулиудад сургалтын хөтөлбөрийг түрших, түгээх удирдамж богино цаг хугацаанд харилцан адилгүй түвшинд хэрэгжсэн тул сургууль, багш нарын ойлголт нэгдмэл болж чадаагүй.

Мөн шинэ сургалтын хөтөлбөрийг үндэсний хэмжээнд бүх ангид шууд хэрэгжүүлсэн нь сургалтын хөтөлбөрийн агуулгын зөрөөтэй байдал үүсэх, сургууль, багш нар шинэ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байсан.



Санал

- Сургалтын хөтөлбөрийг түрших шаардлагатай гэж үзвэл лаборатори сургуулийн бүх анги, хичээлийг хамруулах байдлаар биш, мэргэжлийн байгууллагууд болон сургалтын хөтөлбөр боловсруулагчид тодорхой хичээл, агуулга, арга зүй, үнэлгээний хэсгийг хэсэгчлэн түрших нь түршилтын үр дүнг сургалтын хөтөлбөрт тусган сайжруулах бодит үндэслэл болно.
- Мэргэжлийн байгууллага, лаборатори сургуулиуд түршилтын үр дүнд үндэслэн судалгаат хичээл зохион байгуулах, бусад сургууль, багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлэх, агуулгын зөрөөг гаргах шилжилтийн хугацааны удирдамж боловсруулах зэргээр хамтран ажиллах шаардлагатай.

Сургалтын хөтөлбөрийг танилцуулах, түгээх

БСШУЯ нь мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтран чиг үүргийнхээ хүрээнд 2013-2018 онуудад үндэсний болон орон нутгийн сургагч багш бэлтгэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж ажилласан байна.

Сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд ажиллаж байгаа бага ангийн болон мэргэжлийн багш, боловсролын байгууллагын мэргэжилтэн арга зүйч бүрт, хэвлэж түгээсэн нь шинэлэг, үр дүнтэй ажил болсон.



Санал

- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын шинэ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад сургууль, багшид сургалтын материаллаг орчин, мэргэжил арга зүйн цогц дэмжлэгийг тасралтгүй үзүүлэх үрт хугацааны төлөвлөлттэй ажиллах
- Мэргэжлийн байгууллагууд сургалтын шинэ хөтөлбөрийг таниулах сургалт (сургуулийн захирал, сургалтын менежер, мэргэжлийн багш нар, олон нийт, эцэг эх гэх мэт) зохион байгуулах, хичээлийн арга зүйн санааг боловсруулж сургууль, багш нарт хүргэх, үнэлгээний стандарт, зөвлөмж, сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллах
- Багш бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын чанарыг сайжруулах, багшийг давтан бэлтгэх сургалтыг тогтвортой, үе шаттай, хэрэгцээнд суурилан зохион байгуулах
- Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага үндэсний болон орон нутгийн сургагч багштай гэрээ байгуулж, хамтран ажиллах

4.1.2 Сурах бичгийн боловсруулалтад хийсэн шинжилгээ

Сурах бичиг, багшийн ном зохиох бэлтгэл ажлыг хангах

ЕБС-ийн сургалтад хэрэглэж буй сурах бичгийг шинэчлэх нэгдсэн график, төлөвлөлтийг хугацаа, хүний нөөц, санхүүгийн боломжийг бодитой тооцож төлөвлөөгүйн улмаас сурах бичиг хугацаандаа хэрэглэгчдийн гарт очихгүй байх, сурах бичиггүй хичээллэх, шинэ сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд өмнөх сургалтын хөтөлбөрийн сурах бичиг хэрэглэх асуудлууд тулгарчээ.

Одоо мөрдөгдөж буй сурах бичгийн талаар авч хэрэгжүүлэх бодлого зохицуулалтын баримт бичигт сурах бичгийг шинэчлэх график, хугацаатай холбоотой тодорхой төлөвлөлт тусгагдаагүй байдгаас хэт богино хугацаанд эх зохиох, хянах ажлыг гүйцэтгэх хэрэгтэй болдог. Энэ нь сурах бичгийн чанарт нөлөөлөх томоохон хүчин зүйл болж байна.

Өнөөдрийн байдлаар ЕБС-ийн сургалтад I-V ангид 9 судлагдахууны 34 нэрийн, VI-IX ангид 18 судлагдахууны 59

нэрийн, X-XII ангид заавал судлах 14 судлагдахууны 36 нэрийн, сонгон судлах 1 судлагдахууны 2 нэрийн, нийт 130 нэрийн сурах бичгийг хэрэглэж байна. Мөн үндэстний цөөнх, хос хэлний сургалттай сургуулийн VI-IX ангийн “Казах хэл, уран зохиол” 4 нэрийн сурах бичиг, тусгай хэрэгцээт боловсролын I-V ангийн 4 төрлийн 13 нэрийн сурах бичгүүдийг сургалтад хэрэглэж байна. Ийм тооны сурах бичгийг сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу шинээр зохиох ажлыг 2013 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Бага дунд боловсролын чанарын шинэчлэлийн зураглал”-д 3-4 жилийн хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4.1.2.1 Бага ангийн сурах бичиг

Бага ангийн сурах бичиг	2013-2014 оны хичээлийн жилд				
	I	II	III	IV	V
	6+1	6	6	7	7+1

Хүснэгт 4.1.2.2. Дунд ангийн сурах бичиг

Дунд ангийн сурах бичиг	2015-2016 оны хичээлийн жилд				2017-2018 оны хичээлийн жилд				2018-2019 оны хичээлийн жилд	
	VI	VII	VIII	IX	VI	VII	VIII	IX	VI	VII
	5	5	9	10	1	5+2	5+1	5	3	4

Хүснэгт 4.1.2.3. Ахлах ангийн сурах бичиг

Ахлах ангийн сурах бичиг	2017-2018 оны хичээлийн жилд		2018-2019 оны хичээлийн жилд		
	X	XI	X	XI	XII
	11+1	11	2	3	8

Дээрх хүснэгтүүдээс шинэ сургалтын хөтөлбөрийн дагуух сурах бичиг, багшийн номыг шинээр зохиох ажлыг анхны төлөвлөсөн хугацаанд багтаагүй нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл нэг хичээлийн жилд багтааж эхийг зохиохоор төлөвлөсөн дунд ангийн сурах бичгийг 3 хичээлийн жилийн хугацаанд, ахлах ангийн сурах бичгийг хоёр хичээлийн жилийн хугацаанд зохиож байгаа нь хүний нөөц, санхүү хөрөнгийн төлөвлөлтийг бодитой хийж чадаагүйг харуулж байна.

Сурах бичгийн зохиогчийн багийн бүрэлдэхүүний 49.1 хувийг их, дээд сургуулийн багш, 26.1 хувийг ЕБС-ийн багш, 17.5 хувийг мэргэжлийн байгууллагын судлаач, мэргэжилтэн, арга зүйч, 6.5 хувийг бусад төрийн бус байгууллага зэргийн төлөөлөл бүрдүүлж байна. Хоёр ба түүнээс дээш тооны сурах бичиг болон сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг боловсруулахад ажилласан зохиогчийн эзлэх хувийг хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 4.1.2.4

Хичээлийн жил	2013-2014	2014-2015	2015-2016	2016-2017	2017-2018	2018-2019
Шинээр зохиосон сурах бичиг, багшийн номын эх	32 (328 х.х) сурах бичиг 38 (370 х.х) багшийн ном		29 (362 х.х) сурах бичиг 48 (566 х.х) багшийн ном-		42 (480 х.х) сурах бичиг 14 (275 х.х) багшийн ном	20 (270 х.х) сурах бичиг
Эх зохиосон хүний тоо (давхардсан/ давхардаагүй)	107/166	179/205	-	191/270	110/135	
Редакторын тоо (давхардсан/ давхардаагүй)	92/215	81/154	-	60/112	35/40	
Нэгээс илүү тооны сурах бичигт ажилласан зохиогчийн эзлэх хувь	45.3%	32.1%	-	42.9%	17.3%	
Сургалтын хөтөлбөр боловсруулахад оролцсон зохиогчийн эзлэх хувь	48.5%	41.3%	-	48.1%	38.1%	



Санал

- Дээрх хүснэгтээс харахад зохиогчдын 34.4 хувь нь хоёр ба түүнээс дээш тооны сурах бичигт, 46.8 хувь нь сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг боловсруулахад давхар ажил гүйцэтгэсэн байна. Үүн дээр багшийн номыг боловсруулах ажлыг нэмэхэд зохиогчийн багийн нэг гишүүнд ногдох ажлын ачаалал ойролцоогоор 2 дахин нэмэгдэнэ. Энэ нь зохиогчийн багийн хүний нөөц, хүчин чадлыг бодитой тооцсон төлөвлөлт зайлшгүй хэрэгтэйг харуулж байна.

Өнгөрсөн жилүүдэд сурах бичгийн эхийг зохиосон хугацааг хүснэгт 5-д үзүүлэв.

Хүснэгт 4.1.2.5

2013.07-2014.05	2014.06-2014.09	2015.01-2015.10	2017.04-2017.10	2018.05-2018.10
15-16 сар	9-10 сар	6-7 сар	5-6 сар	

Хүснэгтээс харахад сүүлийн жилүүдэд сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, эх бэлтгэхэд дунджаар 6-7 сар зарцуулсан байна. Үүний 1-2 сарыг эх бэлтгэлд зарцуулдаг гэж үзвэл 5-6 сарыг сурах бичгийн эхийг зохиож байна. Ийм богино хугацаанд сурах бичгийн эхийг боловсруулдаг байдал нийтлэг үзэгдэл болсон. Энэ нь нарийн төлөвлөлтгүйг харуулж буй бөгөөд нөгөө талаас алдаатай, чанаргүй сурах бичиг гарахад хамгийн их нөлөөлж байна.



Санал

- Сургалтын хөтөлбөрийг боловсруулан, баталгаажуулсны дараа шинээр зохиох сурах бичгийн жагсаалт батлах, сурах бичгийн эх зохиохоос 1 жилээс доошгүй хугацааны өмнө шинээр хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг гаргах, баталгаажуулдаг байх, сурах бичгийн эхийг 24-өөс доошгүй сарын хугацаанд боловсруулах, 12-оос доошгүй сарын хугацаатайгаар хянах, засварлахаар төлөвлөлт, зохицуулалтыг хийх шаардлагатай. Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн сонгох хөтөлбөрт ахлах ангийн сурах бичиг, цахим сурах бичгийн талаар ямар бодлого баримтлах, төлөвлөлт болон хугацаагаар хэрхэн зохицуулахыг бодлого зохицуулалтын баримт бичигт тусгах хэрэгтэй байна.

Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, сайжруулах

- Аль ч түвшний сурах бичгийн эх зохиохын өмнө хэрэглэж байсан сурах бичгийг судалж, судалгааны үндсэн дээр шинэчлэх, сайжруулах зүйлсийг тодорхойлох шаардлагатай байна. Сурах бичгийг хэрхэн сайжруулах вэ, юуг өөрчлөх вэ гэдгийг нийт зохиогч нарт тодорхой болгоогүй, нэг сурах бичгийн эх зохиож буй зохиогчид нэгдсэн ойлголттой болж чадаагүй зэрэг нь сурах бичгийн чанарт шууд нөлөөлж байна. Үүнээс үүдэн өмнөх сурах бичгээс ялгагдах ялгаагүй, хуулсан гэх зэрэг шүүмжлэл гарсаар байна.

БДБЧШ-ийн хүрээнд СБСОБ, Боловсролын хүрээлэнгийн СБСОСС сурах бичиг, багшийн номын эх зохиогчийн багийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажилласан. Сурах бичиг судлалыг хөгжүүлэх, өөрийн орны болон гадаад улс орны сурах бичгийн үзэл санаа, бүтэц, агуулга, арга зүй, үнэлгээний зарчим, дасгал даалгаврыг боловсруулж буй байдлын талаар харьцуулсан судалгаа хийх, сурах бичгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох шаардлагатай байсан.

Сурах бичиг, сургалтын орчны судалгааны сектор байгуулагдаад удаагүй, эрдэм шинжилгээний ажилтнуудын судалгааны ажлын туршлага нимгэн, хүний нөөц бага, цаг хугацаа, санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэж сурах бичгийн судалгааны ажил орхигдсон.

Иймд, бэлтгэл ажлын хүрээнд эх зохиохоос жилээс доошгүй хугацаанаас өмнө сурах бичгийн шинэчлэх, сайжруулах шаардлагатай зүйлийг судалгааны үндсэн дээр тодорхойлох хэрэгтэй байна.



Санал

- СБСОСС-ын бүтцэд бага, суурь, бүрэн дунд боловсролын сурах бичгийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнууд байсан. Харин 2016 оноос байгалийн ухааны, нийгмийн ухааны, хэл болон хүмүүнлэгийн ухааны, математик болон мэдээллийн технологийн сурах бичгийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнууд гэсэн бүтэцтэй ажиллаж эхэлсэн. Нэг эрдэм шинжилгээний ажилтан 23-25 сурах бичгийн судалгаа хариуцаж ажилладаг. Энд урлагийн боловсролын сургалтын хөтөлбөрийн сурах бичиг (хөгжим, дүрслэх урлаг, дизайн технологи), хэлний сурах бичгийн судалгаа хариуцсан эрдэм шинжилгээний ажилтан байхгүй тул эдгээр сурах бичгийн судалгаа орхигдохын зэрэгцээ бусад эрдэм шинжилгээний ажлын ачааллыг нэмэгдүүлдэг. Бусад улс орны жишгээс харахад сурах бичгийн судалгаа, боловсруулалт хариуцсан нэгж нь олон тооны бүтэц бүрэлдэхүүнтэй байдаг. Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай хүний нөөцтэй болох, сурах бичгийн судалгаа шинжилгээний ажлыг тогтвортой хийх, чанартай сурах бичгийг хэрэглэгчдэд хүргэх үүднээс СБСОСС-ын бүтцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Сурах бичиг, багшийн номын эх бэлтгэх, хянах, хэвлэх

Сурах бичгийн эхийг хянах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлыг дан ганц агуулга болон техникийн редакторын уншилтаар хязгаарлах боломжгүй юм. Бага ангийн сурах бичиг, багшийн номын сургалтын хөтөлбөртэй агуулга, арга зүй нь нийцэж буй эсэх, анги, хичээл хоорондын агуулгын залгамж холбоог хангасан эсэх, дасгал даалгаврын боловсруулалт, хүүхдийн нас бие, сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх, хүүхдийн хөгжлийг дэмжсэн хэрэглэгдэхүүн болж чадаж буй эсэх гэх мэт шалгуурын дагуу эхийг хянах редакторын багаас гадна БСШУЯ дээр төвлөрсөн олон нийтийн хөндлөнгийн үнэлгээний баг, БХ дээр төвлөрсөн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх баг тус тус ажилласан нь сурах бичгийг нарийн шүүлтүүрээр шүүх, олон нийтийн болон мэргэжлийн хүмүүсийн саналыг тусгах улмаар сурах бичгийн чанарыг сайжруулахад бодитой алхам болж байсан. Гэвч суурь, бүрэн дунд боловсролын сурах бичиг, багшийн номын эхийг хянахад цаг хугацаа, төсөв санхүүгийн хязгаарлагдмал байдлаас үүдэн дан ганц редакторын баг гүйцэтгэсэн.

Иймд мэргэжлийн болон сонирхлын бүлгийн оролцоог хэрхэн хангах, тэдний ажлын урамшуулал зэргийг тодорхойлж, бодлого зохицуулалтын баримт бичигт тусгах хэрэгтэй.

Сурах бичгийг танилцуулах, хангах, ашиглах

Сурах бичгийг хэвлэсний дараа цаасны чанар муу (нимгэн), бүдгийн чанаргүй байх тохиолдол гарсаар байна. Мөн худалдаанд гаргадаг сурах бичгийн хэвлэлийн технологи дутуу (нуруулдаж оёогүй) шууд цавуугаар бэхэлгээ хийх тохиолдол нийтлэг байна.

Жишээ нь, 2017 онд хэвлэсэн Монгол хэл IX сурах бичгийн 29, 50 нүүрийн зургийн чанар муу, Математик XI сурах бичиг оёо хийгдээгүй, шууд наасан байна. 2016 онд хэвлэсэн Бэлтгэл хөтөлбөр I-ийн хавсралт дахь зургийг (стикер) ашиглахад төвөгтэй байсан.

Хэвлэх, хэвлэлийн дараах хяналт, үнэлгээ хийх тогтолцоог сайжруулах арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Сурах бичгийн хангалт, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Ялангуяа дунд, ахлах ангийн сурагчдыг сурах бичгээр хангах түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан ажилласнаар тэднийг 2 дахин бага үнээр сурах бичгийг хэрэглэх боломж олгож байсан. Түрээсийн тогтолцоо нь сурах бичгийн хүртээмжийг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд 45 хүртэлх хувь нэмэгдүүлж байсан нь “сурах бичиггүйгээс хичээлд оролцдоггүй, гэрийн даалгавар хийдэггүй байдлыг багасгаж, сургалтын үр дүнд ахиц гарсан гэж багш нар үзсэн” бөгөөд эцэг, эхэд ч сурах бичгийг нэг дороос түрээслэн авах, санхүүгийн хувьд ч хөнгөлөлт, дэмжлэг болж байлаа. Тухайлбал, 2014 онд дунд, ахлах ангийн сурагчдын 85 хүртэлх хувь сурах бичгээр хангагдаж байв. Сүүлийн 3-4 жилийн хугацаанд түрээсийн тогтолцоо, эргэлтийн сангийн үйл ажиллагаа зогссон байна.

Сурагч нэг хичээлийн жилийн туршид хэрэглэх бүх сурах бичгийг дунджаар 37600 төгрөгөөр худалдан авч байна. Гэсэн хэдий ч эцэг эхийн худалдан авах чадвар тааруу, хүүхдэдээ сурах бичгийг нь бүрэн авч өгөхгүй, худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ байхгүй, сурах бичгийн олдоц муу, нэг ангийн бүх сурах бичгийг нэг дороос авах зохицуулалт байхгүй, дамлан зарах явдал зогсохгүй зэрэг нь сурах бичгийн хүртээмжид хүндрэл үүсгэж байна. Мөн цаг хугацаандаа хэрэглэгчдийн гарт очихгүй байх зэрэг асуудал гарсаар байна.



Санал

- Иймд сурах бичгийн хангалт, хүртээмжийг нэмэгдүүлэхэд оролцогч талууд дараах шийдлийг хийх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:
- Эцэг эхчүүдэд оршин суугаа газраа ойр, нэг дороос хэрэгцээт бүх сурах бичгээ бодит үнээр худалдан авах боломжийг бий болгох
- Сургуулийн удирдлага, багш, номын санч төрөөс хангаж буй сурах бичгийг зорилтот бүлэгт нь зориулах, худалдаж буй сурах бичгийн талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэх, сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарч эцэг эхтэй хамтарч ажиллах, сурах бичгээ татаж авах, сурагчдад олгох, буцааж авах ажлыг төвөг чирэгдэлгүй болгохоор ажиллах
- Аймгийн БСУГ, нийслэл дүүргийн Боловсролын хэлтэс шинээр нийлүүлсэн сурах бичгийг сургуулиудад үнэн зөв хуваарилах, тооцоо хийх, худалдаж буй сурах бичгийн талаарх мэдээллийг сургуулиудад цаг хугацаанд нь хүргэх, орон нутагт сурах бичиг худалдаж буй байдалд хяналт тавих, сурах бичгийг хэвлэсэн хэвлэлийн газартай хуулийн дагуу хамтран ажиллах, сурах бичгийн нэгдсэн худалдаа зохион байгуулах, сурах бичгийн хангалтын талаар судалгаа хийх, хангалтыг нэмэгдүүлэх талаар санаачилга гарган тодорхой ажил зохион байгуулах
- Төрийн зүгээс сурах бичиг хэвлэх, түгээх, худалдан борлуулах харилцааг зохицуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох, түрээсийн тогтолцоо-эргэлтийн санг үргэлжлүүлэн ажиллуулах, сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлж үнэ төлбөргүй ашиглах боломж бий болгох, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг МХХ-ны төрөл бүрийн хэрэгслээр ашиглах программ хангамжийг хөгжүүлэх, цахим сурах бичиг, нээлттэй хэрэглэгдэхүүн боловсруулж, хөгжүүлэх, хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх
- Сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээ, даалгавар, дизайн зохиомж, багтаамж нь сургалтын хөтөлбөр, сурагчийн хэрэгцээ сонирхол, ачаалал, сурах арга барил эзэмших, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд нийцэх нийцэл болон хангалт хүртээмжийн талаар цогц судалгаа хийх
- Эцэст нь чанартай, хүүхдийн хөгжлийг дэмжсэн сурах бичиг боловсруулахад чиглэсэн судалгааг эрчимжүүлэх тогтолцоо бүрдүүлэх шаардлагатай байна.

4.2 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх

4.2.1 Хөтөлбөрийг хэрэгжилтийг дэмжих сургалт зохион байгуулах

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын баг (Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд түшиглэн) сургалт, багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр судалгаа, зөвлөн туслах ажлуудыг зохион байгуулж дараах үр дүнд хүрсэн байна. Үүнд:

1. Бага боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд багшийн хөгжих хэрэгцээний судалгааг хийж, багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлалыг олон улсын туршлага болон өөрийн орны нөхцөл байдалд тулгуурлан боловсруулсан.
2. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг тухайн хөтөлбөр хэрэгжиж эхлэх хичээлийн жил бүр зохион байгуулж ирсэн. Тухайлбал:
 - Бага боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2014 онд нийт 762 сургуулийн бага боловсролын багш нарт
 - Суурь боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2014 онд лаборатори сургуулийн багш нарт, 2015 онд нийт сургуулийн багш нарт,
 - Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2016 онд нийт сургуулийн багш нарт гэх мэтээр үе шаттайгаар зохион байгуулсан.

Хүснэгт 4.2.1.1 Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулсан он дараалал

Сургууль	Бага боловсрол I-V анги		Суурь боловсрол VI-IX анги		Бүрэн дунд боловсрол 9-12 дугаар анги		
					X анги	XI анги	XII анги
Лаборатори сургууль							
Нийт сургууль							
Он	2013	2014	2015	2016	2017	2018	

- Бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг нийт сургуулиудад нэвтрүүлэхдээ:
 - 2016-2017 оны хичээлийн жилд 10 дугаар анги,
 - 2017-2018 оны хичээлийн жилд 11 дүгээр ангид,
 - 2018-2019 оны хичээлийн жилд 12 дугаар ангид гэсэн үе шатаар нэвтрүүлж байгаа нь анги хоорондын агуулгын зөрөө, алдагдал гарах байдлыг бууруулах ач холбогдолтой байна.
- Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд 2014-2016 онд Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт зэрэг мэргэжлийн байгууллагуудаас гадна менежмент, хэрэгжилтийн баг, дэд багууд хамтран ажиллаж, сургууль дээр зөвлөн туслах, мониторинг хийх, "Сайн хичээл, үйл ажиллагааны улсын зөвлөгөөн"-ийг сургууль, бүс, аймаг, нийслэл, улсын хэмжээнд үе шаттай зохион байгуулах, багш, сургуулийн тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлэх олон талт үйл ажиллагааг эрчимтэй хэрэгжүүлсэн нь хөтөлбөр таниулахад дэмжлэг болсон.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын хувьд дараах асуудал, бэрхшээлүүд байсныг цаашдын үйл ажиллагаанд анхаарч ажиллах нь зүйтэй юм. Үүнд:

1. Төлөвлөлт

Хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэхэд Боловсролын хүрээлэн, БМДИ, БҮТ, МУБИС, МУИС зэрэг мэргэжлийн байгууллагуудаас гадна Менежментийн баг, дэд багууд олон талын оролцоотой үйл ажиллагаа зохион байгуулсан дүр зураг харагдаж байна. Гэхдээ тус багийн гишүүд үндсэн ажлын зэрэгцээ хөтөлбөрийн шинэчлэлийг дэмжих багуудад, зарим нь 2 ба түүнээс дээш багт ажиллаж байснаас нэг хүн 2-3 хүний нормт ажлыг гүйцэтгэж байсан. Үүнээс шалтгаалан ажлын бүтээмж буурах, бүтээгдэхүүн хүлээлгэн өгөх хугацаа хоцрох зэрэг асуудал гарч байсан.

Шинэ хөтөлбөрийн нэмэлт агуулгаар хичээл зохион байгуулахад багш нарын онолын мэдлэг хүрэлцэхгүй байх, сурагчдын хувьд анги хооронд агуулгын алгасалт, давхцал гарах, үүний улмаас агуулга болон цагийн зохистой харьцаа алдагдаж байсан. Сургуулиудад шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх материаллаг орчны хүрэлцээ хангамж дутагдалтай, урьдчилсан бэлтгэл хангалтгүй байжээ.

Шинэ хөтөлбөрийг түгээн дэлгэрүүлэхэд сургагч багш нар нэгдсэн ойлголттой болоход 3-4 хоногийн семинар хангалтгүй байсан. Хөтөлбөр таниулах, үндэсний хэмжээний сургалтууд зохион байгуулахад шаардагдах төсөв урьдчилан батлаагүйн улмаас сургагч багш нарт ажлын хөлс, урамшуулал хоцорч олгох асуудал гарч байсан.



Санал

- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, материалын дэмжлэг, хугацааг нарийн тооцоолж, мэргэжлийн байгууллагуудын уялдаа холбоо бүхий тогтвортой, үрт хугацааны нэгдсэн төлөвлөлт, түүнийг дагасан бодит төсөв боловсруулан тогтвортой мөрдөх
- Хөтөлбөр шинэчлэх нэгдсэн төлөвлөгөөнд хөтөлбөр таниулах үйл ажиллагааг 1 жилээс доошгүй хугацаагаар тусгах
- Таниулах үйл ажиллагааны дараа шинэ хөтөлбөрт шилжих шилжилтийн хугацааг нэгдсэн төлөвлөгөөнд тусгах, дунд, богино хугацааны төлөвлөгөө боловсруулж, төсвийг батлуулах
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх хүний нөөц, үйл ажиллагааны цар хүрээ, ажлын хэмжээг нарийн тооцоолох, ажил, үүргийн хуваарийг боловсруулах, ҮЗ, менежментийн баг, хэрэгжилтийн багуудтай байгуулах гэрээнд хийх ажлын төлөвлөгөөний хамт, ажил гүйцэтгэгчдийн ойлголтыг нэгтгэх сургалт, тайлбар хурал зэрэгт хамруулах, түүнд зориулсан хугацааг хангалттай тусгах,

2. Хэрэгжүүлэлт

Багшийн хөгжих хэрэгцээний судалгааны тайлан, багшийн мэргэжил дээшлүүлэх үзэл баримтлалыг боловсруулсан, эрх зүйн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээний тайлан, зөвлөмж хэвлэгдэн, мэргэжлийн байгууллагуудад болон ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтан, багш, мэргэжилтнүүдэд танилцуулаагүй, мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа, эргэх холбоо бүхий тогтолцоо бүрдээгүй байгааг харуулж байна. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагаа ихээхэн чухал болохыг хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад цуглуулсан мэдээлэл харуулж байна.

Хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагуудын оролцоо, дэмжлэг илүү их шаардлагатай байгааг сургалтын тайлан, зөвлөн туслах мониторингийн ярилцлага асуулга дээр дурдсан байна. Энэ нь нэгдсэн төлөвлөлтөд орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагуудын үүрэг, хариуцлагыг хангалтай тусгаагүй, тэдгээр байгууллагууд нь захиргааны болон арга зүйн чиглэлийг ажлыг хослуулан хариуцдаг, ажлын ачаалал их, бүтэц, орон тооны хувьд судлагдахуун бүрийг хариуцсан мэргэжилтнүүд хангалттай тоогоор байдаггүйтэй холбоотой.

Сургуулийн удирдах ажилтны манлайлал дутмагаас багшийн бие даан хөгжих, ажлын байран дахь хөгжлийг дэмжих үйл ажиллагаа орон нутаг, сургууль бүрд жигд бүс байсан. Энэ нь багш, удирдах ажилтны ажлын үнэлгээний шалгуур тэдний мэргэжлийн хөгжлийн хөшүүрэг болж чадахгүй байгаатай холбоотой гэж дүгнэж болох юм.

Лаборатори сургуулиуд БСШУС-ын яаманд шууд харъяалагдаж байсан нь арга зүй удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй орон нутгийн боловсролын газартай хэрхэн ажиллах талаар ойлгомжгүй байдал үүсгэж байв. Лаборатори сургуулиуд нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд бусад сургуулиудад зөвлөн туслах чиг үүрэгтэй байсан нь багшийн ажлын ачааллыг нэмэгдүүлж байв. Шинэ хөтөлбөр хэрэгжүүлж эхэлж байгаатай холбоотой анги тус бүрд үүсэх хөтөлбөрийн агуулгын зөрөөг хэрхэн шийдвэрлэх талаар багшид зориулсан арга зүй зөвлөмж, шилжилтийн үеийн сургалтын төлөвлөгөө хэрэгтэй бөгөөд, сургуулийн материаллаг бааз, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн хүртээмжтэй бүс байгаа нь зөвлөн туслах мониторингийн ажлын дүгнэлт, тайланд дурдагдаж байв. Энэ нь хөтөлбөрийг нийт сургуулиудад хэрэгжүүлж эхлэхийн өмнөх бэлтгэл ажил хангалттай хийгдээгүйтэй холбоотой байна.



Санал

- Судалгаа, шинжилгээ, мониторингийн дүгнэлт, тайлан, зөвлөмжийг түвшин бүрд ил тод мэдээлэх, мэргэжлийн байгууллагуудын ажлын үйлдвэр хангасан эргэх холбоо бүхий тогтолцоог сайжруулан бэхжүүлэх
- Орон нутгийн боловсролын асуудал эрхэлсэн байгууллагуудын хөтөлбөрийн шинэчлэлийн үйл ажиллагаанд оролцох үүрэг, хариуцлагыг тодорхой болгон, жил бүрийн төлөвлөгөө, төсөвт хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих ажлыг тусгаж, үнэлж, дүгнэж байх
- Шинэ хөтөлбөр таниулах материалуудыг боловсруулан түгээх, багш, удирдах ажилтнуудын ойлголтыг нэгтгэн үүлзалт, зөвлөгөөн, онлайн хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр шинэ хөтөлбөрийг орон нутаг, сургуулийн онцлогт тулгуурлан сургуулийн менежменттэй үйлдүүлэх, сургуулийн хөтөлбөр боловсруулахад чиглэсэн арга зүйн зөвлөмж, дэмжлэгийг сургуулийн удирдах ажилтнуудад үе шаттайгаар үзүүлэх хэрэгтэй юм.
- Багш, удирдах ажилтны ажлын үнэлгээг сургуулийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах ажилтай нягт үйлдүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх. Үүний тулд мэргэжлийн байгууллагууд хамтран судалгаанд үндэслэн багшийн ажлын үнэлгээний журмыг боловсруулах, сургуулийн удирдах ажилтнуудын манлайллыг сайжруулах, сонгон шалгаруулалт, томилгоог цаг үеийн шаардлага, боловсролын хөгжлийн бодлогод нийцүүлэн оновчтой зохион байгуулах хэрэгтэй байна
- Лаборатори сургуулийн хувьд багшийн ажлын ачаалал, нормыг бусад сургуулиас онцлогтойгоор тогтоож, хамтын болон ганцаарчилсан судалгааны ажил хийх, бусад сургуулиудад зөвлөх үүргийг ажлын байрны тодорхойлолтод тусгах, багшийн сонголт, ажлын байранд тавих шаардлагыг сайжруулах
- Багш нарт хөтөлбөрт орсон гол өөрчлөлтүүдтэй холбоотой зөвлөмж материал, хичээлийн арга зүйн тодорхой санаануудыг боловсруулан хүргэж байх, хичээлийн судалгааг сургууль, бүсийн хэмжээнд үр дүнтэй зохион байгуулж, багшийн арга зүйн хөгжлийг тасралтгүй дэмжих

3. Үнэлгээ, эргэх холбоо

Багш нарт зохион байгуулсан арга зүйн сургалтуудын чанар, үр өгөөжийг үнэлэх, сургалтын тайланд дүн шинжилгээ хийж, багш нараас гарсан санал, хүсэлтийг нягтлан үзэж, эргэх холбоонд оруулах ажил хангалтгүй хийгдсэн.

Багшийн арга зүйн хөгжилтэй холбоотой асуудлуудыг илрүүлэх мониторинг, түүний үр дүнд суурилсан зөвлөмж, арга зүйг боловсруулан түгээн дэлгэрүүлэх ажил санхүүжилт болон хүний нөөцийн хүрэлцээ, чадавхаас хамааран тасралтгүй, үе шаттайгаар үргэлжлэхгүй, хамрах хүрээ хязгаарлагдмал байна. Сургууль, багш нарт тулгамдаж байгаа, боловсролын бодлого, эрх зүй, санхүүжилттэй холбоотой асуудлыг шийдвэрлэх явц удаашралтай байв.

Боловсролын үнэлгээний төвөөс сурагчдын сурлагын амжилтын судалгааг жил бүр хийж байгаа ч судалгааны үр дүн, тайланг мэргэжлийн болон боловсролын байгууллагуудтай нээлттэй хуваалцахгүй байна. Сурлагын амжилтын судалгааны үр дүнд шинжилгээ хийж, суралцагчдын гүйцэтгэл хангалтгүй байгаа шалтгааныг илрүүлэх, багшид арга зүйн дэмжлэг үзүүлэхүйц зөвлөмж боловсруулагдаагүй байна.



Санал

- Багш нарын санал, хүсэлтэд тулгуурлан үндэсний болон орон нутгийн сургалтуудыг залгамж холбоотойгоор зохион байгуулах, сургалтын үр дүн, тайланд шинжилгээ хийж эргэх холбоог хангах
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад мониторинг хийж, сургууль дээрх зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмолжуулах, мониторингоор илрүүлсэн асуудлуудын шийдлийг боловсролын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллагууд хамтран боловсруулж, шийдвэрлэх эргэх холбоог бэхжүүлэх
- Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулдаг сурлагын амжилтын судалгаа, улсын шалгалтын даалгаврын шинжилгээг мэргэжлийн байгууллагуудын хэмжээнд мэдээлэн танилцуулах, түүнд үндэслэн багш, сургуулийн удирдах ажилтан, боловсролын байгууллагуудын түвшин бүрд зориулсан зөвлөмж, арга зүйгээр хангах
- Сурагчдын даалгаврын гүйцэтгэлд үл суурьтай шинжилгээ хийж, түүндээ үндэслэн хичээлийн арга зүйн тодорхой жишээг боловсруулан түгээх ажлыг жил бүр зохион байгуулж, хэвшүүлэх, үүнд мэргэжлийн байгууллагууд, ялангуяа багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага үнэлгээний байгууллага нягт хамтран ажиллах

4.2.2 Сургууль дээр хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих үйл ажиллагаанд хийсэн дүгнэлт, санал

Сургууль дээр шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх урт бөгөөд дунд хугацааны төлөвлөлт, төсөв батлагдаагүйн улмаас тогтвортой үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй, санхүүжилтээс хамааралтай, тогтолцооны түвшинд тасралтгүй үйл ажиллагаа явуулах боломж хязгаарлагдмал байсан байна. БШУЯ нь шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхийн тулд шүүрхай арга хэмжээ авч “хэрэгжилтийг баг”-ийг байгуулан бүх сургуульд хүрч ажиллахад хүч тавин ажиллажээ. Энэ нь тухайн үед тулгамдсан асуудлыг богино хугацаанд шийдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн эхэн үед хэрэгтэй шийдвэр байсан боловч цаашид тогтвортой, тасралтгүй ажиллахад хүндрэл учирч тогтолцооны шинжтэй доорх асуудлууд тулгарчээ.

Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

2012 оноос эхэлж хэрэгжүүлсэн бага, дунд боловсролын шинэчлэл хийх ерөнхий зураглал 6 жилээр батлагдсан боловч шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд тасралтгүй дэмжлэг үзүүлэх урт, дунд хугацааны төлөвлөгөө, төсөв батлагдаагүй нь сургууль, багшийг дэмжих тогтвортой тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд бэхжүүлэхэд бэрхшээл учруулж байсан байна. Шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх 34 гишүүнтэй “Хэрэгжилтийн баг” нь БСШУЯ-ны СБТГ-ын удирдлага, төлөвлөлтийн дагуу үндэсний, орон нутгийн, сургуулийн түвшинд ажиллажээ. Мөн түүнчлэн, шинэчлэлийн ерөнхий зураглалд шинэ хөтөлбөр, сурах бичиг боловсруулж дуусмагц бүх нийтээр хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн нь хэрэгжилтийн өмнөх бэлтгэл ажил хийх цаг хугацааны хувьд тулгамдсан асуудал байв. Энэхүү цаг хугацаа тулгамдсан нөхцөлд БШУЯ яаралтай арга хэмжээ авч “хэрэгжилтийн баг”-тай гэрээ байгуулсан байна.

Хэрэгжилтийн баг нь 2013/2014-аас 2015/2016 хүртэлх хичээлийн жилүүдэд сургуулиудад цөм хөтөлбөр таниулах, зөвлөн туслах, мониторинг зохион байгуулах зэрэг сургууль дээр хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн ажиллажээ. Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх тогтолцооны “сул орон зай”-г нөхөж ажилласан боловч төсөв батлагдаагүй нь тасралтгүй, тогтвортой ажиллахад бэрхшээл болсон байна. Хэрэгжилтийн багийн гэрээ дууссан учир хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь орон нутаг, сургуулийн удирдлагын санаачлага, ажиллах хүч, санхүү, материаллаг нөөцөөс хамааралтай, тогтвортой бус болсон байна.



Санал

- Шинэ хөтөлбөрт шилжих бэлтгэл хангах, хэрэгжилтэд тогтмол, тасралтгүй дэмжлэг үзүүлэхийн тулд Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих” бүтэц бий болгож урт болон дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж, шаардлагатай төсвийг улсын болон орон нутгийн төсөвт суулгах.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих багийг байгуулахдаа тогтмол үйл ажиллагаатай багшийн мэргэжлийг дээшлүүлэх чиг үүрэг бүхий үндэсний мэргэжлийн байгууллагыг түшиглэн, орон нутгийн боловсролын газар болон холбогдох газрын төлөөллийг хамруулах
- Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх шилжилтийн үйл ажиллагааг төлөвлөж /урьдчилсан хэрэгжилт/, холбогдох зардлыг төсөвт суулгах
- Шинэ хөтөлбөр бүрэн хэрэгжиж эхэлсэнээс хойш тасралтгүй, тогтмол дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа төлөвлөж, холбогдох зардлыг төсөвт суулгах
- Төлөвлөгөө боловсруулахдаа “Төлөвлөх-Гүйцэтгэх-Үнэлэх-Сайжруулах” загварын дагуу хүний, материалын болон санхүүгийн нөөцийг бодитой тооцон хэрэгжихүйц, биелэгдэхүйц, үнэлэгдэхүйц, үр дүнтэй байх зарчмыг баримтлах. Аливаа үйл ажиллагааны бэлтгэл хугацааг хангалттай төлөвлөж байх.
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд тогтмол дэмжлэг үзүүлэх үндэсний болон орон нутгийн хүний нөөцийг чадавхижуулах ажлыг нэгдсэн төлөвлөгөөнд тусгах, төсөв шийдэх

Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл

Дээр дурьдсанчлан, шинэ хөтөлбөрт шилжих цаг хугацаа хангалттай төлөвлөгдөөгүйн улмаас орон нутгийн боловсролын газрын болон сургуулийн бэлэн байдал бүрэн гүйцэд хангагдаагүй байна.

Үндэсний хэмжээнд шинэ хөтөлбөрийг таниулах сургагч багшийг бэлтгэх болон түгээн дэлгэрүүлэх сургалтыг 8 сард зохион байгуулж, 9 сараас орон даяар шинэ хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ. Иймд үндэсний болон орон нутгийн сургагч багш нар бүрэн хэрэгжилт эхэлсэнтэй зэрэгцээд шинэ хөтөлбөр таниулах сургалт хийсэн байна. Бага боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн мониторингийн тайланд дурдсанаар “нэг багш 9-15 удаа сургалт, семинарт хамрагдсан” (лаборатори сургуулийн сургалтыг оруулсан) гэжээ.

Олон сургалт зэрэг зохион байгуулсан боловч сургагч багш нар өөрсдөө нэгдсэн ойлголттой болж амжаагүйн улмаас багш нарт шинэ хөтөлбөрийн талаар цэгцтэй бөгөөд тодорхой мэдээлэл хүргэхэд зарим үед дутмаг байх хандлага ажиглагдсан байна.

Сургуулийн удирдлага нь шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх сургуулийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах ажлыг манлайлах, орчин бүрдүүлэх, багш нарын шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах, сурагчдын өмнөх хөтөлбөрт үзээгүй агуулгын зөрөөг арилгах зэрэг олон тулгамдсан асуудлуудтай тулгарсан байна.



Санал

- Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахын тулд Үндэсний зөвлөл, менежментийн багийн хүрээнд хэлэцэж батлуулах нэгдсэн төлөвлөлтөд шилжилтийн төлөвлөгөө, холбогдох зардлыг тусган батлуулах
- Шилжилтийн үеийн дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулахдаа шинэ хөтөлбөрийг урьдчилсан байдлаар сургуулийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгах. Мөн шилжилтийн үед багш, сурагч хэрэглэх нэмэлт материалуудыг урьдчилан боловсруулсан байх.
- Шинэ хөтөлбөр таниулах сургалтын бэлтгэл ажлыг хөтөлбөр шинэчлэгдэн боловсруулж дуусмагц эхлэх бөгөөд хөтөлбөрийн юу нь шинэчлэгдсэн, түүнийг хэрхэн заах, үнэлэх зэрэг асуудлаар маш тодорхой мэдээлэл бэлдэж нэгдсэн журмаар таниулж сургагч багш нар нэгдмэл ойлголттой болсон байх.
- Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх сургуулийн менежментийн талаар удирдлагуудад зөвлөмж, гарын авлага тарааж сургалт зохион байгуулах, сургалтын орчин бүрдүүлэхэд улсаас болон орон нутгаас дэмжлэг үзүүлэх. Бодит хэрэгцээг илрүүлэхийн тулд шилжилтийн өмнөх нөхцөл байдлын судалгаа хийх шаардлагатай.

- Шилжилтийн үеийн сургуулийн бэлэн байдлыг шалгах, үүнд:
 - Шилжилтийн үеийн сургуулийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх
 - Шилжилтийн үеийн судлагдахууны жилийн төлөвлөгөө боловсруулсан байх
 - Шинэ хөтөлбөрийн нийтлэг зарчим, судлагдахууны агуулга, арга зүй, үнэлгээний өөрчлөлтийн талаар нэгдсэн ойлголтод хүрсэн байх
 - Сурагчдын үзэх хуучин, шинэ хөтөлбөрийн агуулгын зөрөөг арилгах материал боловсруулсан байх

Шинэ хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх

Өмнөх хөтөлбөрийн шинэчлэлээс ялгаатай нь хэрэгжилтийн багийн гишүүд лаборатори сургуулиуд дээр байрлаж (хэд хэдэн сургууль хариуцаж) шинэ хөтөлбөр таниулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлжээ. Багийн гишүүд лаборатори сургуулийн удирдлага, багш нартай хамтарч ажилласан нь тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдэхэд зөвлөн тусалж эргэх холбоо бий болгох ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилтийн баг нь гэрээний дагуу БШУЯ-ны удирдлага зохион байгуулалтаар ажиллаж, ажлын үр дүнгээ тайлагнаж байсан нь шийдвэр гаргах түвшинд тулгамдсан асуудлыг богино хугацаанд шийдэж эргэх холбоотой ажиллахад дэмжлэг болсон. Гэсэн хэдий ч нэгдсэн төлөвлөлт хийгдээгүйн улмаас мэргэжлийн байгууллага, орон нутгийн боловсролын газрын түвшинд мэдээлэл дамжуулалт удаашралтай, эргэх холбоонд татан оролцуулахад цаг хугацаа алдагдалтай байжээ.

Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх бэлтгэл хангагдаагүй, тухайлбал, шинэ хөтөлбөрийн үзэл баримтлалын талаар нэгдсэн ойлголттой болоогүй, зөвлөх ажлын удирдамж, аргачлал бүрэн гүйцэд боловсруулагдаагүй зэрэг бэрхшээл нь “хүүхэд юуг мэддэг, чаддаг болох?, хэрхэн заах, үнэлэх?” зэрэг асуудлуудад цэгцтэй, үнэн зөв хариулт өгөхөд хүндрэлтэй байжээ.

Шинэ хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хөтөлбөр хэрхэн шинэчлэгдсэн тухай ойлголтоо нэгтгэх, тулгамдаж буй асуудлаа хамтдаа шийдэх арга эрэлхийлж, бусдаас туршлага судлах зорилгоор “сайн хичээл, үйл ажиллагаа” улсын зөвлөлгөөн 2014, 2015 онд зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагаа нь багш нар шинэ хөтөлбөрийн үзэл баримтлалаа ойлгох, хэрэгжүүлэх, сургуулийн удирдлагуудад удирдлага, зохион байгуулалтаа сайжруулахад санаа болохуйц үр дүнтэй ажил болсон төдийгүй сайн хичээл, үйл ажиллагааны сан бий болсон байна.

Энэхүү үйл ажиллагааг улс орон даяар зохион байгуулсан нь цаг хугацаа, хүний нөөц, санхүүжилт шаардсан өргөн хэмжээний ажил болжээ. Мөн үндэсний, орон нутгийн, сургуулийн төлөвлөгөөнд уялдаатай мөн урт хугацаанд төлөвлөөгүй учир 2 жил хийгдээд 2016 оноос хойш хэрэгжээгүй байна.



Санал

- Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд “хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” тогтолцоог бүрдүүлж мэргэжлийн болон орон нутгийн боловсролын байгууллагын чиг, үүрэгт сургууль дээр жил бүр мониторинг, зөвлөн туслах үйл ажиллагааг төлөвлөж, төсөвт суулгах
- Шинэ хөтөлбөрийн бүрэн хэрэгжилтэд орохын тулд сургуулийн бэлэн байдалтай танилцаж дэмжлэг үзүүлэх. Тухайлбал:
 - Шинэ хөтөлбөрийн дагуу сургуулийн хөтөлбөр боловсруулсан эсэх
 - Шинэ хөтөлбөрт орсон гол өөрчлөлт, нийтлэг зарчим зэргийг ойлгосон эсэх
 - Сурагчид юу чаддаг болохын тулд юуг хэрхэн сурах, яаж үнэлэх зэрэг гол асуудлуудыг харгалзан сургуулийн хөтөлбөрийн менежментийг шийдсэн эсэх
 - Шинэ хөтөлбөр хэрэгжүүлэх сургалтын орчин бүрдүүлсэн эсэх
- Хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхийн тулд багш, удирдлага, сурагч, эцэг эхэд тулгамдаж буй асуудлын талаар мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, тайлан боловсруулж эргэх холбоог бий болгох буюу олон нийтэд ил болгосоноор, асуудлыг хамтдаа шийдэх хандлага тогтож, хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх

- Хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийх нь хэрэгжиж буй хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг болох төдийгүй дараагийн хөтөлбөрийг сайжруулах үндэслэл болох учир Төлөвлөх-Гүйцэтгэх-Үнэлэх-Сайжруулах (PDCA) гэсэн аливаа үйл ажлыг тасралтгүй сайжруулах циклийг боловсролын байгууллагын түвшин бүрт хэрэгжүүлэх шаардлагатай байна.
- БМДИ нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тулгамдаж буй асуудлыг шийдэх болон тодорхой ажлын шаардлагаар хийгдэх нэмэлт ажлуудыг жил бүрийн төлөвлөгөөндөө тусгах бөгөөд хамтран ажиллах бусад мэргэжлийн байгууллага болон орон нутгийн боловсролын газруудын үйл ажиллагааг тодорхой төлөвлөх
- Түршлага хуваалцан, харилцан суралцах үйл ажиллагааг дэмжин улсын хэмжээнд жил бүр багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр зөвлөгөөн, бага хурал зохион байгуулах

4.3 СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ

4.3.1 Бага, дунд боловсролын үнэлгээний шинэчлэл

2013 оны 05 дугаар сарын 08-ний өдрийн А/155 тоот “Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтын 4.3 дахь хэсэгт Боловсролын үйлчилгээний үр дүнгийн үнэлгээний шинэчлэлийг тодорхойлж гаргасан бөгөөд тус тушаалын 3 дугаар хавсралтаар боловсролын үнэлгээний багийг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

2013 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А/326 дугаар тушаалаар “Багийн бүрэлдэхүүн шинэчлэх, зардал батлах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” тушаалын нэгдүгээр хавсралтаар “...Боловсролын үнэлгээний үзэл баримтлал, бодлого, чиглэл боловсруулах” багийг 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр дахин шинээр байгуулсан байна.

Хүний нөөц: Үнэлгээний баг байгуулагдсан тушаал болон төлөвлөгөө хугацааны хувьд уялдаагүй үйл ажиллагаа явагджээ. Үнэлгээний баг анх байгуулагдах шийдвэр гарснаас эхлээд үнэлгээний шалгалт зохион байгуулагдах хүртэлх хугацаанд нэгдсэн төлөвлөгөө боловсруулагдаагүй. Үнэлгээний багийг байгуулагдсаны дараа БШУЯ-наас зорилго болон чиглэл танилцуулагдсан боловч үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө нь баг байгуулах үеийн тушаалд хавсаргаагүй, нэгдсэн төлөвлөгөө боловсруулагдаагүй байхад үнэлгээний баг ажлаа эхэлсэн байна.

Боловсролын чанар, сурлагын амжилтын бодит байдалд дүн шинжилгээ хийгдээгүй байхад сурлагын амжилтыг үнэлэх үзэл баримтлал боловсруулагдсан. Түүнчлэн үйл ажиллагааны төлөвлөгөөгүйгээр богино хугацаанд бүтээгдэхүүн боловсруулах ажил хийгдсэн ч ажлын явцын хяналт, боловсруулагдан гарсан бүтээгдэхүүний чанарын хяналт хангалттай явагдаагүй. Ялангуяа А/155-р тушаалаар боловсролын үнэлгээний шалгуур үзүүлэлт (бенчмарк) боловсруулах чиглэл гарсан ч гүйцэтгэлт тавих хяналт хангалтгүй байсан.

Нэгдсэн төлөвлөгөө байхгүйгээс үнэлгээний баг болон мэргэжлийн байгууллага хоорондын харилцаа болон ажил үүргийн хуваарь тодорхой бус байсан бөгөөд тухайн баг ажлаа хэрхэн гүйцэтгэх нь тодорхойгүй, мэргэжлийн байгууллагатай хамтарч ажиллаагүй бөгөөд шаардлагатай мэдээллийг дамжуулахад бэрхшээлтэй нөхцөл байдалд үйл ажиллагаа явуулжээ гэж дүгнэхээр байна.

Хугацаа: Богино хугацаанд ажил төлөвлөсөн, нэгдсэн төлөвлөлт тодорхой бус байсан учраас бүтээгдэхүүн-хүрэх үр дүнгийн гүйцэтгэл хангалтгүй, хяналт сул байсан болно.

Бүтээгдэхүүн-хүрэх үр дүн: Үндэсний үнэлгээний баг нь 2013 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гаргасан байна. Үүнд:

1. Үнэлгээний эрх зүйн орчны шинжилгээ
2. Үнэлгээний стандарт хэрэгжилтийн судалгаа
3. Чанарын үнэлгээний шинэчлэл /ерөнхий, багшийн, сурагчийн, сургуулийн үнэлгээний үзэл баримтлал/
4. Сургуулийн, багшийн үнэлгээний шинэ стандарт, зөвлөмж
5. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээ /6 хичээл*5 анги/
6. Боловсролын чанарын үнэлгээний аргачлал, арга зүй
7. Бага ангийн багш нар үнэлгээний сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг төлөвлөсөн байна.

Улмаар 2014 онд:

1. Боловсролын чанарын үнэлгээ хийх /5, 9-р анги/
2. Матемтик, БУ, Монгол хэлний стандартыг 3 түвшинд боловсруулах
3. Суралцагчдын мэдлэг, чадварыг үнэлж дүгнэх аргачлал, зөвлөмж боловсруулах
4. Бага боловсролын сургалтын хөтөлбөрийн үнэлгээний аргачлал боловсруулах

5. Багшийн журналын загвар боловсруулах, түрших гэсэн ажлуудыг төлөвлөсөн байна.

Гэвч үндэсний үнэлгээний баг нь А/309 тоот тушаал түүний хавсралтууд “ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”, А/293 тоот тушаалын 1, 2 дугаар хавсралт дахь “ЕБС-ийн болон цэцэрлэгийн багшийн ажлыг үнэлж, дүгнэх журам”-ыг боловсруулан түүнийг дагалдуулан хэрэгжүүлэх зөвлөмж, түгээн дэлгэрүүлэх сургалтын материалыг бэлтгэсэн байна. Мөн А/309 тоо тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дэх хэсэгт Боловсролын чанарын үнэлгээ хийх тухай тусгаж өгснөөр Боловсролын үнэлгээний төв нь 2014 оноос эхлэн улсын хэмжээнд түүврийн аргаар 100 сургуулийг сонгон 5, 9-р ангийн хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагчдын мэдлэг, чадварын түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулж эхэлсэн.



Санал

- Аливаа үйл ажиллагааг эхлэхийн өмнө нотолгоонд суурилсан судалгаа хийж нөхцөл байдлыг тооцон нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, бүтээгдэхүүн-хүрэх үр дүнд баримжаалан үйл ажиллагааг төлөвлөн түүнд тохирсон төсвийн төлөвлөлтийг хийх, мэргэжлийн байгууллагад түшиглэж мэргэжилтнүүдийг татан оролцуулах шаардлагатай байгааг дээрх үйл ажиллагаанууд харуулж байна.
- Үйл ажиллагаа эхлэхээс өмнө багийн үүрэг, чиглэл, хүрээг тодорхойлон гаргах, боловсруулах бүтээгдэхүүнийг тодорхой зааж, тухайн бүтээгдэхүүнийг боловсруулахад хийх шаардлагатай ажлууд, түүний дараалал, мэргэжлийн байгууллага болон үнэлгээний багийн ажлын хуваарийг багтаасан нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай байна.
- Нэгдсэн төлөвлөгөөг гаргахдаа нөхцөл байдлыг тооцон хүний нөөц, зарцуулах цаг хугацааг зөв тооцоолох хэрэгтэй байна.
- Мэргэжлийн байгууллагуудыг үйл ажиллагаануудад татан оролцуулах, хянуулах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлуудыг зөв оновчтойгоор зохион байгуулах
- Мөн энэхүү төлөвлөгөөнд төсвийн арга хэмжээ болон ижил төстэй үүрэг бүхий байгууллагын ажил үүргийн хуваарийг тодруулж, ажлын дараалал болон бүтээгдэхүүний чанарын хянагчаар мэргэжлийн байгууллагыг томилох зэрэг арга хэмжээ авснаар тус дүн шинжилгээнээс илэрсэн асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлнө.
- Хугацаа богино байснаас багийн гишүүдийг нэгдсэн ойлголттой болгох ажил хангалтгүй түвшинд байгаа нь бүтээгдэхүүн-үр дүнгээс харагдаж байна. Иймээс үйл ажиллагааг илүү томоор, системийн түвшинд авч үзэн нэгдсэн төлөвлөгөө боловсруулснаар багийн гишүүдийг чадавхжуулах боломж бүрдэж, чанартай бүтээгдэхүүн боловсруулах боломжтой болно.

4.3.2 Чанарын шалгалт зохион байгуулах

2013 оны 08 дугаар сарын 16-нд БШУ-ны сайдын А/309 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дэх хэсэгт заасанчлан бага, дунд, бүрэн дунд боловсролын түвшинд чанарын үнэлгээний судалгааг жил бүр түүврийн аргаар, улсын шалгалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана хэмээн заасанчлан БҮТ нь 2014 оноос Чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулж ирсэн.

Хүний нөөц: Сэдэв даалгавар боловсруулах, эксперт хийх, судалгааны материалыг засаж үнэлэх хүний тоо цөөн тул байнга хэдхэн хүний хүрээнд эргэлдэж байдаг бөгөөд хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Судалгааны бичгийн шалгалтыг шаардлагын хэмжээнд зохистой явуулах боловсон хүчний нөөц хомс тул ЕБС-ийн багшид заавар зөвлөмж өгч судалгааг зохион байгуулах ажлыг гүйцэтгүүлж байна. Эдгээр хүмүүс бүгд судалгааны бичгийн шалгалтын задгай даалгаврыг үнэлж дүгнэх ажлыг сэдэв зохиогч болон сургаж бэлтгэсэн хэдхэн шалгагч багшийн хүрээнд зохион байгуулж байна. Нэмэлт боловсон хүчин бэлтгэх шаардлагатай байна. Шалгалтын даалгавар боловсруулах боломжтой хүнийг бэлтгэх, мөн боловсруулагдсан даалгаврыг баталгаажуулах, хэрэгжилтийн үр дүнг баталгаажуулж чадах хүний нөөцийг яаралтай бэлтгэх нь даалгаврын чанарыг хангах хийгээд дээшлүүлэх зайлшгүй нөхцөл болж өгнө.

Хугацаа: Судалгааны бичгийн шалгалтын сэдвийг боловсруулах хугацаа 30 хоног орчим, эксперт хийх хугацаа 10 орчим хоног байдаг. Судалгааг жил бүрийн 3 дугаар болон 4 дүгээр сард зохион байгуулдаг бөгөөд 3-4 хоногт зохион байгуулж дуусгадаг. Судалгааны материалыг дүгнэж оноожуулах ажлыг 10 орчим хоногт хийж гүйцэтгэж байна.

Бүтээгдэхүүн-хүрэх үр дүн: Чанарын үнэлгээний судалгааны үр дүнг нэгтгэн тайлан боловсруулагдан түгээгддэг.


Энэхүү тайланг хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын чанар үр дүнг тооцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход хэрэглэх бүрэн боломжтой бөгөөд БСШУСЯ, БМДИ, БХ, аймаг нийслэлийн боловсролын газар, сургууль, багш нарын хүрээнд хэрэглэх боломж бүхий статистикийн программыг ажиллуулах юм. Чанарын судалгааны тайланг БҮТ-өөс боловсруулж яаманд хүлээлгэн өгч байсан бөгөөд судалгааны үр дүнг зөв хэрэглэх ойлголт, соёл бүрдээгүй гэдэг шалтгааны улмаас судалгаанд хамрагдсан сургууль, байгууллагуудад тайланг нээлттэй хүргэх талаар болгоомжилж байсан.



Санал

- Чанарын үнэлгээний судалгааны үр дүнг хэн нэгэнд арга хэмжээ авах, жагсаан эрэмбэлэхэд биш сургалтын үйл ажиллагааг болон хөтөлбөр, сурах бичгийн агуулга, багш нарын заах арга зүйд дэмжлэг үзүүлэх чиглэлээр ашигладаг байхуйцаар дараах байдлаар шийдэх саналтай байна.
- Чанарын үнэлгээний шалгалтын даалгаврын санг боловсруулах, хянах, тохирцыг үзэх, баталгаажуулах үйл явц, үе шат, хугацааг хэрэгжихүйц тодорхойлон, мэргэжлийн байгууллагуудын үүрэг оролцоо, хамтын шийдлийг эрх зүйн орчноор баталгаажуулах.
- Үнэлгээний чиглэлээр мэргэших хүний нөөцийн хөгжилд тавигдах шаардлага, шалгуурыг тодорхой болгож, мэргэжлийн байгууллагад суурилан хүний нөөцийг төлөвлөлт боловсруулан хэрэгжүүлэх, удирдан зохион байгуулах, үүрэг хариуцлага, урамшуулал дэмжлэгийг тодорхой болгох.
- Хөтөлбөрийн үр дүн, суралцагчдын мэдлэг, чадвар, хандлагын эзэмшилтийн үйл явцыг үнэлэх, хамаарал нөлөөлөл, шалтгааныг тодорхойлох судалгаа, даалгаврын санг боловсруулах чадвартай хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх тасралтгүй сургалт үйл ажиллагааг зохион байгуулах тогтолцоог бүрдүүлэх.
- Даалгаврын гүйцэтгэлийн мэдээлэлд тулгуурлан тухайн агуулга, үр чадварын эзэмшилтийн хүвийг хэрхэн сайжруулах арга зүйн чиглэлийн сургалт, мэдээлэл, материалыг бэлтгэн тогтмол багш нарт хүргэх.
- Чанарын үнэлгээний судалгааны үр дүн, тайланг мэргэжлийн байгууллага нь сайн муугаар жагсаан, уралдуулах биш байх ёстой улсын дунджаас хаана байгааг илрүүлэн сургалт, үйл ажиллагааны арга зүйн зөвлөмжийн хамт боловсролыг чанарыг сайжруулахад ашиглах зорилгоор олон нийтэд нээлттэй болгох.
- Цаашид судалгааны үр дүн ашиглалтыг нэмэгдүүлэх боломжийг дараах байдлаар тодорхойлон зурагласан байна.

Зураг 4.3.2.1



4.3.3 Улсын шалгалт зохион байгуулах

2013 оны 08 дугаар сарын 16-нд БШУ-ны сайдын А/309 тоот тушаалын нэгдүгээр хавсралтын 4 дэх хэсэгт Боловсролын үнэлгээний байгууллагыг бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшинд улсын шалгалтыг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана хэмээн заасанчлан БҮТ нь 2014 онд зөвхөн блюпринтийг боловсруулан өгөх байдлаар зохион байгуулж эхэлсэн бөгөөд 2015 оноос эхлэн ижил түвшний сэдэв даалгаврыг боловсруулан түгээх ажлыг зохион байгуулж ирсэн.

Хүний нөөц: Улсын шалгалтыг БҮТ-ийн даалгаврын санд тулгуурлан зохион байгуулж байна. Энэхүү даалгаврын сангийн даалгавар боловсруулах, эксперт хийх хүмүүс нь чанарын судалгааны сэдэв даалгавар зохиогчид дээрээ тулгуурласан цөөн тоотой байдаг бөгөөд цаашид хүний нөөцийг яаралтай нэмэгдүүлэх, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна. Шалгалтын даалгавар боловсруулах боломжтой хүнийг бэлтгэн гаргах, мөн боловсруулагдсан даалгаврыг баталгаажуулах чадвартай хүний нөөцийг яаралтай бэлтгэх нь даалгаврын чанарыг хангах хийгээд дээшлүүлэх зайлшгүй нөхцөл болж байна.

Хугацаа: Улсын шалгалтын сэдэв даалгаврыг засаж оноожуулах, мэдээллийг шивэх хугацаа богино байгаа нь сургууль, багш нарт хүндрэл учруулж байсан.

Бүтээгдэхүүн-хүрэх үр дүн: Суралцагчдын мэдээллийг шивж оруулсны дараа мэдээлэлд боловсруулалт хийх, статистик мэдээлэл авахад БСУГ, НБГ, БХэлтэс болон сургууль, багш нарт хүндрэлтэй байдаг.



Санал

- Улсын шалгалт нь сургуулийн өөрийн үнэлгээний нэг хэлбэр бөгөөд сургууль дээр багш нар сургалтын хөтөлбөрийг хэрхэн хэрэгжүүлсэн, суралцагчдын мэдлэг, чадварын түвшин ямар байгаа талаар үнэн зөв мэдээлэл авах боломж олгох.
- Суралцагчдын хариултын мэдээллийг шивэх програм хангамжийг ашиглахад хялбар болгох.
- Шивж оруулсан мэдээллийн санд боловсруулалт хийх, ашиглах боломжийг нэмэгдүүлэх.
- Хариултын мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажил учир дутагдалтай байгаа бөгөөд цаашид сургуулийн удирдах ажилтнууд, багш нарт мэдээлэл авах, боловсруулах, үр дүнг хэрхэн ашиглах талаар арга зүйн сургалтуудыг тогтмол зохион байгуулах.
- Улсын шалгалт зохион байгуулсан болон үр дүнгийн талаарх тайлан боловсруулах, тайлангийн үр дүнг цаашдын бодлого үйл ажиллагааны үндэслэл болгох эсэхэд шийдэл гаргах эрх зүйн чадамж бүхий байгууллага, хариуцан ажиллах хүний чиг үүргийг тодорхойлох

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Сүүлийн 30 жилд Монгол улсын боловсролын салбарт тогтолцооны томоохон өөрчлөлт хийгдэж, түүнийг даган сургалтын хөтөлбөр хэд хэдэн удаа өөрчлөгджээ. Ялангуяа сүүлийн жилүүдэд 4 жилийн давтамжтайгаар (2004, 2008, 2012) сургалтын хөтөлбөр өөрчлөгдсөн байна. Богино хугацаанд хийсэн сургалтын хөтөлбөрийн өөрчлөлт нь судалгаанд суурилсан боловсролын бодлого, шийдвэр гаргах, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, баталгаажуулах, сурах бичиг, сургалтын материалыг цаг хугацаанд нь боловсруулж түгээх зэрэг тулгамдсан асуудлуудыг дагуулсаар ирсэн байна.

Тулгамдсан асуудлын учир шалтгааныг илрүүлэх зорилготой бичсэн энэхүү тайланг (1) сургалтын хөтөлбөр, сурах бичиг боловсруулах, (2) сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, (3) сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх гэсэн гурван бүлгээр дараах арга, аргачлалын дагуу боловсруулсан. Үүнд:

1. 2012 оноос эхэлсэн сургалтын цөм хөтөлбөр, сурах бичиг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл ажиллагаанд оролцсон багийн гишүүдээс мэдээлэл цуглуулах (73 гишүүн)
2. Төлөвлөх-Гүйцэтгэх-Үнэлэх-Сайжруулах (Plan-Do-Check-Action) загвараар цуглуулсан үйл явцын мэдээллийг “Үйл ажиллагааны дараалалын бүтэц” (Work Breakdown Structure) аргачлалыг ашиглан эмхэтгэн цэгцлэх
3. “Ажлын хүснэгт”(Хавсралт)-ийн цэгцэлсэн мэдээллийг үндэслэн үйл ажиллагааны давуу ба сул талыг илрүүлэн, цаашид сайжруулах санал зөвлөмж (дүгнэлт, санал) боловсруулах

2012 онд эхлүүлсэн сургалтын хөтөлбөрийн шинэчлэл нь дараах онцлог, давуу талтай байжээ.

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа багшийн мэргэжил дээшлүүлэх институтыг (20 гаруй жилийн дараа) дахин байгуулж, мэргэжлийн байгууллагуудад түшиглэсэн тогтолцооны шинжтэй шинэчлэл эхлүүлсэн
2. Шинэчлэлийг хэрэгжүүлэх бүтцийг үндэсний, мэргэжлийн байгууллагын, сургуулийн түвшинд харилцан уялдаатай ажиллуулах зорилгоор “Менежментийн баг” байгуулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах эхлэлийг тавьсан
3. Сургалтын шинэ хөтөлбөрийг таниулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургууль, багш нарт зөвлөн туслах ажлыг ажлын байранд нь гардаж зохион байгуулсан зэрэг шинэлэг ажлуудыг хэрэгжүүлсэн, боловсролын салбарын олон талын төлөөлийг хамарсан онцлогтой байжээ.

Гэвч дараах 2 асуудал тулгамдаж байсаныг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

1. Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн нэгдсэн зураглал батлагдсан боловч түүнийг дагаж урт болон дунд хугацааны нэгдсэн төлөвлөгөө болон төсөв батлагдаагүй байна. Шинэчлэлийн эхэн үед санхүүжилтийг тодорхой хэмжээнд шийдэж, цөм хөтөлбөр боловсруулах үйл ажиллагаа эхэлсэн боловч цаашид тогтвортой хэрэгжүүлэх санхүүжилт удааширчээ.
2. Сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг 6 жилийн хугацаанд хийх нэгдсэн зураглалыг гаргахдаа сургалтын шинэ хөтөлбөр хэрэгжүүлэхийн өмнөх бэлтгэл ажил хийх хангалттай хугацаа төлөвлөлөөгүйн улмаас богино хугацаанд олон ажил зэрэг хийх шаардлага үүссэн байна.

Иймээс төлөвлөлт хийхдээ санхүүгийн болон цаг хугацааны нөөцийг бодитой тооцоогүйн улмаас багийн гишүүдэд ажлын ачаалал үүсэх, зарим ажил төсвөөс шалтгаалж хойшлох зэрэг бэрхшээл тулгарч үйл ажиллагааны дараалал алдагдаж, энэ нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байжээ.

Эдгээр тулгамдсан асуудлыг шийдэхийн тулд Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанаас үл хамааран сургалтын хөтөлбөрийн менежментийг урт, дунд, богино хугацаанд төлөвлөх нь боловсролын салбар, хүний нөөцийн хөгжил, цаашлаад улс орны хөгжлийн түвшинг тодорхойлоход чухал ач холбогдолтой гэдгийг бодлого, шийдвэр гаргагчид болон мэргэжлийн байгууллагууд харилцан хүлээн зөвшөөрч, оролцогч талуудын эрх үүргийг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Судалгааны болон гүйцэтгэлийн үр дүнд суурилан сургалтын хөтөлбөр нь тасралтгүй хөгжих, мэргэжлийн болон боловсролын байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг харилцан хамааралтай, менежментийн тогтвортой, үр дүнтэй тогтолцоог бий болгох зохицуулалтыг Боловсролын тухай хууль, бага дунд боловсролын тухай хууль болон бусад холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, холбогдох дүрэм, журмыг боловсруулан, баталгаажуулж хэрэгжүүлэх нь чухал юм. Мэргэжлийн болон боловсролын байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургалтын хөтөлбөрийн шинэчлэл хийх Төлөвлөх-Гүйцэтгэх-Үнэлэх-Сайжруулах (Plan-Do-Check-Action) загварын дагуу байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж, эргэх холбоог сайжруулах чиглэлээр түвшин бүрт анхаарч ажилласнаар боловсролын чанарыг

сайжруулах тогтолцоог бэхжүүлнэ.

Иймээс боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүний дэргэд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй, үрт хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор үндэсний зөвлөл, менежментийн болон мэргэжлийн баг, байгууллага хамтран, харилцан үялдаатай ажиллах эрх зүйн орчин бүрдүүлэх хэрэгтэй. Үүнд:


- Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн 10 жилийн буюу үрт, дунд, богино хугацааны үйл ажиллагааг төлөвлөж, хүний, материалын, санхүүгийн, цаг хугацааны нөөцийг зөв тооцон жил бүрийн улсын төсөвт шаардлагатай санхүүжилтийг батлуулах
- Судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх үндэслэл хэрэгцээг тодорхойлох, үзэл баримтлал боловсруулах, олон нийтэд хэлэлцүүлэх, саналыг тусган сайжруулахад зарцуулах хүний болон цаг хугацааны бодит нөөцийг онцгойлон харгалзах
- Суралцагчийн сурлагын амжилтын судалгаа, судлагдахуун судлал, нийгмийн хөгжлийн судалгаанд үндэслэн сургалтын хөтөлбөр боловсруулагчид, сургууль, багш нарыг нэгдсэн ойлголттой болоход дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явц, үр дүнг олон нийтэд нээлттэй хүргэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөр боловсруулах, түрших, батлах үеийн агуулгын зөрөөг шийдэх, шилжилтийн бэлтгэл хангах, сурах бичиг, сургалтын орчныг шинэ хөтөлбөрт нийцүүлэн, судалгаанд суурилан үе шаттай сайжруулах ажлын чиг үүргийг тодорхойлох
- Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулах, хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийх мэргэшсэн экспертүүдийн гүйцэтгэсэн ажлын чанар, үр дүнг тодорхойлох шалгуур үзүүлэлт боловсруулж ажлын хөлсийг тооцох
- Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамжийг баталгаажуулсны дараа шинээр зохиох сурах бичгийн жагсаалтыг батлах, үүний дараа 2 жилийн турш эх зохиох, хянах, хэлэлцүүлэх, техникийн тодорхойлолт гаргах, баталгаажуулах, хэвлэлтэд шилжүүлэх
- Сурах бичиг нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжсэн эсэх, хүүхдийн сурах арга барил, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хэрхэн дэмжиж буй байдал гэх мэт ашиглалтын үр дүнгийн талаар судалгаа хийж боловсруулалт, хэвлэлтэд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг сайжруулан эргэх холбоотой ажиллах
- Сургалтын хөтөлбөр, судалгаа үнэлгээ, сурах бичиг боловсруулах чиглэлээр үндэсний мэргэшсэн мэргэжилтэн, эксперт бэлтгэх хүний нөөцийг чадавхжуулах үйл ажиллагааг үрт хугацаанд төлөвлөх
- Шинэ хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэхийн өмнөх шилжилтийн төлөвлөгөө гаргаж, сургуулийн болон багшийн бэлэн байдлыг хангах, сурагчдын үзэх агуулгын зөрөөг гаргах үйл ажиллагааны зардлыг тусгах
- Үндэсний болон орон нутгийн хэмжээнд нэгдсэн төлөвлөгөө, удирдлага зохион байгуулалтаар хангаж, мониторинг хийх, зөвлөн туслах, түршлага солилцох ажлын үр дүнд шинжилгээ хийж тасралтгүй сайжруулах.
- Багш, мэргэжилтнүүдийн чадавхжих хэрэгцээ, шаардлагад суурилан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт зохион байгуулах, аргачлал, зөвлөмжийг боловсруулах
- Сургуулийн удирдах ажилтнуудын манлайллыг сайжруулах, сонгон шалгаруулалт, томилгоог тогтвортой байлгах үүднээс боловсролын хөгжлийн бодлогод нийцүүлэн оновчтой зохион байгуулах
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл явцын мониторингийн тайланд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, сургууль, багш, сурагч, эцэг, эх, холбогдох олон нийтэд мэдээлэл хүргэх, хамтран ажиллах эргэх холбоотой ажиллах

Эдгээр хэрэгцээ шаардлага нь 1990 оноос хойш байсан хэдий ч үе, үеийн засгийн газар үрт хугацааны тогтвортой хөгжлийн шийдэл болох тогтолцоо бүрдүүлэхээс илүүтэй тухайн засгийн газрын богино хугацааны ажлын гүйцэтгэлд анхаарч ирсэн байна. Харин 2012 онд хэрэгжүүлж эхэлсэн хүүхэд бүрийг хөгжүүлэх боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, сургалтын хөтөлбөрийг боловсруулах, түрших, хэрэгжүүлэх, үйл явцыг тогтолцооны түвшинд хэрэгжүүлэх оролдлого хийсэн хэдий ч Засгийн газрын бүрэн эрхийн хугацаа 2016 онд дууссан байна.

Цаашид боловсролын тогтолцооны нэгдмэл, цогц, тогтвортой байдлыг хангах, хөтөлбөрийн менежментийг сайжруулах зорилгоор өнгөрсөн хугацаанд тулгамдаж байсан асуудлуудыг онцлон илрүүлж, түүнийг шийдэх санал боловсруулсныг цохон тэмдэглэж байна.

Иймээс дараагийн хөтөлбөрийн шинэчлэлийг хэзээнээс хэрхэн хийх зураглал төлөвлөгөө боловсруулах, бэлтгэл ажлын хүрээнд хийх судалгааны үр дүнд шинжилгээ хийх зэрэг асуудлууд тулгамдаж байна. Энэхүү тайланд тусгасан санал, дүгнэлт нь дараагийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэг болно хэмээн найдаж байна.

ХАВСРАЛТ



Phase 1.1 Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулах
Phase - Activity - Task - Subtask

Activity	Task	Subtask	Бүтээгдэхүүн-хүрсэн үр дүн	Хариуцагч	Хамтран ажиллагч баг, байгууллага	Хүний тоо - Хэн	Хүний тоо- Хэнд	Хаана / байршил	Хэдэн өдөр	Эхэлсэн	Дууссан	Хэрэглэгдэхүүн
Phase 1.1. Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэл												
Бага боловсрол												
P1.1.A1. Хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах бэлтгэл хангах												
P1.1.A1.T1. Баг бүрдүүлэх												
		Үндэсний зөвлөл, менежментийн багийг томилох	Багийн ахлагч, багийн гишүүдийн нэр батлагдсан. (БШУ-ны сайдын 2012 оны А/180 дугаар тушаал).	БШУЯ	МУБИС, БХ, БМДИ	32		БШУЯ	30	2012.11	2012.12	CV, анкет
		Стандарт, хөтөлбөрийн үзэл баримтлал боловсруулах, багийг бүрдүүлж томилох	Багийн ахлагч, багийн гишүүдийн нэр батлагдсан. (БШУ-ны сайдын 2013 оны А/155 дугаар тушаал)	БШУЯ	БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС, ТББ	32	126	БШУЯ	60	2013.04	2013.05	CV, анкет
P1.1.A1.T2. Орчуулга, судалгаа хийх												
		Менежментийн багаас хөтөлбөр боловсруулах багуудад үйл ажиллагааны чиглэл өгөх	Хурлын протокол бичигдсэн	МБ	БХ, БМДИ,	14	126	МУБИС	24	2013.04	2014.09	Бичгийн хэрэгсэл
		Гадаад улс орнуудын стандарт, хөтөлбөр орчуулах	3 улсын боловсролын шинэчлэл, сургалтын хөтөлбөрийн амжилт, Бага боловсролын математик, БУ гадаад хэлний сургалтын хөтөлбөрийн орчуулга хийгдсэн	БШУЯ, МБ	БХ, МУБИС, МУИС	25		БШУЯ	60	2012.01	2012.03	Хөтөлбөр, стандартууд
		Сургалтын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа хийх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарсан. Сургалтын төлөвлөгөө батлагдсан.	БХ	БХ, МУБИС, МУИС	15		БХ		2013.05	2014.05	Бичгийн хэрэгсэл
		Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарсан.	БХ	БХ, МУБИС, МУИС	15		БХ		2013.05	2014.05	Бичгийн хэрэгсэл
		Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа хийх	Судалгааны тайлан гарсан.	БХ	ЕБС-ууд	30		Ховд, Өвөрхангай, Замын үүд, Булган, Дорнод, УБ-ын 9 ЕБС		2013.05	2014.05	Судалгааны тайлан, бичгийн хэрэгсэл
P1.1.A1.T3. Ажлын төлөвлөлт хийх						75	181		164			

P1.1.A2.	Сургалтын хөтөлбөр, зөвлөмж боловсруулах удирдамж, бүтцийг хэлэлцэх	БХ-ийн захирлын тушаал гарсан.	БХ	МБ	15	32	БХ, БШУЯ	60	2013.03	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах төсөв, зардлыг батлах, гэрээ байгуулах	Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БШУЯ	БХ	15	126	БХ, БШУЯ	30	2013.07	2013.08	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамжид эксперт хийх төсөв, зардлыг батлах, гэрээ байгуулах	Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БШУЯ	БХ	15	23	БХ, БШУЯ	30	2013.07	2013.08	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр боловсруулагчдад зориулсан удирдамж боловсруулах	Удирдамж гарсан.	БХ, СХСС	ХБ5	15		МУБИС, МУИС	14	2013.04	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын төлөвлөгөөг батлуулах	БШУ-ны сайдын 2014 оны А/240 дугаар тушаалаар батлагдсан.	БХ	БШУЯ	15		БШУЯ	15	2014.05	2014.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр хэвлэх зардлын тооцоог гаргах	Хэвлэлийн зардал төсөвт тусгагдсан.	БШУЯ	БХ	3		БШУЯ	15	2014.07	2014.07	Цөм хөтөлбөр
	P1.1.A2. Сургалтын хөтөлбөр, зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах										
	P1.1.A2.Т1. Судлагдахууны багийн уулзалт зохион байгуулах										
	Судлагдахууны багийн ажлын төлөвлөлт гаргах	Ажлын төлөвлөлт гарсан.	БХ	ХБ5	95		БХ	16	2013.05	2014.06	Бичгийн хэрэгсэл, уулзалтын зардал
	Агуулгын хүрээ, агуулгын залгамж холбоог гаргах	Хөтөлбөрийн агуулга гарсан.	БХ	ХБ5	95		БХ	20	2013.05	2014.06	Бичгийн хэрэгсэл
P1.1.A2.Т2.	Гадаад улс орнуудын туршлага судлах, зөвлөх үйлчилгээ авах	2-3 удаа зөвлөх үйлчилгээ авсан.	БШУЯ	ХБ5	95		БХ	8	2014.05	2014.06	сургалтын зардал
	Сургалтын хөтөлбөр боловсруулах	1-5 дугаар анги тус бүрээр 8 хичээлийн буюу 38 хөтөлбөр боловсруулсан.	БХ	ХБ5	126		БХ	286	2013.05	2014.06	Бичгийн хэрэгсэл
	Зөвлөмж/суралцахуйн удирдамж боловсруулах	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийн төсөл гарсан.	БХ	ХБ5	126		БХ	286	2013.05	2014.06	Бичгийн хэрэгсэл
	P1.1.A2.Т2. Сургалтын хөтөлбөрт эксперт хийх										
	Экспертээс санал дүгнэлт авах	Экспертээс санал дүгнэлт авсан	БХ, ХБ5	БХ	23	80	БХ	22	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл
	Экспертийн санал, дүгнэлтийн дагуу сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг сайжруулах	Хөтөлбөр зөвлөмжийн сайжруулсан хувилбар гарсан.	БХ, ХБ5	БХ	23	80	БХ	22	2013.04	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Экспертийн дүгнэлтэд тайлбар бичиж хүргүүлэх	Тайлбар хүргүүлсэн.	БХ, ХБ5	БХ	23	80	БХ	7	2013.05	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Экспертээс эцсийн дүгнэлт авах	Эцсийн дүгнэлт авсан.	БХ, ХБ5	БХ	23	80	БХ	22	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл
	P1.1.A3. Сургалтын хөтөлбөрийг туршин сайжруулах										
	P1.1.A3.Т1. Сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудад хүргэх										
					328	66		116			
					286	66		81			

	Лаборатори сургуулийг сонгох	21 аймгийн лаборатори 24, нийслэлийн 16 сургууль.	БХ	БХ, БМДИ, ХБ	40	66	БХ	7	2013.05	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын бэлтгэл хангах	Тушаал, сургалтын төсөв гарсан.	БХ	ХБ	66		БХ	22	2014.10	2014.11	Бичгийн хэрэгсэл
	Туршилт хичээл зохион байгуулах	Судалгаат хичээл зохион байгуулсан.	БШУЯ	БМДИ, ХБ	20		БХ	8	2014.11	2014.11	Бичгийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн
	Сургалтын хөтөлбөрийг хэлэлцүүлэх, санал авах	Улирал бүр багш нараас авсан санал, дүгнэлт	БХ	БМДИ, ХБ	80		БХ	28	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөрийг сайжруулах	Лаборатори сургуулийн багш нараар хэлэлцүүлж, саналыг тусган сайжруулсан. Мөн экспертийн саналыг тусгасан.	БХ	БМДИ, ХБ	80		БХ	16	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл
	P1.1.A3.T2. Сургалтын хөтөлбөрийг хэвлэлд өгөх				42	0		35			
	Эх бэлтгэх	Эх бэлтгэл хийгдсэн.	БШУЯ	БХ	3		БШУЯ	7	2014.06	2014.07	Бичгийн хэрэгсэл
			Бэлтгэсэн эхийг редакторлах	БХ	3		БШУЯ	7	2014.06	2014.07	Бичгийн хэрэгсэл
			Хэвлэх	БХ	6		БШУЯ	7	2014.07	2014.07	сургалтын цөм хөтөлбөр
	Сургуулиудад хүргэх	Бага ангийн багш бүрт хүргэгдсэн.	БШУЯ	ХК	30		ХК	14	2014.08	2014.08	сургалтын цөм хөтөлбөр
P1.1.A4. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах					181	310		12			
	P1.1.A4.T1. Лаборатори сургуулийн бага ангийн багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах				45	91					
	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний 120 сургагч багш бэлтгэгдсэн	БХ	БМДИ, ХБ	45	91	БХО	4	2014.06	2014.06	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	P1.1.A4.T2. Орон нутагт түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулах				91	120		4			
	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний 120 сургагч багш бэлтгэгдсэн	БХ	БМДИ, ХБ	91	120	МУБИС	4	2014.06	2014.06	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	P1.1.A4.T3. Зөвлөн туслах сургалт зохион байгуулах				45	99		4			
	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний 99 сургагч багш оролцсон	БХ	БМДИ, ХБ	45	99	МУБИС	4	2014.06	2014.06	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	Суурь боловсрол				2,933	1,492		1,801	2014.07	2015.08	
	P1.1.A1. Хөтөлбөр, Суралцахуйн удирдамж боловсруулах бэлтгэл хангах /Суурь боловсрол/				351	478		913			
	P1.1.A1.T1. Баг бүрдүүлэх				158	-		7.25			
	Менежментийн багийг томилох	БШУ-ны сайдын 2014 оны А/306-р тушаал гарсан	БШУЯ	МУБИС, БХ, БМДИ	10		БШУЯ	0.25	2014	2014	CV, анкет
	Сургалтын хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлж томилох	БХ-ийн захирлын 2014 оны 50-р тушаал гарсан	БХ	БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС, ТББ	148		БХ	7	2014	2014	CV, анкет

P1.1.A1.T2. Орчуулга, судалгаа хийх	Менежментийн багаас хөтөлбөр боловсруулах багуудад үйл ажиллагааны чиглэл өгөх		Чиглэл, удирдамж гарсан	БСШУЯ, МБ	БХ, БМДИ, МУИС, МУБИС	116	148		833			
	Гадаадын улс орнуудын стандарт, хөтөлбөр орчуулах		2-3 улсын 2-5 сургалтын хөтөлбөрийн орчуулга хийгдсэн	БСШУЯ, МБ	БХ, МУБИС, МУИС	30			1	2014.07	2014.07	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа хийх		Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарсан.	БХ	БХ, МУБИС, МУИС	12			44	2014.09	2015.06	Хөтөлбөр стандартууд
	Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийх		Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарна.	БХ	БХ, МУБИС, МУИС	12			284	2014.09	2015.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа хийх		Судалгааны тайлан гарсан байна.	БСШУЯ, БХ	Азийн хөгжлийн банк, хэрэгжилтийн баг	52		УБ хотын 8 дүүргийн 20 сургууль, Хөвсгөл, Хэнтий, Дундговь, Эрдэнэт, Завхан, Увс аймгийн нийт 17 сургууль	220	2015.09	2016.10	Судалгааны тайлан, бичгийн хэрэгсэл
	P1.1.A1.T3. Ажлын төлөвлөлт хийх					77	330		73			
	Сургалтын хөтөлбөр, зөвлөмж боловсруулах удирдамж, бүтцийг хэлэлцэх		БШУ-ны сайдын 2014 оны А/306-р тушаал БХ-ийн захирлын 2014 оны 50-р тушаал гарсан	БХ	БХ	15	148		22	2013.04 2014.10	2014.11	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр, зөвлөмж боловсруулах төсөв, зардлыг батлах, гэрээ байгуулах		Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БХ	БШУЯ	15	148		7	2014.08	2014.08	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр, зөвлөмжид эксперт хийх төсөв, зардлыг батлах, гэрээ байгуулах		Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БХ	БШУЯ	15	34		7	2014.08	2014.08	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр боловсруулагчдад зориулсан удирдамж боловсруулах		Удирдамж гарсан.	БХ	ХББ	15			13	2014.10	2014.10	Бичгийн хэрэгсэл
P1.1.A2. Сургалтын хөтөлбөр, зөвлөмж суралцахуйн удирдамж боловсруулах	Сургалтын төлөвлөгөөг батлуулах		БСШУ-ны сайдын 2015 оны А/220 дугаар тушаалаар батлагдсан.	БХ	БСШУЯ	15			22	2015.05	2015.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөр хэвлэх зардлын тооцоог гаргах		Хэвлэлийн зардал төсөвт тусгагдсан байна.	БСШУЯ	ХК	2			2	2015.07	2015.07	Цөм хөтөлбөр
	P1.1.A2.T1. Судлагдахууны багийн үүлзлэлт зохион байгуулах					1,332	-		777			
	Судлагдахууны багийн ажлын төлөвлөлт гаргах		Ажлын төлөвлөлт гарсан.	БХ	ХББ	148			704			Бичгийн хэрэг, уулзалтын зардал
	Агуулгын хүрээ, агуулгын залгамж холбоог гаргах		Хөтөлбөрийн агуулга гарсан.	БХ	ХББ	148			176	2014.10	2015.06	Бичгийн хэрэгсэл

	Гадаад улс орнуудын туршлага судлах, зөвлөх үйлчилгээ авах	Туршлага судлах болон сургалтуудыг зохион байгуулсан.	БСШУЯ	ХББ	148		БХ	176	2014.10	2015.06	сургалтын зардал
	Сургалтын хөтөлбөр боловсруулах	17 судлагдахууны хөтөлбөр боловсруулагдсан	БХ	ХББ	148		БХ	176	2014.10	2015.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж/суралцахуйн хөтөлбөр, зөвлөмжөө сайжруулан удирдаж боловсруулах	17 судлагдахууны хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдаж боловсруулагдсан.	БХ	ХББ	148		БХ	176	2014.10	2015.06	Бичгийн хэрэгсэл
	P1.1.A2.T2. Сургалтын хөтөлбөрт эксперт хийх				592	0		73			
	Экспертээс санал дүгнэлт авах	Экспертээс санал дүгнэлт авсан	БХ	ХББ	148		БХ	22	2015.03	2015.04	Бичгийн хэрэгсэл
	Экспертийн санал, дүгнэлтийн дагуу хөтөлбөр, зөвлөмжөө сайжруулан засах	Хөтөлбөр зөвлөмжийн сайжруулсан хувилбар гарсан.	БХ	ХББ	148		БХ	22	2015.04	2015.05	Бичгийн хэрэгсэл
	Экспертийн дүгнэлтэд тайлбар бичиж, хүргүүлэх	Тайлбар хүргүүлсэн.	БХ	ХББ	148		БХ	7	2015.05	2015.05	Бичгийн хэрэгсэл
	Экспертээс эцсийн дүгнэлт авах	Санал дүгнэлт авсан.	БХ	ХББ	148		БХ	22	2015.05	2015.06	Бичгийн хэрэгсэл
	P1.1.A3. Сургалтын хөтөлбөрийг туршин сайжруулах				675	148		99			
	P1.1.A3.T1. Сургалтын хөтөлбөрийг лаборатори сургуулиудад хүргэх				633	148		43			
	Лаборатори сургуультай холбогдох	21 аймгийн лаборатори 24, нийслэлийн 16 сургууль.	БСШУЯ	БХ, БМДИ, ХБ	41	148	БХО	1	2013.05	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын бэлтгэл хангах	Тушаал, сургалтын төсөв гарсан	БМДИ	БХ, ХБ	148		БХО	8	2015.10	2015.01	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	Туршилт хичээл зохион байгуулах	Судалгаат хичээл зохион байгуулсан.	БХ	БМДИ, ХБ	148		ЕБС	8	2015.11	2015.11	Бичгийн хэрэгсэл, хичээлийн хэрэглэгдэхүүн
	Сургалтын хөтөлбөрийг хэлэлцүүлэх, санал авах	Улирал бүр багш нараас санал авсан	БХ	БМДИ, ХБ	148		ЕБС, БХ	4	2015.05	2015.06	Бичгийн хэрэгсэл
	Сургалтын хөтөлбөрийг сайжруулах	Лаборатори сургуулийн багш нар болон их дээд сургуулийн мэргэжлийн тэнхимийн багш нараар хэлэлцүүлж, саналыг тусган сайжруулсан. Мөн экспертийн саналыг тусгасан.	БХ	БМДИ, ХБ	148		БХ	22	2015.05	2015.06	Бичгийн хэрэгсэл
P1.1.A3.T2. Сургалтын хөтөлбөрийг хэвлэлд өгөх					42	0		56			
	Эх бэлтгэх	Эх бэлтгэл хийгдсэн.	БСШУЯ	БХ	3		БСШУЯ	14	2015.06	2015.07	Бичгийн хэрэгсэл
	Бэлтгэсэн эхийг редакторлах	Редакторын дүгнэлтийг тусгасан.	БСШУЯ	БХ	3		БСШУЯ	14	2015.06	2015.07	Бичгийн хэрэгсэл
	Хэвлэх	19000 ш хэвлэсэн.	БСШУЯ	БХ	6		БСШУЯ	14	2015.07	2015.07	Хэвлэх зардал
	Сургуулиудад хүргэх	Дунд ангийн багш бүрт хүргэсэн.	БСШУЯ	ХК	30		ЕБС	14	2015.08	2015.08	Хүргэх зардал
P1.1.A4. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах					575	866		12			

Бүрэн дунд боловсрол	Р1.1.А4.Т1. Лаборатори сургуулийн дунд ангийн багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах																		Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
		Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний 160 сургагч багш бэлтгэгдсэн	БХ				БМДИ, ХБ	160	-		БХО	4	2014.06.09	2015.06.09				
	Р1.1.А4.Т2. Орон нутагт түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулах																		Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
		Сургагч багш нарыг бэлтгэх	Орон нутгийн сургагч багш бэлтгэгдсэн	БХ				БМДИ, ХБ	160	433		МУБИС	4	2015.08	2015.08				
	Р1.1.А4.Т3. Зөвлөн туслах сургалт зохион байгуулах																		Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
		Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний 255 сургагч багш бэлтгэгдсэн	БХ				БМДИ, ХБ	255	433		МУБИС	4	2015.08	2015.08				
	Бүрэн дунд боловсрол																		Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	Р1.1.А1. Хөтөлбөр, Суралцахуйн удирдамж боловсруулах бэлтгэл хангах (Бүрэн дунд боловсрол/																		
	Р1.1.А1.Т1. Баг бүрдүүлэх																		
		Менеджментийн багийг томилох	БСШУ-ны сайдын 2015 оны 10-р сарын 22-ны өдрийн А/424-р тушаал батлагдсан.	МУБИС, БХ, БМДИ				МУБИС, БХ, БМДИ	14			БСШУЯ	0.25	2015.10	2016.06				CV, анкет
		Сургалтын хөтөлбөр боловсруулах багийг бүрдүүлж томилох	БСШУ-ны сайдын 2015 оны 10-р сарын 22-ны өдрийн А/424-р тушаал батлагдсан.	БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС, ТББ				БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС, ТББ	14	171		БСШУЯ	7	2015.10	2016.06				CV, анкет
	Р1.1.А1.Т2. Орчуулга, судалгаа хийх																		
		Гадаадын улс орнуудын стандарт, хөтөлбөр орчуулах	5 судлагдахууны сургалтын хөтөлбөрийн орчуулга хийгдсэн	БСШУЯ				БСШУЯ	23	0		БХ, МУИС, МУБИС,	176	2015.10	2016.06				Хөтөлбөр стандартууд
		Сургалтын төлөвлөгөөний харьцуулсан судалгаа хийх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарсан.	БХ, МУБИС, МУИС				БХ, МУБИС, МУИС	23			БХ, МУИС, МУБИС,	176	2015.10	2016.06				Бичгийн хэрэгсэл
		Сургалтын хөтөлбөрийн харьцуулсан судалгаа хийх	Эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан гарсан.	БХ, МУБИС, МУИС				БХ, МУБИС, МУИС	23			БХ, МУИС, МУБИС,	176	2015.10	2016.06				Бичгийн хэрэгсэл
		Сургалтын хөтөлбөрийн хэрэгцээний судалгаа хийх	Ахлах ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх хэрэгцээний судалгаа хийсэн	БХ				БХ, Их, дээд сургуулиуд	10			ЕБС	14	2013.02	2014.06				Судалгааны тайлан, бичгийн хэрэгсэл
	Р1.1.А1.Т3. Ажлын төлөвлөлт хийх																		
		Ахлах ангийн сургалтын хөтөлбөр турших чиглэл, ахлах ангийн сургалтын талаар баримтлах бодлого	БСШУ-ны сайдын 2015 оны 10-р сарын 22-ны А/424-р тушаал БСШУ-ны сайдын 2016 оны 06-р сарын 27-ны А/275-р тушаал гарсан	БСШУЯ				БХ	15			БСШУЯ, БХ	176	2013.04 2015.10	2016.06				Бичгийн хэрэгсэл
		Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж боловсруулах төсөв, зардлыг тооцох, гэрээ байгуулах	Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БХ				БСШУЯ	5			БХ, БСШУЯ	7	2015.10	2015.10				Бичгийн хэрэгсэл
		Сургаллын хөтөлбөр, суралцахуйн удирдамжид эксперт хийх төсөв, зардлыг тооцох гэрээ байгуулах	Ажил гүйцэтгэх гэрээ хийгдсэн.	БХ				БСШУЯ	5			БХ, БСШУЯ	7	2015.10	2015.10				Бичгийн хэрэгсэл

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙГ
БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ, ҮНЭЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ТАЙЛАН

	Сургалтын хөтөлбөрийг сайжруулах	Багш нарын саналыг хөтөлбөрт тусган сайжруулсан.	БХ	МУИС, МУБИС,	171		БХ	22	2016.05	2016.06	Бичгийн хэрэгсэл
P1.1.A3.T2.Сургалтын хөтөлбөрийг хэвлэлд өгөх	Эх бэлтгэх	Эх бэлтгэл хийгдсэн.	БСШУЯ	БХ	3	-		56	2016.06	2016.07	Бичгийн хэрэгсэл
	Бэлтгэсэн эхийг редакторлах	Редакторын дүгнэлтийг тусгасан.	БСШУЯ	БХ	2			14	2016.06	2016.07	Бичгийн хэрэгсэл
	Хөвлөх	16000 ш хөвлөсөн.	БСШУЯ	БХ	6			14	2016.07	2016.07	Хөвлөх зардал
	Сургуулиудад хүргэх	Ахлах ангийн багш бүрт хүргэсэн.	БСШУЯ	БМДИ	30			14	2016.08	2016.08	Хүргэх зардал
P1.1.A4.	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах										
	P1.1.A4.T1. Лаборатори сургуулийн ахлах ангийн багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах				72	472		6			
	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний сургалт зохион багуулах 38 сургагч багш бэлтгэгдсэн.	БХ	БМДИ	38	236		4	2016.06.08	2016.06.08	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	Лаборатори сургуулийн сургалтын менежерүүдийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	УБ хотын 17 лаборатори сургуулийн менежерүүдийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	БХ	ЕБС-ууд	34	236		2	2015.11.04	2015.11.04	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	P1.1.A4.T2. Орон нутагт түгээн дэлгэрүүлэх сургалт зохион байгуулах				132	598		4			
P1.1.A4.T3. Зөвлөн туслах сургалт зохион байгуулах	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний сургалт зохион багуулах 132 сургагч багш бэлтгэгдсэн.	БХ	БМДИ	132	598		4	2017.08.15	2017.08.19	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн
	Сургагч багш нарыг бэлтгэх	Үндэсний сургалт зохион багуулах 324 сургагч багш бэлтгэгдсэн.	БХ	БМДИ	324	14932		3	2018.08.20	2018.08.23	Бичгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн

Тэмдэглэл: Phase, Activity, Task нэгтгэсэн дүн давхарсан хүний тоог илэрхийлнэ.

Сургалтын хөтөлбөр	Хэвлэсэн тоо ширхэг
Бага боловсрол	15,000
Суурь боловсрол	19,000
Бүрэн дунд боловсрол	16,000
Нийт	50,000

Phase 1.2 ЕБС-ийн I-XII ангийн бүх судлагдахууны сурах бичиг, багшийн ном зохиох

Phase - Activity - Task - Subtask

Activity	Task	Subtask	Бүтээгдэхүүн-хүрсэн үр дүн	Хариуцагч	Хамтран ажиллагч баг, байгууллага	Хүний тоо - Хэн	Хүний тоо- Хэнд	Хаана /Байршил/	Хэдэн өдөр	Эхэлсэн	Дууссан	Хэрэглэгдэхүүн
Phase 1.2. Бага, дунд, ахлах ангийн бүх судлагдахууны сурах бичиг, багшийн номын шинэчлэл												
Бага боловсрол												
P1.2.A1. Сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу сурах бичиг, багшийн ном зохиох бэлтгэл ажлыг хангах												
	P1.2.A1.T1. Сурах бичиг, багшийн номын жагсаалт гаргах, эх зохиох баг бүрдүүлэх					234	344		157			
	Сурах бичгийн үзэл баримтлал, бодлого чиглэл боловсруулах мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг хамарсан баг бүрдүүлэх		БШУ-ны сайдын 2013 оны А/155 дугаар тушаал гарсан	БСШУЯ	БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	6		БСШУЯ	30	2013.04	2013.05	Бичгийн хэрэгсэл
	Боловсролын хүрээлэнгийн Сурах бичгийн секторын ЭША-уудаар багийг өргөтгөх		БШУ-ны сайдын 2013 оны А/326 дугаар тушаал гарсан	БСШУЯ	БХ	13		БХО	5	2013.05	2013.08	Бичгийн хэрэгсэл
	Шинэ сургалтын хөтөлбөрийн дагуу зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалт гаргах, хэвлэлийн хуудасны хэмжээг тодорхойлох		Бага боловсролын 10 хичээлийн 70 нэр /32 сурах бичиг, 38 багшийн ном/-ийн сурах бичиг, багшийн номын жагсаалт /хэвлэлийн хуудасны хэмжээтэй жагсаалт/	БХ	БСШУЯ	8		БХО	10	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл
	Шинэ сургалтын хөтөлбөрийн дагуу зохиох сурах бичиг, багшийн номын жагсаалт батлуулах		БСШУЯ-д хүргүүлсэн албан тоот, жагсаалт баталсан сайдын тушаал	БХ	БСШУЯ	1		БСШУЯ	5	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл
	Шинэ сургалтын хөтөлбөрийн дагуу зохиох сурах бичиг, багшийн номын техникийн үзүүлэлтийг тодорхойлох		Бага боловсролын 10 хичээлийн 70 нэрийн сурах бичиг, багшийн номын техникийн тодорхойлолт		БХ	БСШУЯ	8		БХО	10	2014.05	2014.06
Сураглын шинэ хөтөлбөрийн дагуу зохиох сурах бичиг, багшийн номд тавигдах шаардлага, шалгуур боловсруулах												
Сурах бичиг, багшийн номд тавигдах шаардлага, шалгуурын төсөл												
Сурах бичиг, багшийн номд тавигдах шаардлага, шалгуурын төслийг хэлэлцэх, эцэслэх												
Сурах бичиг, багшийн номыг зохиох баг ахлах ахлагчийг томилно												

	Сургалтын шинэ хөтөлбөрийн дагуу сурах бичиг, багшийн номыг зохиох мэргэжлийн байгууллагын төлөөллийг хамарсан зохиогчийн баг бүрдүүлэх	Мэргэжлийн байгууллагуудад хүргүүлсэн албан тоот	БХ	БСШУ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	107		БХО	15	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Сурах бичиг, багшийн номын зохиогчдын багийг баталгаажуулах	БСШУ-д хүргүүлсэн албан тоот, сайдын 2014 оны 5 сарын 22-ны өдрийн А/222 тоот тушаалаар баталгаажсан зохиогчдын багийн нэрс	БХ, БСШУ		1	107	БСШУ	10	2014.04	2014.05	Бичгийн хэрэгсэл
	Сурах бичиг, багшийн номын эх зохиох зардлын тооцоо хийх	Зардлын тооцоо	БХ	БСШУ	1		БХО	3	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Зардлын тооцоог эрх бүхий байгуулагад илгээж, баталгаажуулах	БСШУ-д хүргүүлсэн албан тоот, зардал баталсан тушаал	БХ	БСШУ	1		БСШУ	5	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Сурах бичиг, багшийн номын зохиогчийн багтай байгуулах гэрээний төсөл боловсруулах	Гэрээний төсөл	БХ		8		БХО	10	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Гэрээний төслийг эрх бүхий байгууллагын хуулийн хэлтсээр хянуулах	Хянасан гэрээний төсөл	БСШУ		1		БСШУ	1	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Сурах бичиг, багшийн номын зохиогчийн багтай хийх гэрээг эцэслэх, зохиогчийн багтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	Багуудтай байгуулсан гэрээ	БХ	БСШУ	8	107	БХО	10	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл
	Лаборатори сургуулийн I-V ангийн сурагч, багшийн тоо гаргах /Туршилтын сурах бичиг, багшийн номыг хэвлэх тоо/	Лаборатори сургуулиудад 2013-2014 оны хичээлийн жилд суралцах I-V ангийн сурагч, багшийн тоо	БХ		8		БХО	10	2013.07	2013.08	Бичгийн хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгсэл
	Улирал бүрээр турших сурах бичиг, багшийн номын эхэд дүгнэлт өгөх экспертийн баг байгуулах	Экспертийн баг баталсан Боловсролын хүрээлэнгийн захирлын 2013 оны 8 сарын 12-ны өдрийн 13 тоот тушаал	БХ		8	23	БХО	3	2013.08	2013.08	Бичгийн хэрэгсэл
	Туршилтын сурах бичиг, багшийн номын талаар багш, сурагч, эцэг эхээс авах асуулга боловсруулах	Асуулгын хуудас	БХ	СББ ахлагч нар	16		БХО, СББ ахлагчийн ажил	5	2013.08	2013.08	Бичгийн хэрэгсэл
	P1.2.A1.T2. Ажлын төлөвлөгөө гаргах, үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн зардлыг тооцоолох				16	151		25			
	БДБЧШ-ийн зураглалын дагуу СБСОБ-ийн гурван жилийн ажлын төлөвлөгөө боловсруулах	СБСОБ-ийн гурван жилийн ажлын төлөвлөгөө болон нэг жилийн календарчилсан төлөвлөгөө	БХ	БСШУ	8	22	БХО	10	2013.06	2013.06	Бичгийн хэрэгсэл
	ТНБД, Боловсролын хүрээлэнгийн захирал, менежмент багийн ахлагч нар хамтран СБСОБ-ийн ахлагчтай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах	5 хавсралт бүхий гэрээ байгуулсан	БХ	БСШУ	8	129	БХО	15	2013.06	2013.06	Бичгийн хэрэгсэл

Р1.2.А1.Т3. Сурах бичгийн үзэл баримтлал, бодлого зохицуулалтын журмын төсөл боловсруулах	Сурах бичгийн үзэл баримтлал, бодлого чиглэл боловсруулах багийн ажлын төлөвлөгөө гаргах		Ажлын төлөвлөгөө гарсан	БХ	БХ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	82	227		96	2013.05	2013.06	Бичгийн хэрэгсэл	
	Сурах бичгийн үзэл баримтлал, бодлого чиглэл боловсруулах багийн үйл ажиллагаанд шаардагдах санхүүгийн зардлыг тооцоолох		Санхүүгийн тооцоо хийсэн	БХ		8			30	2013.06	2013.07	Бичгийн хэрэгсэл, техник хэрэгсэл	
	Сурах бичгийн талаар төрөөс баримталж буй бодлогын баримт бичиг, ордо мөрдөгдөж буй бодлого зохицуулалтын баримт бичгийг судлах		Судалгааны материал гарсан	БХ	БСШУЯ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	13			10	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл, судалгааны материал	
	Гадаад улс орнуудын сурах бичгийн талаар баримталж буй үзэл баримтлал болон бодлого зохицуулалтын журмыг орчуулах		Орчуулгын материал гарсан	БХ	БСШУЯ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	13			15	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл, толь бичиг	
	Судалсан материалуудад дүн шинжилгээ хийх		Харьцуулсан судалгааны тайлан гарсан	БХ	БСШУЯ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	13			10	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл	
	БДБ-ын сурах бичгийн үзэл баримтлалын төсөл боловсруулах		Сурах бичгийн үзэл баримтлалын төсөл	БХ	БСШУЯ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	13			10	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл	
	"ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам"-ыг шинэчлэн боловсруулах		"ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам"-ыг шинэчлэн боловсруулсан журмын төсөл	БХ	БСШУЯ, МУБИС, МУИС, БМДИ, ЕБС	13	107		10	2013.03	2013.04	Бичгийн хэрэгсэл	
	Үзэл баримтлал, журмын төслийг эрх бүхий байгуулагад хүргэх		БСШУЯ-д хүргүүлсэн албан тоот	БХ		1			1	2013.04	2013.05	Бичгийн хэрэгсэл	
	Р1.2.А2. Сурах бичиг, багшийн номын эх зохиох, хянах, сайжруулах												
	Р1.2.А2.Т1. Сурах бичиг, багшийн номын эх зохиох багийн уулзалт, сургалт зохион байгуулах						3,512	3,411		1,355			
							72	945		41			
		Багийн ахлагчдын уулзалтыг зохион байгуулж үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, сурах бичиг, багшийн номд тавих шаардлага, түүнийг хянах шалгуур үзүүлэлтийг танилцуулах	Уулзалтын тэмдэглэл, ирцийн бүртгэл	БХ	СББ ахлагч нар	8	9			1	2013.07	2013.07	Бичгийн хэрэгсэл, техник хэрэгсэл
